

Хууль зүй, дотоод
Хэргийн яам

Монголын Нээлттэй
Нийгэм Хүрээлэн

**«ТӨЛБӨРИЙН ЧАДВАРГҮЙ ИРГЭДЭД ХУУЛЬ ЗҮЙН
ТУСЛАЛЦАА ҮЗҮҮЛЭХ
ҮНДЭСНИЙ ТОГТОЛЦООГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ НЬ»**

ҮНДЭСНИЙ БАГА ХУРАЛ ХУРЛЫН ЭМХЭТГЭЛ

2003 оны 3 дугаар сарын 28

АГУУЛГА

Хурлын хөтөлбөр

Хурлын нэгдсэн зөвлөмж

Хурлын нээлтийн үг Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц. Нямдорж

Хурлын нээлтийн үг МННХ-Соросын сангийн Иргэний нийгмийн хөтөлбөрүүдийн захирал Л.Ариунаа

ХУРАЛ ДЭЭР ТАВИГДСАН ИЛТГЭЛҮҮД

«Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах үйл ажиллагаанд цагдаагийн байгууллагаас төлбөрийн чадваргүй иргэдийн өмгөөлүүлэх, хууль зүйн бусад туслалцаа авах эрхийг хангаж буй байдал» ЦЕГ, Хэрэг бүртгэх албаны дарга Л.Сүхээ

«Шүүх хуралдааны ажиллагаанд шүүхээс төлбөрийн чадваргүй иргэдийн өмгөөлүүлэх эрхийг хангахад гүйцэтгэх үүрэг» Дээд шүүхийн шүүгч А.Доржготов

«Прокурорын байгууллагын хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаанд төлбөрийн чадваргүй иргэдийн өмгөөллийн болон хууль зүйн туслалцаа авах эрхийн хэрэгжилтийн хяналт»
Улсын Ерөнхий Прокурорын газрын Мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих хэлтсийн дарга Т.Сүхбаатар

«Төлбөрийн чадваргүй иргэдийн өмгөөллийн болон хууль зүйн туслалцаа авах эрхийн хэрэгжүүлэхэд Монголын Өмгөөлөгчдийн Холбооны гүйцэтгэх үүрэг»
Монголын Өмгөөлөгчдийн Холбооны ерөнхийлөгч Б. Пүрэвням

«Төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн туслалцаа үзүүлж буй төрийн бус байгууллагын туршлага»
Хүний Эрх Хөгжил Төвийн хуульч Н.Дондов

«Хууль зүйн клиникүүд төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн туслалцаа үзүүлж буй байдал»
МУИС-ын Хууль зүйн сургуулийн Хүмүүнлэг клиникийн менежер, багш Н. Туяа

«Төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн товчоод хууль зүйн туслалцаа төлбөргүй үзүүлж буй эрх зүйн үйлчилгээний хэлбэр»
«Сувд» Хууль зүйн товчооны захирал Э.Болорчулуун

«Насанд хүрээгүй хүмүүст хууль зүйн туслалцаа үзүүлж буй байдал» Ричард Прадо, НҮБ-ын Хүүхдийн Сангийн Монгол дахь суурин төлөөлөгч

«Гэмт хэргийн хохирогчдод хууль зүйн туслалцаа үзүүлэх асуудал»
Хүчирхийллийн эсрэг үндэсний төвийн захирал Ц. Энхжаргал

«Хоригдлуудад хууль зүйн туслалцаа үзүүлж буй туршлага»
Олон Улсын Засан Сайжруулах Холбооны Монголын төвийн тэргүүн, Эмэгтэйчүүдийн хорих ангийн дарга Р.Оюунбадам

ХУРАЛ ДЭЭР ТАРААГДСАН СУРВАЛЖ МАТЕРИАЛУУД

Төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн туслалцаа үзүүлэх тогтолцоо” нөхцөл байдлын судалгаа

Зарим орнуудын эрх зүйн туслалцааны үндэсний тогтолцоо

өмнөд Африк улсын эрх зүйн туслалцаа ба Эрх Зүйн Туслалцааны Зөвлөл

Израил улсын өмгөөлөгчдийн товчоо, сургамж, ирээдүйн төлөвлөгөө

Нидерланд улсын эрх зүйн туслалцаа үзүүлэх тогтолцоо

Литва улсын эрх зүйн туслалцааны асуудал

Хууль зүй, дотоод
хэргийн яам

Монголын Нээлттэй
Нийгэм Хүрээлэн

ТӨЛБӨРИЙН ЧАДВАРГҮЙ ИРГЭДЭД ХУУЛЬ ЗҮЙН ТУСЛАЛЦАА ҮЗҮҮЛЭХ ҮНДЭСНИЙ
ТОГТОЛЦООГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ

Үндэсний хурал
2003.03.28

Хөтөлбөр

I хэсэг. Төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн туслалцаа үзүүлж буй өнөөгийн байдал
Хурал удирдагч:Ж. Амарсанаа, Хууль зүйн Үндэсний төвийн захирал, Өмгөөлөгчдийн мэргэжлийн хорооны дарга

9.00-9.30 Оролцогчдыг бүртгэх

9.30-9.50 Хурлын нээлт:

Ц. Нямдорж Хууль зүй, дотоод хэргийн сайд
Л.Ариунаа МННХ-Соросын сангийн Иргэний нийгэм хөтөлбөрүүдийн захирал

Төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн туслалцаа үзүүлэх тогтолцоо”
Нөхцөл байдлын судалгааны танилцуулга
М. Ичинноров Судалгааны багийн ахлагч

Цагдаагийн байгууллагаас хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд төлбөрийн чадваргүй иргэдийн өмгөөлүүлэх эрхийг хангаж буй байдал.
Л.Сүхээ, ЦЕГ-ын Хэрэг бүртгэх албаны дарга

Төлбөрийн чадваргүй иргэдийн өмгөөлүүлэх эрхийг хангахад шүүхийн байгууллагын гүйцэтгэх үүрэг
Улсын Дээд шүүхийн Иргэний Хэргийн танхимын шүүгч А.Доржготов

Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааны явцад төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн туслалцаа үзүүлэхэд тавих прокурорын хяналт
Т.Сүхбаатар Улсын Ерөнхий Прокурорын газрын Мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих хэлтсийн дарга

10.50-11.00 Хэлэлцүүлэг

11.00-11.15 Цайны завсарлага

11.15-11.30 Төлбөрийн чадваргүй иргэдийн хууль зүйн туслалцаа авах эрхийг хангахад өмгөөлөх байгууллагын гүйцэтгэх үүрэг
Б. Пүрэвням Монголын Өмгөөлөгчдийн Холбооны ерөнхийлөгч

11.30-11.45 Төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн туслалцаа үзүүлж буй төрийн бус байгууллагын туршлага
Н.Дондов Хүний Эрх Хөгжил Төв

11.45-12.00 Хууль зүйн клиникүүдээс төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн туслалцаа үзүүлж буй байдал
Н. Туяа, МУИС-ын Хууль зүйн сургуулийн Хүмүүнлэг клиникийн менежер, багш

Хууль зүйн товчоодоос төлбөрийн чадваргүй иргэдэд төлбөргүйгээр үзүүлж буй эрх зүйн үйлчилгээний хэлбэр
Э.Болорчулуун, Хууль зүйн «Сувд» товчооны захирал

Хэлэлцүүлэг

12.25-12.40 Насанд хүрээгүй иргэдэд хууль зүйн туслалцаа үзүүлж буй байдал

Ричард Прадо, НҮБ-ын Хүүхдийн Сангийн Монгол дахь суурин төлөөлөгч

12.40- 12.55 Гэмт хэргийн хохирогчдод хууль зүйн туслалцаа үзүүлэх асуудал
Ц. Энхжаргал Хүчирхийллийн эсрэг үндэсний төвийн захирал

12.55-13.10 Хоригдлуудад хууль зүйн туслалцаа үзүүлж буй туршлага
Р.Оюунбадам Олон Улсын Засан Сайжруулах Холбооны Монголын төвийн
тэргүүн, Эмэгтэйчүүдийн хорих ангийн дарга

13.10-13.20 Хэлэлцүүлэг

13.20-14.20 Үдийн хоол

II хэсэг. Хууль зүйн туслалцаа үзүүлэх олон улсын стандарт болон хууль зүйн туслалцаа
үзүүлэх тогтолцооны хэлбэрүүд

14.20- 14.35 Төлбөрийн чадваргүй иргэдэд үзүүлэх хууль зүйн туслалцаа олон улсын
хүний эрхийн гэрээ, конвенцид тусгагдсан нь
Эдвин Рекош АНУ-ын Колумбийн Их сургуулийн Олон Нийтийн Ашиг Сонирхлыг
хамгаалах эрх зүйн санаачилга байгууллагын гүйцэтгэх захирал

14.35-15.00 Хууль зүйн туслалцаа үзүүлэх тогтолцооны хэлбэрүүд

- 1/ Улсын өмгөөлөх байгууллага
- 2/ Хууль зүйн туслалцааны зөвлөл
- 3/ Гэрээгээр хууль зүйн туслалцаа үзүүлэх
- 4/ Бусад хэлбэрүүд

Эдвин Рекош АНУ-ын Колумбийн Их сургуулийн Олон Нийтийн Ашиг Сонирхлыг
хамгаалах эрх зүйн санаачилга байгууллагын гүйцэтгэх захирал

15.00-15.10 Хэлэлцүүлэг

15.10-15.25 Цайны завсарлага

III хэсэг Монголын хууль зүйн туслалцаа үзүүлэх үндэсний тогтолцоог боловсронгуй
болгох нь

15.25-17.30 Бүлгээр хэлэлцэх, зөвлөмж гаргах

Бүлэг 1. Хууль зүйн туслалцаа үзүүлэх төрийн тогтолцоо
/Бүлгийн даргалагч Ж.Амарсанаа/

Бүлэг 2. Хууль зүйн туслалцаа үзүүлэх төрийн бус тогтолцоо, ТББ, клиник, хууль
зүйн товчоодын хамтын ажиллагаа
/ Бүлгийн даргалагч М.Ичинноров/

17.30-17.50 Бүлгүүдээс гарсан зөвлөмжүүдийг танилцуулах

17.50-18.00 Хурлыг хаах

Б. Цэрэндорж Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга
Л.Ариунаа МННХ-Соросын сангийн Иргэний нийгэм хөтөлбөрүүдийн захирал

«ТӨЛБӨРИЙН ЧАДВАРГҮЙ ИРГЭДИЙН ХУУЛЬ ЗҮЙН ТУСЛАЛЦАА ҮЗҮҮЛЭХ
ТОГТОЛЦООГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ НЬ»
ҮНДЭСНИЙ БАГА ХУРЛААС ГАРГАХ ЗӨВЛӨМЖ

2003 оны 3 дугаар
сарын 28-ны өдөр

Улаанбаатар
хот

*Төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн
Туслалцаа үзүүлэх үндэсний тогтолцоог
боловсронгуй болгох тухай*

Төлбөрийн чадваргүй иргэний хууль зүйн туслалцаа үзүүлэх үндэсний тогтолцоог боловсронгуй болгох талаар дор дурдсан үндсэн хэлбэрүүдийг авч үзэж, хэрэгжүүлэхийг Улсын Их Хурал, Монгол Улсын Засгийн Газар, Хууль зүй Дотоод Хэргийн яам, Монголын өмгөөлөгчдийн холбоо болон бусад холбогдох байгууллагуудад зөвлөж байна.

Нэг. Төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн туслалцаа үзүүлэх
үндэсний тогтолцооны талаар

1.Төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн туслалцааг Монголын өмгөөлөгчдийн холбооны аймаг, нийслэлийн салбар зөвлөлийн өмгөөлөгчид, хуулийн байгууллагуудын болон хүний эрхийн төрийн бус байгууллагуудын ажилтнууд, төрийн ба хувийн их, дээд сургуулийн хууль зүйн клиникийн багш, оюутнууд өөрийн чиг үүргийнхээ дагуу, эсхүл санаачлагаараа үзүүлэх.

2.Иргэдэд хууль зүйн туслалцаа үзүүлэх үүнд төлбөрийн чадваргүй иргэнд хууль зүйн туслалцаа үзүүлэх тухай асуудлаар хууль гаргах асуудлаар судалгаа хийх, нэгтгэн дүгнэж төсөл боловсруулах, Засгийн газар, Улсын Их Хуралд оруулах арга хэмжээ авах. Хуулийн төсөл боловсруулахдаа дараах асуудлыг судлан үзэж тусгах :

- Хууль зүйн туслалцаа үзүүлэх шаардлагатай төлбөрийн чадваргүй иргэний тодорхойлолт, хүрээ, заагийг тогтоох, үйлчилгээний хэлбэр, төлбөрийн чадваргүйг тогтоох аргачлалыг оруулах

- Төлбөрийн чадваргүй иргэний хууль зүйн туслалцаа үзүүлэх үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэх_тусгай сан байгуулах

- Хууль зүйн туслалцаа үзүүлэх үйл ажиллагааг бодлогын хувьд зангидах, байгууллагуудын энэ талаарх ажлыг уялдуулан зохицуулах хамтын ажиллагааг хангах, төлбөрийн чадваргүй иргэний хууль зүйн туслалцаа үзүүлэх үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэх_тусгай сангийн үүсвэрийг бүрдүүлэх, зарцуулалтанд хөндлөнгийн хяналт тавих зорилго бүхий Хууль Зүйн Дотоод Хэргийн яам, Монголын өмгөөлөгчдийн Холбоо, хууль зүйн клиник төвүүд болон эрх зүйн туслалцаа үзүүлдэг ТББ-ууд болон бусад холбогдох байгууллагуудын төлөөлөл бүхий орон тооны бус зохицуулах зөвлөл байгуулах

- Тусгай сангаас санхүүжигдэн төлбөргүй чадваргүй иргэнд өмгөөллийн туслалцаа үзүүлэх өмгөөлөгчийг Монголын өмгөөлөгчдийн Холбооны аймаг, нийслэлийн салбар зөвлөлөөс өмгөөлөгчийг сонгон гэрээ байгуулан томилох

3.Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, шүүн таслан ажиллагааны үе шатуудад төлбөрийн чадваргүй иргэдэд өмгөөлөгчид гэрээ байгуулан томилолтын үндсэн дээр хууль зүйн үнэ төлбөргүй зөвлөгөө өгч, өмгөөллийн туслалцаа үзүүлэх.

4. өмгөөлөгч бүр жилд 2 удаа төлбөрийн чадваргүй иргэнийг өмгөөлөх талаар өмгөөллийн хуулиар хүлээсэн үүргээ заавал биелүүлж хэвших, хэрэгжилтэнд нь хяналт тавих тусгай журмыг гаргаж мөрдөх, энэ үүргээ биелүүлээгүй тохиолдолд торгууль оногдуулах, уг орлогыг санд төвлөрүүлэх, дараагийн шатанд өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгуулах арга хэмжээ авах;

5. Төрийн бус байгууллагууд, төрийн ба хувийн их, дээд сургуулийн хууль зүйн клиникүүд болон эрх зүйн мэдээлэл сургалтын төвүүд өөрийн чиг үүргийнхээ дагуу, эсхүл санаачлагаараа хууль зүйн мэдээлэл, лавлагаа, зөвлөгөө өгөх, өмгөөллийн туслалцаа үзүүлэх.

Хоёр. Төлбөрийн чадваргүй иргэдэд үзүүлэх хууль зүйн туслалцааны зардлыг санхүүжүүлэх талаар

1 Улсын төсөв, эрүүгийн болон захиргааны шийтгэлийн журмаар оногдуулсан торгуулийн мөнгөний тодорхой хувийг төвлөрүүлэх, төсөл, хандивын хөрөнгөөр хуримтлал бий болгох замаар тусгай сан байгуулж төлбөрийн чадваргүй иргэний хууль зүйн туслалцааны зардлыг санхүүжүүлэх.

2. Санд хандивласан мөнгөн хөрөнгийн хэмжээнээс хамааран тухайн байгууллага, иргэдэд татварын хөнгөлөлт үзүүлэх, татвараас чөлөөлөх эрх зүйн орчныг бүрдүүлэх асуудал боловсруулж шийдвэрлүүлэх арга хэмжээ авах

3. Санг эрхлэн хөтлөх журам тогтоож мөрдүүлэх

4. өмгөөллийн хөлсийг өмгөөллийн чанар, үр дүн болон ажилласан нийт цагаар тооцон үнэлгээг тогтоодог болох, энэхүү үнэлгээ болон өмгөөлөгчтэй байгуулсан гэрээний дагуу өмгөөллийн хөлсийг сангаас олгох механизмийг бүрдүүлэх

Гурав. Төлбөрийн чадваргүй иргэнд үзүүлэх хууль зүйн туслалцааг өргөжүүлэх талаар

1. ЭБШ хуулийн хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, шүүгч нараас сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн өмгөөлөгч авах эрхийг тайлбарлах тухай заалтыг хэвшүүлэх, тогтоолыг танилцуулан гарын үсэг зуруулдаг журам бий болгон мөрдүүлэх.

2. Хууль зүйн клиникийг олноор байгуулах, тэдгээрийн үйл ажиллагааг шинэ төвшинд гарган чанартай ажиллуулах, сургалтын хөтөлбөрт нэвтрүүлэх, төрөлжих үйл явцыг дэмжих, шүүх болон төрийн бус байгууллагатай хамтын ажиллагааг дэмжих, үйл ажиллагаа явуулах боломж нөхцлөөр шүүх, Хууль зүйн яам Дотоод хэргийн яам, Монголын Өмгөөлөгчдийн холбоо зэрэг байгууллагуудаас хангах:

3. Их, дээд сургуулийг магадлан итгэмжлэх журамд нэмэлт оруулах замаар хууль зүйн клиник байгуулах, клиникийн сургалтыг багшийн ачаалалтай нь уялдуулан төрөлжүүлж мэргэшүүлэх, үйл ажиллагааг нь өргөжүүлэн чанаржуулах;

4. Иргэдэд хууль зүйн туслалцаа үзүүлж байгаа төрийн бус байгууллага болон энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн байгууллагуудын хамтын ажиллагааг уялдуулан харилцан мэдээлэх, арга зүйгээ солилцох, туршлагаа хуваалцах нээлттэй механизмыг бий болгох ;

5. Өмгөөлөгчийн нөөцийн асуудлыг хууль зүйн клиникт суралцаж амжилттай төгссөн оюутнуудаас сонгон шалгаруулж ажиллуулах замаар шийдвэрлэх.

6. МУИС- ХЗС-иас Сүхбаатар дүүргийн шүүхтэй, Шихихутуг дээд сургуулиас Чингэлтэй дүүргийн шүүхтэй хамтран ажиллаж байгаа эхлэлийг дэмжиж Хууль зүйн яам Дотоод хэргийн яам, Монголын Өмгөөлөгчдийн холбоо, шүүх зэрэг байгууллагуудаас төлбөрийн чадваргүй иргэдийн асуудлыг дээрх клиникүүдэд төвлөрүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авах.

7. Хоригдлын хууль зүйн туслалцаа авах талаар хуульд заасан эрхийг хэрэгжүүлэх механизмийг боловсруулах, холбогдох байгууллагад оруулах арга хэмжээ авах арга хэмжээ авах

ХУРЛЫГ НЭЭЖ ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД Ц.НЯМДОРЖИЙН ХЭЛСЭН ҮГ

Хууль зүй, дотоод хэргийн яам, Монголын Нээлттэй Нийгэм Хүрээлэнгээс хамтран зохиож байгаа “Төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн туслалцаа үзүүлэх үндэсний тогтолцоог боловсронгуй болгох нь” сэдэвт үндэсний бага хуралд оролцож байгаа зочид, төлөөлөгчид та бүхэнд энэ өдрийн мэндчилгээг дэвшүүлье.

1992 онд батлагдсан Монгол Улсын Үндсэн хууль нь тус улсын хууль тогтоомжийг бүхэлд нь шинэтгэх эрх зүйн үндсийг бий болгосон билээ. Монгол Улсын Үндсэн хуулиар хүний эрх, эрх чөлөө, шударга ёсыг дээдэлж хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгож тунхагласан.

Хууль тогтоомжийг Үндсэн хуульд нийцүүлэн боловсронгуй болгох ажлыг төр, засгаас онцгой анхаарч сүүлийн 10-аад жилийн хугацаанд тодорхой үе шаттайгаар төлөвлөн хэрэгжүүлсээр ирлээ. Тухайлбал, УИХ-ын 2001 оны намрын чуулганаар Иргэний хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Эрүүгийн хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг баталж, 2002 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдүүлсэн. Дээр дурдсан хуулиудыг багцлан шинэчилсний дараа тэдгээрийг хэрэгжүүлэх шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагуудын зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг төгөлдөржүүлэх зорилгоор шүүх, прокурор, өмгөөллийн тухай хуулиудыг шинэчилж, цагдаа, нотариатын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж мөн 9 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдүүллээ.

Багц хуулиуд хүчин төгөлдөр болж мөрдөгдөж байгаа 9 сарын явцаас ажиглахад эдгээр хуулиуд нь чирэгдэлгүй, шат дамжлага багатай бүтэц, олон шинэ зохицуулалт бий болгож, шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагуудын үйл ажиллагааны үндсэн зарчмыг тодорхойлж уялдаа холбоог сайжруулсан, хүний эрх, эрх чөлөөг илүүтэй хамгаалсан, зах зээлийн шаардлага, олон улсын практикт нийцсэн, бизнесийн таатай орчин, хөрөнгө оруулалт хийх боломжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн, Монгол Улс дахь эрх зүйн шинэтгэлийг эрчимжүүлэхэд чухал нөлөө үзүүлэхүйц баримт бичиг болсныг манай эрдэмтэн мэргэд ч, олон улсын байгууллагууд ч үнэлж дүгнэж байна.

Эрх зүйн шинэтгэлийн хүрээнд гарсан дээрх хуулиудыг тайлбарлан таниулах, сурталчлах, хэвлэн нийтэлж нийтийн хүртээл болгоход шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагуудаас гадна төрийн бус байгууллагууд, гадаадын хандивлагч байгууллагууд идэвхтэй оролцож байгааг онцлон тэмдэглэхэд таатай байна. Мөн түүнчлэн хуулийг хэрэгжүүлэх явцад бодит бэрхшээл, техник, тусгай хэрэгслийн хангамжийн дутагдал, санхүүгийн хүндрэл хаа хаагүй байна. Төр, засгаас эдгээр бэрхшээлийг даван туулах зорилгоор дотоодын бүхий л нөөц бололцоогоо дайчлахын зэрэгцээ гадаадын түншүүдийн тусламж дэмжлэгт ихээхэн найдвар тавьж байна. Гадаадын түншүүд ч бидний байдлыг ойлгож бодитой дэмжлэг, туслалцаа үзүүлсээр байна. Үүний нэг тод илэрхийлэл нь манай улсад Монголын Нээлттэй Нийгэм Хүрээлэнгээс хэрэгжүүлж байгаа “Төлбөрийн чадваргүй хүмүүст хууль зүйн туслалцаа үзүүлэх тогтолцоог боловсронгуй болгох нь” сэдэвт төсөл юм.

Төлбөрийн чадваргүй иргэдэд төрийн, төрийн бус болон мэргэжлийн өмгөөлөх байгууллага хэрхэн туслалцаа үзүүлэх, өмгөөллийн зардлыг хэрхэн зохицуулах асуудлаар илэн далангүй ярилцаж, энэ чиглэлээр олон улсын жишигт нийцсэн үндэсний тогтолцоог бий болгох талаар зөвлөлдөж, санал бодлоо илэрхийлж зохих чиглэлийг тодорхойлоход энэ бага хурлын ач холбогдол оршино.

Өнөөдрийн үндэсний бага хурлаар хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулж шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагууд, төрийн бус байгууллагууд, Монголын Нээлттэй Нийгэм Хүрээлэн, НҮБ-ын Хүүхдийн сангийн төлөөлөгчид тус тусын чиглэлээр иргэн өмгөөлүүлэх, хууль зүйн туслалцаа авах эрхээ хэрэгжүүлэхэд нь хэрхэн дэмжин тусалж байгаа, үнэ төлбөргүйгээр эрх зүйн үйлчилгээ хэрхэн үзүүлж байгаа, цаашид яаж боловсронгуй болгох талаар тодорхой ярих болно.

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14-д Монгол Улсын иргэн: “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан

хохирлыг нөхөн төлүүлэх, өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах, нотлох баримтыг шалгуулах, шударга шүүхээр шүүлгэх, хэрэг шүүх ажиллагаанд биеэр оролцох, шүүхийн шийдвэрийг давж заалдах, уучлал хүсэх эрхтэй...” гэж заасан байдаг. Энэ нь сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хохирогчид нэгэн адил хамаарах заалт юм. Гэтэл бид сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах асуудалд илүү анхаарал хандуулж хохирогчийн асуудалд хайнга хандаж ирснийг зориуд тэмдэглэх хэрэгтэй. Дээр дурдсан хуулиудыг боловсруулж батлуулахад урьд байсан дээрх дутагдлыг засах талаар нэлээд дорвитой алхмууд хийгдсэн. Гэвч энэ нь асуудлыг бүрэн төгс шийдвэрлэсэн гэсэн үг биш зөвхөн ажлын эхлэл юм. Энэ чиглэлээр өнөөдрийн үндэсний бага хурал дээр хөндөгдөж яригдана гэж бодож байна.

Ер нь цаашдаа хохирогчийн эрхийг хамгаалах асуудлыг хараа хяналтаас гаргаж болохгүй. Үүнтэй холбогдуулан “Гэмт хэргийн улмаас иргэнд учирсан хохирлыг барагдуулах журмын тухай” хуулийн төслийг манай яам боловсруулж байна. Уг хуулийг боловсруулахдаа Монгол Улсын Үндсэн хууль, НҮБ-ын “Гэмт хэрэг болон эрх мэдлээ урвуулан ашигласны улмаас хохирсон хохирогчийн талаархи эрх зүйн зохицуулалтын үндсэн зарчмын тухай” тунхаглал, Европын холбооны “Гэмт хэргийн хохирогчдын хохирол барагдуулах тухай” Конвенцийг тус тус үндэслэсэн болно. Төслийг боловсруулахдаа дараахь хэдэн гол асуудалд анхаарал хандуулсан. Үүнд:

1.Гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэм буруутайд тооцож үл болох тул шүүхийн шийдвэр гарах хүртэл сэжигтэн, яллагдагчийг албадан хохирлыг төлүүлэх боломжгүй байдаг.

Дээрх нөхцөл байдлаас шалтгаалан шүүхийн шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болохоос өмнөх шатанд гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг сэжигтэн, яллагдагч сайн дураараа барагдуулахгүй л бол хохирлыг нөхөх өөр эх үүсвэргүй болоход хүрч байна.

Иймд төслийг боловсруулахдаа эмнэлгийн яаралтай тусламжийн болон оршуулгын зардал гаргах шаардлагатай болсон, түүнчлэн тухайн гэмт хэргийн улмаас амьжиргааны эх үүсвэрээсээ салсан зэрэг онцгой тохиолдолд шүүхийн шийдвэр гарахаас өмнөх шатанд хохирлын тодорхой хувийг төрөөс урьдчилсан хэлбэрээр барагдуулах боломжийг тусгасан болно.

2.Онолын хувьд хохирлыг гэмт хэрэг үйлдсэн этгээд бүрэн барагдуулах үүрэгтэй боловч амьдрал дээр гэмт хэрэг илрэхгүй байх, илэрсэн боловч гэмт хэрэг үйлдсэн этгээд нас барсан, эрх зүйн бүрэн чадамжгүй, эсхүл хөрөнгөгүй зэрэг шалтгаанаар хохирол төлөгдөхгүйд хүрч байна.

Иймд төслийг боловсруулахдаа эдгээр тохиолдолд төр нийгмийн ашиг сонирхлын үүднээс хохирлын зохих хувийг барагдуулж болохоор тооцож байна.

3.Эрүүгийн эрх зүйн зарчмын дагуу зөвхөн бодит учирсан материаллаг хохирлыг барагдуулдаг ба сэтгэл санааны хохирлыг иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны журмаар шүүхэд хандаж барагдуулах боломжтой гэж үздэг боловч одоогоор энэ талаар шүүхийн практик төлөвшөөгүй байна.

Иймд хуулийн төслөөр хохирогчийн эд хөрөнгийн хохирлыг мөнгөн хэлбэрийн нөхөн төлбөр олгох замаар барагдуулахаас гадна түүний сэтгэл санааны хохирлыг арилгах зорилгоор зарим төрлийн үйлчилгээ үзүүлэх боломжийг нээлттэй орхихоор төлөвлөж байна.

Хуулийн төсөл батлагдвал нийгэм эдийн засгийн дараахь үр дагавар гарна гэж тооцож байна. Үүнд:

1.Гэмт хэргийн улмаас иргэнд учирсан нэн яаралтай барагдуулбал зохих хохирлыг төрөөс барагдуулж байх, ингэснээр төрөөс гэмт хэргийн улмаас хохирогч болсон иргэддээ халамж, үйлчилгээ үзүүлж байх нийгмийн шинэ харилцааны эрх зүйн орчин бүрдэнэ.

2.Монгол Улсын иргэдийн Үндсэн хуульд заасан үндсэн эрхийн баталгаа дээшилнэ.

3.Эдийн засгийн хувьд уг санг байгуулах, үйл ажиллагаа явуулах нөхцөлийг бүрдүүлэхтэй холбоотой улсын төсвөөс тодорхой хэмжээний хөрөнгийг тухайн санд жил бүр төвлөрүүлж байх шаардлага гарна.

Үндэсний бага хурлаас төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн туслалцаа үзүүлэх үндэсний тогтолцоог боловсронгуй болгох асуудлаар тодорхой зөвлөмж гаргана. Уг зөвлөмжийг хэрэгжүүлэхэд Хууль зүй, дотоод хэргийн яам, Монголын өмгөөлөгчдийн холбоо анхаарлаа төвлөрүүлж ажиллах болно.

Монголын Нээлттэй Нийгэм Хүрээлэн хэлэлцэж буй асуудлаар бидэнтэй цаашид үр дүнтэй хамтран ажиллана гэдэгт эргэлзэхгүй байгаагаа илэрхийлье.
Үндэсний бага хурал нээснийг мэдэгдье. Та нөхдөд ажлын амжилт хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

----oOo----

**ХУРЛЫГ НЭЭЖ МОНГОЛЫН НЭЭЛТТЭЙ НИЙГЭМ
ХҮРЭЭЛЭНГИЙН ИРГЭНИЙ НИЙГЭМ ХӨТӨЛБӨРҮҮДИЙН
ЗАХИРАЛ Л.АРИУНААГИЙН ХЭЛСЭН ҮГ**

Эрхэм хүндэт ноёд, хатагтай нараа,

Монгол Улсад иргэний нийгмийг төлөвшүүлэн хөгжүүлэх, эрх зүйт төрийг бэхжүүлэх, хууль хяналтын байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд хүртээмжтэй, ил тод нээлттэй болгох, хариуцлагын тогтолцоог дээшлүүлэхэд чиглэсэн хөтөлбөр, төсөл хэрэгжүүлэх нь МННХ-гийн эрхэм зорилго юм. Үүний нэг жишээ болгож “Төлбөрийн чадваргүй иргэдэд үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа үзүүлэх тогтолцоог боловсронгуй болгох” сэдэвт энэхүү үндэсний бага хурлыг Хууль зүй, Дотоод хэргийн яамтай хамтран зохион байгуулж байна.

Хүний эрхийг хөндсөн аливаа асуудал, хүндрэл бэрхшээл нь нийтийг хамрах шинжтэй байдаг хэдий ч энэ нь нийгмийн эмзэг бүлгийн хүмүүст илүү хүндээр тусч, Үндсэн хуулиар олгогдсон хүний эрх, эрх чөлөөгөө бүрэн эдлэх боломж тэдэнд хязгаарлагдмал байдаг. Төлбөрийн чадваргүй иргэдийн хууль зүйн туслалцаа авах эрхийн асуудал нь хүний эрхийн төлөв байдлыг тодорхойлох нэг бүрэлдэхүүн гэж үздэг.

Өнөөдөр амьжиргааны доод түвшнээс доогуур орлоготой хүмүүс Олон улсын гэрээ, Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуулиудаар хууль зүй туслалцаа үнэ төлбөргүй хүртэх эрхээ эдлэх боломж хангалтгүй байгааг МННХ-ийн дэмжлэгтэйгээр хийсэн нөхцөл байдлын судалгааны дүн ч харуулсан юм.

Дээрх асуудлыг шийдвэрлэж, хууль зүйн туслалцааны асуудлыг боловсронгуй болгоход Хууль зүй, Дотоод хэргийн яам, хууль шүүхийн байгууллагууд, Монголын Өмгөөлөгчдийн Холбоо зэргээс гадна хүний эрхийн чиглэлээр ажилладаг төрийн бус байгууллагууд, хуулийн клиникүүдийн хамтын ажиллагааны чармайлт нэн чухлаар тавигдаж байна. Учир нь дээрхий байгууллагуудын хуримтлуулсан туршлага, идэвх санаачилга нь уг асуудлыг цогцоор шийдвэрлэхэд чухал хувь нэмэр оруулна гэж үзэж байна.

Өнөөдрийн хурлаар та бүхэн төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн туслалцаа үзүүлэх тогтолцоог боловсронгуй болгох асуудалд анхаарлаа хандуулж, учирч буй бэрхшээлийн талаар хэлэлцэж, бусад улс орны хууль зүйн туслалцааны загвар системээс санаа авч, цаашид хууль зүйн туслалцаа авах эрхийг баталгаажуулах, иргэдэд хүртээмжтэй болгоход чиглэгдсэн тодорхой санал зөвлөмжийг дэвшүүлэн тавьж, энэ асуудлыг дорвитой хэрэгжүүлэхэд МННХ, ХЗДХЯ, Монголын өмгөөлөгчдийн холбоо зэрэг бусад байгууллагуудтай нягт хамтран ажиллана гэдэгт итгэж байна.

Анхаарал тавьсан та бүхэнд баярлалаа.

**ХЭРЭГ БҮРТГЭХ, МӨРДӨН БАЙЦААХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД
ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГААС ТӨЛБӨРИЙН ЧАДВАРГҮЙ
ИРГЭДИЙГ ӨМГӨӨЛҮҮЛЭХ, ХУУЛЬ ЗҮЙН БУСАД ТУСЛАЛЦАА
АВАХ ЭРХИЙГ ХАНГАЖ БУЙ БАЙДАЛ**

ЦЕГ-ын Хэрэг бүртгэх газрын дарга Л.Сүхээ

Монгол Улсын Үндсэн хуульд хүний эрх, эрх чөлөөг баталгаажуулснаар бусад хууль тогтоомжуудад ч хүний эрхийг хамгаалахад чиглэгдсэн заалтууд бүрэн тусгагдаж эрх зүйн орчин бүрдлээ.

Өнгөрсөн оноос шинээр мөрдөж байгаа Эрүү, эрүүгийн байцаан шийтгэх, өмгөөлөлийн болон шүүхийн тухай хуулиудад гэмт хэрэгт холбогдсон, хохирсон иргэдийг өмгөөлүүлэх эрхээр хангах талаар олон шинэ заалт тусгагдан хэрэгжиж байна.

Төр, засгаас гарч байгаа эрхийн актууд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүхийн ажиллагаанд өмгөөлөгчийг заавал оролцуулах, өмгөөлөгчид хөлс олгох тухай асуудлыг шийдвэрлэхэд чиглэгдэж байна.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 38, 39, 40 дүгээр зүйлүүдэд “өмгөөлөгчийг сонгон авах, заавал оролцуулах” талаар шинэ агуулгатай заалтууд орлоо.

Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд өмгөөлөх эрхээр хангаагүй тохиолдол нь шүүхэд эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгох үндэслэл болох тухай чухал заалт ч бий.

Үүний зэрэгцээ Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 38-2, 39 дүгээр зүйлүүдэд эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд заавал мэргэжлийн өмгөөлөгч оролцохгүй байж болох, өөрөөр хэлбэл мэргэжлийн өмгөөлөгч оролцох боломжгүй бол эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцоход харшлах шалтгаангүй этгээдийг өмгөөлөгчөөр сонгох боломж , эрх зүйн үндсийг бүрдүүлж өгсөн байна.

Ийнхүү манай хууль тогтоомжуудад иргэдийн өмгөөлүүлэх эрхийг хуульчлан зааж, энэхүү эрхээ эдлэхийн тулд хуулийн туслалцаа авах эрхийг баталгаажуулсан байна.

Гэвч иргэдийн өмгөөлүүлэх эрх бүрэн хангагдахгүй, тухайлбал, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаанд өмгөөлөгч оролцохгүй явдал байгаа нь дараахь хэдэн шалтгаантай байна. Үүнд :

1-рт : - Хэргийн холбогдогч, хохирогч нар төлбөрийн чадваргүйгээс хамаарч шүүх ажиллагаа хүртэл “өөрөө өөрийгөө өмгөөлнө” гэдэг явдал түгээмэл байна.

Энэ оны эхний 2 сарын байдлаар нийслэлийн 6 дүүрэгт хэрэг бүртгэлтийн шугамаар нийт 705 хүнийг яллагдагчаар татсаны 189 буюу 26.8 хувь нь өмгөөлөгч авч, 516 буюу 72,3 хувь нь өмгөөлөгч аваагүй байна.

Өмгөөлөгч авахгүй байгаа шалтгааныг авч үзэхэд “хэргийн байдал тодорхой учир өмгөөлөгч авахгүй”, “маргаантай асуудал гарсан” үед, эсвэл “шүүх хурал дээр өмгөөлөгч авна” гэдэг боловч гол үнэн хэрэгтээ өмгөөлөгчид төлөх төлбөрийн чадваргүй байдалтай холбоотой байна.

2-рт : - Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд өмгөөлөгчийн хүрэлцээ хангалтгүй, улсын хэмжээнд бүрэн хангах боломж, бололцоо ч байхгүйтэй холбоотой. Тухайлбал :

- аймгийн төвд 3-4 орчим өмгөөлөгч байдаг нь хаана ч хүрэлцэхгүй байна.

- Ялангуяа хөдөө сумдад хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтанд өмгөөлөгч оролцуулах боломж туйлын хомс.

Нийслэл хотод ч гэсэн шаардлагатай, яаралтай үед өмгөөлөгч олдохгүй байх явдал байнга гарч эрэл сурал болж байдаг нь хэвийн үзэгдэл юм.

3-рт : - Өмгөөллийн хөлс, ялангуяа хөнгөн, хүндэвтэр гэмт хэрэгт олгох хөлсний хэмжээ харьцангуй бага байдгаас өмгөөлөгч оролцох сонирхолгүй байдаг байна.

Энэ төрлийн гэмт хэрэгт оролцсон ч ёс төдий, хэлбэрдэх байдлаар оролцож сэжигтэн, яллагдагчдад бодит туслалцаа үзүүлж чадахгүй байна.

Энэ оны 1 дүгээр сард Төв аймгийн Зуунмод суманд насанд хүрээгүй яллагдагчид “ял сонсгох” байцаалтанд өмгөөлөгч оролцуулахаар 3-4 удаа хүсэлт гаргаад ирээгүй учир байцаагч нь өөрөө очиж хувийн журмаар гуйж оролцуулан, ирсэн өмгөөлөгч нь оролцсон дүр үзүүлж өнгөрсөн байна.

Ийм жишээ олон тохиолдож байна.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 40 дүгээр зүйлийн дагуу өмгөөлөгч заавал оролцох 5 тохиолдолд болон хүнд ноцтой хэргүүдэд өмгөөллийн ажиллагаа явагдаж, бусад тохиолдолд хэлбэрийн төдий байна.

4-рт : - Хохирогч, сэжигтэн, яллагдагчийн эрх зүйн мэдлэг муугаас өмгөөлөгч авах ач холбогдлыг төдийлөн сайн ойлгодоггүй.

5-рт : - Байцаан шийтгэх хуулийн бусад боломжийг иргэд бүрэн ашиглаж чаддаггүй байна.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 38-2-т заасан заалтыг мэдэхгүйгээс заавал мэргэжлийн өмгөөлөгч авалгүй, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалж чадах өөр этгээдээр өмгөөлүүлэх явдал дутагдалтай төдийгүй мөрдөн байцаагч, шүүгч нар ч төдийлөн ойлгохгүй, ойшоохгүй явж ирснээс практик дээр бараг хэрэглэгдэхгүй байна.

Энэ заалтыг хэрэглэж хэвшсэнээр өмгөөлүүлэх эрхээр хангах өргөн боломж нээгдэж болох юм.

Сэжигтэн яллагдагчийн эцэг эх, ах дүү, төрөл садан, өөрийнх нь хүссэнээр \харшлах шалтгаангүй этгээд\ хэнийг ч оролцуулдаг болсноор өмгөөлөгчийн гачигдлаас гарах бололцоотой болно гэж үзэж байна.

6-рт : - Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нар Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 40-2 дахь заалтыг төдийлөн биелүүлдэггүйгээс өмгөөллийн ажиллагаа дутагддаг тал байна.

Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд өмгөөллийн ажиллагаа дутагдаж байгаа дээрх үндсэн шалтгаанууд байгаа учир эдгээрийг зохих хэмжээгээр багасгах, цаашид ахиц дэвшил гаргах зорилгод нийцүүлэн дараахь саналууд дэвшүүлж байна. Үүнд:

1. Гэмт хэргийн сэжигтэн, яллагдагчийн “төлбөрийн чадваргүй” гэсэн тодорхойлолтыг оршин суугаа хороо хориноос олгох нь хүндрэлтэй байгааг харгалзан хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нар тодорхойлолт олгодог болох боломжийг судалж шийдвэрлэх.

2. Гэмт хэргийн гаралт ихтэй нийслэлийн дүүргүүд, зарим аймгийн цагдаагийн газар, хэлтсүүд дээр өмгөөлөгч байнга ажиллуулдаг болох асуудлыг судалж зохион байгуулалтын арга хэмжээ авах.

Өнгөрсөн оноос нийслэлийн Сүхбаатар дүүргийн цагдаагийн хэлтэс дээр өмгөөлөгч нарт зориулсан өрөө байр тохижуулан 4 өмгөөлөгч тогтмол ажиллуулснаар өмгөөлөх эрхээр хангахад тодорхой дэвшил гарсан байна.

Тус хэлтэс дээр энэ оны 2 сард хэрэг бүртгэлтийн шугамаар 188 холбогдогчийг яллагдагчаар татсаны 125 буюу 69.0 хувьд нь өмгөөлөгч оролцуулсан нь нийслэлийн хэмжээнд хамгийн олон өмгөөлөгч оролцсон жишээ юм.

3. Өмгөөлөгчид олгох хөлсний хэмжээ, ялангуяа хөнгөн, хүндэвтэр хэрэгт олгох хөлсийг нэмэх хэрэгтэй байна.

Өмгөөлөгчид төлбөр олгох асуудлыг хүндрэлгүй зохион байгуулах, ялангуяа төсвөөс олгох хөлсийг баталгаатай болгох.

4. Иргэдийн хууль зүйн боловсрол, түүний дотор өмгөөлүүлэх эрхээ эдлэх мэдлэгийг дээшлүүлэхэд өмгөөллийн, төрийн бус байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэх.

Олон улсын төслүүдийг үүнд чиглүүлэх, хэвлэл мэдээллийн хэрэгслийг ашиглан сургалт, сурталчилгаа зохион байгуулах, оюутан сурагчдын дунд уралдаан тэмцээн зохион байгуулах, өмгөөлөх, хүний эрхийн байгууллагуудын хаяг байршил, утасны дугаар, харилцах хүмүүсийн нэр зэргийг байнга зарлах, мэдээлэл, санамжууд бэлтгэн гаргаж олон нийтэд тараах, байрлуулах.

Жишээлбэл: Өмгөөлүүлэх эрхийн тухай хуулийн заалтуудыг эмхэтгэсэн санамж гаргаж, иргэдэд, ялангуяа гэмт хэрэгт холбогдсон, хохирсон иргэдэд олгодог болох зэрэг хуулийн сургалт сурталчилгааг өргөжүүлэх.

5. Мэргэжлийн өмгөөлөгчөөс гадна хууль ёсны өмгөөлөгчийг Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 38-2-т заасан заалтын дагуу оролцуулдаг практикийг хуулийн байгууллагууд мөрдөж хэвших.

Зөвхөн мэргэжлийн өмгөөлөгч оролцуулна гэдэг хязгаарлалтыг багасгах талаар өмгөөллийн байгууллагаасаа эхлэн санаачилга гаргаж Эрүүгийн байцаан шийтгэх хуулиар олгогдсон бусдын өмгөөлөх эрхийг тэгш хангах талаар эргэлт гаргах.

Мөрдөн байцаах, хэрэг бүртгэх, прокурорын байгууллагууд, хорих, баривчлах байгууллагууд Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 38-2-т заасан үндэслэлээр өмгөөлөгчөөр оролцож байгаа этгээдийг хүртэл мэргэжлийн өмгөөлөгчийн хэмжээнд хүндэтгэн үзэж, дэмжлэг туслалцаа үзүүлж байх.

Энэ чиглэлээр шаардлагатай эрхийн актууд нэмж гаргах, хуулийн ажилтнуудад зориулсан сургалт, сурталчилгаа зохиох нь зүйтэй.

Хүний эрхийг хангах, хууль ёсны өмгөөлүүлэх эрхийг нь хангуулах хуулийн заалтыг хэрэгжүүлэх талаар прокурорын зүгээс тавих хяналт, санал, санаачилгыг ч өндөржүүлэх шаардлагатай гэж бодож байна.

6. Хүний эрхийг хамгаалах, тэр тусмаа өмгөөлөх эрхээр хангах асуудал дээр төрийн бус байгууллагууд гэмт хэрэгт сэжиглэгдэж байгаа сэжигтэн, яллагдагчид гол анхаарлаа тавьж, тэдний эрх ашгийг хамгаалахад илүү анхаарал тавьж байгаа байдал ажиглагддаг.

Гэтэл гэмт хэргийн улмаас сэтгэл санаа, эд материалын хохирол хүлээсэн хохирогч нарын эрх ашгийг хамгаалах асуудал орхигдож байна.

Гэмт хэргийн улмаас хохироод дээр нь өмгөөлөгчийн хөлс төлж “ямаан дээр тэмээний гарз” гаргаж байгаа хохирогчийн эрхийг хамгаалах, төлбөрийн чадваргүй хохирогчийн өмгөөллийн зардлыг төсвөөс төлөх асуудал дээр онцгой анхаарах цаг болсон гэж үзэж байна.

Энэ талаар үндэсний бага хурлаас гарах зөвлөмж шийдвэрт тодорхой заалт орно гэдэгт найдаж байна.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**ШҮҮХ ХУРАЛДААНЫ АЖИЛЛАГААНД ШҮҮХЭЭС ТӨЛБӨРИЙН ЧАДВАРГҮЙ
ИРГЭДИЙН ӨМГӨӨЛҮҮЛЭХ ЭРХИЙГ ХАНГАХАД
ГҮЙЦЭТГЭХ ҮҮРЭГ**

Илтгэгч: А.Доржготов-УДШ-ийн шүүгч

Монгол Улсын шинэ Үндсэн хуулийн дагуу төлөвшин буй ардчилсан нийгэмд өмгөөллийн үйлчилгээний хэрэгцээ, шаардлага улам бүр өсч байна. Энэ нь өмнө үеэсээ мөн чанарын ихээхэн ялгаа гарч өмгөөллийн үйлчилгээ хөгжлийн шинэ шатанд орлоо гэж хэлж болох юм.

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14 дэх хэсэгт Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсэн гэж үзвэл эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, өөрийгөө өмгөөлөх хууль зүйн туслалцаа авах эрхийг бататган заажээ. Түүнчлэн “шүүгдэгч өөрийгөө өмгөөлөх эрх” ба шүүгдэгч энэ эрхээ хэрэгжүүлэхэд хүсэлтээр нь буюу хуульд зааснаар хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлнэ” гэж тодорхойлсныг шүүхийн гүйцэтгэх үүргээс ангид авч үзэх бололцоогүй. Иймээс ч Шүүхийн тухай Монгол Улсын хуульд “Шүүгдэгч болон шүүхээр эрхээ хамгаалуулж байгаа аливаа этгээд өөрийгөө өмгөөлөх, өмгөөлөгчөө чөлөөтэй сонгон авах, хэргийн баримт сэлттэй танилцах эрхтэй” болохыг заахын хамт шүүхийн гүйцэтгэх үүргийг тодруулан заасан байна.

Хуулийн заалтын агуулгыг нарийвчлан авч үзвэл:

а/эрүүгийн хэргийн шүүгдэгч;

б/шүүхээр эрхээ хамгаалуулж байгаа аливаа этгээд, тухайлбал иргэний хэргийн ба захиргааны хэргийн зохигч, оролцогчдыг хамааруулан тодорхойлсон гэж үзэж болно.

Шүүх нь дээр дурьдсан шүүгдэгч болон эрхээ хамгаалуулж байгаа аливаа этгээдэд үйлчлэхдээ дараахь үүргийг гүйцэтгэнэ:

Нэгдүгээрт: Шүүгдэгч, эрхээ хамгаалуулж байгаа этгээдэд эрхийг нь тайлбарлах үүрэг хүлээнэ.

Хоёрдугаарт: Эрхээ хэрэгжүүлэх боломжийг хангах үүрэг хүлээнэ.

Гуравдугаарт: Шүүгдэгч болон эрхээ хамгаалуулж байгаа этгээдийг шүүх хуралдаанд биечлэн оролцох эрхийг хангана.

Шүүхийн дээр дурьдсан үйл ажиллагааны хүрээнд **төлбөрийн чадваргүй иргэн** хууль зүйн туслалцаа авах эрхийн асуудал чухал суурь эзлэх ёстой.

Шүүхийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд зааснаас үзвэл шүүгдэгч болон шүүхээр эрхээ хамгаалуулж байгаа аливаа этгээд өмгөөлөх, өмгөөлүүлэх эрхээ хэрэгжүүлэхэд төлбөрийн чадваргүй иргэний өмгөөллийн зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ. Энэхүү санхүүжилтийг Өмгөөллийн тухай хуульд заахдаа Монголын өмгөөлөгчдийн холбоонд олгоно. Уг зардлыг санхүүжүүлэх, тайлан тооцоо гаргах журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн баталж, хэрэгжилтэд нь хяналт тавина. Харин төлбөрийн чадваргүй иргэний өмгөөлөх, өмгөөлүүлэх эрхээр хангах үүрэг нь шүүхийн ажиллагааны дээр дурьдсан хүрээгээр тодорхойлогдоно гэж үзэж болох юм.

Эдгээр нийтлэг зүйлээс гадна шүүн таслах ажлын төрөл тус бүрдээ онцлогтой гэж үзэж болно. Өмгөөлүүлэх эрх нь Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны нэг үндсэн зарчим төдийгүй, шүүгдэгч, Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцогчийн эрх, ашиг сонирхлыг хууль зүйн дагуу хамгаалах баталгаа болдог.

Шүүх төлбөрийн чадваргүй иргэний хууль зүйн туслалцаа авах эрхийг хэрэгжүүлэхийн тулд тэдгээрийн өмгөөлөгч сонгон авах эрхээр хангах явдал чухал.

Эрүүгийн байцаан шийтгэх хуульд /39 дүгээр зүйл/ зааснаас үзвэл шүүх дараахь үүрэгтэй гэж үзэж болно.

а/ Шүүгдэгч, хохирогчийн өмгөөлөгчөө сонгох эрхээр хангана. Энэ эрхийг хэрэгжүүлэхдээ:

1. Өмгөөлөгчөө өөрөө сонгоно;

2. Шүүгдэгч, хохирогчийн зөвшөөрснөөр эсхүл тэдгээрийн хүссэнээр хууль ёсны төлөөлөгч, гэр бүлийн гишүүн, төрөл садангийн хүн нь өмгөөлөгч сонгон авах бололцоогоор хангана.

б/ Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд өмгөөлөгч оролцох боломжийг хангана. Энэ ойлголт нь төлбөрийн чадваргүй шүүгдэгч, хохирогч, өмгөөлөгчөө өөрөө сонгон аваагүй бол түүний хүсэлтээр шүүн таслах ажиллагаанд **өмгөөлөгч оролцох боломжийг шүүх хангана.**

Ийнхүү өмгөөлөгч оролцох боломжийг хангахдаа тодорхой өмгөөлөгчийг нэр заан тулгаж болохгүй. Тэгэхлээр энэ боломжийг яаж хэрэгжүүлэх вэ? Үүнд:

1. Өмгөөлөгчийн нэрийн жагсаалтыг танилцуулж, түүнээс өөрөөр нь сонгуулж болох.
2. Өмгөөллийн байгууллагад хандаж өмгөөлөгч томилуулахыг зөвлөж болох.

в/ Шүүн таслах ажиллагаанд өмгөөлөгчийн заавал оролцуулах үүрэг бий. Энэ талаар Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 40 дүгээр зүйлд зааснаар дараахь тохиолдолд шүүх хуралдааны ажиллагаанд өмгөөлөгчийг заавал оролцуулна. Үүнд: өөрийгөө өмгөөлөх болон өмгөөлүүлэх эрхээ эдэлж чадахгүй хүмүүс /хэлгүй, дүлий, хараагүй, сэтгэцийн өвчтэй зэрэг/; насанд хүрээгүй; монгол хэл мэдэхгүй; цаазар авах ял шийтгэгдэж болох; хэргийнхээ талаар харилцан эсрэг сонирхолтой шүүгдэгчийн аль нэг нь өмгөөлөгчтэй байгаа бол бусад шүүгдэгч тус тус өмгөөлөгч сонгон аваагүй бол шүүх уг хэрэгт өмгөөлөгч оролцуулах явдлыг хангах үүрэгтэй. Энд төлбөрийн чадваргүй шүүгдэгч, хохирогч нэгэн адил хамаарах нь ойлгомжтой юм.

г/ Эрүүгийн хэргийн шүүх хуралдаанд оролцож байгаа өмгөөлөгч нь шүүгдэгч, хохирогчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалж хууль зүйн туслалцаа үзүүлэх үүрэгтэй байдаг. Өмгөөлөгч нь эрх, үүргээ хэрэгжүүлэхдээ шүүхэд хүсэлт тавих, санал, гомдол гаргаж болох бөгөөд шүүх эдгээрт анхаарах, төлбөрийн чадваргүй этгээдийн өмгөөлөгчийн гаргасан хүсэлт санал, гомдолд онцгойлон хандаж байх нь зүйтэй. Учир нь тэдгээрийн эрх зүйн үйлчилгээний чанар төлбөрийн чадвар бүхий этгээдээс сул байж болох талтай.

д/ Шүүх эдгээр үүргийг шүүх хуралдааны үед гүйцэтгэхээс гадна хэргийг хянан шийдвэрлэхдээ эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокуророос төлбөрийн чадваргүй этгээдийн өмгөөлөх, өмгөөлүүлэх эрхийг хэрхэн хангасныг анхаарч байх нь зүйтэй юм.

е/ Хууль зүйн туслалцаа хүсэгч төлбөрийн чадвар болон бусад шалтгаанаар өмгөөлүүлэх эрхээ өөрөө хэрэгжүүлэх боломжгүй, түүнчлэн өмгөөлөгчөө сонгон авч чадаагүй нөхцөлд шүүх энэ тухай өмгөөлөгчдийн байгууллагад мэдэгдэж өмгөөлөгч томилуулах арга хэмжээ авах үүрэгтэй.

ё/ Дээр дурьдсан үндэслэлүүдээр төлбөрийн чадваргүй этгээдийг өмгөөлүүлэх эрхээ хангах явцад тэдгээрийг мэргэжлийн өмгөөлөгч оролцох боломжгүй бол байцаан шийтгэх ажиллагаанд оролцоход харшлах шалтгаангүй этгээдийг шүүгдэгч өөрөө сонгож болох бөгөөд энэ бололцоогоор шүүх хангах ёстой.

Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд төлбөрийн чадваргүй иргэдийн өмгөөлөх эрхээр хангах асуудал шүүхэд хамааралтай гэж үзнэ.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд төлбөрийн чадваргүй иргэний хэрэгт өмгөөлөгч заавал оролцуулах талаар тусгайлан заагаагүй. Гэвч энэ нь түүний өмгөөлөх, өмгөөлүүлэх эрхийг хязгаарласан явдал биш. Шүүхийн тухай хуульд заасан зарчимд тулгуурлан өөрийгөө өмгөөлүүлэх, өмгөөлөгчөө чөлөөтэй сонгон авах ба энэ эрхийг нь тайлбарлаж, хэрвээ төлбөрийн чадваргүй иргэн өөрөө хүсвэл түүнийг эрхээ хэрэгжүүлэх боломжийг шүүхээс хангах үүрэгтэй гэж ойлгож болно.

Үүнээс гадна Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиар “нэхэмжлэгч төлбөрийн чадваргүй болохыг нь:

- түүний өөрийн нь тайлбар;
- бусад нотлох баримтаар тогтоогдсон;
- хуульд заасан бусад үндэслэлийг харгалзан улсын тэмдэгтийн хураамжаас чөлөөлөхөөр зохицуулсан.

Нөгөө талаар зохигчдын /хэргийн оролцогчийн/ эд хөрөнгийн болон бусад байдлыг харгалзан шүүх шийдвэрээрээ улсын тэмдэгтийн хураамж төлөх хэмжээг багасгах, хугацааг хойшлуулах, хэсэгчлэн төлүүлэх боломжтойгоор зохицуулсан нь төлбөрийн чадваргүй иргэнийг эрхээ хамгаалах эрх зүйн боломж таатай нөхцлийг бий болгосон гэж үзэж болно.

Төлбөрийн чадваргүй иргэний өмгөөлүүлэх эрхээ хэрэгжүүлэх боломжийг шүүх хангахдаа түүнийг улсын тэмдэгтийн хураамжаас чөлөөлсөн, багасгасан зэрэгтэй холбоотойгоор авч үзэх нь зүйтэй. Гэхдээ төлбөрийн чадваргүй иргэнтэй холбогдох хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд өмгөөлөгч оролцуулахдаа түүний төлөөлөх эрх нь эрх зүйн туслалцаа авч байгаа этгээдийн хүсэлтээр тодорхойлогдоно гэдгийг мартаж болохгүй. Энэ нь зөвхөн төлбөрийн чадваргүй иргэний хүсэлтэд тулгуурлан түүний эрхийг зөрчихгүй гэж үзэх үндэслэлийг бий болгоно. Та төлбөрийн чадваргүй тул заавал өмгөөлөгч авах ёстой гэж албадаж болохгүй. Тэрээр өөрийгөө өмгөөлөх, эрх зүйн туслалцаа хүсэх, өмгөөлөгч сонгох, төлөөлөгчөөрөө дамжуулан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох бүрэн эрхтэй юм.

Энд цухас дурьдахад иргэний харилцааг шийдвэрлэх эрх зүйн үндэслэл нь иргэн сайн дураараа төлөөлүүлэх, гэрээний үндсэн дээр өмгөөлөгчөөр төлөөлүүлэх нь өөр хоорондоо ялгаатай ойлголт юм.

Төлбөрийн чадваргүй иргэний хүсэлтээр өмгөөлөгч эрх зүйн туслалцаа үзүүлэхдээ гэрээний үндсэн дээр түүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, хуулинд заасан бүх арга хэмжээ авах, шаардлагатай эрх зүйн туслалцаа үзүүлэх, хэргийн бодит байдлыг тогтооход туслах үүрэгтэй бол шүүх энэхүү эрхээ хэрэгжүүлэх боломжийг хангах үүрэгтэй байна.

Шүүх энэ үүргээ хэрхэн биелүүлж байгаа талаар нарийвчилсан мэдээ судалгаа үгүй боловч Монголын Нээлттэй Нийгэм Хүрээлэн /Соросын сан/-ийн “төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн туслалцаа үзүүлэх тогтолцоо” гэсэн судалгааны үзүүлэлтээр төдийлөн хангалттай бус харагдаж байна.

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд өмгөөлөгч оролцох эрх зүйн онцлогийг Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар тодорхойлжээ. Үүнд:

1. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд өмгөөлөгч гэрээний үндсэн дээр төлөөлнө. Энэ нь иргэн төлбөрийн чадвартай эсэхийг харгалзахгүй гэж үзэх үндэслэлтэй.
2. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аль ч үе шатанд өмгөөлөгчийн туслалцаа авч болно.
3. Өмгөөлөгчийн бүрэн эрх нь **хууль зүйн туслалцаа авч байгаа талын хүсэлтээр** тодорхойлогдоно. Иймээс шүүх захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд төлбөрийн чадваргүй иргэн оролцох тохиолдолд түүний өөрийгөө өмгөөлөх, өмгөөлөгчөө сонгох, эрхийг нь нэхэмжлэл гаргах үеэс нь тайлбарлан ойлгуулж, эрхээ хэрэгжүүлэх боломжоор хангахад анхаарах ёстой гэж үзнэ.

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож байгаа өмгөөлөгч нь оролцогч биш юм. Захиргааны хэргийн оролцогч нь нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээдийг хамааруулна. Харин нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээдийн төлөөлөгч, өмгөөлөгч нь захиргааны хэргийн бие даасан оролцогч бус зөвхөн төлөөлүүлж, өмгөөлүүлж байгаа этгээдийнхээ эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалж байгаа этгээд мөн.

Энэ ойлголт нь цаашдаа иргэний хэргийн оролцогчийн асуудал, тэдгээрийн эрх зүйн байдлыг адилтган зохицуулж хэвшүүлбэл зохино. Эндээс уламжлан хэргийн оролцогчийн хүсэл зориг өмгөөлөх эрхээр хангах асуудлыг зааглан тодорхойлоход ач холбогдолтой гэж үзнэ.

Төлбөрийн чадваргүй иргэний өмгөөлүүлэх эрхээр хангах тухай асуудал нь шүүх эрх мэдлийн хэрэгжүүлэх зарчмуудыг хэрэгжүүлэхтэй холбогдсон шүүхийн заавал хэрэгжүүлэх үүрэг гэж үзэж болно. Энэ нь мэтгэлцэх зарчим, хүн бүр хууль шүүхийн эрх тэгш байх, өмгөөлөх өмгөөлүүлэх эрхийг хэрэгжүүлэх шүүхийн үйл ажиллагааны тасралтгүй хэсэг байх учиртай гэж үзэж байна.

“Төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн туслалцаа үзүүлэх тогтолцоо” гэсэн **нөхцөл байдлын судалгаа** нь төлбөрийн чадваргүй иргэнийг өмгөөлөх эрхээр хангах тэдгээрт үзүүлэх хууль зүйн үйлчилгээ, туслалцааг боловсронгуй болгоход чухал ач холбогдолтой зүйл болжээ.

Уг судалгаанаас үзвэл 2000-2002 оны эхний хагас хүртэл эрүүгийн хэрэгт 4031 хүн иргэний хэрэгт 528 хүн төлбөрийн чадваргүй хүнийг өмгөөлүүлжээ. Үүний дийлэнх хувь нь хөлс төлөөгүй байхад түүнд зарцуулагдах ёстой зардлын 40-95 хүртэлх хувь нь зарцуулагдахгүй үлджээ. Иймээс цаашдаа өмгөөллийн хөлсийг төрөөс хариуцах хүмүүс, тухайлбал, төлбөрийн чадваргүй иргэн насанд хүрээгүй хүмүүс, тахир дутуу хүмүүс зэрэг амьдралын гачигдалтай иргэдийг өмгөөлүүлэх эрхийг хангах асуудлыг хуулиар зохицуулах, энэ хуулиар түүнд зарцуулах сан байгуулах, зарцуулах журмыг тодорхойлох, шүүх хийгээд бусад байгууллагын үүргийг тодорхойлох нь зүйтэй мэт санагдана.

Миний бодоход төсвөөс цалинждаг өмгөөлөгчөөс илүү зориулалтын сантай, түүнтэй өмгөөлөгчид гэрээтэй ажиллахаар зохицуулах нь зүйтэй мэт санагдана. Харин сан байгуулбал Хууль зүй, дотоод хэргийн яамны дэргэд байх нь зохистой биз ээ.

Нөгөө талаар төлбөрийн чадваргүй иргэний шүүн таслах ажиллагаанд оролцсон өмгөөлөгчийн хөлсний асуудлыг шүүхийн тогтоол шийдвэрт шууд зааж өгдөг. Үүнийг үндэслэн чирэгдэлгүй олгодог журам тогтоож болох юм.

Судалгаанд тусгагдсан бусад хэлбэрийн үйл ажиллагаа саналыг үгүйсгээгүй болно.

**.ХЭРЭГ БҮРТГЭХ, МӨРДӨН БАЙЦААХ АЖИЛЛАГААНЫ ЯВЦАД
ТӨЛБӨРИЙН ЧАДВАРГҮЙ, ИРГЭДИЙН ӨМГӨӨЛЛИЙН БОЛОН
ХУУЛЬ ЗҮЙН ТУСЛАЛЦАА АВАХ ЭРХИЙН ХЭРЭГЖИЛТЭНД
ТАВИХ ПРОКУРОРЫН ХЯНАЛТ**

Улсын Ерөнхий прокурорын туслах, Мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих хэлтсийн дарга Т.Сүхбаатар

Та нөхдийн энэ өдрийн амгаланг айлтгая.

Монгол оронд хүний эрх, эрх чөлөө, шударга ёсыг эрхэмлэн дээдэлсэн хүмүүнлэг, ардчилсан иргэний нийгэм байгуулж байгаа энэ түүхэн үед Монгол Улсын Үндсэн хуульд заасан Монгол улсын иргэний үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай хангах нь шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагуудын үйл ажиллагааны нэг чухал хэсэг юм.

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 13-т “Монгол улсын иргэн ... өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах, нотлох баримтыг шалгуулах ... эрхтэй” гэж заасан. Энэхүү эрхийн хэрэгжилт ямар байгаа, цаашид иргэд хууль зүйн туслалцаа авах байдлыг хэрхэн боловсронгуй болгож, ямар цогц арга хэмжээ авах нь зүйтэйг өнөөдрийн Үндэсний бага хурлаар хэлэлцэж байгаа нь чухал ач холбогдолтой юм.

- Монгол Улсын Үндсэн хуулийн 56 дугаар зүйлд заасны дагуу прокурор “Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавьж, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцох” чиг үүргийг хэрэгжүүлж байна. Прокурорын байгууллага Үндсэн хуулиар хүлээсэн энэхүү чиг үүргээ хэрэгжүүлэхдээ Монгол улсын иргэн өөрийгөө

өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах, нотлох баримтыг шалгуулах эрхийг нь хангахад үйл ажиллагаагаа чиглүүлж байна.

- Сүүлийн 3 жилд хэрэг бүртгэх байгууллагууд гэмт хэргийн тухай 119,7 мян гомдол, мэдээлэл хүлээн авч, 55856 гомдол, мэдээлэлд эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж, 58323 гомдолд эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзаж шийдвэрлэжээ.

- Сүүлийн 3 жилд мөрдөн байцаах байгууллага эрүүгийн 52213 хэрэгт мөрдөн байцаалт явуулсан байна. Прокурорын байгууллага сүүлийн 3 жилд 48063 хэргийн мөрдөн байцаалтын ажиллагаатай танилцаж, давхардсан тоогоор 68974 хэргийн материалыг уншиж хянан, 24523 хэрэгт яллах дүгнэлт үйлдэн шүүхэд шилжүүлжээ.

- Сүүлийн 3 жилд Прокурорын байгууллага хэрэг бүртгэх, мөрдөн байцаах байгууллагын үйл ажиллагааны талаар 9221 өргөдөл, гомдол, мэдээлэл хүлээн авч шийдвэрлэж, хэргийг үндэслэлгүй шийдсэн, хуулийн заалт зөрчсөн гэж үзэж хэргийг бүрэн гүйцэд шалгуулах, хохирогчийн эрх ашгийг хамгаалах, өмгөөлөгчийн хүсэлтийг хангуулахаар хэрэг бүртгэх, мөрдөн байцаах байгууллагад 13491 даалгавар бичиж, биелэлтийг тооцжээ.

Прокурор эрүүгийн хэргийн хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавихдаа Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны оролцогч болох сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтан тэдний хууль ёсны төлөөлөгч, хохирогч түүний өмгөөлөгч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагчийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах, тэдгээрийн өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах, нотлох баримтыг шалгуулах эрхийг нь хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор хэрхэн хангаж байгааг нэгэн адил хянаж, зөрчигдсэн эрхийг нь сэргээж, хангуулах талаар хуульд заасан арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.

Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны оролцогчдын хууль зүйн туслалцаа авах эрхийг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нар хэрхэн хангаж байгааг хянахдаа прокурор тухайн хэргийн газрын үзлэг болон нэгжлэг, туршилт, нүүрэлдүүлэн байцаах зэрэг байцаан шийтгэх бусад ажиллагаа явуулахад биечлэн оролцож хуулийн заалтыг хэрхэн хэрэгжүүлж байгаад хяналт тавьж, байцаан шийтгэх ажиллагааны оролцогчдоос хууль зүйн туслалцаа авах, эрхээ хангуулах талаар гаргасан хүсэлт, гомдлыг хүлээн авч хянан шийдвэрлэж байна. 2002-2003 оны эхний 3 сард Улсын Ерөнхий прокурорын газарт 1185 өргөдөл, гомдол ирж шийдвэрлэгдсэний 136 буюу 11,5 хувь нь өмгөөлөгчөөс гаргасан өргөдөл, хүсэлт байгаагийн багагүй хэсэг нь төлбөрийн чадваргүй иргэдийн хүсэлт, гомдол байна.

Сүүлийн 3 жилийн байдлаар прокурор хэргийн газрын болон бусад байцаан шийтгэх ажиллагаанд 15951 удаа оролцож, хуулийн заалтыг хангуулах арга хэмжээ авсны гадна байцаан шийтгэх ажиллагаанд оролцогчдоос хууль зүйн туслалцаа авах талаар гаргасан хүсэлт, гомдлыг шалгаж ажиллажээ.

Прокурорын байгууллага эрүүгийн хэргийн хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавихдаа төлбөрийн чадваргүй иргэдийн өмгөөллийн болон хууль зүйн туслалцаа авах эрхийг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор хэрхэн хангаж байгаад хяналт тавьж, Монгол Улсын Үндсэн хуульд заасан өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах, нотлох баримт шалгуулах эрхийг нь хангах талаар ЭБШ хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд тодорхой арга хэмжээ авч байна.

Төлбөрийн чадваргүй иргэдийн өмгөөллийн болон хууль зүйн туслалцаа авах эрхийг хангах талаар шинээр батлагдан мөрдөгдөж байгаа Монгол Улсын ЭБШ хууль, Прокурорын байгууллагын тухай хуульд зарчмын ач холбогдолтой олон чухал заалтууд орсон нь прокуророос үйл ажиллагаагаа явуулах эрх зүйн шинэ орчинг бүрдүүлж өгчээ.

Байцаан шийтгэх ажиллагааны оролцогч нь тодорхой байцаан шийтгэх ажиллагаа явуулах хэрэгт ач холбогдол бүхий нөхцөл байдлыг шалган тогтоох, түүнчлэн эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулахаар хүсэлт гаргах, /ЭБШХ-ийн 102.1/, өмгөөлөгч заавал оролцох /ЭБШХ-ийн 40.1/, насанд хүрээгүй этгээдийн үйлдсэн гэмт хэрэгт ЭБШ ажиллагаа явуулах тусгай журам /ЭБШХ-ийн 42-р бүлэг/, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаа хуульд заасан үндэслэл журмын дагуу явагдаагүй гэж үзвэл прокурор мөрдөн шалгах ажиллагаа явуулах /Прокурорын байгууллагын тухай хуулийн 12.3.1/ зэрэг зүйл, заалт нь хууль зүйн агуулгаараа төлбөрийн чадваргүй иргэдийн хууль зүйн туслалцаа авах эрхийг хангахад чиглэгдсэн гэж үзэж болохоор байна.

Прокурор эрүүгийн хэргийн хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавихдаа төлбөрийн чадваргүй иргэдийн хууль зүйн туслалцаа авах эрхийг нь хангаагүй хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурорын үйл ажиллагаа, шийдвэрийн талаар гарсан гомдлыг Монгол Улсын Прокурорын байгууллагын тухай хуулийн 12.2.10-т заасан бүрэн эрхийнхээ дагуу шалгаж шийдвэрлэх бөгөөд илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах арга хэмжээ авна.

Гэмт хэрэг зөрчлийн мэдээ, судалгаанаас үзэхэд сүүлийн жилүүд төлбөрийн чадваргүй, өөрөөр хэлбэл эрхэлсэн тодорхой ажил, сургуульгүй, насанд хүрээгүй, амьжиргааны доод түвшингээс доогуур амьдралтай иргэд гэмт хэрэг үйлдэх явдал өсч байгаагаас тэдгээр иргэдэд эрх зүйн туслалцаа үзүүлсэн өмгөөлөгчид төлөх зардал улсын хэмжээнд хүрэлцэхгүй байгаа нь Монгол улсын иргэн хууль зүйн туслалцаа авах эрхтэй гэсэн Үндсэн хуулийн заалт бодит байдалд хэрэгжихгүйд хүрч байна.

Шүүхийн өмнөх шатанд эрүүгийн хэргийн хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтад прокурор хяналт тавьж, төлбөрийн чадваргүй иргэдийн өмгөөллийн болон хууль зүйн туслалцаа авах эрхийг хангахдаа тухайн иргэн үнэхээр төлбөрийн чадваргүй эсэхийг хянахын зэрэгцээ хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор уг хүний өмгөөлөх болон хууль зүйн туслалцаа авах эрхийг нь хангах талаар хуульд заасан арга хэмжээг бүрэн гүйцэд авсан эсэхийг хянана. Хэргийн сэжигтэн, яллагдагч нарт өөрийгөө өмгөөлөх, аль эсхүл өмгөөлөгч авах эрхтэйг нь тайлбарлаж өгсөн эсэх, өмгөөлөгчтэйгөө ганцаарчлан уулзах эрхээр хангасан эсэх /ЭБШХийн 35.2.7, 36.2/, сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хохирогч өмгөөлөгчөө өөрөө сонгон авсан эсэх /ЭБШ хуулийн 39/, гэр бүлийн гишүүн, төрөл садангийн хүн нь өмгөөлөгчийг сонгон авсан эсэх /ЭБШХ-ийн 39.2/ зэрэг асуудлыг хэрхэн шийдвэрлэснийг прокурор хянаж, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авна.

Монгол улсын Прокурорын байгууллагын тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль болон тэдгээрийг дагаж мөрдөх талаар гарсан эрх зүйн бусад бичиг баримтад зааснаар ял эдлүүлэх ажиллагаанд ялтны хууль ёсны эрхийг хэрхэн хангаж байгаад прокурор хяналт тавина. НҮБ-аас баталсан “Хоригдогчтой харьцах наад захын жишиг дүрмүүд”-д ялтнуудын эдэлбэл зохих наад захын эрхүүдийг тусгасан хэдий ч ялтан нь төлбөрийн чадваргүй субъектийн хувьд өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах эрх нь зарим байдлаар хязгаарлагдмал байдаг. Ялангуяа ялтан хорих ангиас оргох, дахин давтан гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд тэдгээрийг өмгөөлөгчөөр хангах асуудал бэрхшээлтэй хэвээр байна. Иймд ялтны хөдөлмөрийн хөлсийг нэрийн дансанд нь бүрэн хэмжээгээр хийж, хууль зүйн туслалцаа авах нөхцөл боломжоор хангахад прокурорын хяналт чиглэгдэх ёстой бөгөөд энэ чиглэлээр зарим арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.

Төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн туслалцаа үзүүлэх үндэсний тогтолцоог боловсронгуй болгох асуудалтай холбогдуулж дараахь арга хэмжээг авах нь зүйтэй гэж үзэж байна. Үүнд :

1. Төлбөрийн чадваргүй иргэдийн өмгөөллийн зардлыг төсвөөс санхүүжүүлэх журмыг шинэчлэн боловсруулж, өмгөөллийн зардлын хүртээмж, хэмжээг нэмэгдүүлэх
2. Төлбөрийн чадваргүй иргэдэд өмгөөлөл болон хууль зүйн туслалцаа үзүүлэх явдал өсөн нэмэгдэж байгааг харгалзан Монгол Улсын Өмгөөллийн тухай хуулийн 12.3.8-д өмгөөлөгч жилд 2 удаа төлбөрийн чадваргүй иргэнийг өмгөөлөх гэсэн заалтыг өөрчилж, тоо хэмжээг нь нэмэгдүүлэх талаар хуульд нэмэлт өөрчлөлт оруулах .

Анхаарал тавьсанд баярлалаа.

**ТӨЛБӨРИЙН ЧАДВАРГҮЙ ИРГЭДИЙН ХУУЛЬ ЗҮЙН
ТУСЛАЛЦАА АВАХ ЭРХИЙГ ХАНГАХАД ӨМГӨӨЛӨХ
БАЙГУУЛЛАГЫН ГҮЙЦЭТГЭХ ҮҮРЭГ**

*Монголын Өмгөөлөгчдийн Холбооны
ерөнхийлөгч Б.Пүрэвням*

Үндэсний бага хурлын эрхэм төлөөлөгчид, хатагтай, ноёд, уригдан ирсэн хүндэт зочид оо!

Та бүхэнд энэ өдрийн мэнд дэвшүүлье! Өнөөдрийн энэхүү үндэсний бага хурлыг зохион байгуулах санаачилга гаргасан байгууллага, хүмүүст мөн талархаж байгаагаа илэрхийлье.

Тус улсаас сүүлийн 10 гаруй жилийн туршид эрчимтэй явуулж байгаа эрх зүйн шинэтгэлийн хүрээнд хүний эрхийг баталгаатай хангах талаар нэлээд олон асуудлыг амжилттай шийдвэрлэж ирлээ. Та бидний ярилцаж, санал бодлоо солилцох өнөөдрийн сэдэв маань ч энэ шинэтгэлээс хоцрох ёсгүй бөгөөд бусад улс, үндэстний нэгэн адил төр нь төлбөрийн чадваргүй иргэддээ эрх зүйн зохистой үйлчилгээ үзүүлэх хамгийн оновчтой тийм тогтолцоог бий болгоход энэ бага хурлын түүхэн ач холбогдол чухал байх болно.

Хэрэв ядуу хүмүүст эрх зүйн туслалцаа үзүүлэх асуудал хоцрогдсон хэвээр байвал ардчилал, хүний эрх, эрх чөлөөг баталгаатай хангах үнэт зүйл үгүй болж, улмаар эрх зүйн тогтолцооны агуулга нийгмийн хөгжил дэвшилд сөргөөр нөлөөлөх болно.

Иймд энэ асуудалд төр засгийн шийдвэр тэдний дэмжлэгийг авах нь юу юунаас чухал юм. Та бид ч энэ түүхэн үйл явдлын гэрч болох учиртай тул идэвхи санаачилгатай, бүтээлч байр сууринаас хандахыг уриалж байна.

Өмгөөллийн тухай Монгол Улсын хууль батлагдсанаар Өмгөөлөх байгууллага, Монголын өмгөөлөгчдийн нийгэмд гүйцэтгэх үүрэг рольд зарчмын өөрчлөлт орсны нэг нь төлбөрийн чаваргүй хүмүүст өмгөөлөл, эрх зүйн туслалцаа үзүүлсний хөлсийг төр даах тухай зохицуулалт байсан юм.

Хууль зүйн энэ заалтын дагуу төлбөрийн чадваргүй иргэдийн өмгөөллийн зардалд УИХ анх удаагаа 1995 онд 2 сая төгрөг төсөвт тусгаж энэ ажил эхэлсэн түүхтэй. Ийм зарчмаар жил бүрийн улсын төсөвт тодорхой тооны зардал тусгагдаж байсан хэдий ч өмгөөлөгчдөд 2002 оныг хүртэл энэ хөлс олгогдож байсан баримт байхгүй байна.

Гэсэн хэдий ч манай өмгөөлөгчид энэ хүндрэлийг үл тоон төлбөрийн чадваргүй иргэний эрх ашгийг хамгаалах үйлсэд зүтгэсээр ирснийг тэмдэглэх хэрэгтэй.

Харин 2002 онд Монгол Улсын засгийн газраас дээрх зардалд зориулж 9 сая төгрөг төсөвлөж, Өмгөөлөх байгууллагад олгосон нь хүний эрхийг хамгаалах, төр иргэнийхээ, ялангуяа ядуу иргэдийнхээ өмнө хүлээсэн үүргээ биелүүлсэн анхны том алхам байлаа. Үүнийг манай өмгөөлөгчид ганц удаагийн төрийн тэтгэлэг гэж үзэхгүй байна, харин бидний төсөөлж, байгуулахаар зорьж буй тэр л тогтолцооны эхлэл суурийг тавьж өгсөн чухал шийдвэр боллоо гэж үзэж байна.

Одоогийн дагаж мөрдөж байгаа хууль, тогтоомжоор төлбөрийн чадваргүй байдлыг тодорхойлохдоо Засгийн газраас тогтоосон амьжиргааны баталгаат доод түвшинг үндсэн шалгуур болгоно. Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн өөрийгөө болон гэр бүлээ тэжээх сарын орлого нь Засгийн газраас тогтоосон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнд хүрэхгүй, үүнээс хамааран байнгын хязгаарлагдмал хэрэглээтэй амьдардаг иргэдийг төлбөрийн чадваргүй өмгөөлүүлэгч гэж тооцно. Тухайн иргэний төлбөрийн чадваргүй болохыг сум, баг, хороодын засаг дарга нар тодорхойлно гэжээ.

Ийнхүү дээрх байдлаар тодорхойлолт авсан хүмүүс гэмт хэрэгт холбогдож, өмгөөлөгч хүссэн тохиолдолд тэдний, эсвэл хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн хүсэлтээр аймаг, нийслэлийн өмгөөлөгчдийн зөвлөл өмгөөлөгч томилон оролцуулж байна.

Судалгаагаар манай өмгөөлөгчдийн дийлэнхи нь зөвхөн эрүүгийн хэргийн яллагдагч, шүүгдэгч нарт өмгөөлөл, хууль зүйн туслалцаа үзүүлдэг болох нь тогтоогдсон байна. Гэтэл гэмт хэргийн төлбөрийн чадваргүй хохирогч, иргэний хэргийн оролцогчид, захиргаа, арбитра, үндсэн хуулийн цэц зэрэг ач холбогдол, хууль зүйн үр дагаврын хувьд ч хамгийн чухал газруудад эрх зүйн туслалцаа авах асуудал хоцрогдсон хэвээр байна.

Тэгвэл төлбөрийн чадваргүй иргэн гэдэг ойлголтод тавигдах наад захын стандарт бий болгох, эрх зүйн туслалцааг зөвхөн эрүүгийн хэрэгт бус, иргэний, захиргааны, арбитра, Үндсэн хуулийн цэцийн маргаанд ч өмгөөлөгч авах боломжийг нэг мөр шийдэх, төлбөрийн чадваргүйг зөвхөн засаг даргын тодорхойлолтоор бус, орон гэр, байнга оршин суух хаяггүй, аймаг сум дамжин гэмт хэрэгт холбогдсон хүмүүсийг төлбөрийн чадваргүй болохыг нь шүүх тогтоож, шийдвэртээ тусгах байдлаар шийдвэрлэх нь зүйтэй байна. Энэ нь олон шат дамжлагыг багасгах сайшаалтай механизм болохыг ч үгүйсгэхгүй юм.

Гэхдээ төлбөрийн чадваргүй иргэн гэх үү, эсвэл төлбөрийн чадваргүй хүн гэх үү гэдгээс шалтгаалан зохицуулалт нь өөр байх учиртай.

Сүүлийн үед төлбөрийн чадваргүй гэсэн тодотголтой хүмүүсийн тоо эрс нэмэгдэж байна. Энэ нь дараах шалтгаантай холбоотой юм.

Засаг даргын тодорхойлолтыг нь хуурамчаар хэн нэгэн хүн гарын үсэг зурдаг, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчид засаг даргаараа тодорхойлолт хийлгээд ир, төрөөс хөлсийг нь төлдөг болсон гэх мэтээр хандаж байгаа зохисгүй үзэгдэл гарах хандлагатай байна. Төлбөрийн чадвартай хүн дээрхи аргаар өмгөөлөгч томилуулсан явдал ч гарсан нь анхаарах асуудал гарцаагүй мөн.

Монголын Өмгөөлөгчдийн Холбоо энэ асуудалд тавих хяналтыг сулруулахгүй, нягт нямбай хандах болно, хавтгайрч болох сөрөг үзэгдэлтэй ч шийдвэртэй тэмцэх нь бидний баримтлах нэг бодлого болно гэдгийг хариуцлагатай хэлэх байна.

Тооцоо алдсан буруу тогтолцоо ямар үр дагавар авчрах нь ойлгомжтой юм. 1995 онд батлагдсан төлбөрийн чадваргүй иргэний өмгөөллийн зардлыг төсвөөс санхүүжүүлэх, тайлан тооцоо гаргах журмыг Өмгөөллийн шинэ хуультай уялдуулан шинэчлэж, Хууль Зүй Дотоод Хэргийн Яаманд хүргүүлээд байна. Төрийн сангаас өнгөрсөн онд олгосон 9 сая төгрөгийг өмгөөлөгчиддөө олгохдоо юуны өмнө өмгөөлөгчийн зарцуулсан цаг, хэргийн зүйлчлэл, ангилалт, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд оролцсон эсэх, шүүх хуралд оролцсон байдал, гарсан үр дүн зэрэг үзүүлэлтийг харгалзан ялгамжтай байдлаар олгохыг хичээв.

Тухайлбал 2002 оны байдлаар 612 эрүүгийн хэрэгт холбогдсон төлбөрийн чадваргүй 740 иргэнийг нийт 116 өмгөөлөгч өмгөөлжээ. Тэдний бүрдүүлсэн баримтаар 19 сая 417 мянган төгрөг өмгөөллийн хөлс гэж нэхэмжилснээс 46.4 хувь буюу 9 сая төгрөгт багтаан хуваарилсан байна. Үүнээс 10 сая 417 мянган төгрөг буюу 53.6 хувийг нь олгож чадаагүй байна.

Төлбөрийн чадваргүй иргэний үйлдсэн эрүүгийн нэг хэрэгт дунджаар 14705 төгрөг олгогджээ.

2002 онд Улсын хэмжээнд 24100 иргэний хэрэг шийдвэрлэгдсэнээс 5352 хэрэгт өмгөөлөгч оролцож туслалцаа үзүүлсэн байна.

Энэ нь нийт хэргийн 11.1 хувьд өмгөөлөгч оролцсон гэсэн тооцоо гарч байгаа юм. Үүний цаана төлбөрийн чадваргүйгээс эрх ашгаа хамгаалуулж чадахгүй мянга мянган иргэд хохирч байна. Үүний цаад агуулга нь төлбөрийн чадваргүй байдлаас өмгөөлөх байгууллага, өмгөөлөгч нарт хандаж чадахгүй байна гэсэн дүгнэлтэд хүрч байна.

1995 онд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 49 төгрөг 23 мөнгө байсан бол засгийн газрын 2002 оны 263 дугаар тогтоолоор хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 177 төгрөг 51 мөнгө болж 3.6 хувиар нэмэгдсэн байна.

Үүнийг одоогийн нөхцөл байдалд жишиж үзье.

Үүнд:

	1995 онд	2002 оны байдлаар
Хэргийн ангилал	өмгөөллийн хөлс Мян/төг	Мян/төг
1. Хөнгөн гэмт хэрэг	3.500	12600
2. Хүндэвтэр гэмт хэрэг	6.000	21600
3. Хүнд гэмт хэрэг	8.000	28800
4. Онц хүнд хэрэг	12.000	43200

Хүний эрхийн үдсэний комиссоос 2001 онд өмгөөлүүлэх эрхийн хэрэгжилт ямар байгаа талаар явуулсан судалгаанаас зарим нэг орон нутагт өмгөөлөгчийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд оруулдаггүй талаар дурьджээ.

Судалгаанд оролцогчдын нилээд нь өмгөөлүүлэх эрхтэйг тайлбарлаж өгөөгүй, төлбөрийн чадваргүйгээс өмгөөлөгч авах боломжгүй гэж хариулжээ.

Үүнээс авч үзвэл хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд өмгөөлөгч оролцож чадахгүй байгаа нь байцаан шийтгэх ажиллагаа шударга явагдах, хүний эрх зөрчигдөхгүй байх, нотлох баримтыг хууль бус аргаар цуглуулах болон бусад тохиолдолд ямар ч хяналтгүй болно гэсэн үг юм. Ийм тохиолдолд ямар үр дагавар гарах нь ойлгомжтой юм.

Өмгөөлөгчдийг томилохын эерэг тал нь өмгөөлөгчөөр шуурхай хангаж байгаа мэт харагдах боловч тухайн өмгөөлөгчид тавих хяналт байхгүй, үйлчилгээний чанар сул, сайн ур чадвартай өмгөөлөгчид энэ ажилд оролцохгүй байх зэрэг сөрөг үр дагавар ажиглагдаж байна.

Төлбөрийн чадваргүй ядуу иргэнд өмгөөлөл, хууль зүйн туслалцаа үзүүлэх үндэсний тогтолцоог боловсронгуй болгох асуудалд өөрийн саналаа илэрхийлье.

1.Төлбөрийн чадваргүй иргэнд үзүүлэх эрх зүйн туслалцаа гэдэгт зөвхөн эрүүгийн хэрэгт холбогдсон хүнд үйлчилгээ үзүүлэх тухай бус, гэмт хэргийн хохирогч, эрүү, иргэний хэргийн иргэний нэхэмжлэгч, хариуцагч, захиргаа арбитр, үндсэн хуулийн цэцийн маргаанд төлбөрийн чадваргүй иргэнийг өмгөөлөгчөөр хангах асуудлыг нэг мөр шийдэх.

2.Төлбөрийн чадваргүй иргэнд тооцох шалгуурыг нарийн судалж шийдэх нь зүйтэй байна. Тухайлбал өрхийн орлого нь амьжиргааны баталгаажих доод түвшингээс доогуур байх уу, эсвэл тухайн иргэний орлого доогуур байхыг ойлгох уу, түүнийг нь ямар арга замаар хэн тогтоох талаар бодмоор юм байна.

3. Хууль тогтоогчийн зүгээс зөвхөн хүний эрхийн талаархи эрх зүйн орчинг боловсронгуй болгоход анхаараад зогсохгүй, эрх зүйн үйлчилгээ авагчийн нөхцлийг сайжруулах, хэрэгжих мяханизмд анхаарах нь чухал байна.

4. Өөрийн орны онцлог байдал, гадаад улс орнууд энэ асуудлыг шийдвэрлэсэн туршлагыг судлах, ялангуяа засгийн газрын дэмжлэг туслалцаа, түүний оролцоог хуульчлан өгөх нь чухал ач холбогдол, үр дагавартай болно. Ялангуяа үйл ажиллагаа тогтмол явуулах байраар хангах, энэ чиглэлээр тусгайлсан сан хөмрөг бий болгох үүргийг Засгийн газрын чиг үүрэг болгох:

5. Төлбөрийн чадваргүй хүмүүст үзүүлэх эрх зүйн туслалцааны чанар, үр нөлөөг дээшлүүлэх чиглэлээр өмгөөлөх байгууллагын хүлээх үүрэг өмгөөлөгчдийн боловсрол, давтан сургалт, мэргэшүүлэх асуудалд төр засгаас дэмжих хэрэгтэй байна.

6.Үндэсний тогтолцоог Монголын Өмгөөлөгчдийн Холбоо, аймаг, нийслэлийн өмгөөлөгчдийн зөвлөлийг түшиглэн байгуулах нь манай орны онцлогт тохирох оновчтой хувилбар гэж үзэж байна. Харин өмгөөллийн зардлыг тусгай сан байгуулж, түүний хуваарилалт, зарцуулалт, хяналт тавих асуудлыг зохицуулах удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг Сангийн яам, Хууль зүйн яам, Монголын Өмгөөлөгчдийн Холбоо болон Шүүхийн ерөнхий зөвлөлийн төлөөлөлтэй бүрдүүлж болох юм.

Төлбөрийн чадваргүй иргэнд өмгөөлөл, хууль үйн туслалцаа үзүүлэх оновчтой тогтолцоог бий болгох талаар санал бодлоо илэрхийлж байгаа, бага хурлыг зохион байгуулахад санхүүгийн болон бусад дэмжлэг туслалцаа үзүүлсэн нийт байгууллага, хүмүүст дахин баяр хүргэж энэхүү бага хурлын ажиллагаанд амжилт хүсье.

Анхаарал тавьсан явдалд баярлалаа.

ТӨЛБӨРИЙН ЧАДВАРГҮЙ ИРГЭДЭД ХУУЛЬ ЗҮЙН ТУСЛАЛЦАА ҮЗҮҮЛЖ БУЙ ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГЫН ТУРШЛАГА

*Хүний эрх хөгжил төвийн ажилтан,
хуульч С.Дондов*

Монгол улс хүний эрх, эрх чөлөөг дээдэлж, хүмүүнлэг иргэний ардчилсан нийгэм байгуулах замд эргэлт буцалтгүй орсон энэ цаг үед төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн туслалцаа үзүүлэх тогтолцоог боловсронгуй болгох асуудлаар үндэсний бага хурал зохион байгуулж буй ХЗДХЯ, МННХ Соросын санд талархал илэрхийлж, төлбөрийн чадваргүй иргэдэд эрх зүйн туслалцаа үзүүлж буй өнөөгийн байдал, цаашдын зорилтын талаар та бүхэнтэй санал солилцох болсондоо баяртай байна.

Хүний эрх ба хөгжил төв нь Монгол Улсын хэмжээнд хүний эрхийг дэмжин хамгаалах үйлсэд ахиц гаргах зорилготой байгуулагдсан төрийн бус байгууллага юм. Үйл ажиллагааны хувьд үндсэн хэд хэдэн хөтөлбөр хэрэгжүүлэн ажиллаж байна.

1.Баримт мэдээлэл судалгааны хөтөлбөрийн хувьд: Хүний эрхийн зөрчлийн талаарх факт баримтыг цуглуулах, судалгаа хийж мэдээлэл түгээх ажил ордог. Английн хүүхдийг ивээх сан, Соросын сан, Азийн сан, Траст фонд, Нидерландын элчин сайдын яам, НҮБ-ын хөгжлийн хөтөлбөр зэрэг санхүүжүүлэгч байгууллагуудын дэмжлэгээр Хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн байдал, Жендер судлалыг хөгжүүлэх хэрэгцээ сонирхлыг үнэлэх асуудал, Эмзэг бүлгийн хүний эрхийн төлөв байдал, ДОХ БЗХӨ-тэй хүмүүсийн нууцын асуудал ба хүний эрх, Монгол улс дахь эмэгтэйчүүд, хүүхдийг худалдах гэмт хэргийн байдал, Цагдан хорих төвүүдийн хүний эрхийн байдал, Монгол улс дахь эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл ба хууль эрх зүйн орчин зэрэг асуудлаар Хууль зүй дотоод хэргийн яам, Хүний эрхийн үндэсний комисс, Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр, Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах конвенцийн хэрэгжилтийг хангах үндэсний сүлжээний төв, Хүчирхийллийн эсрэг төв зэрэг байгууллагуудтай хамтран судалгаа хийж, хийсэн судалгаанууддаа тулгуурлан тухайн асуудлаар олон нийтийн мэдлэг, мэдээлэл ямар байна, одоо байгаа мэдээлэл хүмүүст хэрхэн хүрч, хэр зэрэг үнэн зөв ойлголт өгч байна, асуудал одоогоор хэрхэн шийдвэрлэгдэж байгаа, цаашид юунд анхаарах шаардлагатай зэрэгт дүгнэлт хийж тайланг гарган олон нийтийн гарт хүргээд байна.

2. Манай байгууллагын үйл ажиллагааны хөтөлбөрийн нэг хэсэг болох хүний эрхийн боловсролын хүрээнд иргэд, цагдаагийн байгууллагын хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор ЦЕГ-тай хамтран Соросын сангийн дэмжлэгтэй Цагдаа ба хүний эрх төслийг хэрэгжүүлж ТВ-ийн богино хэмжээний арван кино хийснийг хот, хөдөөгийн ТВ-ийн студид тарааж олны хүртээл болгосноос гадна Сэжигтэн яллагдагчийн эрх, Цагдаагийн байгууллагад өргөдөл гомдол гаргах нь гэх мэт иргэдийн зайлшгүй мэдвэл зохих асуудлуудаар 13 төрлийн гарын авлагыг бэлтгэн хэвлэж цагдаагийн байгууллагаар дамжуулан хөдөлмөрчдийн хүртээл болгосон.

Монгол улс дахь хүний эрхийн байдлын талаар үнэн зөв мэдээллийг тогтмол гаргах үүднээс Хүний эрх хөгжил сонин, Монгол улс дахь хүний эрхийн байдал тэмдэглэл, Хүний эрхийн мэдлэгт радио хичээл, төвийн веб хуудас зэргийг ажиллуулснаар хүний эрхийн мөн чанар, түүний ач холбогдол, ойлголтыг олон нийтэд таниулах үйл ажиллагаа явуулж байна.

Дээр дурдсан үйл ажиллагаануудын иргэдэд хүрч буй илрэл нь ард иргэд хүний эрхийн асуудлаар, мөн хууль зүйн чиглэлээр зөвлөгөө авах гэж манай төвд олноор ирэх болсон юм.

3. Нөгөөтэйгүүр Монгол улсад төлбөрийн чадваргүй иргэний үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа авах эрх, хууль, шүүхийн практикт бодитойгоор хэрэгжихгүй байгаа, өмгөөлөгчөө чөлөөтэй сонгож чаддаггүй байдал, ихэнх тохиолдолд өмгөөлөгчид өмгөөллийн зардлаа төрөөс ч, хувь хүнээс ч олж авч чаддаггүй. Учир нь төлбөрийн чадваргүй иргэний өмгөөллийн зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэхээр заасан хуулийн заалтыг үндэслэн гаргасан журам нь олон шат дамжлагатай, мөн төсвөөс өгч буй мөнгийг нь өмгөөлөгчдийн холбоонд бус шүүхийн ерөнхий зөвлөл, аймаг нийслэлийн шүүхүүдээр

дамжуулж олгохоор заасан нь өмгөөлөгч нарт очдоггүй зэрэг хүндрэлүүдээс болж өмгөөлөгчид төлбөрийн чадваргүй иргэдийг өмгөөлөх сонирхол байдаггүй, мөн иргэд төлбөрийн чадваргүй тухайгаа хаана хандаж ямар материал бүрдүүлэхээ мэдэхгүй, мэдсэн ч зарим нэгд нь холбогдох баримт бичиг байдаггүй зэргээс болж иргэд өмгөөлөгчийн туслалцаа авч чадахгүй хохирох явдал байсаар байна. Харин тэр хохирогсдын цөөн хувь нь ойр дөт холбоотой байдгаар нь төрийн бус байгууллагад ханддаг явдал их байна. Тус төвийн хуульчид хууль зүйн зөвлөгөө авч буй хүмүүст хүний эрхийн чиглэлээр гарсан олон улсын гэрээ конвенц, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ болон үндэсний хууль тогтоомжоор хууль зүйн зөвлөгөө өгөх, мөн өргөдөл, нэхэмжлэл бичиж өгөх, гэрээ байгуулах болон бусад эрх зүйн шинжтэй баримт бичиг үйлдэхэд туслах зэргээр мэргэжлийн туслалцаа үзүүлдэг. Ихэнх үйлчлүүлэгчид цаашид үргэлжлүүлэн эрх зүйн туслалцаа авах, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүхийн шатанд өмгөөлөгчөөр оролцуулах хүсэлт тавьдаг учраас тус төвийн хуульчид төлбөрийн чадваргүй хүмүүсийн Үндсэн хуулиар олгогдсон эрх, эрх чөлөөгөө бүрэн эдлэх боломжийг хэрэгжүүлэх үүднээс ажлын ачааллаа тэнцүүлэн аль болох цаг зав гарган ажиллаж байна. Жишээ нь Югослав улсад хил дамжуулан худалдагдсан 2 охины асуудал, ДОХ-той гэж хэвлэлээр гүтгэгдсэн эмэгтэйн нэр төрийг сэргээж буруутай этгээдэд хариуцлага тооцуулах хэрэг, насанд хүрээгүй хүүхдийн бие эрхтнийг түлж гэмтээсэн хэрэг, танхайрч бусдын биед гэмтэл учруулсан хэрэг, хөдөлмөрийн хууль зөрчиж цалин олгохгүй байгаа, ажлаас хууль бусаар халсан, гэр бүлийн хүчирхийлэлд өртөж гэмтэл авсан хохирлоо төлүүлж, гэрлэлтээ цуцлуулах зэрэг маргаантай асуудлаар хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүхийн шатанд тус төвийн өмгөөлөгчид өмгөөлөгчөөр оролцож асуудлыг шийдүүлж байна.

Тус төв ажлын ачааллаа зохицуулах зорилгоор 3, 5 дахь өдрүүдэд хууль зүйн зөвлөгөө өгөх хуваарь гарган ажиллаж байна. Тус төвөөр үйлчлүүлж буй ихэнх хүмүүс төлбөрийн чадваргүй ажилгүй гэрээрээ байдаг ихэвчлэн радиогоор сонссон, манай төвөөс үнэгүй тараадаг сонин, тэмдэглэл уншлаа, танилаасаа сонссон гэх мэтээр эрх зүйн туслалцаа авахаар хандаж ирэх нь элбэг байна. Тус төв нь байгуулагдсан цагаасаа хойш нийт 300 орчим хүнд зөвлөгөө өгсөн байна. Сүүлийн 1 жилийн зөвлөгөө өгсөн байдлаас ажиглахад Эрүүгийн хэрэг -13, Иргэний хэрэг-8, Хөдөлмөрийн маргаан -4, Гэр бүлийн хүчирхийлэл -5, Гэрлэлт цуцлах 4 хэрэгт тус тус өмгөөлөгчөөр оролцож эрх ашгийг нь хууль зүйн хүрээнд хамгаалан ажилласан байна. Тус төвийн хуульчид эрх ашгийг нь хамгаалж буй хүмүүсийнхээ асуудлыг аль болох бүрэн гүйцэд хуулийн хүрээнд хийхийг эрмэлзэж, тэднийг төлбөрийн чадваргүй, мөнгө төгрөггүй байдлаас болж эрх ашиг нь хохироохгүй байх тал дээр анхааралтай ханддаг юм.

Харин манай төвийн хувьд хууль зүйн зөвлөгөөг дагнан хариуцаж ажилладаггүй учраас ажлын ачаалал ихсэх, бүх хүнд хүрч ажиллах боломж хангалтай биш байдаг, төв үйл ажиллагаагаа нэг том өрөөнд явуулдаг учраас үйлчлүүлэгчид өмгөөлөгчтэйгээ ганцаарчлан уулзах боломж хомс байгаа зэрэг бэрхшээлүүд байна. Энэ ажлыг өмгөөлөгчөөр олон жил ажилласан дадлага туршлагатай, өмгөөлөгчийн ажилдаа дур сонирхолтой хүмүүс өөрийнхөө сэтгэлээр хийж гүйцэтгэж байгаа гэдгийг хэлэх хэрэгтэй.

Цаашид өмгөөллийн хөлс төлөх чадваргүй иргэдийн эрх ашгийг хамгаалан ажиллах хамгийн боломжтой аргын нэг нь үйл ажиллагаа нь тогтворжсон төрийн бус байгууллагыг түшиглэн зөвлөгөө өгөх төв байгуулах, тус төв нь төлбөрийн чадваргүй иргэдийн эрх ашгийг хамгаалах ажлыг хийхээс гадна иргэдийн өмгөөлүүлэх эрхийг нь сурталчлан таниулах, тэднийг өөрийнхөө эрхийг эдлэхийн төлөө тэмцэж чаддаг чадвартай болгох, өөрөөр хэлбэл тэдэнд эрхээ хамгаалах наад захын ойлголтыг хамгийн энгийн хэлбэрээр ойлгуулах ажлуудыг зохион байгуулах явдал юм. Харин тэнд ажиллагсдын цалин, байрны асуудлыг төрөөс зохицуулж эсхэл санхүүжүүлэгч байгууллагын туслалцаатайгаар ажиллуулвал тэдний эрх ашигт илүү бодитой нийцэх боломж байна.

Анхаарал тавьсан явдалд баярлалаа.

ТӨЛБӨРИЙН ЧАДВАРГҮЙ ИРГЭД БА ХУУЛЬ ЗҮЙН КЛИНИК ТӨВҮҮД

*Н.Туяа МУИС-ийн ХЗС-ийн багш Хууль зүйн
клиник төвийн эрхлэгч*

Нийгмийн эмзэг бүлгийн эрх зүйн хамгаалалтын асуудал нь хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх, хүний эрх чөлөөг баталгаатай хангах гэсэн утга санаатай салшгүй холбоотой бөгөөд тэгш байдлын талаархи хууль цаазын хэмжүүр болж байдаг. Хүний эрхийг баталгаатай хангах чадвар бүхий ирээдүйн хуульчдыг хэрхэн бэлтгэх вэ? Онолын хуульч, практикийн хуульч гэсэн нэр томъёог сөргүүлэн тавьсаар байх уу? Нийгмийн эмзэг бүлгийнхний хууль ёсны эрх ашгийг тууштай хамгаалж чадаж байна уу? гэдэг нь бидний сэтгэлийг зовоож байдаг эмзэг асуудлууд мөн билээ. Тэгвэл эдгээр асуудлыг нэгэн зэрэг цогц байдлаар шийдэх боломжийг нээж өгдөг хууль зүйн клиник сургалтын талаар товч танилцуулахыг хүсэж байна.

Сургалтын энэхүү шинэ хэлбэр Монголын хууль зүйн боловсролын системд нэвтэрснээс хойш бүтэн 3 жилийг ардаа орхижээ.

МННХ (Соросын сан)-ийн санхүүгийн дэмжлэгтэйгээр 1999 онд МУИС-ХЗС дээр анхны клиник төв байгуулагдаж байсан бол Шихихутуг ХЗДС-ийн Буян төв, УБИС-ийн Хэрэглээний эрх зүйн клиник төвүүд бий болж, идэвхитэй үйл ажиллагаа явуулж байна. Хууль зүйн клиник сургалт нь их дээд сургуулийн нэр хүндийг илэрхийлэх чимэг зүүлт биш, бусад орны жишигийг даган дууриах оролдлого ч биш юм. Харин бодит шаардлага хэрэгцээний явцад бий болсон сургалтын шинэлэг хэлбэр мөн. Хууль зүйн дээд боловсрол олгох сургуулийн тоо 30 хүрч жил бүр 2000 орчим оюутан диплом гардан авч буй өнөө үед төгсөгчдөд практик дадал олгох одоогийн тогтолцоо шаардлага хангаж байна уу. Дан ганц үйлдвэрлэлийн дадлагад найдаж болно гэж үү. Тэгээд ч нийслэлийн шүүх прокурорын практик хуульчдын тоотой харьцуулахад дадлагын чанар ямар түвшинд явагдах нь ойлгомжтой.

Хууль зүйн клиник сургалт гэдэг нь хуулийн сургуулийн төгсөх ангийн оюутнууд багшийнхаа удирдлагын дор нийгмийн эмзэг бүлгийн хүмүүст хууль зүйн туслалцаа үнэ төлбөргүй үзүүлнэ гэсэн үг юм.

Клиник сургалтын явцад сайн хуульч болох оюутны хүсэл эрмэлзлэл, хууль зүйн туслалцаа авах төлбөрийн чадваргүй иргэдийн хэрэгцээ шаардлага, ашиг сонирхол нэг цэг дээр давхцаж байдаг онцлогтой.

Гэвч бид дан ганц оюутны хүсэл эрмэлзлэлээр хууль зүйн зөвлөгөө өгөх боломжгүй. Үүний тулд нэг хичээлийн жилд цөөн тооны оюутныг сонгон шалгаруулж (24 оюутан) авсны дараа тэдэнд тусгай хөтөлбөрийн дагуу хичээл зааж Клиник сургалтын ойлголт, мөн чанар, үйлчлүүлэгчийг хүлээн авч уулзах, ярилцлага явуулах, бусдыг сонсох, нэгтгэн дүгнэх, өмгөөлөгчийн байр суурь, мэргэжлийн ёс зүйн сэдвүүдээр сургалт явуулж өмгөөлөгчийн үйл ажиллагааны дадал, эв дүй олгодог юм. 1999 оноос хойш нийт 269 оюутан клиник төвүүдэд суралцаж өмгөөллийн дадал эзэмшиж төгссөн байна.

Бидэнд тохиолдсон бэрхшээл, хүндрэлтэй талууд.

Их сургуулийн бүтцэд ажиллах Клиник нь:

1. Төв нь олон давуу талтай боловч төвийн үйл ажиллагаа, нэгэнт батлагдсан сургалтын төлөвлөгөө хоерыг хэрхэн зохицуулах асуудал нэлээд төвөгтэйд орно.

Иймд сургуулийн захиргаа, сургалтын албаны зөвшөөрөл авч үйлдвэрлэлийн дадлагын хугацаанд болон хичээлийн бус цагаар Клиник сургалтыг явуулах уян төлөвлөгөө график гаргах замаар шийдвэрлэсэн юм.

Мөн 2002-2003 оны хичээлийн жилээс манай сургуулийг төгссөн ангийн оюутнууд бүтэн 5 сарын хугацаанд үйлдвэрлэлийн дадлага хийх болсон нь таатай нөхцлийг бүрдүүлж байна. Гэвч цаашид клиник сургалт хичээлийг сонгон суралцах курсын хэмжээнд тооцуулах талаар тууштай арга хэмжээ авах нь оновчтой шийдэл мөн.

2. Хууль зүйн Клиник төвд ажиллах багш нарыг хэрхэн бэлтгэхээс клиник сургалтын чанар шууд хамаарна. Үнэндээ хууль зүйн клиник сургалт гэдэг нэр томъёо хэвшээгүй

байсан үед багш нарыг бэлтгэх асуудал хүндрэлтэй байх нь ойлгомжтой. Манай “Хүмүүнлэг” төвийн үйл ажиллагаа эхлэж байсан. 1999 онд бидний гар дээр Клиникийн ном, сурах бичиг, гарын авлага материал одоогийнх шиг цагт элбэг хангалттай байгаагүй. Харин Соросын сангийн шугамаар 1999 оны хавар Польш улсын Варшав, Краков хотод болсон Клиник боловсрол олгох олон улсын коллеквиумд монголын төлөөлөгчид оролцож сургалтанд хамрагдсан явдал чухал ач холбогдолтой болсон. Гэвч бид бүх багш нарыг гадаадад бэлтгэх учир дотоод нөөц, олон улсын байгууллагын мэргэжилтэн, төрийн бус байгууллагын идэвхтэй, сайн дурынхны хүчийг аль болох үр дүнтэй ашиглах арга замыг эрж хайх ёстой.

МУИС- Хууль зүйн сургууль, МННХ, хуульч эмэгтэйчүүдийн холбоо хамтран “Монгол дахь хууль зүйн Клиник сургалт: онол практикийн асуудал сэдэвт сургалт – семинар 1999.08.25-26-ны өдрүүдэд зохион байгуулсан нь Клиник боловсрол олгох ажлын эхлэл байсан юм. Энэхүү сургалтын эцэст эрх зүйч заах уламжлалт арга, хуульчийн практик дадал, эв дүй олгох интерактив арга хоорондын ялгаа заагийг тогтоох, сургалтын шинэ хэлбэрийг нэвтрүүлэх арга зүй, мөрдөж ажиллах журмуудыг тодорхойлж, Клиник төвд ажиллах удирдагч багш нарыг сонгосон билээ.

3. Удирдагч багш нарыг сонгох, тэднийг сургах асуудлын дараа тэдний ажлыг хэрхэн үнэлэх вэ, ачааллыг хэрхэн зохицуулах вэ гэсэн асуултанд хариу өгөх ёстой.

Клиник төвд туршлагатай, чадварлаг багш нарыг дан ганц захиргааны шийдвэрээр, дан ганц хүсэл эрмэлзлэлээр удаан барих бололцоогүй. Ер нь клиник сургалтын хэлбэр нь ихээхэн цаг хугацаа шаарддаг, үнэлэмж өндөртэй байдлаараа академик сургалтаас ялгарч байдаг. Тухайлбал, нэг удирдагч багш 6-8 оюутантай тулж ажиллана, оюутны шийдсэн асуудлын эцсийн хариуцлагыг хүлээнэ гэх мэтээр багшид тавих шаардлага өндөр, үнэ цэнэ бүхий сургалт юм.

Иймд удирдагч багш нарын ажлын үнэлгээ хөлсийг ямар хэлбэрээр олгохыг сургууль бүр өөрийн нөхцөлд тохируулан шийдвэр гаргах нь Клиник төвийн ажиллах хэвийн нөхцлийг хангах болно. МУИС- багш оюутны кредит үнэлгээний системд шилжсэн бөгөөд Хүмүүнлэг төвд ажиллах практик дадлага бүхий ахлах багшийн нэг хичээлийн жилийн ачаалал нь 14 кредиттэй тэнцүү байна. ХЗС- ийн захирлын тушаалаар Клиник сургалтад зориулсан цагийг кредитэд шилжүүлж, жилийн гүйцэтгэх цагийн нормоос 3 кредитийг хасаж тооцохоор шийдвэрлэсэн юм. Өөрөөр хэлбэл удирдагч багшид Клиник сургалтыг зохион байгуулж ажилласны төлөө багшийн 3 кредит олгох юм. Энэхүү урамшуулал нь Клиник сургалтын эцсийн үр дүнг дээшлүүлэх гол нөхцлийн нэг мөн. Түүнчлэн удирдагч багш нарын заах арга зүйг дээшлүүлэх олон улсын болон бүс нутгийн семинар, уулзалт, сургалтад хамрагдаж байна. Энэ чиглэлээр хоёр талын гэрээ тохиролцоонд үндэслэн туршлага судлах, богино хугацааны сургалт зохион байгуулах нь ач холбогдолтой.

4. Клиник сургалтад хамрагдаж байгаа оюутаны статус ямар байх вэ?

Тэд дадлагажигч өмгөөлөгч гэсэн асуултаас дараагийн бие даасан хүндрэл бэрхшээл тодорхой болно. Клиник боловсрол олгох олон арван жилийн туршлагатай АНУ-д холбооны болон муж улсын Дээд шүүхийн захирамжаар оюутанд эрх олгож хууль зүйн зөвлөгөө, үйлчилгээ үзүүлэх бодит боломжоор хангаж өгдөг байна. Бид оюутанд дадлагажигч- өмгөөлөгчийн статус олгохоор төлөвлөж байсан боловч дадлагажигч-өмгөөлөгчид тавигдах шаардлагын босгыг давж чадахгүй байсан юм. Иймд оюутан иргэний хэрэг маргааны асуудлыг шийдэхэд итгэмжлэлийн дагуу, эрүүгийн хэрэг бүртгэл, мөрдөн байцаалт, шүүн таслах ажиллагааны үед удирдагч багшийн хамт дагалдан оролцдог хувилбарыг сонгон хэрэглэсэн юм. Хүмүүнлэг төвийн оюутнуудад энгэрийн таних тэмдэг, түр үнэмлэхийг олгож байсан нь хууль зүйн аливаа үйлчилгээ үзүүлэхэд дөхөмтэй байсан болно.

5. Үйлчлүүлэгч нарыг хэрхэн урин дуудах вэ? Тэдний үл итгэх хандлагыг хэрхэн өөрчлөх вэ? гэдэг мөн л хүндрэлтэй асуудал байсан.

Өнгөрсөн туршлагаас үзэхэд МӨХ, хууль зүйн товчоод, дүүргийн хууль хамгаалах байгууллагуудын дэмжлэг нэн шаардлагатай байсныг дурьдах нь зүйтэй болов уу.

Дээрх дурьдсан бэрхшээл хүндрэлийг даван туулахад МННХ-ийн санхүүгийн болон оюун санааны дэмжлэг, хуулийн болон төрийн бус байгууллагын хамтын

ажиллагаа, хөндлөнгийн үнэлгээ хийсэн шинжээчдийн зөвлөмж, санамж онцгой үүрэг гүйцэтгэсэн юм.

Бидний онцлог, давуу талууд

1. Хууль зүйн Клиник сургалт төслийг Монголд анх удаа хэрэгжүүлэх сургуулиар шалгарч МННХ–Соросын сангийн тэтгэлэг хүлээн авсан явдал нь бидний боловсруулсан төсөл, үйл ажиллагааны чиглэл, төлөвлөсөн үр дүн биелэх таатай нөхцлийг бүрдүүлсэн юм.

Үүний зэрэгцээ тэтгэлэг хүлээн авсан байгууллагын үүрэг хариуцлага, санхүүгийн сахилга, тайлагнах журмыг чанд мөрдөж ажиллав. МУИС-ийн ректорат, ХЗС-ийн захиргаа клиник сургалт хөтөлбөрийг нэвтрүүлэхэд бүх талын тусалцаа үзүүлж “Хүмүүнлэг” төв нь үйлчлүүлэгчийг хүлээн авах өрөө, сургалтын танхим, багш нарын өрөөнөөс бүрдэх тохилог байртай бөгөөд сургалтын материаллаг баазыг бүрдүүлсэн компьютерын дотоод сүлжээ, интернет холбоо, утас факсаар тоноглогдсон юм.

2. Манай сургуулийн багш нарын 80 орчим хувь нь өмгөөллийн эрхтэй учир удирдагч багш нарын сонголт хийх, зарим нэг багшийн хууль зүйн товчоод дээр дадлага хийлгэх давуу талтай. Энэхүү давуу тал дээр түшиглэн клиник сургалтын төрөлжсөн салбаруудыг нээн ажиллуулахаар төлөвлөж байна. Ийнхүү эрх зүйн төрөл, институтээр дагнан ажиллах мэргэшсэн салбарууд бий болгох нь зуны сургалт явуулах, илүү тогтвортой ажиллах нөхцлийг бүрдүүлэх учиртай. Тухайлбал, Украин улсын Донецкийн Үндэсний их сургуулийн дэргэдэх Практик сургалтын төв нь 9 клиник, 14 мэргэшсэн салбарыг (интернатура) нэгтгэн зохион байгуулж ажилласнаар клиник сургалтыг чанарын шинэ түвшинд гаргажээ

3. Хууль зүйн клиник сургалтыг амжилттай явуулах үндсэн нөхцлийн нэг нь сургалтын бааз, бусад хамтран ажиллах түшиц газартай байх явдал мөн. Ийм учраас Сүхбаатар дүүргийн шүүх, МУИС-ийн ХЗС хамтран ажиллах гэрээ байгуулж 2001 оны 9 сараас эхлэн шүүх дээр Клиник сургалтын салбарыг нээн ажиллуулж эмзэг бүлгийн хүмүүст хууль зүйн тусалцаа үнэ төлбөргүй үзүүлэх, эрүү иргэний шүүн таслах ажиллагаа, шүүхийн практик судалж дүн шинжилгээ хийх замаар оюутанд мэргэжлийн дадлага, эв дүй олгох онцгой ач холбогдолтой болсон юм.

Ийнхүү мэргэжлийн хуулийн байгууллагын дэргэд клиник сургалтын салбар нээн ажилласны дүнд оюутан хууль хэрэглэх үйл ажиллагааны бодит практикт ойртох, үйлчлүүлэгч хүмүүсийн ашиг сонирхлыг хамгаалах, элдэв чирэгдлийг багасгах, шүүхийн ажилтнуудад мэргэжлийн шинэ ном, сурах бичиг, эрдэм шинжилгээний ажлын мэдээллийг цаг алдалгүй хүргэх зэрэг олон талын сонирхлыг нэгтгэх бололцоо нээгдсэн юм. Хүмүүнлэг төвийн туршлагаар Шихихутаг ХЗС-ийн /Буян төв Чингэлтэй дүүргийн шүүх клиник сургалтын салбараа ажиллуулж байна/. Цаашид энэхүү эхлэлийг улам илүү өргөн хүрээг хамруулан хуулийн бусад байгуулага, ТББ, засаг захиргааны нэгжид зохион байгуулж болох талтай.

4. Үйл ажиллагааны болон нутаг дэвсгэрийн чиглэлээр бусад байгууллагуудтай хамтран ажиллах талаар багагүй амжилт олж, зарим нэг шинэ эхлэл санаачлага гарсныг дурьдаж болох юм. Клиник сургалтыг эрчимтэй явуулахын тулд үйлчлүүлэгч ирэхийг хүлээж суух биш, бүх төрлийн сувгийг ашиглаж эрэл хайгуул хийх нь зүйтэй. Тухайлбал, “Хүний эрх хөгжил” төвөөс зохион байгуулсан “хХүний эрх зөрчсөн баримт фактыг цуглуулах арга зүй” сургалтанд оюутныг хамруулах, ХЭҮТ – ийн төслийн дагуу СБД- ийн ЦХ дээрх “Хохирогчдийг хүлээн авах байранд” оюутнууд жижүүрлэн ажиллаж байна.

Мөн СБД-ийн хорооны байцаагч, хорооны нийгмийн ажилтантай хамтран ажиллах чиглэл тогтоож харьяа нутаг дэвсгэрт оршин сууж байгаа тахир дутуу иргэд, тэтгэврийн насны хүмүүстэй уулзалт зохион байгуулах, ганцаарчлан асуулт хариултын ярилцлага, хууль зүйн асуудлаар лавлагаа, зөвлөгөө өгсөн нь манай төвд хандах хүмүүсийн тоог нэмэгдүүлэхэд мэдэгдэхүйц нөлөөлсөн билээ. Ийнхүү дүүргийн хороодод нүүдлэн ажиллах нь Клиник сургалтын агуулага, мөн чанарт нийцэхээс гадна нийгэмд хуульчийн гүйцэтгэх үүргийг мэдрэх, мэргэжлийн ёс зүй, хариуцлагын асуудалд хүндэтгэлтэй хандах сэтгэл зүй төлөвшүүлнэ.

Төлбөрийн чадваргүй иргэдийн эрх зүй хамгаалалтын байдлыг дээшлүүлэхийн тулд дараах саналыг дэвшүүлж байна.

1.Өмгөөлүүлэх эрх, түүнийг хэрэгжүүлэх арга хэлбэрийг үзэл баримтлалын түвшинд тайлбарлаж олон түмэнд хүргэх, гэгээрүүлэх арга хэмжээ авах. Тухайлбал, ЭБШХ-ийн 38 дугаар зүйлийн 2 хэсгийн заалт клиникийн оюутнууд эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцох өргөн боломж олгож байна.

2.Өмгөөллийн зардлын төсөв, бодит хэрэгцээ хоёрын хооронд хол зөрүү байдгийг анхааран үзэх нь зүйтэй болов уу? Жишээ нь хамгийн өндөр хэмжээнд төсөвлөгдсөн 2002 оны 9 сая төгрөгийг хэргийн хүнд, хөнгөний байдлаас үл хамааран хүн тус бүрт 15.0 төгрөг зарцуулна гэж бодоход төлбөрийн чадваргүй ердөө 600 хүнд үйлчлэх тоо гарч байна. Гэтэл үнэн хэрэг дээрээ жил тутам дунджаар хорихоос суллагдсан 2000 гаруй хүн давтан гэмт хэрэг үйлдэж байдаг бөгөөд эдгээр нь хамгийн өндөр магадлалтай төлбөрийн чадваргүй хүмүүс билээ.

3.Мөн төлбөрийн чадваргүй иргэдийн тооны өсөлт нь өмгөөлөгчдийн тооны өсөлтөөс хэдэн арав дахин илүү байгааг харгалзан үзэх ёстой. Тухайлбал, Монгол Улсад өмгөөлөгчдийн тоо 450-700-д хүрч нэмэгдсэн, тэд тус бүр 2 ядуу хүнд хууль зүйн туслалцаа үзүүлэхээр тооцоход нийт 1400 хүнээс хол давахгүй юм. Гэтэл Монгол Улсад гарч буй гэмт явдлын 48 хувийг хулгайлах гэмт хэрэг эзэлж байгаагаас 68.1 хувь нь иргэдийн өмчийн хулгай байна. Нийслэл Улаанбаатар хотод 2002 оны байдлаар 3944 удаа иргэдийн өмчид их бага хэмжээгээр халджээ. Хулгай хийгчдийн нийгмийн байдлыг авч үзэхэд хорих ангиас суллагдсан, шилжин суурьшсан, мэргэжилгүй, эрхэлсэн ажилгүй, төлбөрийн чадваргүй хүмүүс байдаг. Энэ тоо баримт мэргэжлийн өмгөөлөгчдийн хүчээр энэхүү асуудлыг шийдэх бололцоогүй болохыг батлаж байна. Иймээс төрийн бус байгууллага, их, дээд сургуулийн дэргэдэх хууль зүйн клиник төвүүдийн хүч бололцоог дээд зэргээр ашиглах шаардлагатай байна. Жишээ нь, Нэг Клиник төв жилд дунджаар 300 гаруй хүнд хууль зүйн туслалцаа үнэ төлбөргүй үзүүлж байна. Бидэнд ямар хүмүүс хандаж, бид хэрхэн тусладагийг тоо баримтаар сонирхуулая

өндөр насны тэтгэвэр	35%
тахир дутуугийн групп	27%
оюутан	10%
эрхэлсэн ажилтай	16%
хоригдол	7.0%
бусад	5.0%

Манай Клиникүүд ямар туслалцаа үзүүлдэг вэ.

өргөдөл
нэхэмжлэл
гэрээний төсөл
шүүхэд төлөөлөх
хариу тайлбар бичих
хууль тогтоомжийн лавлагаа өгөх
- эрүүгийн шүүх хуралд удирдагч багшийн хамт оролцох гэх мэт.

4. Клиник төвүүдийн багш нар эрүү, иргэний хэрэгт оюутнаа дагалдуулан оролцож эмзэг бүлгийн хүмүүсийн эрх ашгийг хамгаалж байгаа тул багш-өмгөөлөгчийн идэвхи санаачлагыг дээшлүүлэх хөшүүргүүдийг бий болгох нь зүйтэй. Жишээ нь: Өмгөөллийн татвараас чөлөөлөх, татварын хэмжээг бууруулах гэх мэт.

5.Өмгөөлөгчийн нөөцийн асуудлыг шийдвэрлэхдээ хууль зүйн клиникт суралцаж амжилттай төгссөн оюутныг сонгон авч ажиллуулах.

6.МУИС-ХЗС-ийн болон Шихихутуг ХЗДС –ийн Клиник төвүүд дүүргийн шүүхтэй хамтран ажиллаж байгаа эхлэлийг дэмжиж МӨХ-ны зүгээс дээрх шүүхүүд дэх төлбөрийн чадваргүй иргэдийн асуудлыг дээрх клиникүүдэд төвлөрүүлэх талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч болох юм.

Ийнхүү төлбөрийн чадваргүй эмзэг бүлгийн хүмүүст хууль зүйн туслалцаа үзүүлэх үйл хэрэгт Клиник төвүүдийн оруулж буй хувь нэмрийг хүлээн зөвшөөрч Үндэсний тогтолцоонд зохих байр суурь эзлэнэ гэдэгт итгэж байна.

Анхаарал тавьсанд баярлаа.

ХУУЛЬ ЗҮЙН ТОВЧООДООС ТӨЛБӨРИЙН ЧАДВАРГҮЙ ИРГЭДЭД ТӨЛБӨРГҮЙГЭЭР ҮЗҮҮЛЖ БҮЙ ЭРХ ЗҮЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХЭЛБЭР

*Хууль зүйн «Сувд» товчооны
захирал Э.Болорчулуун*

Монгол Улсын иргэн өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах эрхтэй болохыг Монгол Улсын Үндсэн хуулиар, харин төлбөрийн чадваргүй иргэний хувьд хууль зүйн үнэ төлбөргүй туслалцаа авах эрхтэй гэдгийг Монгол Улсын Шүүхийн тухай болон Өмгөөллийн тухай хуулиар хуульчлан баталгаажуулсан байдаг. Үндсэн хуулиар хамгаалагдсан өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах эрхийг хэрэгжүүлэхэд мэргэжлийн өмгөөлөгч, хууль зүйн товчоодын үүрэг, оролцоо чухал ач холбогдолтой юм.

Өмгөөллийн тухай хуулиар өмгөөлөгч нь хууль зүйн товчоо байгуулах, товчоо нь хуулийн этгээдийн эрх эдлэх, өөрийгөө санхүүжүүлэх үндсэн дээр үйл ажиллагаа явуулах тухай заасан, энэ хүрээнд Монгол Улсад 1997 оноос өмнө байгуулагдсан боловч ХЗДХЯамны шинэчилсэн бүртгэлд ороогүй 25, 1998 оны 4-р сарын 3-наас 2002 оны 5-р сарын 13-ны хооронд байгуулагдан Монгол Улсын ТББайгууллагын тухай хуулийн 15-р зүйлд заасны дагуу ХЗДХЯаманд бүртгүүлж үйл ажиллагаа явуулж буй хот, хөдөөгийн нийт 82 хууль зүйн товчоо, 21 зөвлөлд 600 гаруй өмгөөлөгч мэргэжлийн үйл ажиллагаа явуулж байдаг.

Ядуу, бага орлоготой, төлбөрийн чадваргүй иргэд хууль зүйн туслалцаа авах эрэлт хэрэгцээ, мөн тийм шаардлага маш их байдаг нь өмгөөлөгч бидэнд өдөр тутам байнга мэдрэгдэж байна. Тэдэнд өмгөөлөгчид хүч бололцооныхоо хирээр хууль зүйн үнэ төлбөргүй туслалцааг үзүүлдэг ч энэ нь хангалттай бус байдаг.

Нэг талаар энэ нь Монгол Улсад өнөөдөр төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн үнэ төлбөргүй туслалцаа үзүүлэх үр дүнтэй тогтолцоо байхгүй байгаатай холбоотой юм. Нөгөө талаар төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн үнэ төлбөргүй туслалцаа үзүүлэхтэй холбоотойгоор үйлчилж байдаг хоорондоо зарим нэг “зөрчилтэй”, бодит байдалд үл нийцсэн хууль тогтоомж, “өмгөөлүүлэх эрх”-ийг хангах тухай хуулийн зүйл, заалтыг биелүүлэхгүй байх зэрэг явдал нөлөөлж, мөн зохион байгууллалтын арга хэмжээ байнга дутагдаж байдгийг тэмдэглэх хэрэгтэй болов уу.

Бид төлбөрийн чадваргүй иргэний өмгөөлүүлэх эрхийн талаар хөндөж ярилцаж байна. Харин “төлбөрийн чадваргүй иргэн” гэдгээ хэрхэн ойлгох вэ гэхлээр, нэг талаар мэдээжийн юм шиг боловч нөгөө талаар эргэлзээтэй бөгөөд зөрчилтэй зүйл байдаг. “Төлбөрийн чадваргүй иргэний өмгөөллийн зардлыг төсвөөс санхүүжүүлэх, тайлан тооцоо гаргах журам”-д “төлбөрийн чадваргүй өмгөөлүүлэгч гэдгийг сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн өөрийгөө болон гэр бүлээ тэжээх сарын орлого нь засгийн газраас тогтоосон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнд хүрэхгүй, үүнээс хамааран байнгын хязгаарлагдмал хэрэглээтэй амьдардаг иргэдийг төлбөрийн чадваргүй өмгөөлүүлэгч гэж тооцно” гэж заасан байдаг. Үүнээс дүгнэн үзэхэд, төлбөрийн чадваргүй иргэн гэж тооцох нэг үндэслэл бол Засгийн Газраас тогтоосон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шалгуур болгосон нь харагдаж байна. Өнөөдөр Засгийн газраас тогтоосон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 30.000 төгрөг байна. Энэ журмаар бол тухайн этгээдийн өөрийгөө болон гэр бүлээ тэжээх сарын орлого нь энэ 30.000 төгрөгнөөс хэтрэхгүй байх ёстой, хэтрээд 35.000, 40.000 төгрөг болвол уг этгээдийг “төлбөрийн чадваргүй иргэн” гэж тооцохгүй болж байна. Өнөөдөр сарын 30.000 төгрөгний орлоготой, мөн 40.000 юм уу 50.000 төгрөгний сарын орлоготой, хууль зүйн туслалцаа авах бололцоо муутай ядуу иргэд их байдаг.

Төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн туслалцаа үзүүлэх асуудлаа бодит ядуурлын байдалтай уялдуулах хэрэгтэй гэдэг нь харагдаж байгаа байх. Ер нь ядуурлыг дотор нь туйлын (нэн ядуу /ажилгүй/, ядуу, бага орлоготой өрх), харьцангуй, субъектив

гэж ангилдаг юм байна. Ядуу, төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн туслалцаа үзүүлэх асуудал хөндөгдөж байгаа үед ялгаагүй тэр 40.000, 50.000 төгрөгний сарын орлоготой ядуу иргэдийн хувьд хууль зүйн үнэ төлбөргүй туслалцаа авах эрх нь адил тэгш байх ёстой. Тэгэхлээр энэ 30.000 төгрөг гэдэг нь бодит байдалд төдийлөн нийцэхгүй гэдгийг харуулж буй хэрэг.

Үүн дээр нэмж хэлэхэд, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг “төлбөрийн чадваргүй иргэн” гэдэг ойлголтоо тодорхойлох шалгуур болгож байгаа нь бодит байдалтай нийцэхгүй юм. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг эрүүгийн торгох ялд хэрэглэдэг. 40.000, 50.000 төгрөгийн сарын орлоготой ядуу иргэдээ хууль зүйн үнэгүй туслалцаанд хамруулъя гээд нэмэх гэхээр торгуулийн хэмжээ нэмэгдээд явчихна. Ийм эсрэг, тэсрэг үр дагавартай зүйл дээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шалгуур болгож байгаа нь тохиромжгүй юм. Дээр дурдсан журамд заасан төлбөрийн чадваргүй иргэн гэж тооцох 2 дахь үндэслэл бол засгийн газраас тогтоосон амьжиргааны баталгаат доод түвшин байхаар заасан нь илүү бодит байдалд нийцэж байгаа юм. Иймд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шалгуур болгох тухай заалтыг өөрчлөх нь зүйтэй юм.

Төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн товчоодоос төлбөргүйгээр үзүүлж буй эрх зүйн үйлчилгээний хэлбэр нь Монгол Улсын Өмгөөллийн тухай хуульд зааснаар:

- 1) эрх зүйн асуудлаар амаар болон бигээр лавлагаа, зөвлөгөө өгөх
- 2) эрх зүйн ач холбогдол бүхий баримт бичгийн эх зохиож туслах
- 3) иргэний хэрэг, захиргааны зөрчлийн хэргийг эрх бүхий байгууллага хянан шийдвэрлэхэд үйлчлүүлэгч этгээдийг төлөөлөх
- 4) хэрэг бүртгэлт, мөрдөн байцаах ажиллагаанд болон эрүүгийн хэргийг шүүхээр хянан шийдвэрлэхэд өмгөөлөгчөөр оролцох
- 5) иргэд, байгууллагын хүсэлтээр хууль тогтоомжид заасан хууль зүйн туслалцаа үзүүлэх
- 6) хууль тогтоомжоор хориглоогүй эрх зүйн бусад туслалцаа зэрэг байна.

Харин бодит байдал дээр Монгол Улсад үйл ажиллагаагаа явуулж байгаа хууль зүйн товчоодоос төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн үнэ төлбөргүй туслалцаа үзүүлэх асуудлаар баримталж буй бодлого, чиглэл, үйлдэл байхгүй байгаа болно. Өөрөөр хэлбэл, мэргэжлийн өмгөөлөгчдөөс бүрдсэн өөрийн удирдлага, зохион байгуулалт бүхий хууль зүйн туслалцааны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг анхан шатны нэгж болох товчоод нь төлбөрийн чадваргүй иргэдэд төлбөргүйгээр хууль зүйн туслалцаа үзүүлэх тогтолцоонд ямар нэгэн үүрэг гүйцэтгэдэггүй гэсэн үг.

Өнөөдрийг хүртэл хугацаанд төлбөрийн чадваргүй иргэдэд төлбөргүйгээр үйлчилгээ үзүүлэх ажлыг ихэвчлэн ямар нэгэн товчоонд хамрагддаггүй, бие даасан өмгөөлөгчид гүйцэтгэж иржээ. Эдгээр өмгөөлөгчид нь төлбөрийн чадваргүй иргэдийн эрхийг хамгаалах үйлчилгээгээ бодитой үзүүлсэн гэдгийг тэмдэглэхийн хамт бие даасан өмгөөлөгчдийг бодвол хууль зүйн товчоод нь тухайн асуудалд тодорхой бодлоготойгоор, зохион байгуулалттайгаар оролцох, мэдээллийн сан бүрдүүлэх, төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн туслалцаа үзүүлэх асуудлыг товчоон дээр төвлөрүүлэх, төрийн болон төрийн бус байгууллагуудтай хуулийн этгээдийн хувьд хамтран ажиллах зэрэг давуу талтай.

Иймд төлбөрийн чадваргүй иргэдэд туслалцаа үзүүлэх асуудалд хууль зүйн товчоодыг зохион байгуулалттайгаар татан оролцуулах нь уг асуудалд ахиц гаргахад ач холбогдолтой болно. Үүнийг дараах байдлаар хэрэгжүүлэх боломжтой юм. Үүнд:

- 1) засаг захиргааны нэгжүүдэд байрлаж буй тодорхой товчоодыг сонгон шалгаруулах замаар төсвөөс олгох хөрөнгийг хуваарилан, уг асуудлаар тогтвортой ажиллах үйл ажиллагааг дэмжих;

- 2) улсын төсөв, эдийн засгийн чадавхийг харгалзан хандивлагч болон нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллагуудын дэмжлэг туслалцаатайгаар энэ чиглэлээр хууль зүйн товчоодын дунд уралдаан, төсөл хэрэгжүүлэх;

НАСАНД ХҮРЭЭГҮЙ ИРГЭН ХУУЛЬ ЗҮЙН ТУСЛАЛЦАА АВАХ АСУУДЛЫН ТУХАЙ

*НҮБ-ын Хүүхдийн Сангийн суурин
төлөөлөгч ноён Ричард Прадо*

Эрхэм хүндэт ноён ХЗДХ-ийн Сайд Нямдорж, МННХ-гийн Гүйцэтгэх захирал
Стефэн Ванс, хүндэт оролцогч ноёд хатагтай нараа,

Танилцуулга

ХЗДХЯ, МННХ болон бусад хамтран ажиллаж буй төрийн болон төрийн бус байгууллагууд ийнхүү чухал арга хэмжээг зохион байгуулж, санаачилсанд НҮБ-ын Хүүхдийн Сангийн нэрийн өмнөөс талархал илэрхийлье. Монгол Улс дахь шилжилт үе хийгээд эрх зүйн шинэтгэлийн үед эмзэг бүлгийнхний ашиг сонирхлыг хамгаалах нь нэн чухал билээ.

НҮБ-ын Хүүхдийн сан хэрэгт холбогдсон хүүхдүүдийн эрхийг хамгаалах, тэднийг дэмжих явдлыг дэлхий даяар тулгамдсан бөгөөд нэн түрүүнд шийдвэрлэх асуудлын нэг болоод байна гэж үздэг юм. Гэмт хэрэгт сэжиглэгдсэн буюу яллагдагчаар татагдаад байгаа хүүхдүүдийн үндсэн эрхүүд нь хамгийн их зөрчигдөж болзошгүй байдаг билээ.

Хууль зөрчсөн хүүхдүүд: Тулгамдсан асуудал

Хууль зөрчсөн хүүхэд, залуучуудыг ойлгох, тэдэнд мэдрэмжтэйгээр хандах хэрэгтэй. Тогтвортой бус байдал, шилжилтийн үе болон нийгэм, эдийн засгийн хурдацтай өөрчлөлтийн үед залуу үеийнхэн хууль зөрчих илүү хандлагатай байдаг гэдэг нь түүхээр илэрхийлэгдэнэ. Зах зээлийн эдийн засагт шилжих үеийн бэрхшээлтэй тулгарахын зэрэгцээ Монгол Улсад залуучуудын ядуурал, гэр бүл салалт, гэр бүлийн хүчирхийлэл өссөн нэмэгдэхийн хэрээр хүүхэд залуучуудын эерэг нийгэмшлэлийн нөхцлийг /гэр бүл, сургууль, хүүхэд залуучуудын клуб зэрэг/ сулруулж байна. Үүний үр дүнд насанд хүрээгүй хүмүүсийн үйлдсэн гэмт хэрэг өнгөрсөн 10 жилтэй харьцуулахад 2 дахин өсөж, 1991 оны бүртгэлийн дагуу насанд хүрээгүй хүүхдүүдийн үйлдсэн гэмт хэрэг нь 733 байхад 2002 он гэхэд энэ тоо 1676 хүртэл өссөн байна.

Нөгөө талаас, Монгол Улсад хүүхэд залуучуудад зориулсан хууль зүйн туслалцаа олгох тогтолцоо байдаггүй. Эрүүгийн болон ЭБШХ-д 18 нас хүрээгүй хүүхэд үйлчилдэг зарим зүйл, заалт тусгасан хэдий ч насанд хүрээгүй хүүхдийн хэргийг хяна шийдвэрлэх дагнасан шүүх, насанд хүрээгүй хүүхдийн асуудлыг хариуцсан тодорхой алба /насанд хүрээгүй хүүхдүүдийн асуудлаархи цагдаагийн хэлтсээс гадна/, хууль зөрчсөн хүүхэд ба төр хоёрын хоорондын харилцааны асуудлыг зохицуулсан хууль зүйн болон бодлогын аливаа баримт бичиг байдаггүй юм байна. Иймээс ихэнх тохиолдолд насанд хүрэгсдэд үйлчилдэг эрх зүйн хэм хэмжээ нь мөн хүүхдүүдэд хэрэглэгддэг юм.

ХЗДХЯ болон бусад байгууллага, төрийн бус байгууллагууд хуулийн энэхүү хийдлийг арилгах зорилгоор зарим тодорхой арга хэмжээ авч байна. Тухайлбал, Монгол Улсаас 1991 онд соёрхон баталсан Хүүхдийн эрхийн тухай олон улсын конвенц /"ХЭОУК"/, НҮБ-ын Шүүн таслах ажиллагаа явуулах наад захын жишиг дүрэм /"Бээжингийн Дүрэм"/, Насанд хүрээгүй хүүхдүүдийг гэмт үйлдлээс урьдчилан сэргийлэх тухай НҮБ-ын Удирдамж /"Риадхийн удирдамж"/, Эрх чөлөөгөө хасуулсан насанд хүрээгүй хүүхдүүдийг хамгаалах тухай НҮБ-ын Журамд Монгол Улсын хууль зөрчсөн насанд хүрээгүй хүнд холбогдох хууль зүйн тогтолцоог нийцүүлж, хэрэгжүүлэх ажил явагдаж байгаа билээ.

Одоогоос сар гаруйн өмнө ХЗДХЯ, НҮБ-ын Хүүхдийн Сан нар энэхүү хуралтай төсөөтэй нэгэн хурлыг зохион байгуулсан бөгөөд тус хурлаар хууль зөрчсөн хүүхдийн асуудлыг авч хэлэлцсэн билээ. Энэ завшааныг ашиглан насанд хүрээгүй хүүхдүүдэд хууль зүйн туслалцаа авах боломжийг олгох тухай эл хуралтай зарим талаараа холбогдож болох бөгөөд тус хурлаар шийдвэрлэсэн өндөр ач холбогдолтой үнэлгээ, зөвлөмжийг та бүхэнд танилцуулъя.

Өнөөгийн байдал

Монгол Улсад 400 орчим өмгөөлөгч байдаг тоо баримт байна. Тэдгээрийн ихэнх нь нийслэл болон бусад хотуудад төвлөрсөн байдаг ба ихэнх аймагт өмгөөлөгч дутагддаг байна. Шүүхээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд, үүнд насанд хүүрээгүй хүүхдийн шүүх ажиллагаанд өмгөөлөгчийг оролцуулдаг олон жилийн практик байгаа хэдий ч ийм төлөөллийн чанар, хараат бус байдал, мөрдөн байцаалтын шатанд хууль зүйн туслалцаа авах боломжийн асуудал хурцаар тавигдаж байгаа билээ.

Хэдийгээр насанд хүрээгүй хүнд хамаатай ЭБША-ны бүхий л шатанд өмгөөлөгч заавал оролцохоор ЭБШХ-д заасан ч энэ заалтын амьдрал дээрхи хэрэгжилтийг, ялангуяа хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд, үнэлж дүгнэх нь арай эрт байна.

Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор нар ЭБША-ны үеэр насанд хүрээгүй хүнийг өмгөөлөгчөөр ямагт хангадаг гэдэг. Манай судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн ихэнх нь эрхээ мэдэхгүй, баривчлах үед нь хэн ч ямар мэдээлэл, тайлбар өгөөгүй гэж хариулжээ. Хэргийг прокурорт шилжүүлсэн үеэс л, эсвэл шүүх хурлын өмнө л өмгөөлөгч авах эрхтэй гэж тэд боддог гэнэ.

Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд хууль зүйн туслалцаа авсан хүүхдүүдийн талаар статистик мэдээ байхгүй ч 2001 оны 4 дүгээр сард Хүний Эрхийн Үндэсний Комиссоос “Ганц худаг”-т хийсэн судалгаагаар тэнд хоригдсон хүмүүсийн 80 хувь, насанд хүрээгүйчүүдийн 60 хувь нь хууль зүйн зөвлөгөө аваагүй байсан нь илэрчээ. Үүний шалтгаан нь ихэнх хоригдогсад өмгөөлөгч авах эрхтэй гэдгээ мэддэггүй, эсвэл хоригдож байсан тул өөрийн өмгөөлөгчтэй холбоо барьж чадаагүй, тэднийг төлөөлөх хүн байгаагүй буюу өмгөөлөгчийн хөлсийг төлөх мөнгөгүй байсан гэж хариулжээ. Мөн судалгаанд хамрагдсан хүмүүс өмгөөлөгч авах, төлбөрийн чадваргүй нөхцөлд өмгөөлөгч томилуулах эрхтэй болохоо мэддэггүй гэв. Мөн хэрэгт холбогдсон хүүхдүүдийн эцэг эх ихэнх тохиолдолд хууль зүйн туслалцаа авах, үнэ төлбөргүй туслалцаа авах эрхтэй, ЭБША-нд эхнээсээ хууль зүйн төлөөлөгчтэй байхын ач холбогдлыг мэддэггүй гэв. “Хүний Эрх, Хөгжил Төв” ТББ-ын 2000 оны Хүний эрхийн тэмдэглэлд хоригдогсад эрхээ мэддэг ч хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч уг эрхээ эдлэхэд нь саад учруулдаг гэж тэмдэглэсэн байна.

Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд хүүхэд өмгөөлөгч авсан бол энэ нь ихэвчлэн хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийн сонгосон хүн байдаг. Сэжигтэн, яллагдагч өмгөөлөгч авах эрхтэй гэж хуульд заасан боловч тухайн хүүхдийн эцэг эх өмгөөлөгч хөлслөн авах боломжгүй бол хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч байцаалтад байлцах хүнийг шийддэг гэж олон хүн үздэг. Ихэнх тохиолдолд хүүхэд өмгөөлөгчтэйгээ байцаалтын үеэр л анх уулздаг ба үүнээс өмнө уулзаж ярилцах боломж олддоггүй байна. Зарим хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нар бүх хэрэгт 1-2 өмгөөлөгчийг л оролцуулах практик байдаг. Энэ нь өмгөөлөгчийн хараат бус байдлыг ноцтойгоор зөрчиж байгаа явдал ба хүүхдүүдийн хэлснээр ийм өмгөөлөгчид ихэнхдээ хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийн талд орж, хүүхдийн ашиг сонирхлыг зүй ёсоор хамгаалдаггүй байна. “Хүний эрх ба Хөгжил” ТББ-ын 2000 оны Тэмдэглэлд зарим өмгөөлөгчдийн албан тасалгаа нь хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурорын байранд байдаг тул цагдаа, прокурортой найрсаг харьцаа тогтоож байгаа нь олон нийтийн зүгээс тэдний хараат бус байдалд эргэлзэхэд хүрч байна гэжээ.

Шүүх хурлын үе дэх хууль зүйн туслалцаанд дээр дурдсан хүндрэл бэрхшээл мөн адил гардаг байна. Насанд хүрээгүй хүн өөрөө өмгөөлөгч аваагүй бол шүүгч өмгөөлөгчийг томилох үүрэгтэй байдаг. Ихэнх тохиолдолд өмгөөлөгчийг шүүх хурлын өмнөх өдөр л томилдог тул ийнхүү томилогдсон өмгөөлөгч шүүх хуралд зүй ёсоор бэлтгэж амждаггүй байна.

МННХ-гээс саяхан хийсэн судалгаанд хамрагдсан нийт өмгөөлөгчдийн 83 хувь нь төлбөрийн чадваргүй сэжигтэн, яллагдагч нар өмгөөлөгчөө өөрсдөө сонгож чаддаггүй гэжээ.

Монгол Улсад өмгөөлөгч авах боломж хомс, өмгөөллийн чанар тааруу байгаагийн нэг үндсэн шалтгаан нь эрх зүйн туслалцааны тогтолцоо төлөвшөөгүй байгаатай холбоотой гэж үзэж байна. Өмгөөллийн зардлыг хууль зөрчсөн насанд хүрээгүй хүн бүр

төлөх чадваргүй байдаг ба ихэнх өмгөөлөгчид ийм хүний өмгөөлөгчөөр оролцох сонирхол бага байдаг. МӨХ-ноос 2002 онд явуулсан судалгаагаар насанд хүрээгүй хүний өмгөөлөгчийн дундаж хөлс эрүүгийн хэрэгт 15,000-20,000 төгрөг байсан ба нийт хэргийн хагасаас илүү хувьд хөлс аваагүй байв. Өмгөөлөгчид төлбөрийн чадвар бүхий үйлчлүүлэгчид л чанартай үйлчилдэг. Хууль зүйн туслалцааны сангаас өмгөөлөгчийн хөлсийг төлөх баталгаа байхгүй, эсвэл төлдөг хөлс нь бага байдаг тул насанд хүрээгүй хүмүүст чанартай хууль зүйн туслалцаа үзүүлэх нь маш хязгаарлагдмал байдаг нь тус судалгаанаас харагдаж байна.

Төлбөрийн чадваргүй иргэний өмгөөллийн зардлыг жил бүр улсын төсөвт тусгаж баталдаг ч энэхүү зардлыг зөв, оновчтой захиран зарцуулах механизм үр дүнтэй хэрэгжихгүй байна. Өмгөөллийн зардлыг шүүхээр дамжуулж төлбөрийн чадваргүй иргэдийн өмгөөлөгчдөд төлөх ёстой байдаг. Гэтэл энэ мөнгийг шүүхийн ерөнхий зардалд зориулдаг байна. Мөн үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа авах эрх зөвхөн шүүх хуралдаанд л хамаардаг ба өмгөөлөгч нар хэргийг шүүх хурлаар авч хэлэлцсэн нөхцөлд л хөлсөө авдаг тул шүүхийн өмнөх шатанд оролцохоос зайлсхийдэг аж. Насанд хүрээгүй хүн хууль зүйн үнэ төлбөргүй туслалцаа авахын тулд харъяалах Засаг даргаас төлбөрийн чадваргүй болох тухай тодорхойлолтыг авах шаардлагатай байдаг.

Монгол Улсын Өмгөөллийн тухай шинэ хуулийн дагуу өмгөөллийн зардлыг ХЗДХЯ хариуцаж, Монголын Өмгөөлөгчдийн Холбоогоор дамжуулан олгох болсон аж. Хэдийгээр ХЗДХЯ өмгөөллийн зардалд 9 сая төгрөгийг төсөвлөсөн боловч орон нутагт хууль зүйн туслалцаа шаардлагатай байгаа хэргүүдийн жагсаалтыг МӨХ гаргаж өгөөгүйн улмаас тус мөнгийг зарцуулах боломжгүй гэнэ.

Эрх зүйн туслалцааны тогтолцоо нь зохих ёсоор хэрэгжихгүй байгаа ч насанд хүрээгүй хүнийг өмгөөлөх, хууль зөрчсөн хүүхдүүдэд дэмжлэг үзүүлж, зөвлөгөө өгч, сургалт, үнэгүй хууль зүйн туслалцаа үзүүлдэг олон төрийн бус байгууллага, өмгөөлөгчид байдаг.

Үнэлгээ ба зөвлөмж

Шинэ ЭБШХ-д насанд хүрээгүй сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчид холбогдох хэргийн ЭБША-ны бүх шатанд өмгөөлөгч заавал оролцуулахаар заасан нь насанд хүрээгүй хүний, нэн ялангуяа төлбөрийн чадваргүй хүүхдийн эрхийг хамгаалахад чиглэсэн чухал алхам болжээ. Насанд хүрээгүй хүүхдэд холбогдох хэргийн ЭБША-ны бүх шатанд өмгөөлөгчийг оролцуулах явдлыг шүүгч, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор нар хангах үүрэгтэй ч энэ нь цаасан дээрх заалт төдий байсаар байна.

Насанд хүрээгүй цөөн тооны хүн л хараат бус өмгөөлөгчөөр эрхээ хамгаалуулсан ба цөөн тооны өмгөөлөгч л үйлчлүүлэгчийнхээ эрх ашгийг шударгаар хамгаалдаг болох нь хүүхдүүдийн ярианаас илэрхий байна.

ЭБША-ны бүх шатанд хараат бус өмгөөлөгчийг аль болох өргөнөөр оролцуулах нь ЭБША-г хүний эрхийг хүндэтгэж, хуулийн дагуу, шударгаар явуулахад зайлшгүй шаардлагатай юм. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд хараат бус өмгөөлөгчийг оролцуулах нь хүүхдийг хүчирхийлэл, албадлагаас хамгаалах, дарамт, шахалтаас урьдчилан сэргийлэх ач холбогдолтой юм. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд хараат бус өмгөөлөгчийг оролцуулах нь хүүхдийг баривчлах, цагдан хорих шийдвэр гаргах, хэрэгжүүлэх явцад хууль ёсыг сахиулахад мөн чухал. Учир нь ЭБШХ-д заасны дагуу ийм тохиолдолд шүүхэд нотлох баримт гаргаж өгөх эрх, үүргийг сэжигтэн, яллагдагчид бус, харин түүний өмгөөлөгчид олгосон байдаг.

Тиймээс, хараат бус өмгөөлөгч авах хүүхдийн эрхийг хангахад хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүхээс тодорхой хүний нэр зааж тулгахыг хориглосон ЭБШХ-ийн заалтыг зохих ёсоор хэрэгжүүлэх шаардлагатай байна. Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийн сонгон томилсон өмгөөлөгч, үйлчлүүлэгчийн хооронд шаардлагатай байдаг итгэл, нууцын харилцаа тогтохгүй. Үйлчлүүлэгч хүүхдэд ч түүний өмгөөлөгч хүүхдийн талд байх төдийгүй ямагт түүний ашиг сонирхлын төлөө ажиллаж, тэдний эрхийг хамгаалах болно гэдэгт итгэлтэй байх ёстой.

Өмгөөлөгч авах эрхийг тайлбарласан болон өмгөөлөгчийг хэрхэн хөлсөлж болох тухай мэдээлэл (үүнд, жишиг хөлс, хууль зүйн туслалцааг үнэ төлбөргүй авах, МӨХ, түүний орон нутгийн салбарууд, хууль зүйн клиник сургалтын төвүүд, хууль зүйн зөвлөгөө үнэгүй өгдөг ТББ-уудтай холбоо барих мэдээлэл г.м.) бүхий товхимлыг боловсруулж, хүүхэд, эцэг эхийн хүртээл болгох нь өмгөөлөгч авах эрхийг жинхэнэ утгаар нь хэрэгжүүлэхэд чиглэсэн нэгэн арга хэмжээ юм. Жишээ нь, цагдаагийн хэлтэс нь баривчлагдсан, эсхүл түр саатулагдсан хүүхдэд энэхүү товхимлыг өгөх нь зүйтэй.

Өмгөөлөгч нар өмнөх тогтолцоонд прокурор, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нартай харьцуулахад харьцангуй билэгдлийн шинжтэй байж, тэнцүү бус байр суурьнаас шүүн таслах ажиллагаанд оролцдог байсан тул орчин үед тэдний насанд хүрээгүй хүнийг өмгөөлөх ур чадварыг нь сайжруулахад чиглэсэн сургалт семинарыг зохион байгуулахыг холбогдох хүмүүс санал болгодог. Монгол Улс мэтгэлцэх зарчмыг хууль тогтоомждоо тусгасан өнөөгийн нөхцөлд өмгөөлөгчдийн үйлчлүүлэгчийнхээ эрх ашгийг төлөөлж хамгаалахад гүйцэтгэх үүрэг, ач холбогдол улам өсөн нэмэгдэх болно. АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлагийн санхүүжилт бүхий Шүүх эрх мэдлийн шинэтгэлийн хөтөлбөр, Монголын Өмгөөлөгчдийн Холбоо, Хууль тогтоомж, шүүх эрх мэдлийн эрдэм шинжилгээ, сургалт, мэдээлэл, сурталчилгааны үндэсний төв (“Хууль зүйн үндэсний төв”) зэрэг байгууллагуудаас хуульчийн мэргэжлийн ёс зүй, мэтгэлцэх ур чадварын сэдвээр сургалтыг зохион байгуулж ирлээ. Энэ ажлын хүрээнд өмгөөлөгч насанд хүрээгүй хүнийг өмгөөлөх холбоотой онцлог ур чадвар, үүрэг, ач холбогдлын тухай төрөлжсэн сургалтыг зохион явуулах нь зүйтэй гэж үзэж байна. Улмаар сургалтад оролцогчдод тусгай гэрчилгээ олгох замаар насанд хүрээгүй хүний хэргээр мэргэшсэн өмгөөлөгчдийг цаашид бий болгож болох юм.

Бас насанд хүрээгүй хүүхдэд хууль зүйн туслалцаа үзүүлдэг өмгөөлөгч, ТББ-ын ажилтнууд, хуулийн ангийн оюутнуудад зориулан тусгай гарын авлагыг боловсруулах саналтай байна. Ийм гарын авлага нь насанд хүрээгүй хүнтэй холбоотой олон улсын болон дотоодын хууль тогтоомжийг танилцуулахаас гадна насанд хүрээгүй хүнийг ЭБША-нд үр өгөөжтэй төлөөлж өмгөөлөх ур чадвараас зааж болох юм. МӨХ болон Хууль зүйн үндэсний төв хоёр ийм гарын авлагыг боловсруулахаар оролцоход бэлэн буйгаа илэрхийлсэн болно.

Төлбөрийн чадваргүй иргэний өмгөөллийн зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэхэд учирдаг хүнд суртлын саад бартааг арилгах, төлбөрийн чадваргүй тохиолдолд үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа авах хүүхдийн эрхийг баталгаажуулах, өмгөөлөгчийн ажлынхаа хөлсийг авах эрхийг хангах шаардлагатай байна. Гэхдээ энэ асуудлыг эрх зүйн туслалцааны тогтолцоог бүхэлд нь өөрчлөн шинэчлэхгүйгээр шийдвэрлэх боломжгүй юм. Саяхан МННХ-гээс явуулсан эрх зүйн туслалцааны тогтолцооны үнэлэх судалгааны ажлын тайланг бид бүхэнд тараалаа. Энэхүү Тайланд төрөөс томилогдож, ниймгийн эмзэг бүлгийн хүмүүст хууль зүйн туслалцаа үзүүлэх орон тооны байнгын өмгөөлөгчийн тогтолцоо бий болгохыг зөвлөсөн байна. Эрх зүйн туслалцааны тогтолцооны асуудлыг аль ч хэлбэрээр шийдвэрлэсэн ч хууль зөрчсөн хүүхдийг өмгөөлөгчөөр хангах асуудал нь нэн түрүүнд тавигдах ёстой.

Анхаарал тавьсанд баярлалаа.

ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОГЧДОД ХУУЛЬЗҮЙН ТУСЛАЛЦАА ҮЗҮҮЛЭХ АСУУДАЛ

*Хүчирхийллийн эсрэг үндэсний
төвийн захирал Ц. Энхжаргал*

1. Гэмт хэргийн хохирогчдод эрхзүйн туслалцаа үзүүлж буй өнөөгийн байдал болон практик

Гэмт хэргийн улмаас хохирсон хохирогчийн эрх ашиг бүрэн гүйцэд хангагдахгүй, хамгаалалтгүй байгаа явдал нийгмийн тулгамдсан, төрийн шийдэл шаардсан асуудлын нэг байсаар байна. Эмзэг хохирогчдод хуульзүйн болон сэтгэлзүйн

туслалцаа дэмжлэг үзүүлж ирсэн байгууллагынхаа 8 жилийн туршлага дээр үндэслэн дүгнэхэд хохирогчийн эрх хангагдах эсэх нь үндсэндээ 3 хүчин зүйлээс шууд хамааралтай байна гэж хэлж болохоор байна.

1.Өөрийнх нь эрх ашгийг бүрэн гүйцэд хамгаалахад туслах өмгөөлөгчийг хөлслөх санхүүгийн боломжоос

2.Хохироосон этгээд нь төлбөрийн чадвартай болон хохирлоо барагдуулах чин хүсэл эрмэлзэлтэй эсэхээс

3.Хэргийг шийдвэрлэж буй хуулийн ажилтны хандлагаас

Дүгнэн хэлбэл дээрх гурван хүчин зүйлийн цаана тогтолцооны асуудал хөндөгдөж байна.

Дээрх дүгнэлтээ бататгахын тулд баримт түшиж ярихыг хүсч байна. 2003 онд МННХ-ийн санхүүжилтээр Гэмт хэргийн хохирогчийн эрхзүйн хамгаалалт төслийн хүрээнд төслийн баг болон ЦЕГ, ХЭҮТ-ийн захиалгаар ШУА-ийн Эрхзүйн философи,социологийн хүрээлэнгээс хэрэг бүртгэлт,мөрдөн байцаалт,шүүх болон шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн шатанд хэргээ хөөцөлдөж буй 800 хохирогчоос авсан судалгааны зарим дүнгээс танилцуулья.

- Хууль хяналтын байгууллагад хандах явцад хохирогчдод тохиолддог бэрхшээлтэй зүйл нь эрүүгийн процессийн талаар мэдлэггүй байх явдал хэмээн судалгаанд оролцсон хохирогчдын 92.7 хувь нь хариулсан байна. Үүнээс үзэхэд хуулийн байгууллага иргэддээ хуулиар үйлчлэх тогтолцоонд шилжээгүйгээс,өөрөөр хэлбэл бүтэц,тогтолцоо, хандлага,арга барил өөрчлөгдөөгүйгээс шалтгаалан эдгээр байгууллагын шат дамжлага,хүнд суртлаас бэргэн цэрвэж мэдээ мэдээлэл хүлээн авах болон хэргийн талаар тайлбар хийх үндсэн эрхээ хохирогч эдлэх нь хангалтгүй байгаа нь харагдаж байна. Хохирогчийн эрхээ мэдэж авсан арга замыг сонирхоход судалгаанд оролцсон хохирогчдын 42.7 хувь нь буюу бараг 2 хүн тутмын 1 нь эрхийнхээ талаар бусдаас дам сонсож,хүнээр яриулсан гэсэн байна.

Хохирогч хамгийн түрүүнд ЦБ-д очиж гэмт хэрэгт өртсөн тухайгаа мэдээлдэг. Тиймээс хохирогчид анхны мэдээлэл хүргэх байгууллага нь цагдаа. Гэтэл судалгаанд оролцсон 5 хүн тутмын 1 нь л цагдаагийн ажилтан танилцуулснаар эрхээ мэдэж авсан хэмээн хариулсан байгаа нь хангалтгүй үзүүлэлт гэж хэлж болохоор байна. Хохирогчийн мэдээлэлд хүрэх хамгийн эхний суваг нь цагдаагийн байгууллага учраас хохирогчид түүний эрх болон олгогдсон боломжийн талаар мэдээлэх үндсэн үүргийг цагдаад бий болгох шаардлагатай байна. Хохирогчдод түүний эрхийн талаар мэдүүлэх үүргийг цагдаа, шүүгч , прокурор хүлээх ёстойг хуулинд нарийвчлан зааж өгөөгүй тохиолдолд эдгээр практик ажилтнуудад хуулийн заалтыг бүрэн хүлээн авах сэдэл байхгүй байхаас гадна үүнийг хэрэгжүүлэх итгэл үнэмшил ч бага байх болно. Үүнээс гадна практик ажилтнууд эдгээр заалтыг мэддэг байсан ч мэдэгдэхүйц хэмжээнд тэдгээрийг үл тоомсорлон харгалзахгүй байдаг бололтой.

Хохирогчийн мэдээлэлд хүрэх өөр нэгэн суваг бол өөрийнх нь өмнөөс хэрэгтэй нь танилцаж, мэргэжлийн туслалцаа үзүүлэх өмгөөлөгч авах явдал юм. Мэргэжлийн эрхзүйн туслалцаа авах энэ боломжоо хохирогчид хэр эдэлж байгааг дээрх судалгаагаар тандахад судалгаанд оролцсон хохирогчдын 72.8 хувь нь өмгөөлөгч аваагүй байна. Үүнийхээ шалтгааныг:

- Авах шаардлагагүй хөнгөн хэрэг 35.3

- Санхүүгийн бололцоогүй 22.8

- Авсан аваагүй ялгаагүй,өмгөөлөгчид ажилладаггүй хэмээн итгэл алдарсан 19.2 хувь нь үзжээ.

- Үлдсэн хувь нь өөрийгөө өмгөөлөх чадвартай,танил хуулийн ажилтнаас зөвлөгөө авсан,гэмт хэрэгтэн тодорхойгүй,шүүхээр шийдвэрлэгдэх болоогүй,өмгөөлөгч яаж авах,хэрхэн хандахаа мэдэхгүй хэмээн тус тус тайлбарласан байна.

- Түүнчлэн өмгөөлөгчийг тулгаж өгдөг гэж хохирогчдын 8.5 хувь нь хариулжээ

Хохирогчид өмгөөлөгч авах эсэхэд

1. Хэргийн төрөл,хүнд,хөнгөн,хохирлын хэмжээ, хэргийн байдал
2. Мөнгөн санхүүгийн бололцоо нөлөөлөх гол хүчин зүйл болж байна.

Түүнчлэн өмгөөлөгчид үл итгэх, тэдний талаарх таагүй ойлголт, өөрөөр хэлбэл өмгөөлөгчид ажилладаггүй,хэргийн эцсийн үр дүнг дуустал тууштай явдаггүй гэсэн ойлголт нийтлэг байгаа нь гуравдагч хүчин зүйл болж байна.

II. Гэмт хэргийн хохирогчдод эрхзүйн туслалцаа үзүүлэх тогтолцоог боловсронгуй болгоход чиглэгдсэн практик алхмууд

Өнөөгийн тогтолцоонд хэрэгт холбогдогч хохирогчийг цохисон эсэх, хэрэв цохисон бол ямар шийтгэл оногдуулах вэ? гэдгийг шийддэг болохоос хохирол төлөгдсөн болон хохирогчийн эрх ашиг хангагдсан эсэх нь тийм ч чухал бус байгаагаас хуулийн ажилтнууд хохирогчийн сэтгэлзүй рүү өнгийхгүй, тэдний байр суурийг бүрэн гүйцэд ойлгодоггүй, ойлгохыг ч хүсэхгүй байна.

Хэрэгтэн болон улсаас нөхөн төлбөр төлүүлэх үндсэн эрх болон түүнийг хэрэгжүүлэх механизм оновчтой хуульчлагдаагүй байна..

Цаашид нөхөн төлбөр ба хохирол барагдуулалтын хариуцлагыг төр хариуцдаг болгож үндэсний хэмжээний сан бүрдүүлэх, хохирогчдод ээлтэй эрхзүйн орчинг боловсронгуй болгохын тулд үе шаталсан тодорхой өөрчлөлтүүдийг хийх шаардлагатай байна.

Хохирогчтой хамгийн түрүүнд нүүр тулан уулздагийн хувьд Цагдаагийн байгууллага, гэмт хэргийн хохирогчийн тодорхой хувийг эзэлдэг гэр бүлийн болон бэлгийн хүчирхийллийн хохирогсдын эрх ашгийг хамгаалахын төлөө үйл ажиллагаа явуулдаг байгууллагын хувьд ХЭҮТ хамтран эхний алхмуудыг хийж эдгээр өөрчлөлтөнд хуулийн болон бусад холбогдох байгууллагуудыг уриалан өдөөх хүсэл эрмэлзэлтэйгээр МННХ-ийн санхүүжилтээр Гэмт хэргийн хохирогчийн эрхзүйн хамгаалалт туршилтын төслийг хэрэгжүүлж байна. Гэмт хэргийн хохирогчид бусад байгууллагаас илүү Цагдаагийн байгууллагад хандах нь илүү тул гэмт хэргийн хохирогсдод хандах Цагдаагийн хариу үйлдэл маш чухал. Цагдаагийн ажилтан нь гэмт хэрэг үйлдэгдсэний дараа газар дээр нь хамгийн түрүүнд авагдах хариу үйлдлийг үзүүлдэг тул төслийн үйл ажиллагаа Цагдаагийн байгууллагад голлон төвлөрч явагдана.Гэмт хэргийн хохирогчийн эрхзүйн хамгаалалтын үр дүнтэй тогтолцоог бий болгоход чиглэсэн эхний алхмуудыг Сүхбаатар дүүргийн Цагдаагийн хэлтсээс эхлэн туршиж байна.

Төслийн зорилго:

1. Эрүүгийн эрхзүйн систем дэх хохирогчийн байр суурь ямар түвшинд байгааг илрүүлэн гаргаж шийдвэр гаргагчид, хууль тогтоогчдын сонорт хүргэх
2. Гэмт хэргийн хохирогчдод үзүүлдэг туслалцааг сайжруулах
3. Цагдаагийн байгууллага болон харилцагч талуудаас бүрдсэн ажлын хэсгийг бий болгож мэргэшүүлэх замаар хамтын ажиллагааг хөгжүүлэх.

Зорилгодоо хүрэхийн тулд:

Гэмт хэргийн хохирогчдоос авах судалгаа - Гэмт хэргийн хохирогчдын байр суурь, хэрэгцээ шаардлага, өнөөгийн байдлыг судлах зорилгоор хэрэг бртгэлт,мөрдөн байцаалт,шүүх, шийдвэр гүйцэтгэлийн шатанд хэргээ шийдвэрлүүлэхийг хүлээж буй хохирогчдоос санал асуулгын болон ганцаарчилсан ярилцлагын аргаар судалгаа аваад байна.

Ингэснээр тэдний хуулийн байгууллагад хандсаны дараахь сэтгэл ханамжийн байдал, байр суурь, хэрэгцээ шаардлагын талаар өнөөгийн дүр төрхийг илэрхийлсэн дүгнэлт гарахад бэлэн болоод байна.

Сургалт- Эхний ээлжинд Сүхбаатар дүүргийн Цагдаагийн хэлтсийн анхан шатны нэгж дээр ажиллаж байгаа хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, хэсгийн байцаагчдад сургалт явуулна. 50 хүн оролцоно. Цагдаагийн байгууллага шат дараалсан бүтэцтэй учир 2 дахь шатанд Цагдаагийн удирдлагуудыг сургалтанд хамруулна. Сургалтыг Цагдаагийн ажилтан, гэмт хэргийн хохирогчдод ямар үйлчилгээ, хариу үйлдэл үзүүлэх гол чиглэл, удирдамжинд нийцүүлэн явуулна. Сургалтын агуулга нь хохирогчийн асуудлыг хэрхэн шийдвэрлэх, ямар үйлчилгээ үзүүлэх, түүнд яаж хандах талаарх сэдвүүдээс бүрдэх ба Цагдаагийн ажилтнуудын хохирогчтой холбоотой ажил үүрэгт хандах сөрөг байр суурийг багасгахад чиглэгдэнэ. Ингэснээр Цагдаагийн ажилтнууд хохирогчтой ажиллахдаа тэднийг сонсож, хүндэтгэн харьцах, мөрдөн байцаах ажлынхаа талаар болон тэдэнд авч болох тусламж, үйлчилгээнийхээ талаар мэдээллээр хангах чадварыг эзэмшүүлэхээр зорьж байна.

Мэдээлэл түгээх

Мэдээлэл түгээх нь аман болон бичгэн гэсэн 2 хэлбэрийг хослуулах замаар хийгдэж байна.

Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд хэрэг нь байгаа хохирогчдод эргэж мэдээлэх зорилгоор Сүхбаатар дүүргийн Цагдаагийн хэлтэст гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ахлах байцаагч гэх мэт 3-4 хүний ажил үүргийн хуваарьт нь нэмэлт оруулж, нийслэлийн Цагдаагийн газрын даргын тушаалаар баталгаажуулаад байна. Эдгээр ажилтнуудыг удирдлага чиглэлээр хангах нэг ажилтан ажиллаж байна

Мэдээлэл өгөх ба хүлээн авах цэг дээр холбогдох ТББ-ын төлөөлөгчид болон өмгөөлөгч, хуулийн сургууль дээрх клиникийн оюутнууд тодорхой графиктайгаар, тодорхой гэрээтэйгээр үйлчлэх суурь тавигдаад байна.

Хохирогсдод үйлчилгээ үзүүлэхэд чиглэгдсэн дотоод процедурыг тодорхой болгоно.

Хохирогчдод үйлчилгээ үзүүлдэг болгох болон үзүүлж эхэлж буй үйлчилгээгээ сайжруулахын тулд Сүхбаатар дүүргийн Цагдаагийн хэлтэс нь дотоод процедураа тодорхой болгож өгнө. Үүний тулд цагдаагийн ажилтны зүгээс хохирогчидтой хэрхэн хүндэтгэн харьцах, тэднийг хэрхэн мэдээллээр хангах зэрэг асуудлыг нарийвчлан тусгасан шинэ журмыг боловсруулан үйл ажиллагаандаа мөрдөнө. Энэхүү шинэ журмыг боловсруулахдаа уг асуудлыг дотоод процедуртаа яаж тусгадаг, хэрхэн хэрэгжүүлдэг, хэрэгжилтээ яаж үнэлдэг талаарх бусад орны туршлагыг судлан жишиг болгоно.

/Хохирогсдыг хүлээж авах үйлчилгээ үзүүлэх журам/

Цагдаагийн байгууллагад хохирогсдод мэдээлэл өгөх ба хүлээн авах кабинет бий болгоод байна.

Энэ кабинет нь хохирогч өөртөө хэрэгцээт анхан шатны мэдээллийг хурдан, хялбар авч болохоор зохион байгуулагдсан.

Эмзэг хохирогчдод зориулсан тусгай өрөө:

Сүхбаатар дүүргийн Цагдаагийн хэлтэс дээр нэг өрөөг камерын тусламжтайгаар мэдүүлэг авах өрөөг тоноглоно. Энэ байр нь мөн сэжигтэн, яллагдагч хохирогчийг хараад танихаас урьдчилан сэргийлсэн нэг талаасаа харагддаг байх нөхцлийг бүрдүүлсэн маягаар тоноглогдоно.

8. Ажлын хэсэг

Ажлын хэсэг нь 9 хүнээс бүрдсэн. /Хуульзүй Дотоод Хэргийн Яам, Шүүх эмнэлэг, Монголын Өмгөөлөгчдийн Холбоо, Хуульзүйн дээд сургуулийн дэргэдэх Клиник сургалтын төв, Цагдаагийн Ерөнхий Газар, Нийслэлийн Цагдаагийн Газар, Сүхбаатар

Дүүргийн Цагдаагийн хэлтэс, дүүргийн Прокурор, Хүчирхийллийн Эсрэг Үндэсний Төвөөс тус бүр нэг хүний бүрэлдэхүүнтэй байна. Ажлын хэсгийн уулзалтыг сар тутам хийнэ.

Ажлын хэсгийг Нийслэлийн Цагдаагийн Газрын дарга ахална. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орсон төлөөллүүд цөм тухайн байгууллагынхаа удирдах шатны хүмүүс байх ба энэ нь төслийн үйл ажиллагааны үр дүн, амжилт нь урт удаан хугацаанд үргэлжлэхэд нөлөөлнө. Энэхүү ажлын хэсгийн зорилго нь төслийн үр дүнг нэмэгдүүлэх, олон талын үр ашигтай хамтын ажиллагааны уялдааг хангахад чиглэгдэнэ.

III. Цаашид анхаарах асуудлууд:

- Хохирогчдод хуульзүйн туслалцаа үзүүлэх, хамгаалахад чиглэгдсэн ажил үүргийг цагдаагийн алба хаагчийн ажил дүгнэх үзүүлэлтэд оруулах
- ТББ, олон нийтийн оролцоог эрхзүйн туслалцааны идэвхтэй нэг тал хэмээн хүлээн зөвшөөрөх.
- Хохирогчийг чадавхижуулахад чиглэгдсэн үйлчилгээний идэвхтэй загварыг нэвтрүүлэхэд анхаарах
- Хохирогчдод үйлчлэх төр болон төрийн бус байгууллагууд хамтран ажиллах сүлжээт тогтолцоог хэвшил болгох.

- Ямар төрлийн мэдээллийг ямар байгууллага хохирогчид хэзээ дамжуулах талаар тов тодорхой бодлого дутаж байна. Юуны түрүнд байгууллага болгонд тусгай үүрэг хариуцлага ноогдуулах

- Хохирогчтой анхны харилцааг хэрхэн тогтоохоос эхлээд хэрэг хэрхэн шийдвэрлэгдсэн талаарх мэдээллийг өгөх хүртэлх бүхий л үйл ажиллагааг журамлан зохицуулах шаардлагатай байна. Хохирогчийн хувь заяа ямар мэдлэг чадвартай, ямар хандлагатай хуулийн ажилтанд очсоноос шууд шалтгаалж байгааг арилгах

ХОРИГДЛУУДАД ХУУЛЬЗҮЙН ТУСЛАЛЦАА ҮЗҮҮЛЖ БУЙ ТУРШЛАГА

*Эмэгтэйчүүдийн хорих ангийн дарга,
Олон Улсын Засан Сайжруулах Холбооны
Монголын төвийн тэргүүн Р.Оюунбадам*

Энэ өдрийн зохион байгуулж байгаа үндэсний бага хуралд сэтгэл дүүрэн байна.

Засан сайжруулах холбоо нь хэсэг хуульчид, хорих байгууллагын ажилтнуудын санаачлагаар 2001 оны 10 дугаар сард байгуулагдаж Хууль зүйн яаманд бүртгүүлсэн, албан ёсны төрийн бус байгууллага мөн.

Холбооны нэрнээс нь хүртэл харахад хорих ял эдэлж байгаа хүмүүсийн эрхийг хамгаалах, засан хүмүүжүүлэх агуулгыг багтаасан болох нь ойлгомжтой гэж бодож байна.

Тус холбооны зорилго нь хоригдлын эрхийг хамгаалахад бүхэлдээ чиглэгдэнэ.

- НҮБ-аас баталж гаргасан “Хоригдолтой харьцах наад захын жишиг дүрэм” болон олон улсын бусад гэрээг хорих байгууллагуудад хэрэгжүүлэхэд туслах
- Монголын хорих байгууллагыг олон улсын жишигт ойртуулах, тэдний дэвшилттэй талыг нэвтрүүлэхийн тул мэдээлэл олж авах сургалт сурталчилгаа зохион байгуулах.
- Хорих байгууллагын дэлхийн хөгжлийн хандлагаас судлах, суралцах, бусад орны хорих байгууллагад хэрэгжиж байгаа дэвшилттэй туршлагаудаас өөрийн орны онцлогт тохируулан авч хэрэгжүүлэх гэх мэт зорилгууд тавьж байна.

Хууль зүйн шинэчлэлийн хүрээнд олон улсын засан сайжруулах байгууллагуудад шинчлэл, өөрчлөлтүүд нэвтрүүлэх хоригдолын боловсролын асуудалд анхаарлаа хандуулж, тэднийг нийгэмд буцаан өгөх, засан хүмүүжүүлэх байгуулгын ажилтнуудын боловсролд анхаарч өндөр мэдлэгтэй боловсон хүчнээр ЗХБ-ын эгнээг өргөтгөж байх талаар өргөн хүрээнд үйл ажилгаагаа явуулж байгаа олон улсын шоронгийн холбоонд 2001 оны 12-р сард монгол улсаас засан сайжруулах холбоо гишүүнээр элсэн орж 2 жилийн хугацаанд хамтын холбоо харилцаатай үйл ажилгаа явуулж байгаа нь бидэнд ихнөлөө өгч байна

Хууль зүйн туслалцаа авах эрхийн хэрэгжүүлэлтийг тодорхойлох нэг гол үзүүлэлт бол нийгмийн тодорхой бүлэг болох төлбөрийн чадваргүй ядуу иргэдийн хууль зүйн туслалцаа, эрхийн асуудлаар өнөөдөр ярилцаж байна.

Тэгвэл хорих ял эдэлж байгаа хүн бол нийгэмд гэмт хэрэг үйлдэж гэм хор учруулсаны төлөө эрх чөлөөгөө алдаж, эрхийн хязгаарлалын дор амьдарч байгаагийн хувьд дээрх катигорит нэгэн адил хамааруулан авч үзэх ёстой гэж бодож байна. Гэвч хорих ял эдэлж байх хугацаандаа хоригдол дахин давтан гэмт хэрэг үйлдэх, шүүх хурлаар асуудлаа хэлэлцүүлэх, өөрийн талаар хуулийн дээд байгууллагад хүртэл өргөдөл гомдлоо өгөх бүртээ хууль зүйн туслалцаа авах, өмгөөлүүлэх эрх нь амьдрал дээр хэрэгжихгүй байна.

Ийм учраас өнгөрсөн оны 9 дүгээр сард “Хорих байгууллага дахь хүний эрх” гэсэн сэдвээр төсөл бичиж Соросын санд оруулан дэмжлэг авсандаа бид баяртай байдаг.

Соросын сангийн төслөөр бид дараахь үйл ажиллагаа явуулж байна. Хамгийн нэгдүгээрт хоригдлуудад хууль зүйн зөвлөгөө өгөх, өмгөөлүүлэх эрхээр бага боловч хангаж байна.

1994 онд батлагдсан Хорих байгууллагын болоод Хорих ял эдлүүлэх хуулинд хоригдол хууль зүйн туслалцаа авах болон өмгөөлүүлэх эрхээр хангах тухай заалт орж, үүнээс хойш 1996 оны ШШБ тухай Монгол Улсын хууль, 2002 оны ШШГ тухай хуулиудад удаа дараалан дээрх заалтууд заагдсан хэдий ч өнөөг хүртэл энэ заалтыг жинхэнэ утгаар нь хэрэгжүүлээгүй байсан.

Иймд бүх хорихуудын дотроос эмэгтэйчүүдийн хорих болон насанд хүрээгүйчүүдийг сонгон авч эдгээр хорихуудад ял эдэлж байгаа 425 хоригдлын тусын тулд жилд 51 удаа нийт 928 цагаар 2 өмгөөлөгчийг ажиллуулж байна.

➤ Дашрамд хэлэхэд дэлхийн өндөр хөгжилтэй бусад орны Хорих байгууллагуудад сэтгэл зүйч, өмгөөлөгчийг байнга ажиллуулдаг туршлага байдаг. Тэгвэл Монголын хорих байгууллагууд үүсэж хөгжиж ирсэн 80 жилийн түүхэнд хорих газруудад сэтгэл зүйч, өмгөөлөгч ажиллуулж байсан туршлага байгаагүй гэж хэлж болно.

Нийт хорих ял эдэлж байгаа хүмүүсүүдийн дотроос эмэгтэйчүүд, насанд хүрээгүйчүүд сэтгэл зүйн хэт их хямралд орсон байдаг ба үүнээсээ шалтгаалан дахин давтан гэмт хэрэг үйлдэх, амиа хорлохыг завдах, өөрийнхөө бие эрхтэнд гэмтэл учруулах, өвчлөх зэрэг сөрөг үзэгдлүүд гардаг учир эдгээр хорих анги дахь хоригдлуудын 50-100 хувийг хамааруулан сэтгэл зүйн зөвлөгөө өгөгдөж байна.

Сэтгэл зүйн зөвлөгөө нь тухайн хоригдлыг сэтгэл зүйн хямрал, дарамтаас салгаж аливаа асуудалд эрүүл саруулаар сэтгэн бодоход нь туслах юм. Дээрх хорихуудад мэргэжлийн хоёр сэтгэл зүйчдийг ажиллуулаж 495 хоригдлыг хамааруулан өмгөөлөгчдийн нэгэн адил жилд 51 удаа 928 цагаар байнга ажиллаж байна.

Хоригдлын чөлөөт цагийг зөв өнгөрүүлэх, тэдэнд мэдлэг олгох зорилгоор хоригдлуудын дунд явуулын номын сан ажиллуулж байна. Эдгээр номын сангуудад хүний эрх, шинэ хууль тогтоомжууд, эмхтгэл гарын авлага, уран зохиолын номууд тодорхой байр суурийг эзэлж байна.

Төслийн хүрээнд хоёр ч удаа 3600 ширхгээр 6 төрлийн гарын авлага товхимол бэлдэж бүх хорих ангиудад хүргүүлсэн. Төслийн хүрээнд Засан сайжруулах холбоо өөрийнхөө холбооны үйл ажиллагаа явуулах гадаад харилцаагаа өргөжүүлэх зорилгоор компьютерийн фондтой болоод байна. Хорих ангиудад хоригдлын эрх хэрхэн зөрчигдөж байгаа болон түүнийг арилгах, цаашдаа ажлын арга барилдаа авч ашиглах зорилгоор хоригдлын эрхийн зөрчлийн талаар тоо баримт цуглуулан баримтжуулах судалгааны ажил хийгдэж байна.

Энэ судалгаанд

- эмэгтэйчүүдийн хорихын 305,
- насан хүрээгүйчүүдийн 108, бүгд 413 хоригдол, 513 ажилтанд орон нутгийн болон харьяаллын 1200 иргэд оролцож байна. Судалгааны гол зорилго ялтнуудын ямар эрх нь илүү зөрчигдөж байгааг судлан илрүүлж зөрчлийг арилгахад оршиж байгаа юм. Судалгааны дүнгээс хархад дараах эрхүүд илүү зөрчигддөг тухай ялтнууд хариулж байна.

- Судалгаанд оролцсон ялтны 90 гаруй хувь нь хууль зүйн туслалцаа авмаар байна, өргөдөл гомдлоо яаж гаргах, хэнд хандхаас эхлээд наад захын юм мэдэхгүй байна гэлээ. Мөрдөн байцагчаасаа өмгөөлүүлэх эрхээр хангагдаж чадахгүй байна гэв.

- Сэтгэл санааны хүнд хямралтай байна. Ер нь бусад орны туршлагаас үзэхэд өөрийн амьдралаас дэлгэрэнгүй ярих

- Эрүүл мэндээ хамгаалуулах тухай мөн судалгаанд оролцогчдын их нь сэтгэл дундуур байгаа. Мөрдөн , дамжин хорих өвчин хугацаа алддаг, өвчинөө бүрэн эдгэртэл эмчлүүлж чадахгүй

- Судалгаанаас үзэхэд ял эдлэж байгаа нийт эмэгтэйчүүдийн 50-иас илүү нь бэлгийн зам, эмэгтэйчүүдийн өвчтэй

- Нийгмийн болон зах зээлийн амьдралын мэдээлэл хангалттай авч чадахгүй байна.

- Ном болон өдөр тутмын хэвлэлээр хангагдахгүй

- Хэрэгт орхын өмнө байсан амжиргааны болон эд хөрөнгөө хамгаалуулж чадахгүйгээс суллагдсаны дараа амьдрах нөхцөл муу байна.

- Сурах, мэргэжил эзэмших эрх хангалтгүй байна гэжээ.

Энэхүү судалгааны үр дүн болон Олон Улсын Шоронгийн холбооноос ирүүлж байгаа мэдээ, мэдээлэл тэндээс гаргадаг News ICPA сэтгүүл, Ази номхон далайн хорих байгууллагуудын удирдах ажилтны бага хурлын материалуудыг нийтэлдэг News Letter сонин, Финлянд улсын Шорон ба эмэгтэйчүүд, шорон ба гэмт хэрэгтнүүд зэрэг сэтгүүлүүд, мөн ОХУ-ын Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллагуудын дэвшилтэд туршлагаадаас орчуулан гарын авлага номонд оруулахаар бэлдэж байна.

Бид төслөө амжилттай хэрэгжүүлснээрээ хүний эрхийн салшгүй хэсэг болох хоригдлын эрхийг хамгаалах, олон нийтэд хорих байгууллагын талаар, хүний эрхийн талаар ойлголт өгөх, хоригдолд тодорхой мэдлэг хүмүүжил олгож тэднийг нийгэмд сайн иргэд болон төлөвшүүлэхэд хувь нэмрээ оруулах юм.

Монголын хорих байгууллага дэлхийн бусад орны хорих байгууллагын дэвшилтэй туршлагаас суралцахгүйгээр, тэдгээр орнуудтай хамтран ажиллаж харилцан туслалцахгүйгээр, хорих ял эдлүүлэх хэцүү бөгөөд нарийн асуудлыг дан ганцаараа шийднэ гэж үзвэл үнэхээр өрөөсгөл болно.

Тухайлбал хоригдлын зан байдал, хийсэн хэргээс нь шалтгаалж нарийн ялгамжтайгаар ял эдлүүлдэг, тэднийг иргэншүүлэхийн төлөө их зүйлийг хийж байгаа бусад орны туршлагаас суралцаж, ажил амьдралдаа хэрэгжүүлэх хугацаа аль хэдийнээ болчихоод байна.

- Гэмт хэрэг өсөх хандлагатай байгаа өнөө үед хэрэгтэнгүүдэд хорих ялыг биечлэн эдлүүлдэг хорих ангиуд зөвхөн олон хүний бөөгнөрлийн газар байж таарахгүй. Эндээс юу хэлэх гээд байна вэ? гэвэл тэднийг ял эдэлж байгаа хугацаанд тархи толгойд нь юм бодуулж, гэм буруугий нь ойлгуулж, гэмшихэд нь төрийн бус байгууллагын болон олон нийтийн оролцоо юу юунаас илүү хэрэгтэй байна.
- Зөвхөн эмэгтэйчүүдийн болон насанд хүрээгүйчүүдийн хорихоор хязгаарлах бус ер нь монголын бүх хориход сэтгэл зүйч, өмгөөлөгч ажиллуулах нь үнэхээр хэрэгтэй байна.
- Хоригдлын доторхи сургалт, хүмүүжлийн ажил ч доогуур төвшинд байгаа учраас их зүйлийг хийж болмоор бодогдож байна. Тухайлбал: Хууль зүйн Клиник сургалтыг хорих ял эдлэж байгаа ялтнуудын сургалт хүмүүжлийн ажилд өргөнөөр зохион байгуулах нь чухал байна.

- Товчоор хэлбэл ял эдэлж байгаа хүний ялын хугацаа тодорхой бөгөөд богинохон юм.

Хамгийн гол нь өнөөдөр ялтан байгаа хүн маргааш нийгэмдээ эргэн очиж бидний дунд ажиллаж амьдрах учраас тэдний амьдрах эрх зүйн орчныг нь ял эдлэж байгаа үед нь бүрдүүлэх нь бидний гол зорилго мөн. Ийм учраас хүний эрхийн чиглэлээр ажиллаж байгаа төрийн бус байгууллагууд төрдөө туслах зорилгоор ажиллаж байдаг учраас өөр хоорондоо нэгдэж хамтран ажиллавал зохих үр дүнд хүрнэ.

ХУРАЛ ДЭЭР ТАРААГДСАН СУРВАЛЖ МАТЕРИАЛУУД

«ТӨЛБӨРИЙН ЧАДВАРГҮЙ ИРГЭДЭД
ХУУЛЬ ЗҮЙН ТУСЛАЛЦАА ҮЗҮҮЛЭХ ТОГТОЛЦОО»

НӨХЦӨЛ БАЙДЛЫН СУДАЛГАА

Судалгааны багийн бүрэлдэхүүн

М.Ичинноров	Эрхзүйн шинэтгэлийг дэмжих хуульчдын төвийн тэргүүн
Б.Цэвээн	ХЗДХЯ-ны өмгөөллийн асуудал хариуцсан ахлах ажилтан
Д.Оросоо	Глоб Интернэшнл ТББ-ын ажилтан

Агуулга

1. ОРШИЛ
2. ХУУЛЬ ЗҮЙН ТУСЛАЛЦАА ҮЗҮҮЛЭХ АСУУДАЛ
3. ЭРҮҮГИЙН ХЭРЭГТ ХУУЛЬ ЗҮЙН ТУСЛАЛЦАА ҮЗҮҮЛЭХ АСУУДАЛ
 - Эрүүгийн хэрэгт үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа үзүүлэх үйл явц
 - Гэмт хэргийн хохирогчдод үзүүлэх хууль зүйн туслалцаа
4. ИРГЭНИЙ ХЭРЭГТ ТӨЛБӨРИЙН ЧАДВАРГҮЙ ИРГЭДЭД ХУУЛЬ ЗҮЙН ТУСЛАЛЦАА ҮЗҮҮЛЭХ АСУУДАЛ
5. НИЙТИЙН ЭРХ ЗҮЙН ХҮРЭЭНД ҮНЭ ТӨЛБӨРГҮЙ ХУУЛЬ ЗҮЙН ТУСЛАЛЦАА АВАХ ЭРХИЙН БАТАЛГАА, ХЭРЭГЖИЛТИЙН БАЙДАЛ
 - Үндсэн хуулийн эрх зүй
 - Захиргааны хэрэг, маргаан
 - Олон улсын эрх зүй
6. ХУУЛЬ ЗҮЙН ТУСЛАЛЦАА ҮЗҮҮЛЭХ БАЙГУУЛЛАГЫН ТОГТОЛЦОО
 - Хууль зүйн туслалцаа үзүүлэх асуудлыг хариуцсан төрийн захиргааны төв байгууллага
 - Монголын Өмгөөлөгчдийн Холбоо
 - Бүх шатны шүүх
 - Цагдаа, Прокурорын байгууллага
 - Төрийн бус механизм
7. ХУУЛЬ ЗҮЙН ҮНЭ ТӨЛБӨРГҮЙ ТУСЛАЛЦААНЫ САНХҮҮЖИЛТ
8. ӨМГӨӨЛӨГЧИЙН ХҮРЭЛЦЭЭ БА ХУУЛЬ ЗҮЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР
9. ЭМЗЭГ БҮЛГИЙН ХҮМҮҮСТ ҮЗҮҮЛЭХ ХУУЛЬ ЗҮЙН ТУСЛАЛЦАА
10. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Оршил

Монгол Улсад 1990 онд өрнөсөн ардчилсан хувьсгалын үр дүнд тоталитари дэглэмийг халж, хүний эрх, эрх чөлөөг дээдэлсэн иргэний нийгэм байгуулах үйл явц эхэлж, 1992 онд батлагдсан, ардчилалын үзэл баримтлалыг гүн шингээсэн, шинэ Үндсэн хуулиар хүний үндсэн эрх, эрх чөлөөг тунхаглан баталгаажуулсан юм.

Монгол Улсын Үндсэн хуульд (1992) шүүхэд гомдол гаргах замаар эрхээ хамгаалуулах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг, эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах, нотлох баримтыг шалгуулах, шударга шүүхээр шүүлгэх иргэдийн эрхийг тунхаглан заасан байдаг. Эдгээр чухал эрхүүд зөрчигдөж байгаа эсэхэд өмгөөлүүлэх эрхийг хэрэгжүүлэхгүйгээр хяналт тавих боломжгүй юм. Иймээс дараахь байдлаар өмгөөлүүлэх эрхийг хууль тогтоомжоор баталгаажуулж өгчээ. Тухайлбал, Үндсэн хуулийн 55 дугаар зүйлд өөрийгөө өмгөөлөх болон хууль зүйн мэргэжлийн туслалцаагаар хангагдах шүүгдэгчийн эрхийг тунхагласан бол Эрүүгийн байцаан шийтгэх хуульд гэмт хэрэг үйлдсэн явдалд сэжиглэгдсэн, албадан саатуулагдсан буюу байцаагдах үеэс өмгөөлөгч оролцох тухай зааж сэжигтэн, яллагдагч өмгөөлөгчийг өөрөө буюу тэдний зөвшөөрснөөр, хүссэнээр төрөл садны хүмүүс, хууль ёсны төлөөлөгч нь сонгон авна гэж өмгөөлөгчөө сонгож авах эрхийг баталгаажуулсан байна. Хэрэв өмгөөлөгчөө сонгон аваагүй бол түүний хүсэлтээр хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүх энэ эрхийг нь хангах бөгөөд өмгөөлөгчөө сонгоход нь тодорхой хүний нэр зааж тулгах замаар өмгөөлүүлэх эрхэнд нь халдахыг хориглосон. Түүнчлэн заавал өмгөөлөгч оролцуулах хэргийг хуульчилж өгсөн байдаг.

Өмгөөллийн тухай болон шүүхийн тухай хуульд дээрх зарчмыг дэлгэрүүлэн хуульчилж баталгаажуулан өмгөөлүүлэх эрхийн тухай заалт, зарчим нь олон улсын хэм хэмжээ, жишгээс нэг их зөрөхгүй байгаа нь харагдаж байна. Хууль зүйн туслалцаа авах эрхийн хэрэгжилтийг тодорхойлох нэг гол үзүүлэлт бол нийгмийн тодорхой бүлэг болох төлбөрийн чадваргүй, ядуу иргэдийн хууль зүйн туслалцаа авах эрхийн асуудал юм. Өмгөөллийн тухай хуульд (1994) төлбөрийн чадваргүй иргэдийн өмгөөллийн зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэх тухай болон энэ зардлыг санхүүжүүлэх, тайлан тооцоо гаргах журмыг холбогдох эрх бүхий байгууллага тогтоохоор энэ эрхийг баталгаажуулж өгсөн. Гэвч практикаас харахад төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн туслалцаа үзүүлэх үйл ажиллагаанд зориулж улсын төсвөөс тодорхой хэмжээний хөрөнгө гаргадаг боловч энэ төсөв нь шүүх, Шүүхийн Ерөнхий зөвлөл болон ХЗДХЯаманд төвлөрч байгаагаас үл хамааран хүрэх ёстой хүндээ хугацаандаа хүрэх асуудал хангалтгүй байна. 2002 оны хаврын чуулганаар батлагдсан Өмгөөллийн тухай шинэчилсэн хуулиар өмгөөлөгч жилд 2 удаа төлбөрийн чадваргүй иргэнийг өмгөөлөх тухай шинэ заалт оруулсан нь энэ асуудалд ахиц гаргах алхам хийжээ.

Энэхүү судалгааны тайланд төлбөрийн чадваргүй иргэдэд үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа үзүүлэх асуудал өнөөдөр ямар түвшинд байгааг эрүү болон иргэний хэргийн хүрээнд, түүнчлэн гэмт хэргийн хохирогчид, эмзэг бүлгийнхэнд хэрхэн хүрч байгаа одоогийн байдлыг харуулахыг зорьсны зэрэгцээ энэ асуудалд зарчмын өөрчлөлт хийх хэрэгцээ, боломжийн талаар санал, зөвлөмж боловсруулан оруулсан болно.

Судалгааны баг энэхүү судалгааны тайланг 2002 оны 8-р сарын 1-ний дотор боловсруулсан тул шүүр эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагын үйл ажиллагааг тухайн үед зохицуулж байсан хуулийн заалтыг иш татаж ашигласныг дурдах нь зүйтэй гэж үзэж байна.

ХУУЛЬ ЗҮЙН ТУСЛАЛЦАА ҮЗҮҮЛЭХ АСУУДАЛ

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14 дэх хэсэгт (1992) “Монгол улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах...эрхтэй”, 55 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Шүүгдэгч өөрийгөө өмгөөлөх эрхтэй”. 2 дахь хэсэгт “Шүүгдэгчид энэ эрхээ эдлэхэд хүсэлтээр нь буюу хуульд зааснаар хууль

зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлнэ” гэж хууль зүйн туслалцаа авах эрхийг үндсэн хуулийн хэмжээнд хуульчлан баталгаажуулжээ.

Төлбөрийн чадваргүй иргэдийн хууль зүйн туслалцаа авах эрхийн асуудал бол Монгол улс дахь хүний эрхийн төлөв байдлыг тодорхойлох нэг бүрэлдэхүүн хэсэг юм.

Монгол Улсад хийгдсэн Амьжиргааны түвшний түүвэр судалгаагаар ядуу хүн амын өсөлтийг 1995, 1998 оны байдлаар гаргажээ.

/ядуу хүн амын өсөлт, 1995-1998 онд/

	Байршил	ядуу хүн ам /мян/		ядуу хүн амын өсөлт	
		1995	1998	мян. хүн	%
1.	Хот Үүнээс:	471	479,9	8,9	1,9
2.	УБ	214	221.6	7.6	3.6
3.	Аймгийн төв	257	258,3	1,3	0,5
4.	Хөдөө	357		12.9	3,6
	Бүгд		849.8	21.8	2.6

1995 оны судалгаагаар ядуу хүний тоо 828 мянга байсан бол 1998 онд 849.8 мянгад хүрч ядуу хүний тоо 2.6 хувь буюу 21.8 мянган хүнээр нэмэгдсэн байна. Энэ нь Монгол Улсад төлбөрийн чадваргүй буюу хууль зүйн үнэ төлбөргүй туслалцаа авах иргэд 1998 оны байдлаар 849.8 мянган байсан гэсэн үг юм. Гэхдээ энэ нь эдгээр иргэдийн хэдэн хувь нь хууль зүйн туслалцаа авах шаардлагатайгаас шалтгаалан харьцангуй асуудал болно.

Ядуу, орлого бага, төлбөрийн чадваргүй иргэдийн хувьд Үндсэн хуулиар баталгаажсан Монгол Улсын иргэний баталгаатай эдлэх шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг, эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, нотлох баримтыг шалгуулах, шударга шүүхээр шүүлгэх, шүүхийн шийдвэрийг давж заалдах, уучлал хүсэх зэрэг үндсэн эрхээ хэрхэн хэрэгжүүлэх нь хууль зүйн үнэ төлбөргүй туслалцаа авах эрх хэрхэн хангагдаж байгаагаас шалтгаалдаг байна. Иймд төлбөрийн чадваргүй иргэний хууль зүйн үнэ төлбөргүй туслалцаа авах эрх нь нэлээд хэд хэдэн хувийн эрхийг хангах суурь “эрх” юм.

Иргэдэд хууль зүйн үнэгүй туслалцаа үзүүлэх баталгааг Шүүхийн тухай хуулийн 20, Өмгөөллийн тухай хуулийн 17-р зүйлд тус тус хуульчлан заасан байдаг. Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч нараас эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцохдоо өөрийгөө өмгөөлөх, өмгөөлүүлэх, хууль зүйн бусад туслалцаа авах, өмгөөлөгчөө хэрхэн сонгох талаар ЭБШХ-ийн 20,45,46, Өмгөөллийн тухай хуулийн 5-р зүйлүүдэд тодорхой заасан байдаг бөгөөд хэрэгжүүлэх үүргийг өмгөөлөх, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, шүүхийн байгууллага, хяналт тавих үүргийг прокурорын байгууллага тус тус гүйцэтгэдэг.

Төлбөрийн чадваргүй иргэний хууль зүйн үнэ төлбөргүй туслалцаа авах эрхийн талаар Монгол улсын Шүүхийн (2002) болон Өмгөөллийн тухай хуульд (2002) өмгөөллийн хөлс төлөх чадваргүй шүүгдэгчид төрөөс туслалцаа үзүүлэх, өмгөөллийн зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэх талаар заажээ.

2002 онд батлагдсан шинэ Өмгөөллийн хуулийн 21 дүгээр зүйлд Төлбөрийн чадваргүй иргэний өмгөөллийн зардлын тухай заалтанд “Төлбөрийн чадваргүй иргэний өмгөөллийн зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ. Энэхүү санхүүжилтийг Монголын Өмгөөлөгчдийн Холбоонд олгох бөгөөд уг зардлыг санхүүжүүлэх, тайлан тооцоо гаргах журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн баталж, хэрэгжилтэнд нь хяналт тавина” гэжээ. Гэвч энэ журам одоогоор батлагдаагүй байгаа бөгөөд Монгол Улсын Хууль зүйн сайд, Сангийн сайд, Хүн амын бодлого, хөдөлмөрийн сайдын хамтарсан 1995 оны 5 дугаар сарын 4-ны өдрийн 43/76/62 дугаар тушаалаар батлагдсан “Төлбөрийн чадваргүй иргэний өмгөөллийн зардлыг төсвөөс санхүүжүүлэх, тайлан тооцоо гаргах” журам үйлчилж байна.

Уг журмаар дараахь зүйлүүдийг зохицуулж байна:

1.Төлбөрийн чадваргүй байдлыг тодорхойлох үндсэн шалгуур, төлбөрийн чадваргүй өмгөөлүүлэгч гэж үзэх үндэслэл, тодорхойлолт гаргах;

2.Төлбөрийн чадваргүй өмгөөлүүлэгчийн зардлын төсвийг боловсруулах, шүүхийн жилийн төсвийн төсөлд тусгах, УИХ-д оруулах, батлагдсан төсвийг орон нутгийн шүүхийн байгууллагуудад хуваарилах тухай;

3.Сум, дүүрэг, баг, хороодын Засаг даргын тодорхойлсноор хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, шүүгч нь төлбөрийн чадваргүй өмгөөлүүлэгчийн өмгөөллийн зардлыг төсвөөс төлөх карт бөглөн шүүхийн нягтлан бодогчид шилжүүлдэг, нягтлан бодогч сар бүрийн эцэст өмгөөлөгчид өмгөөллийн хөлсийг олгох тухай.

Уг журамд төлбөрийн чадваргүй өмгөөлүүлэгч гэдэгт сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн өөрийгөө болон гэр бүлээ тэжээх сарын орлого нь Засгийн газраас тогтоосон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнд хүрэхгүй, үүнээс хамааран байнгын хязгаарлагдмал хэрэглээтэй амьдардаг иргэнийг ойлгох тухай заажээ. Тухайн иргэн буюу өмгөөлүүлэгчийн төлбөрийн чадваргүй болохыг сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга тодорхойлох бөгөөд Хүн амын бодлого, хөдөлмөрийн сайд, Сангийн сайдын 1993 оны 156/199 дугаар тушаалаар батлагдсан “Амьдрал ядуу, бага орлоготой өрх, иргэдэд туслах сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах журам”-ын 7 дугаар зүйлийг баримталдаг байна. Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, шүүгч зэрэг эрх бүхий албан тушаалтан нь сум, дүүрэг, баг, хороодын Засаг даргын тодорхойлсноор энэ тухай өөрсдийн шийдвэрт тусгаж эл журмын 1 дүгээр хавсралт, төлбөрийн чадваргүй өмгөөлүүлэгчийн өмгөөллийн зардлыг төсвөөс төлөх тухай улсын нэгдсэн дугаартай картыг бөглөн гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарж шүүхийн байгууллага хариуцсан нягтлан бодогчид хүргүүлдэг. Шүүхийн байгууллагын нягтлан бодогч нь уг картыг үндэслэн төлбөрийн чадваргүй өмгөөлүүлэгчийн өмгөөллийн зардлыг батлагдсан жишгийн дагуу сар бүрийн эцэст нэг удаа тухайн өмгөөлөгчид нь бэлнээр олгох тухай заасан байдаг. Энэхүү журам нь эрүүгийн төдийгүй иргэний хэрэгт адил үйлчилдэг байна. Гэвч уг журмын хэрэгжүүлэлт хангалтгүй байгаагийн улмаас төлбөрийн чадваргүй иргэдэд үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа үзүүлдэг өмгөөлөгчдөд уг мөнгө нь хүрч чаддаггүй байна. Улмаар төлбөрийн чадваргүй иргэд маань мөрдөн байцаах болон шүүхийн үйл ажиллагааны шатанд чанартай өмгөөллийн туслалцаа авах боломж нь хязгаарлагддаг.

Төлбөрийн чадваргүй иргэний өмгөөллийн үйл ажиллагааны зардлын хэмжээг (журмын “дөрөв”-ийн 1-д заасан жишигт нийцүүлэн) ядуу, нэн ядуу алин болохыг харгалзан аймаг, нийслэлийн өмгөөлөгчдийн зөвлөлийн дарга тогтоох талаар журамд заасан ч зардлын хэмжээг жишигт тогтоосон хэмжээнээс ихэсгэх эрхгүй гэжээ. Төлбөрийн чадваргүй иргэний өмгөөллийн үйл ажиллагааны зардлыг гарсан бодит хэмжээгээр бус жишигт нийцүүлэн бодит бусаар тогтоох талаар заасан нь өмгөөллийн үйл ажиллагааны чанар, үр дүнд нөлөөлж байгаа юм. Цаашид төлбөрийн чадваргүй иргэний өмгөөллийн үйл ажиллагааны зардлыг гарсан бодит хэмжээгээр нь төлөх, эсхүл жишигийн хэмжээг ихэсгэх шаардлага байгааг харуулж байна. Нийт 50 шүүгч, прокурор, мөрдөн байцаагч оролцсон хэсэгчилсэн судалгаанаас харахад “Улсаас баталсан жишиг хэмжээ амьдралд нийцэхгүй байна” гэж тэдний 56 хувь нь үзэж байна.

Төрийн, төрийн бус болон судалгааны байгууллагуудаас төлбөрийн чадваргүй ядуу иргэдэд хууль зүйн туслалцаа үзүүлэх асуудалд сүүлийн таван жилд хийсэн ямар нэгэн судалгааны албан ёсны материал байхгүй байна. Гэхдээ өмгөөлүүлэх эрхийн хэрэгжилтийн талаар Монгол Улсад хүний эрхийг хангах төслийн “Монгол Улс дахь хүний эрхийн төлөв байдал 2001” судалгааны хүрээнд энэ асуудал хөндөгдсөн байна. Хүний эрхийн үндэсний комиссоос нийт хичнээн хүнд үнэгүй өмгөөллийн туслалцаа үзүүлсэн талаар тоо баримтаас үзвэл 2001-2002 оны байдлаар Нийслэлийн өмгөөлөгчдийн зөвлөл, Мөрдөн байцаах газраас ирүүлсэн албан бичгийн дагуу нийт 44 хүнд, Шүүхээс ирүүлсэн албан бичгийн дагуу нийт 52 хүнд тус тус өмгөөлөгч томилжээ.

Судалгааны баг аймаг, нийслэлийн 200 шахам өмгөөлөгчдийн дунд “төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн үнэ төлбөргүй туслалцаа үзүүлэх асуудал” сэдэвт судалгааны анкет тараасан ба нийслэлийн 81, 10 аймгийн 43, бүгд 124 өмгөөлөгчид хариу ирүүлсэн. Үүнд:

1. 83 өмгөөлөгч буюу 66,9 хувь нь Монгол Улсад төлбөрийн чадваргүй иргэний үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа авах эрх хууль, шүүхийн практикт бодитойгоор хэрэгжихгүй байна гэжээ.

2. 107 өмгөөлөгч буюу 86,3 хувь нь өмгөөллөөс гадна эрх зүйн асуудлаар амаар болон бичгээр зөвлөгөө өгдөг, 90 өмгөөлөгч буюу 72,6 хувь нь эрх зүйн ач холбогдол бүхий баримт бичгийн эх зохиож тусалдаг, 63 өмгөөлөгч буюу 50,8 хувь нь төр, захиргааны байгууллагыг төлөөлдөг гэжээ.

3. 107 өмгөөлөгч буюу 86,3 хувь нь төлбөрийн чадваргүй сэжигтэн яллагдагч, нэхэмжлэгч, хариуцагч нар өөрсдөө өмгөөлөгчөө чөлөөтэй сонгож чаддаггүй гэжээ.

4. 51 өмгөөлөгч буюу 41,1 хувь нь өмгөөлөгчийн үзүүлж байгаа хууль зүйн туслалцааны чанарыг хангах, үйлчилгээг үнэлэх, хяналт тавих механизм дунд зэрэг, 48 өмгөөлөгч буюу 38,7 хувь нь хангалтгүй гэжээ.

5. Төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн үнэ төлбөргүй туслалцаа үзүүлэх асуудлыг хэрхэн зохицуулах нь зохистой болох талаар бидний дурдсан асуултанд хариулсан нь:

- улсаас цалинждаг орон тооны өмгөөлөгч бий болгох / 43 өмгөөлөгч буюу 40,2 хувь нь /
 - хуримтлал бий болгон тусгай сан байгуулах замаар зохицуулах / 44 өмгөөлөгч буюу 41,1 хувь нь /
 - өмгөөлөгч жилд 2 удаа төлбөрийн чадваргүй иргэнийг өмгөөлөх /18 өмгөөлөгч буюу 16,8 хувь нь /
 - одоогийн зохицуулалт зөв / 10 өмгөөлөгч буюу 9,3 хувь нь /
- (Тайлбар : 17 өмгөөлөгч хариулаагүй тул 107 хүнд хувааж хувийг гаргасан болно)

Ихэнх тохиолдолд өмгөөлөгч хөлсөө олж авах магадлал бараг байдаггүй учраас төлбөрийн чадваргүй иргэдийг өмгөөлөх сонирхолгүй байдаг. Харин энэ тоо бол анхнаасаа үнэ төлбөргүй туслалцаа үзүүлье гэж тохирсноос илүүтэй төлбөрийн чадваргүй хүмүүстэй гэрээ хийж өмгөөллийн туслалцаа үзүүлсэнтэй холбоотой гарсан тоо гэж үзэж байна. Судалгааны явцад бид хэд хэдэн өмгөөлөгчидтэй энэ асуудлаар ярилцахад тэд үнэ төлбөргүй өмгөөллийн туслалцаа үзүүлье гэсэн үүднээс оролцдоггүй байна. Цөөхөн тохиолдолд яалт ч үгүй ийм шийдвэр гаргахад хүрдэг байна. Түүнээс гадна судалгааны анкет бөглөсөн өмгөөлөгчид дараахь санал нэмж бичсэн байна. Үүнд:

1. Хүний эрхийг хохироохгүйн тулд төрөөс санхүүжүүлж, МӨХ-нд зохицуулах эрхийг нь олгох/ бүгд 11 өмгөөлөгч бичжээ/.

2. Улсаас цалинждаг орон тооны өмгөөлөгчийн цалин нь одоо Сангийн яамнаас хуваарилагдсан, УИХ-аас төсөвт суулгасан мөнгөнөөс санхүүжигдэх боломжтой.

3. Одоо шүүхэд очсон мөнгөнөөс олж авахын тулд бүрдүүлэх материал нь боломжгүй байдаг ба иргэд тодорхой хаяггүй, биеийн байцаалтгүй тул хэзээ ч биелэгдэхгүй /2 өмгөөлөгч/

4. Иргэд тэр бүр төлбөрийн чадваргүй тухайгаа өмгөөлөх байгууллагад хандахаа мэддэггүй.

5. Хугацаат цэргийн албан хаагчдын өмгөөллийн зардлыг төсөвлөдөг байх, энэ асуудал завсардаж байна.

6. Өмгөөллийн татвараас авдаг хариуцлагын даатгалын зохих хувиас өгч болох юм.

7. Тэтгэвэрт гарсан өмгөөлөгчдөөр төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн туслалцаа үзүүлж цалинжуулах.

8. Төлбөрийн чадваргүй иргэний төлөх мөнгөний хэмжээг шүүхийн тогтоол шийдвэрт тусгаж өгөх /2 өмгөөлөгч/

9. Хоригдогчид хэрэгт их холбогддог байдлыг харгалзан тусгай сангаас аймгуудын өмгөөлөгчдийн зөвлөлд хөлсийг нь хуваарилахдаа ялгамжтай хандах.

Төлбөрийн чадваргүй иргэний өмгөөллийн хөлсийг зохицуулах талаар дор дурдсан арга хэмжээ авах нь зүйтэй гэж үзэж байна.

1. Хуримтлал бий болгон тусгай сан байгуулж санхүүжүүлэх .Үүнд:

- a) Сангийн хөрөнгийг ХЗДХЯ-ны хяналтын дор МӨХ захиран зарцуулж байх
- b) Сангийн хөрөнгийг батлагдсан журмын дагуу зөвхөн төлбөрийн чадваргүй иргэний өмгөөллийн хөлсний асуудал / өмгөөллийн хөлс, энэ чиглэлийн сургалт г.м/-тай холбогдсон зүйлд зарцуулах
- c) Сангийн хөрөнгийн үлдэгдлийг дараа онд шилжүүлэн ашиглах
- d) Сангийн зарцуулалтад МӨХ-ны санхүү, Хянан шалгагчдын зөвлөл байнгын хяналт тавьж ашиглах

Төлбөрийн чадваргүй иргэний өмгөөлөлд аймаг, нийслэлийн дүүргийн шүүхийн албан бичгийг үндэслэн аймаг, нийслэлийн өмгөөлөгчдийн зөвлөлийн дарга томиллолт бичиж өмгөөлөгч оролцуулах журам тогтоож хэвшүүлэх . Үүнд:

- Томилолтын бүртгэлийг үндэслэн 2-оос илүү төлбөрийн чадваргүй хүний өмгөөлөлд орсон өмгөөлөгчийн хөлсийг олгож байх:
- Хэн нэгэн хүний гуйлтаар төлбөрийн чадваргүй нэрийн дор өмгөөлөлд ордогийг зогсоох

3. Хууль зүйн сайд, Хүн амын бодлого хөдөлмөрийн сайдын 1995 оны 44/63 дугаар тушаалаар баталсан төлбөрийн чадваргүй иргэний эрх ашгийг хамгаалахад төлөх хөлсний жишгийг хэргийн хөнгөн, хүндээр ялгаварлан 35-50 хувиар өсгөх замаар шинэчлэн мөрдүүлэх

“Төлбөрийн чадваргүй иргэдэд үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа үзүүлэх асуудлаар сургалт, семинар зохион байгуулагдаж байсан уу?” гэсэн асуулгад судалгаанд хамрагдсан өмгөөлөгчид бүгд тийм сургалт явагдаж байгаагүй гэж хариулсныг үзвэл энэ чиглэлээр өмгөөлөгчдийг боловсруулах, гэгээрүүлэх явдал дутагдаж байна гэж дүгнэж болохоор байна.

Хоёр. Эрүүгийн хэрэгт төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн туслалцаа үзүүлэх

Өмгөөлүүлэх эрх нь эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны нэг үндсэн зарчим, сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч нараас эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцоходоо өөрийн эрх, ашиг сонирхлыг хууль зүйн дагуу хамгаалах эрхийн баталгаа мөн.

Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч нь мэргэжлийн өмгөөлөгчийн тусламжинд түшиглэн хуулиар олгогдсон эрхээ бүрэн бөгөөд ашигтай, боломжтой байдлаар эдлэх, хариуцлага хүлээх эсэхийг шийдвэрлэхэд хуулиар олгогдсон өмгөөлүүлэх эрхийн хэрэгжилт чухал ач холбогдолтой байдаг. Хууль зүйн туслалцаа авах эрхийг хэрэгжүүлэхийн тулд өмгөөлөгч сонгон авах, зарим онцгой тохиолдолд хууль зүйн туслалцаа авах эрхийг хангасан байх явдлыг хуульчлан баталгаажуулах нь хүний эрхийг хангах нэг гол арга зам юм.

Хуучин (1995) ЭБШХ-ийн 45 дугаар зүйлийн дагуу гэмт хэрэг үйлдсэн явдалд сэрдэгдэж албадан саатуулагдах үеэс эхлэн эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд өмгөөлөгч оролцох эрхтэй байсан. Тэгвэл шинэ (2002) ЭБШХ-ийн 38.3-т зааснаар гэмт хэрэгт сэжигтнээр тооцогдсон үеэс эхлэн эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд өмгөөлөгч оролцох эрхтэй гэж хуульчилжээ. Үүгээр өмгөөлөгч авах боломжийг арай илүү өргөн болгож өгчээ. Харин өмгөөлүүлэх эрхийг тодорхой хэмжээнд батлаж өгсөн энэ байдлыг иргэдэд сурталчлах явдал дутмаг байна.

Иргэний өмгөөлүүлэх эрхийг хэрэгжүүлэх, мэргэжлийн өмгөөлөгчийг хэн хэрхэн сонгож авахыг Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 46 дугаар зүйлд /1995/ зааснаар дор дурдсан байдлаар хэрэгжиж байсан:

1.Сэжигтэн, яллагдагч өөрөө өмгөөлөгчөө сонгон авах:

2.Сэжигтэн, яллагдагчийн зөвшөөрснөөр буюу хүссэнээр түүний төрөл садны хүмүүс, хууль ёсны төлөөлөгч нь өмгөөлөгчийг авах:

3.Хэрэв сэжигтэн, яллагдагч өмгөөлөгчөө сонгон аваагүй бол түүний хүсэлтээр эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд өмгөөлөгч оролцох боломжийг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор буюу шүүх хангах бөгөөд өмгөөлөгчөө сонгоход нь тодорхой хүний нэр зааж тулгахгүй байх.

4.Сэжигтэн, яллагдагчийн сонгож авсан өмгөөлөгч уг хэрэгт оролцох боломжгүй болсон, түүнчлэн өмгөөлөгчөөсөө татгалзсан бол сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч өөр өмгөөлөгч сонгон авах.

Шинээр (2002) батлагдсан ЭБШХ-ийн 39 дүгээр зүйлд дээрх заалтыг хэвээр үлдээсэн бөгөөд шинээр “Нэг этгээд хэд хэдэн өмгөөлөгчтэй байж болно” гэсэн заалтыг оруулсан нь төлбөрийн чадвартай хүмүүс мэргэжлийн өндөр түвшинд, чанартай өмгөөллийн туслалцаа авахыг илүү нээлттэй болгож буй заалт боловч төлбөрийн чадваргүй иргэдэд хамааралгүй заалт юм.

Түүнчлэн хуулийн дээрх заалт амьдрал дээр тэр болгон хэрэгждэггүй байна. Ялангуяа хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүх иргэнийг өмгөөлөгчөө сонгоход нь хүний нэр заан тулгаж болохгүй гэдэг заалт тодорхой хэмжээнд зөрчигддэг гэдгийг хуульчид ч, мөн иргэд ч ярьж байна. Шүүхээр хэрэг нь таслан шийдвэрлэгдээд хорих ял авсан хүмүүс иймэрхүү жишээ

олонтаа ярьдаг. Харин энэ талаар хэрэг үүсгэж, зөрчлийг албан ёсоор тэмдэглүүлж, зохих байгууллага, албан тушаалтанд гомдол гаргаж, шийдвэрлүүлсэн баримт алга байна.

Түүнчлэн Өмгөөллийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар хууль зүйн туслалцаа хүсэгч нь эрүүл мэнд, төлбөрийн чадвар болон хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар өмгөөлүүлэх эрхээ өөрөө хэрэгжүүлэх боломжгүй, түүнчлэн өмгөөлөгчөө сонгон авч чадаагүй тохиолдолд хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, шүүх, прокурорын байгууллага энэ тухай өмгөөлөгчдийн байгууллагад мэдэгдэж өмгөөлөгч томилуулах арга хэмжээ авах үүрэгтэй гэжээ.

1995 оны Монгол Улсын ЭБШХ-ийн 47 дүгээр зүйлд хууль зүйн туслалцаа авах эрхийг хангахын тулд эрүүгийн хэргийг шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэхэд заавал өмгөөлөгч оролцуулах үндэслэлүүдийг заахдаа дор дурьдсан хэргийг шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэхэд өмгөөлөгчдийг заавал оролцуулна гэж заасан байдаг. Үүнд:

- 1.Уг хэрэгт улсын яллагч оролцож байгаа бол;
- 2.Хэлгүй, дүлий, хараагүй зэрэг эрхтэн дутуу буюу сэтгэл мэдрэлийн гэмтлийн улмаас өмгөөлөх эрхээ биелүүлж чадахгүй байвал;
3. Насанд хүрээгүй хүмүүсийн хэрэгт;
4. Монгол хэл мэдэхгүй этгээдийн хэрэгт;
5. Хэргийнхээ талаар харилцан эсрэг сонирхолтой яллагдагчдын аль нэг нь өмгөөлөгчтэй байгаа бол;
6. Шүүхэд шилжсэн этгээдийн үйлдсэн гэмт хэрэгт ялын дээд хэмжээ оногдуулж болох байвал. Энэ тохиолдолд яллагдагч, эсвэл түүний хууль ёсны төлөөлөгч буюу төрөл садны хүн, түүнчлэн яллагдагчийн хүссэнээр буюу зөвшөөрснөөр бусад хүмүүс өмгөөлөгчийг уриагүй бол мөрдөн байцаагч буюу шүүх уг хэрэгт өмгөөлөгч оролцуулах явдлыг хангах үүрэгтэй. Ийнхүү манай хууль тогтоомжид иргэний өмгөөлүүлэх эрхийг хуульчлан зааж, энэхүү эрхээ хэрэгжүүлэхийн тулд мэргэжлийн өмгөөлөгчөөс хууль зүйн туслалцаа авах арга, хэлбэрийг баталгаажуулж өгсөн байдаг. Хуулийн практикаас харахад хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд өмгөөлөгч оролцуулаагүй байдал шүүх хуралдааны шатанд өмгөөлөгч оролцуулаагүй хэргийг шийдвэрлэсэн байдлаас илүү байдаг нь ажиглагдсан. ЭБШХ-иар шүүх хуралдаан дээрх хэргүүдэд өмгөөлөгч заавал оролцуулна гэж хуульчилсан байдаг тул оролцуулаагүй шийдвэрлэсэн тохиолдолд хууль зөрчсөн шалтгаанаар шүүхийн шийдвэр хүчингүй болох тул шүүгчид энэ асуудалд анхаарал хандуулдаг байна.

Харин 2002 оны 9 дүгээр сарын 1-нээс хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн ЭБШХ-иар уг хэрэгт улсын яллагч оролцож байгаа бол өмгөөлөгч заавал оролцохоос бусад үндэслэлүүдийг хэвээр үлдээж, өмгөөлөгч заавал оролцох явдлыг зөвхөн шүүх хуралдаанаар хэрэг хянан шийдвэрлэхэд төдийгүй хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаанд өмгөөлөгч заавал оролцуулах тухай заажээ.

Өмгөөлөгч заавал оролцуулах хэргүүдийн нэг болох сэтгэл мэдрэлийн гэмтлийн улмаас өмгөөлөх эрхээ биелүүлж чадахгүй тохиолдлыг оруулж байсан. Тэгвэл шинэ

хуулинд “сэтгэцийн өвчний улмаас өөрийгөө өмгөөлөх болон өмгөөлүүлэх эрхээ эдэлж чадахгүй байвал” гэж өөрчилсөн нь хууль зүйн томъёоллын хувьд дээр болжээ. Түүнчлэн ЭБШХ-ийн 395 дугаар зүйлд /шинэ хуулийн 380-р зүйл/ нийгэмд аюултай гэмт хэргийг ухаан солиу байх үедээ үйлдсэн буюу гэмт хэрэг үйлдсэнийхээ дараа сэтгэл мэдрэлийн өвчнөөр өвчилсөн этгээдийн хэрэгт өмгөөлөгчийг заавал оролцуулах тухай заасан юм. Хэдий тийм боловч энэ асуудал манайд хуульчдын анхаарлын төвөөс гадуур, төрийн анхаарлаас ч хол байдаг нь эдгээр хүмүүсийн эрх хэрхэн зөрчигдөж, хамгаалагдаж байгаа талаар ямар нэгэн судалгаа, тоо баримт байхгүйгээс харагдаж байна. Сэтгэцийн өвчний улмаас өөрийгөө өмгөөлөх, өмгөөлүүлэх эрхээ хэрэгжүүлж чадахгүй хүмүүст өмгөөллийн туслалцаа хэр хүртээмжтэй байдаг, эдгээр хүмүүсийн өмгөөлүүлэх эрх хэрхэн зөрчигдөж байгаа талаар тоо баримт, судалгаа ерөөсөө байхгүй байна.

Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд иргэдийн өмгөөлүүлэх эрх ноцтойгоор зөрчигдсөөр байна. Жишээ нь: 2001 оны 4 дүгээр сард Цагдан хорих төв “Ганц худаг”-т хийсэн шалгалтаар мөрдөн байцаалтын шатанд цагдан хоригдсон 619 хүний 80 орчим хувь нь өмгөөлөгч огт аваагүй байв. Шалтгааныг лавлахад олонхи нь өмгөөлөгч авдгийг мэдэхгүй, өөрөө хоригдсон болохоор ар гэрийнхэн нь хөөцөлдөж мэддэггүй, өмгөөлөгч авах талаар мөрдөн байцаагч яриагүй гэх буюу өмгөөлөгчийн хөлс төлөх мөнгөгүй гэж хариулцажээ.¹

Өмгөөлөгч, шүүгч нарын дунд шүүн таслах, мөрдөн байцаах ажиллагааны явцад өмгөөлүүлэх эрхийг хэрхэн хангаж байгаа талаар хийсэн судалгааны дүнгээс² үзвэл, өмгөөлөгчөө сонгоход албан тушаалтны зүгээс нөлөөлдөг, албадан саатуулах, цагдан хорих үед өмгөөлөгч, гэр бүлийнхэнд нь тэр бүр мэдэгддэггүй байна.

Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах шатанд Монгол улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14-т заасан өмгөөлүүлэх эрхийг хэрхэн хангаж байгаа талаар шүүгч, өмгөөлөгчдөөс авсан судалгаа

/Судалгаанд 50 хүн хамрагдсан/

1	Асуулт	Хариулт /хүний тоо, хувь/			
		Тийм	хувь	Үгүй	хувь
1.	Сэжигтнээр тооцсон үеэс өмгөөлөгчийг оролцуулдаг эсэх	24	49%	25	51%
2.	Албадан саатуулах, цагдан хорих үед өмгөөлөгчид нь мэдэгддэг эсэх	14	29%	35	71%
3.	Албадан саатуулах, цагдан хорих үндэслэл, шалтгааныг сэжигтэн, яллагдагчид өөрт мэдэгддэг эсэх	36	72%	13	27%
4.	Албадан саатуулах, цагдан хорих үндэслэл, шалтгааныг сэжигтэн, яллагдагчийн гэр бүлийнхэнд нь мэдэгддэг эсэх	17	34%	29	59%
5.	Өмгөөлөгч сонгоход нь тодорхой хүний нэр заан тулгаж байгаа эсэх	27	55%	22	45%
6.	Өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг, эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхийг хангаж байгаа эсэх	29	59%	18	36%
7.	Өмгөөлүүлэх эрхийг зөрчсөн нь шүүхийн шийдвэрийг хүчингүй болгох үндэслэл болж байсан эсэх /тийм бол тоогоор бичнэ./	16 /13 удаа/	33%	31	62%

¹ “Монгол улс дахь хүний эрхийн төлөв байдал” УБ., 2001 он, 93-94 дүгээр хуудас

² Улс төрийн болон хувийн эрхийн судалгааны тайлан., “Монгол Улсад хүний эрхийг хангах төсөл”, 2001 он.

Шүүхээс шүүгдэгчийг өмгөөлүүлэх эрхээр хэрхэн хангаж байгаа талаар мгөөлөгчдөөс авсан судалгаа

/Судалгаанд 50 хүн хамрагдсан/

1	Асуулт	Хариулт /хүний тоо, хувь/			
		Тийм	Хувь	Үгүй	Хувь
1.	Өмгөөлүүлэх бололцоогоор бүрэн хангаж байгаа эсэх	38	77%	11	22%
2.	Өмгөөлөгчөө өөрөө сонгон авч байгаа эсэх	31	62%	19	38%
3.	Өмгөөлөгч сонгоход нь тодорхой хүний нэр заан тулгаж байгаа эсэх	19	38%	30	60%
4.	Өмгөөлүүлэх эрхийг зөрчсөн нь шүүхийн шийдвэрийг хүчингүй болгох үндэслэл болж байсан эсэх /тийм бол тоогоор бичнэ./	12 /16 удаа/	24%	35	70%

Үүнд нэг талаар хүн амын дийлэнх хэсэг нь хууль зүйн туслалцаа авах эрхийн тухай ойлголтгүй, нөгөө талаар сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн хууль зүйн туслалцаа авах эрхийг хангаж байдаг өмгөөлөгчийн мэргэжлийн эрх хэмжээ эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд хязгаарлагдмал зөвхөн “хүсэлт” гаргах хэмжээнд байдагтай холбоотой юм. Түүнчлэн иргэдийн өмгөөлүүлэх эрхийг баталгаатай эдлүүлэх үүрэг хүлээсэн субъектуудын үйл ажиллагаа дутмаг байгаатай холбоотой гэж үзэж болохоор байгаа юм.

Шинэ Эрүүгийн байцаан шийтгэх хууль хэрэгжиж эхэлснээр мэтгэлцэх зарчмыг шүүн таслах үйл ажиллагаанд жинхэнэ утгаар нь хэрэглэнэ гэж манай хууль, шүүхийнхэн бэлтгэлээ базааж байна. Мэтгэлцүүлэн шүүдэг тогтолцоонд шүүгч харьцангуй төвийг сахисан байр суурьтай байж талуудыг хооронд нь эрх тэгш байдлаар мэтгэлцүүлээд түүний үр дүнг үндэслэн шийдвэр гаргадаг бол мөрдөн шүүдэг тогтолцоонд үүний эсрэгээр шүүгч шүүхийн хэлэлцүүлэгт голлох үүрэг гүйцэтгэж нотлох баримтыг өөрөө шинжлэх, түүндээ үндэслэн эцсийн шийдвэр гаргах зарчмыг баримталдаг.

2002 онд батлагдсан энэ Эрүүгийн байцаан шийтгэх хуульд мэтгэлцэх зарчмын тухай ойлголтыг тодотгоод зогсоогүй, үүнтэй холбогдох ойлголтуудыг мэтгэлцэх зарчимд нийцүүлэх, мэтгэлцэх тогтолцоо үүсгэхэд чиглэгдсэн хэд хэдэн чухал хэм хэмжээнүүдийг тусгасан байна. Үүнд “Шүүн таслах ажиллагаа нь тэгш эрх бүхий яллах, өмгөөлөх талын мэтгэлцээний үндсэн дээр явагдана. Талууд шүүх хуралдааны үед нотлох баримтыг шинжлэн судлахад оролцох, хүсэлт гаргах, хэрэгт ач холбогдол бүхий ямар ч асуудлаар саналаа илэрхийлэх талаар эрх тэгш байна” гэж заасан нь яллагдагч, шүүгдэгчийн зүгээс ихээхэн хүч чармайлт, оюун ухаан шаардагдах ба өөрийгөө хамгаалахад иргэд өөрсдөө идэвхтэй байр сууринаас хандахыг чухалчилсан гэсэн үг.

Энэхүү мэтгэлцүүлэн шүүх нь тухайн хэрэг маргааныг шударгаар шийдвэрлэх, хүний эрхийг хамгаалах, гэм буруугүй этгээд хэлмэгдэн шийтгэгдэхгүй байх баталгааг хангахад илүү анхаардаг хэдий ч манай өнөөгийн нөхцөлд иргэдийн хууль, эрх зүйн мэдлэг сул дорой, өмгөөлөгчдийн туслалцаа авч чадахгүйгээр, авсан ч чанаргүй туслалцаа авсанаар мэтгэлцээний нэг тал болон шүүхэд өөртөө ашиггүй шийдвэр гаргуулахад хүрэх явдал гарах илүү магадлалтай. Чухам иймээс ялангуяа төлбөрийн чадваргүй, ядуу, хууль эрх зүйн мэдлэг хомс иргэдийнхээ өмгөөлүүлэх эрхийг нь баталгаатай болгох ач холбогдол бүхий шинэлэг, найдвартай алхам хийх нь чухал байгааг харуулж байна.

Эрүүгийн хэрэгт үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа үзүүлэх үйл явц

Гэмт хэрэгт сэжиглэгдэж байгаа сэжигтэнд тэр даруй гэр бүл, өмгөөлөгчид нь 48 цагийн дотор чухам ямар гэмт хэрэгт сэрдэгдэж байгааг мэдэгдэж, байцаахын өмнө Эрүүгийн байцаан шийтгэх тухай хуулийн 50 дугаар зүйлд заасны дагуу уг хуулийн 45

дугаар зүйлд заасан буюу гэмт хэрэг үйлдсэн явдалд сэрдэгдэж албадан саатуулагдсан буюу байцаагдах үеэс эхлэн өмгөөлөгч авах, өмгөөлөгчтэйгээ ганцаарчлан уулзах зэрэг эрхийг нь хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч тайлбарлан өгч, өмгөөлүүлэх эрхийг нь хангах талаар заажээ. Гэвч энэхүү хуулийн заалт амьдрал дээр төдийлөн сайн хэрэгжихгүй байна гэж үзэж болно. Тухайлбал, 2001 онд нийслэлийн прокурорын газраас Цагдаагийн байгууллагын албадан саатуулах ажиллагаанд хийсэн шалгалтын дүнгээс үзэхэд: “2001 оны эхний зургаан сард нийслэлийн хэмжээнд 1967 хүнийг албадан саатуулсны 524 хүний ар гэр, өмгөөлөгчид мэдэгдээгүй” байсан байна.

Харин төлбөрийн чадваргүй сэжигтэний хувьд хууль зүйн үнэ төлбөргүй туслалцаа авах эрхийг хангах талаар ЭБШХ-д тухайлан заагаагүй, нөгөө талаар “төлбөрийн чадваргүй иргэний өмгөөллийн зардлыг төсвөөс санхүүжүүлэх, тайлан тооцоо гаргах” журмын талаар хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, төлбөрийн чадваргүй иргэд төдийлөн сайн мэддэггүйгээс ихэнх тохиолдолд төлбөрийн чадваргүй иргэд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд өмгөөлөгч авдаггүй байна.

Бидний хийсэн судалгааны дүнгээс үзэхэд судалгаанд оролцсон 83 өмгөөлөгч буюу 66.9 хувь нь “Монгол Улсад төлбөрийн чадваргүй иргэний үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа авах эрх хууль, шүүхийн практикт бодитойгоор хэрэгжихгүй байна” гэжээ. Дүгнэн үзвэл, төлбөрийн чадваргүй иргэдийг өмгөөлөхөд төлөх зардлын жишиг хэмжээг үнэ ханшны өөрчлөлттэй уялдуулан тухай бүр шинэчлэн тогтоодоггүйгээс хэт доогуур, үндэслэл муутай, зардлыг нь цаг хугацаанд нь өмгөөлөгчид бүрэн олгож чаддаггүй зэргээс шалтгаалан өмгөөлөгчид ийм хэргийг өмгөөлөх сонирхол бага, өмгөөлсөн ч хууль зүйн туслалцааны чанар хангалттай байдаг эсэх нь эргэлзээтэй юм.

Хууль зүйн туслалцаа авах эрхтэй салшгүй холбоотой нэг эрх бол өмгөөлөгчөө чөлөөтэй сонгох эрх юм. Энэхүү төслийн судалгаанд хамрагдсан өмгөөлөгчдийн 107 өмгөөлөгч буюу 86.3 хувь нь “төлбөрийн чадваргүй сэжигтэн, яллагдагч, нэхэмжлэгч, хариуцагч нар өөрсдөө өмгөөлөгчөө чөлөөтэй сонгож чаддаггүй” гэжээ.

Энэ нь нэг талаар өмгөөлөгчийн хүрэлцээ муу, өмгөөлөгчөө чөлөөтэй сонгох боломж хязгаарлагдмал байгаатай холбоотой юм. Өмгөөлөгч нар хот суурин газар ихээр төвлөрсөн, харин хөдөө, орон нутагт өмгөөлөгч боловсон хүчин дутагдалтай байдаг байна. Төлбөрийн чадваргүй иргэнийг өмгөөлөх өмгөөлөгчийг аймаг, нийслэлийн өмгөөлөгчдийн зөвлөл томилох тухай “Хууль зүйн туслалцаа үзүүлэхэд төлөх хөлсний жишиг”-г заажээ. Төлбөрийн чадваргүй иргэний өмгөөллийн зардлыг төсвөөс санхүүжүүлэхэд ямар нэгэн хязгаарлалт байхгүй юм. Өөрөөр хэлбэл төлбөрийн чадваргүй иргэн жилд хэдэн ч удаа хууль зүйн үнэ төлбөргүй туслалцаа авч болно гэсэн үг.

Түүнчлэн хоригдлын өмгөөллийн болон хууль зүйн туслалцаа авах эрхийг хангах нь асуудал чухал юм. 1996 онд Монгол Улсын Хууль зүйн сайдын тушаалаар “Хоригдлын өмгөөллийн болон хууль зүйн туслалцаа авсны хөлс төлөх журам” батлагдсан бөгөөд гяндан, хугацаагүй хорих тусгай салбар, дамжин өнгөрүүлэх, насанд хүрээгүйчүүдийн хорих ангид ял эдэлж байгаа болон тахир дутуугийн I, II зэрэгтэй хоригдлын өмгөөллийн хөлсийг улсын төсвөөс, харин хорих ангид ял эдэлж буй хоригдлын өмгөөллийн хөлсийг тухайн хорих анги хариуцдаг байна. Хорих анги нь хоригдлын өмгөөллийн хөлсийг түүний хөдөлмөрийн хөлснөөс суутгадаг. ЭБШХ-иар төлбөрийн чадваргүй иргэдийг шүүхийн зардал төлөхөөс чөлөөлдөггүй байна.

Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны бүх үе шатанд өмгөөлөгчийн үзүүлэх хууль зүйн туслалцаанд дараахь үйл ажиллагаа орно:

- Хууль зүйн асуудлаар зөвлөгөө, мэдээлэл, лавлагаа өгөх;
- Эрх зүйн ач холбогдол бүхий баримт бичгийн эх зохиож туслах;
- Иргэний хэрэг, захиргааны зөрчлийн талаар шүүх болон төр, захиргааны байгууллагад төлөөлөх;
- Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаа болон эрүүгийн хэргийг шүүхээр шийдвэрлэхэд өмгөөлөгчөөр оролцох;
- Иргэд, байгууллагын хүсэлтээр хууль тогтоомжид заасан хууль зүйн бусад туслалцаа үзүүлэх зэрэг хууль зүйн туслалцааг үзүүлнэ гэж хуульчлан заажээ.

Шинэ Эрүүгийн байцаан шийтгэх хуулинд сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн өмгөөлүүлэх эрхийг баталгаатай хангах зорилгоор байцаан шийтгэх ажиллагаанд өмгөөлөгчийн оролцоо, эрх мэдлийг нэмэгдүүлэх тал дээр дараахь өөрчлөлтүүдийг оруулсан нь энэ эрхийн хэрэгжилтэнд дэвшил гарах алхмуудын нэг юм. Үүнд:

- Хуучин хуулинд өмгөөлөгч заавал оролцуулах хэргийн жагсаалтыг зөвхөн шүүхийн процесст хамааруулж байсан бол шинэ хуулийн 40.1-д зааснаар хэрэг, бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүх хуралдааны ажиллагаанд өмгөөлөгч заавал оролцуулах хэргийн жагсаалтыг хуульчилсан байна.
- ЭБШХ-ийн 38.2-т “Мэргэжлийн өмгөөлөгч оролцох боломжгүй бол байцаан шийтгэх ажиллагаанд оролцоход харшлах шалтгаангүй этгээдийг сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч өөрөө өмгөөлөгчөөр сонгоно” гэсэн нэмэлтийг оруулж өгсөн нь өмгөөлөгч хүрэлцээгүй болон чанартай мэргэжлийн өмгөөлөгчийн туслалцаа авч чадахгүй байгаа олон иргэдийн эрхэд нийцсэн заалт болжээ гэж хуульчид болон иргэд үзэж байгаа юм.
- ЭБШХ-ийн Өмгөөлөгчийн эрх, үүрэг гэсэн 41-р зүйлийн 3.3-т хохирогч, гэрч, шинжээчийг байцаахад байлцаж, тэдгээрт асуулт тавих эрхтэй гэж заасан нь хуучин хуулинд байсан “хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийн зөвшөөрснөөр дээрх субъектүүдийг байцаахад байлцах эрхтэй” гэснээс арай өөр, илүү эрхтэй болгож өгсөн явдал юм.
- ЭБШХ-ийн 41.3.5-д “өөрийн байлцсан байцаан шийтгэх ажиллагааны тэмдэглэлтэй танилцаж, засвар оруулах тухай саналаа бичгээр гаргах эрхтэй” гэж өөрчилсөн нь хуучин хуулинд заасан “өөрийн байлцсан хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааг протоколд бүрэн зөв бичсэн эсэх тухай саналаа бичгээр гаргах эрхтэй” гэснээс зарчмын хувьд арай өөр бөгөөд өмгөөлөгчид илүүтэй эрх олгосон заалт гэж үзэж болохоор байна.
- Хуучин хуулинд “шинжээчийн дүгнэлт гаргуулах хүсэлт тавих эрхтэй” гэж байсан боловч шинэ хуулинд тийм зүйл байхгүй байна. Гэвч шинэ хуулийн 41.3.2-т “Хуулийн 92-р зүйлд заасны дагуу хууль зүйн туслалцаа үзүүлэхэд шаардлагатай эд зүйл, баримт бичиг, мэдээлэл, бусад нотлох баримтыг цуглуулах талаар хүсэлт тавих, гаргаж өгөх, түүнийгээ шалгуулах, хавтаст хэрэгт тусгуулах эрхтэй” гэж заасан байна. Тэгвэл ЭБШХ-ийн 92.2-т “мөрдөн байцаагч, хэрэг бүртгэгч, прокурор талуудын хүсэлтээр болон өөрийн санаачилгаар энэ хуульд заасан журмын дагуу мэдүүлэг авах, дүгнэлт гаргуулахаар шинжээч томилох, үзлэг, нэгжлэг хийх болон энэ хуульд заасан бусад байцаан шийтгэх ажиллагаа явуулах, байгууллага, албан тушаалтан, иргэнээс болон гүйцэтгэх ажил эрхэлж байгаа байгууллагаас хэрэгт ач холбогдол бүхий эд мөрийн баримт, баримт сэлтийг гаргуулан авах, эрх бүхий байгууллага, албан тушаалтнаар шалгалт, үзлэг хийлгүүлэхийг шаардах эрхтэй” гэж хуульчилсан байна.
- Өмгөөлөгчийн байцаан шийтгэх ажиллагаанд эдлэх эрхийн хүрээнд шинэ хуульд заасан хамгийн гол чухал заалтуудын нэг нь өмгөөлж байгаа сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих асуудлыг шүүхэд шийдвэрлэхэд хүсэлтээрээ байлцаж, шүүхэд санал гаргах эрхийг баталгаажуулсан явдал юм.

Шинэ хуулийн дээрх заалтууд иргэдийн өмгөөлүүлэх эрхийг баталгаатай эдлүүлэхэд байцаан шийтгэх ажиллагааны бүхий л үе шатанд хязгаарлагдмал байсан өмгөөлөгчийн эдлэх эрхийг нэлээд өргөн болгож өгснөөрөө дэвшилттэй юм.

Гэмт хэргийн хохирогчдод үзүүлэх хууль зүйн туслалцаа

Гэмт хэргийн улмаас хохирсон иргэнд хууль зүйн туслалцаа үзүүлэх нь анхаарлын гадна үлдсэн асуудал юм. Гэмт хэргийн улмаас хохирсон хохирогчийн эрх ашиг бүрэн гүйцэд хангагдахгүй, түүнчлэн бие махбод, сэтгэл санаа, эд материалын хувьд ихээхэн хохирол учирдаг. Оны эхний хоёр сарын байдлыг Цагдаагийн ерөнхий газрын мэдээнд тулгуурлан харахад бүртгэгдсэн гэмт хэргийн тоо 3.9 мянга байна. Тэгвэл гэмт хэргийн улмаас нийтдээ дөрвөн тэрбум төгрөгийн хохирол учирсны дөнгөж 9.1 хувийг нөхөн төлүүлсэн байх юм³.

Эрх зүйн хүрээнд авч үзвэл, ЭБШХ нь хохирогчийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах, хангах талаар тусгагдсан зүйл бага, харин гэмт хэргийг илрүүлэх, гэмт этгээдийг олох, ял шийтгэл оногдуулахад чиглэгдэж, хохирогчид хууль зүйн туслалцаа үзүүлэх асуудал сэжигтэн, яллагдагчийн нэгэн адил өмгөөлүүлэх эрхийг нь илүү

³ Д.Энхжаргал, ХЭҮТ-ийн захирал, “Гэмт хэргийн хохирогчийн эрх зүйн хамгаалалт” илтгэл, Эрх Зүйн Шинэтгэлийг Дэмжих Хуульчдын Төвөөс хэвлүүлсэн Хүний эрхийн форумын тайлан, 2002 он

баталгаатай болгоход чиглэгдээгүй байна. Тухайлбал, ЭБШХ-ийн 46 дугаар зүйлд зөвхөн сэжигтэн, яллагдагчийн өмгөөлүүлэх эрхээ хэрэгжүүлэх баталгааг заажээ.

Гэмт хэргийн хохирогчийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах үүднээс хохирогчдод хууль зүйн туслалцаа үзүүлэх асуудал төрийн ивээлд байх учиртай. Түүнчлэн гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг барагдуулах явдал хохирогчийн эрхийг хамгаалах гол үзүүлэлт юм.

“Төлбөрийн чадваргүй иргэний өмгөөллийн зардлыг төсвөөс санхүүжүүлэх, тайлан тооцоо гаргах журам”-д “Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн өөрийгөө болон гэр бүлээ тэжээх сарын орлого нь Засгийн газраас тогтоосон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнд хүрэхгүй, үүнээс хамааран байнгын хязгаарлагдмал хэрэглээтэй амьдардаг иргэдийг төлбөрийн чадваргүй өмгөөлүүлэгч гэж тооцно” гэсэн нь төлбөрийн чадваргүй хохирогчийн хууль зүйн туслалцаа авах эрх хангагдах боломжгүй болж байна.

Гэмт хэргийн хохирогч, түүний гэр бүл, ойр дотны хүмүүст бие махбод, сэтгэл санаа, санхүүгийн хувьд урт удаан хугацааны туршид нөхөж баршгүй хор хохирол учирдаг. Үүн дээр нэмээд өмгөөлөгч хөлслөх гээд хохирсон дээрээ илүү хохирдог явдал бий. Өмгөөлөгч заавал орох хэргүүдээс бусад хэргийн зарим хохирогч санхүүгийн байдлаасаа хамааран хууль зүйн зөвлөгөө, туслалцаа авч чадахгүй байна. Төлбөрийн чадваргүй иргэдэд өмгөөлөгч томилуулах явдал голчлон сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчид мөрдөн байцаагч, шүүгчээс гаргасан хүсэлтийн дагуу МӨХ-оос гаргуулах явдал илүүтэй байна. Харин гэмт хэргийн хохирогчид өмгөөлөгч заавал авах эрх болон хэрхэн үнэ төлбөргүй өмгөөллийн туслалцаа авах ёстой гэдгээ мэддэггүйгээс, мөн энэ талаар эрх бүхий албан тушаалтан мэдээлэл өгдөггүйгээс төлбөрийн чадваргүй хохирогчдын өмгөөлүүлэх эрх ихээхэн зөрчигдөж байна.

Гурав. Иргэний хэрэгт төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн туслалцаа үзүүлэх асуудал

Иргэн, хуулийн этгээд маргаж байгаа болон зөрчигдсэн эрхээ хамгаалуулах эрхтэй бөгөөд Монгол Улсын иргэний баталгаатай эдлэх үндсэн эрхийн нэг бол өмгөөлүүлэх, хууль зүйн туслалцаа авах эрх юм. Энэхүү эрхийн Үндсэн хуулийн эх сурвалж бол Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14 дэх хэсэгт заасан “өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах” эрхтэй гэсэн хувь хүний эрхээ хамгаалах бололцоо, механизм бүхий заалт болно. Энэхүү эрх нь цаашид иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль ИХШШТХ-д тусгалаа олж, тус хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Иргэн нь өөрийн биеэр, төлөөлөгчөөрөө дамжуулан шүүхэд хэрэг хянан шийдвэрлэхэд оролцоно”, 2 дахь хэсэгт “Төлөөлөл нь хуульд зааснаар, эсхүл сайн дураар буюу гэрээгээр төлөөлөх хэлбэртэй байна” гэж заажээ.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд иргэд, хуулийн этгээд өөрийн эрх, эрх чөлөө, ашиг сонирхлоо хамгаалах үйл ажиллагааг өөрөө хэрэгжүүлэх буюу төлөөлөгчөөр дамжуулан гүйцэтгүүлдэг. Өөрийн эрх, ашиг сонирхлоо өөрийн биеэр шүүхэд хамгаалах асуудал нь Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14 дэх хэсэгт заасан “өөрийгөө өмгөөлөх” эрхээр баталгаажиж байна. Харин төлөөлөгчөөр дамжуулан эрх, ашиг сонирхлоо хамгаалах нь хууль зүйн туслалцаа авах эрхтэй холбоотой юм. Энэ талаар Иргэний хуулийн 5 дугаар зүйлд “Талууд эрхээ хамгаалуулах этгээдийг хуульд заасны дагуу өөрсдөө сонгон тодорхойлох эрхтэй” гэжээ. Мөн ИХШШШ ажиллагаанд хуульд зааснаар төлөөлөх гэсэн ойлголт байдаг ба энэ нь 1.Хуульд зааснаар (хууль ёсны төлөөлөл), 2. Сайн дураар, 3. Гэрээний үндсэн дээр төлөөлөх гэж ангиллагддаг. ИХШШТХ-ийн 30, 31 дүгээр зүйлд зааснаар иргэнийг хуульд зааснаар төлөөлөх үндэслэл, эрх бүхий этгээд нь:

1. Эрх зүйн бүрэн чадамжгүй болон зарим буюу хэсэгчилсэн чадамжтай хүний эрх, эрх чөлөө, хуулиар хамгаалагдсан ашиг сонирхлыг түүний хууль ёсны төлөөлөгч, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч;

2. Сураггүй алга болсонд тооцогдсон хүн оролцвол зохих байсан хэрэгт түүний эд хөрөнгийг хамгаалахаар томилогдсон этгээд;

3. Нас барсан буюу нас барсан гэж зарлагдсан хүний өв залгамжлагч оролцвол зохих байсан хэрэгт өв залгамжлагч нь уул өвийг хүлээж аваагүй байвал өвлөгдөх эд хөрөнгийг хамгаалахаар томилогдсон этгээд.

Эрх зүйн чадамжгүй болон зарим буюу хэсэгчилсэн чадамжтай хүний эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд өөрийн сонгон авсан төлөөлөгчийг оролцуулж болно. Эрх зүйн бүрэн чадамжгүй болон зарим буюу хэсэгчилсэн чадамжтай, сураггүй алга болсонд тооцогдсон болон нас барсан буюу нас барсан гэж зарлагдсан этгээдийн эрх, эрх чөлөө, хуулиар хамгаалагдсан ашиг сонирхлыг шүүхэд хамгаалах төлөөлөгчийг хуульчлан баталгаажуулсан нь хүний эрхийг хамгаалах, хууль зүйн туслалцаа авах эрхийг хангаж буй явдал мөн. Иргэн нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд төлөөлөгчөөр оролцож болохгүй дараахь үндэслэлүүдийг хуулиар тогтоожээ. Үүнд:

- 1.18 насанд хүрээгүй;
2. Эрх зүйн бүрэн чадамжгүй;
3. Шүүгч, прокурор, мөрдөн байцаагч.

Гэхдээ шүүгч, прокурор, мөрдөн байцаагч нь эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хувиар болон өөрийн ажиллаж байгаа байгууллагын төлөөлөгчөөр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож болно (ИХШХШТХ-ийн 35 дугаар зүйл). Сайн дурын төлөөлөл гэдэг нь эрх зүйн бүрэн чадамж бүхий иргэн сайн дураараа, гэр бүлийн гишүүн, төрөл садангаараа төлөөлүүлэх явдал юм. Харин гэрээний үндсэн дээр төлөөлөл нь тодорхой гэрээний үндсэн дээр өмгөөлөгчөөр төлөөлүүлэхийг ойлгодог.

Иргэний хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагаанд өмгөөлөгч дараахь мэргэжлийн хууль зүйн туслалцаа үзүүлдэг. Үүнд:

- Хууль зүйн асуудлаар зөвлөгөө, мэдээлэл, лавламж өгөх, эрх зүйн ач холбогдолтой баримт бичиг боловсруулах, түүнд санал өгөх
- Иргэний хэргийг шүүхэд хянан шийдвэрлэхэд төлөөлөгчөөр оролцох;
- Хуулиар хориглоогүй хууль зүйн бусад туслалцаа үзүүлэх (дүрэм боловсруулах, хуулийн этгээд бүртгүүлэх).

Төлбөрийн чадваргүй иргэд хууль зүйн үнэ төлбөргүй туслалцаа авах эрхээ иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны туршид (анхан шат, давах болон хяналтын шатны шүүхэд) эдлэх боломжтой. Энэ талаар хууль болон журамд ямар нэгэн хязгаарлалт байхгүй юм. Харин төлбөрийн чадваргүй иргэд давах болон хяналтын шатны шүүхэд гомдол гаргах замаар эрхээ хамгаалах энэ арга, механизмыг хэр зэрэг үр дүнтэй ашигладаг болох талаар ямар нэг тоо, баримт, судалгаа алга болно. Гэхдээ ажиглалтаас үзэхэд ялангуяа давж заалдах болон хяналтын шатанд төлбөрийн чадваргүй иргэдийн хууль зүйн туслалцаа авах эрх илүү хязгаарлагдмал болох нь харагдаж байв. Төлбөрийн чадваргүй иргэний өмгөөллийн үйл ажиллагаатай холбогдсон зардлын асуудал бол төлбөрийн чадваргүй иргэний хууль зүйн туслалцаа авах эрхийг хангахад чухал үүрэгтэй юм.

Монгол улсад одоогоор төлбөрийн чадваргүй иргэний хэрэгт өмгөөлөгч заавал оролцуулах тухай тодорхой заалт байхгүй бөгөөд ИХШХШ ажиллагааны үед төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн туслалцаа үзүүлэх асуудлыг “Төлбөрийн чадваргүй иргэний өмгөөллийн зардлыг төсвөөс санхүүжүүлэх, тайлан, тооцоо гаргах журам”-аар зохицуулдаг байна.

Төрийн зохих байгууллагаас тодорхой үйлчилгээ үзүүлсний төлөө зохих этгээдээс төлж байгаа мөнгөн хөрөнгийг улсын тэмдэгтийн хураамж гэдэг. Улсын тэмдэгтийн хураамж хураах 10 гаруй үйлчилгээг хуулиар тогтоосон байдаг бөгөөд үүний нэг нь шүүхээс эрх зүйн маргааныг хянан шийдвэрлэхэд төлөх хураамж юм. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6-д төлбөрийн чадваргүй иргэний шүүхээр эрхээ хамгаалуулах эрхийг хангахын тулд “шүүхийн зардал төлөх хөрөнгөгүй учир шүүхийн шийдвэр, магадлалаар шүүхийн зардал төлөхөөс чөлөөлөгдсөн иргэний нэхэмжлэл”-ийг хураамжаас бүрэн чөлөөлөх тухай заажээ. Энэхүү заалт нь төлбөрийн чадваргүй иргэдийн тухайд шүүхэд гомдол гаргах эрхээ эдлэхэд маш их ач холбогдолтой болно. Гэвч хуулиар олгогдсон эл боломжийн талаархи мэдээлэл, ухуулга сурталчилгаа муу байдгаас төлбөрийн чадваргүй иргэд төдийлөн сайн мэддэггүй юм.

Түүнчлэн мөн зүйлийн 2 дахь хэсэгт “Шүүх хуульд заасны дагуу өргөдөл, гомдол, нэхэмжлэл гаргагчдын эд хөрөнгийн байдлыг харгалзан хураамж төлөх хугацааг хойшлуулж, тэдний хураамжаас чөлөөлөх буюу төлөх хураамжийн хэмжээг багасгаж болно” гэсэн нь зөвхөн төлбөрийн чадваргүй иргэдийн тухайд бус, орлого, төлбөрийн

чадвар бага иргэдийн хувьд хураамж төлөх хугацаагаа хойшлуулах, чөлөөлөгдөх, хэмжээг нь багасгуулах талаар өргөн боломж хуулиар олгогдсон гэж үзэж болохоор байна. Энэ бүхнээс дүгнэн үзвэл, төлбөрийн чадваргүй иргэдийн нэхэмжлэл улсын тэмдэгтийн хураамж төлөхөөс хуулиар чөлөөлөгдсөн учир хууль зүйн туслалцаа авах эрх, шүүхэд гомдол гаргах эрхээ эдлэхэд нэн таатай боломжийг бүрдүүлж байна.

Төлбөрийн чадваргүй иргэдийн хувьд шинжээч, орчуулагчийн тээвэр, байр, хоолны зардал, гэрчийн тээвэр, байр, хоолны зардал, цалин, хөдөлмөрийн хөлс, үзлэг хийх, туршилт явуулах, таньж олуулах ажиллагаа явуулахад гарсан зардал, эд мөрийн баримт хадгалуулсны зардал зэрэг шүүхийн зардал нөхөн төлөхөөс чөлөөлж болох талаар ИХШХШТХ-ийн 53 дугаар зүйлд заажээ.

Гэхдээ энэ нь төлбөрийн чадваргүй эмзэг бүлгийн гишүүдийн хувьд хууль зүйн үнэ төлбөргүй туслалцаа авах эрх нь нээлттэй, хууль зүйн баталгаа биш юм.

Иргэний хэргийн хувьд хууль зүйн үнэ төлбөргүй туслалцаа эрсэн хүмүүсийн ихэнх нь орон сууцны маргаантай бөгөөд орон байрнаасаа хөөгдөхөд тулаад байгаа, ажлаас үндэслэлгүй халагдсан гэх асуудалтай төлбөрийн чадваргүй иргэд байдаг байна.

Цаашид хуульд зааснаар төлөөлөх төлөөллийн хүрээг өргөтгөн, төлбөрийн чадваргүй иргэдийн хууль зүйн туслалцаа авах эрхийг хуульчлах шаардлага байна. Энэ нь төлбөрийн чадваргүй иргэдийн хууль зүйн туслалцаа авах эрхийг хангахад чухал ач холбогдолтой бөгөөд төлбөрийн чадваргүй иргэний хууль зүйн туслалцаа авах эрхийг иргэний хэргийг хянан шийдвэрлэх бүх шатанд заавал хангасан байх нь зүйтэй юм гэж манай зарим хуульчид үзэж байна.

Дөрөв. Нийтийн эрх зүйн хүрээнд үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа авах эрхийн баталгаа, хэрэгжилтийн байдал

Үндсэн хуулийн эрх зүй

Үндсэн хуулийг дээдлэх зарчим нь түүнийг бусад хуулиас илүү хүчин чадалтайд тооцох нөхцлийг бүрдүүлдэг ба Үндсэн хуулийн байгууллагуудын хооронд үүсч буй улс төрийн өндөр түвшингийн маргаануудыг ч шийдвэрлэхэд /эрх мэдэл хоорондын маргаан/, түүнчлэн өдөр тутмын амьдралд үүсдэг маргаануудыг иргэдээс ирүүлэх өргөдлийн дагуу шийдвэрлэхэд ч ихээхэн ач холбогдолтой хэмээн үздэг.

Үндсэн хуулийг дээдлэх зарчмын биет илрэл нь Үндсэн хууль шууд үйлчлэх, түүнийг эрх бүхий шүүхээс хэрэглэх явдал юм.

1992 оны Үндсэн хууль батлагдсанаар Монгол Улс анх Үндсэн хуулийн Цэц хэмээх оноосон нэртэй Үндсэн хуулийн шүүхтэй болсон юм. Цэц нь үндсэн хуулийн биелэлтэнд дээд хяналт тавьж маргааныг магадлан шийдвэрлэнэ. Тэгвэл манай ҮХЦ-ийн (Үндсэн хуулийн цэц) тавьдаг хяналт бол хийсвэр юм. Энэхүү хийсвэр хяналт нь амьдралын тодорхой нэг зөрчил буюу маргаанаас ангид байдлаар эрх бүхий субъектуудын хүсэлтээр хэрэгждэг. Тодруулж хэлбэл, амьдралын тодорхой нэг маргаан үүссэн эсэхээс үл хамааран өргөдөл, хүсэлт гаргагчид өөрт нь үл хамаарах асуудлаар ч гэсэн, түүний үндсэн эрх зөрчигдөөгүй байхад гагцхүү хуулинд заасан цөөн тооны объектыг зөрчсөн гэж үзсэн тохиолдолд Цэцэд хандаж болдог энэхүү хязгаарлалт чухамхүү Үндсэн хуулийг шууд үйлчлэх хууль зүй болгоход саад учруулж байгаа юм. Үндсэн хуулийн жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт Үндсэн хуулийн Цэцийн шийдвэрлэх маргааны харъяаллыг тогтоожээ. “Үндсэн хуулийн Цэцийн харъяалан шийдвэрлэх маргааныг ерөнхийд нь 1. Маргаанд харьяалагдах актууд, 2. Маргаанд харьяалагдах албан тушаалтнууд гэж хоёр хэсэгт багцалж байна”.⁴

Үндсэн хууль зөрчсөн эсэх талаар Үндсэн хуулийн Цэцийн харъяалан дүгнэлт гаргадаг актуудад: 1/Улсын Их Хурлаас баталсан хууль, 2/Улсын Их Хурлын бусад шийдвэр, 3/Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, 4/Улсын Ерөнхийлөгчийн бусад шийдвэр, 5/Засгийн газрын шийдвэр, 6/Монгол Улсын олон улсын гэрээ, 7/Ард нийтийн санал асуулгын талаар сонгуулийн ерөнхий хорооноос гаргасан шийдвэр, 8/Улсын Их хурал, түүний гишүүдийн сонгуулийн талаар Сонгуулийн ерөнхий хорооны шийдвэр, 9/Улсын ерөнхийлөгчийн сонгуулийн талаар Сонгуулийн ерөнхий хорооны шийдвэрүүд.

Үйл ажиллагаа нь Үндсэн хуулийн заалт зөрчсөн эсэх талаар Үндсэн хуулийн Цэцэд харьяалагддаг албан тушаалтнууд нь: 1/Улсын ерөнхийлөгч, 2/Улсын Их Хурлын

⁴ Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар., УБ., 2000 он, 259-р хуудас

дарга, 3/Улсын Их хурлын гишүүд, 4/Ерөнхий сайд, 5/Засгийн газрын гишүүд, 6/Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч, 7/Улсын ерөнхий прокурор.

Тэгэхээр иргэн нь Үндсэн хуулинд заасан хяналтын объектоор Цэцэд хандах эрхтэй. Харамсалтай нь энэхүү объектод үндсэн эрх ордоггүй. Тэгвэл төлбөрийн чадваргүй иргэд маань ядуу учраас тэдний үндсэн эрх зөрчигдсөн, төр засгийн албан тушаалтны зүгээс тэднийг ялгаварлан гадуурхсан байдаг. Ийнхүү асуудлаар иргэн Үндсэн хуулийн цэцэд хандсан тохиолдолд маргаан харьяаллын бус учир өргөдлийг хүлээж авахгүй гэдэг нь ойлгомжтой.

Үндсэн хуульд заасан үндсэн эрх нь зөрчигдсөн иргэн Цэцэд хандах эрх зүйн орчин бүрдээгүй, иргэн хүн хуульд заасан цөөн тооны объектыг л Үндсэн хууль зөрчсөн эсэхийг хянуулахаар, өөрөөр хэлбэл, өөрт нь хамааралгүй асуудлаар Цэцэд хандах эрхтэй байгаа нь үндсэн эрхийг шууд үйлчлэх шинж чанаргүй болгож байгаа юм. Үүнээс үзэхэд манайд Үндсэн хуулиар олгогдсон үндсэн эрхээ зөрчигдсэн гэж үзээд гомдол гаргах гарц хаагдмал байгааг харуулж байна.⁵ Гэхдээ төлбөрийн чадваргүй иргэд хуульд заасан үндэслэлээр Үндсэн хуулийн Цэцэд хандах эрх нь нээлттэй, хууль зүйн баталгаатай. Харин хууль зүйн туслалцаа авах эрхийг нь хэрхэн хангах талаар Үндсэн хуулийн Цэцийн (1992) болон Үндсэн хуулийн Цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд (1997) тодорхой зүйл, заалт байхгүй болно.

“Төлбөрийн чадваргүй иргэний өмгөөллийн зардлыг төсвөөс санхүүжүүлэх, тайлан тооцоо гаргах гаргах журам” нь зөвхөн эрүү, иргэн, захиргааны хэрэгт хууль зүйн туслалцаа авах төлбөрийн чадваргүй иргэдэд үйлчилдэг. Тийм учраас төлбөрийн чадваргүй иргэд Үндсэн хуулийн Цэцэд маргаан шийдвэрлэх ажиллагаанд өөрсдөө өмгөөллийн зардлыг төлөх болж байгаа юм. Дүгнэн үзвэл, төлбөрийн чадваргүй иргэд хууль зүйн үнэ төлбөргүй туслалцааг эрүү, иргэн, захиргааны хэрэгт авч болдог, харин Үндсэн хуулийн Цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд энэхүү журам нь хамаарахгүй байгаа нь ойлгомжгүй байгаа юм. Одоогоор үндсэн хуулийн Цэцэд маргаан шийдвэрлэх ажиллагаанд оролцох төлбөрийн чадваргүй иргэдэд төрөөс хууль зүйн үнэ төлбөргүй туслалцаа үзүүлэх, хууль зүйн туслалцаа авах эрхийг нь хангах талаар тогтоосон ямар нэгэн журам, заавар байхгүй. Цэцийн хуралдаанд маргагч талууд өөрсдийн итгэмжлэгдсэн төлөөлөгч, өмгөөлөгчтэй байх эрхтэй бөгөөд итгэмжлэгдсэн төлөөлөгч нь иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд заасан журмын дагуу томилогдсон байна. Монгол Улсын иргэдээс гадна Монгол Улсын нутаг дэвсгэрт хууль ёсоор оршин суугаа гадаад улсын иргэн, харьяалалгүй хүн Цэцэд өргөдөл, мэдээлэл, гомдол гаргах эрхтэй байдаг. Цэцээс гадаадын иргэн буюу монгол хэл мэдэхгүй хүнд хэлмэрчээр дамжуулан төрөлх буюу сайн мэдэх хэлээрээ ярих, ойлгох бололцоог олгодог. Цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцсон гэрч, шинжээч, мэргэжилтэн, орчуулагчийн болон бусад шаардлагатай зардлыг улсын төсвөөс төлдөг байна.

Захиргааны хэрэг, маргаан

Монгол Улсын Үндсэн хуулийн арван зургаа дугаар зүйлд: “Иргэн төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх эрхтэй. Төрийн байгууллага, албан тушаалтан нь иргэдийн өргөдөл, гомдлыг хуулийн дагуу шийдвэрлэх үүрэгтэй” гэж заасан бөгөөд уг харилцааг “Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай” (1995) хуулиар, харин захиргааны зөрчил гаргасан этгээдэд захиргааны хариуцлага хүлээлгэхтэй холбогдсон харилцааг “Захиргааны хариуцлагын тухай” (1992) хуулиар тогтоон хэрэгжүүлж байна.

1996-2000 оны бүрэн эрхийн хугацаанд УИХ-д 6400 шахам иргэн (жилд дунджаар 1600 хүн) өргөдөл, гомдол ирүүлсэн байх бөгөөд нийт өргөдөл, хүсэлтийн 38.6 хувь нь “ахуй амьдралын хүндрэл бэрхшээлээ шийдвэрлүүлэх үүднээс зээл, мөнгөн болон эд материалын тусламж үзүүлэх” асуудлыг хөнджээ. УИХ-д ирүүлсэн гомдлын дийлэнх нь “иргэний зөрчигдсөн эрхийг төрийн байгууллага зохих ёсоор хамгаалж чадахгүй” байгаа тухай өгүүлжээ. Засаг захиргааны байгууллага, албан тушаалтны хууль бус үйлдлээс иргэдийг шүүхийн журмаар хамгаалах механизм өдгөө бүрдээгүй байгаа нь иргэдийн энэхүү эрхийг хангах явдалд тохиолдож буй гол бэрхшээлийн нэг гэж үзэж болно.⁶

⁵ М. Ичинноров “Хүний эрх: Монгол Улсын Үндсэн хууль, эрүү, ЭБШХ, иргэн, ИХШХТХ”

⁶ Монгол Улс дахь хүний эрхийн төлөв байдал., УБ, 2001 он

Үндсэн хуулиар баталгаажсан хүний эрх, эрх чөлөөг захиргааны зөрчлийн улмаас засаг захиргааны байгууллага, түүний албан тушаалтан зөрчихөөс өмгөөлөгч урьдчилан сэргийлэх, зөрчигдсөн эрхийг сэргээхэд хууль зүйн туслалцаа үзүүлэх, зөрчил гаргасан этгээд хууль зүйн туслалцаа авах эрхтэй (Захиргааны хариуцлагын тухай хуулийн 9 дүгээр зүйл). Захиргааны журмаар албадан саатуулагдсан, зөрчил гаргасан этгээдийн гэр бүл, өмгөөлөгчид нь албадан саатуулагдсан этгээд хаана, ямар газар, албан тушаалтны мэдэлд байгааг мэдэгдэх тухай, захиргааны зөрчил ногдуулсан шийдвэрийг зөрчил гаргасан этгээд, хохирогч, тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч буюу өмгөөлөгч давж заалдах эрхтэй гэж Захиргааны хариуцлагын тухай хуулийн 13.5, 19.1 дэх хэсэгт тус тус заажээ. Захиргааны зөрчлийг хянан шийдвэрлэх ажиллагаанд хууль зүйн туслалцаа болон өмгөөлөгч заавал авах тухай, түүнчлэн төлбөрийн чадваргүй иргэний хууль зүйн туслалцаа авах эрхийг тусгайлан хуульчлан зохицуулсан зүйл байхгүй болно.

“Төлбөрийн чадваргүй иргэний өмгөөллийн зардлыг төсвөөс санхүүжүүлэх, тайлан тооцоо гаргах журам” нь захиргааны хэрэгт хууль зүйн туслалцаа авах төлбөрийн чадваргүй иргэдэд үйлчлэх ёстой хэдий ч захиргааны зөрчил, хэрэг маргаанд оролцогч төлбөрийн чадваргүй иргэдийн зүгээс үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа авах явдал хэрхэн хангагддаг нь нэлээд бүрхэг, тодорхойгүй бөгөөд энэ талаар бидэнд ямар нэгэн тоо баримт илрээгүй болно.

Олон улсын эрх зүй

Монгол Улсын Үндсэн хуулийн 14 дүгээр зүйлд: “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна” гэж заасан бөгөөд гадаадын иргэн, харьяалалгүй хүмүүсийн хувьд хууль зүйн туслалцаа авах эрх нь нээлттэй юм. Түүнчлэн Үндсэн хуулийн 53 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт: “Монгол хэл мэдэхгүй хүнд хэргийн баримт сэлтийг хэлмэрчлүүлэн бүрэн танилцуулах бөгөөд шүүх хуралдаан дээр эх хэлээр нь үг хэлэх эрх олгоно” гэж заасан. ЭБШХ-иар гадаадын иргэд буюу монгол хэл мэдэхгүй этгээдийн хэрэгт заавал өмгөөлөгч оролцуулах талаар заасан гадаадын иргэдийн хууль зүйн туслалцаа авах эрхийг хангаж буй чухал баталгаа болно.

Монголд одоогийн байдлаар Олон улсын байгууллагад тодорхой иргэд, байгууллагын хэрэг маргааны талаар гомдол гаргасан явдал байхгүй байна. Харин саяхан хүний эрхийн 32 төрийн бус байгууллагыг нэгтгэсэн Хүний эрхийн форум хүний халдашгүй дархан байх эрх, хууль шүүхийн өмнө тэгш байх эрх, шударга шүүхээр шүүлгэх эрх нь зөрчигдсөн тодорхой хүний хэргээр НҮБ-ын хүний эрхийн хороонд хандахаар ажилласан нь, хүний эрхийн зөрчилд төрийн бус байгууллагууд олон улсын байгууллагад хандах оролдлого хийж буй анхны тохиолдол юм.

Тав. Хууль зүйн туслалцаа үзүүлэх байгууллагын тогтолцоо

Үйл ажиллагааныхаа үндсэн зорилт, чиг үүрэгтэйгээ уялдуулан хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагууд иргэд, аж ахуйн нэгжид хууль зүйн туслалцааг дараахь 2 чиглэлээр үзүүлдэг. Үүнд:

1. Хууль тогтоомж сурталчлах, тайлбарлан таниулах;
2. Хүний эрх, эрх чөлөөг хангах, хамгаалах.

Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомжийг сурталчлах, тайлбарлан таниулах ажлыг хуулийн байгууллагууд өөр өөрийн онцлогт нийцүүлэн явуулдаг:

1/ Хууль зүй, дотоод хэргийн яам нь хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын хувьд хууль тогтоомжийн бүртгэл-лавламжийн сан бүрдүүлж иргэд, аж ахуйн нэгжид лавлагаа, мэдээлэл өгөх, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах, тайлбарлан таниулах, хууль тогтоомжийг эмхтгэн хэвлүүлж нийтийн хүртээл болгох, зайны болон эчнээ сургалт зохион байгуулах зэргийг тухайн ажил хариуцсан Мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний газрын шугамаар хэрэгжүүлдэг.

2/ Улсын дээд шүүх хуулийн тайлбар гаргах, дээд шүүхийн бүгд хурлын тогтоолыг эмхтгэн хэвлүүлэх, хэвлэл мэдээллийн хэрэгслээр хууль тогтоомж сурталчлах, тайлбарлан таниулах хэлбэрээр хэрэгжүүлдэг.

3/ Улсын ерөнхий прокурорын газар, Цагдаагийн ерөнхий газар салбарын хууль тогтоомжийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах, тайлбарлан танилцуулах хэлбэрээр хэрэгжүүлдэг.

4/ ХЗДХЯ, УДШ, УЕПГ, ЦЕГ-ын орон нутгийн байгууллагууд хууль тогтоомж сурталчлах, тайлбарлан таниулах ажлыг тухайн нутаг дэвсгэрийн хэмжээнд хамтын хүчээр зохион байгуулдаг.

Хүний эрх, эрх чөлөөг хангах, хамгаалахтай холбогдуулж юуны өмнө иргэн өөрийгөө өмгөөлөх, өмгөөлүүлэх эрхээ хэрхэн хэрэгжүүлэхэд нь туслах үүрэг бүхий хуулийн байгууллагын үйл ажиллагаа харилцан адилгүй байдаг. Тухайлбал:

1. Монголын өмгөөлөгчдийн холбоо, түүний харьяа аймаг, нийслэлийн өмгөөлөгчдийн зөвлөл нь сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийг хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, шүүхэд хянан шийдвэрлэх бүхий л ажиллагаанд эхнээс нь мэргэжлийн өмгөөлөгч оролцуулан хууль зүйн туслалцаа үзүүлэх үндсэн үүрэгтэй. Өмгөөлөгч нь сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийг цагаатгах буюу түүний хариуцлагыг хөнгөрүүлэх байдлыг тодорхой болгох зорилгоор хуульд заасан бүх арга хэмжээг авч тэдэнд шаардагдах хууль зүйн туслалцаа үзүүлэх ёстой.

2. Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаах, прокурор, шүүхийн байгууллага сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийг эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны бүхий л үе шатанд өмгөөлөгчөө өөрөө сонгох, өмгөөлөгчөөр өмгөөлүүлэх боломжоор хангах, өмгөөлүүлэх эрхээ бүрэн хэрэгжүүлэхэд нь хуульд заасны дагуу туслалцаа үзүүлэх үүрэг хүлээнэ.

Хууль зүйн туслалцаа үзүүлэх асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага

Монгол Улсын хууль зүйн албаны анхны систем нь 1921 оны 7 дугаар сард байгуулагдсан Монгол Улсын Ардын засгийн Шүүх явдлын яам, 1923-1924 оны эхээр байгуулагдсан олон аймаг, хошууны зарга шийтгэх хэлтсүүдээс анхлан бүрдэж, ардчилсан зарчмуудад үндэслэн үйл ажиллагаагаа эхэлсэн түүхтэй.

Хууль хамгаалах болон эрх зүйн ажлыг нэгэн зэрэг эрхэлж байсан төрийн захиргааны төв, орон нутгийн байгууллагаас 1926 онд шүүхийн, 1930 онд прокурорын байгууллага салбарлан үүсч, цаашдаа тус тусын систем болж бэхэжсэн болно. Түүнчлэн Шүүх яам, түүний орон нутгийн байгууллагын харьяанд байсан Засан хүмүүжүүлэх газруудыг 1936 онд удирдлагын өөр системд шилжүүлсэн. Монголын өмгөөлөгчдийн байгууллагыг “Шүүн таслах явдлын тухайд тусламж үзүүлэх бүлгэм” нэртэйгээр 1928 онд үүсгэж байгуулж, улмаар тус яаманд харьяалуулсан байна. Ер нь цаг үеийн шалгуураар өөрчлөгдөн зохион байгуулагдаж байсан Шүүх яам, Хууль зүйн яамны бүтцэд Өмгөөлөгчдийн хэлтэс, Эрхийн үйлчилгээ, өмгөөллийн хэлтэс, Хууль зүйн алба, өмгөөллийн хэлтэс гэсэн албан ёсны нэгж байсаар ирсэн. Одоо ч гэсэн Хууль зүй, дотоод хэргийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт өмгөөлөх байгууллагын асуудал хариуцсан албан тушаалтан ажиллаж байгаа болно. Энэ нь өмгөөлөх байгууллагыг төр, засаг тодорхой хэмжээгээр ивээлдээ байлгаж, шаардагдах дэмжлэг туслалцаа үзүүлж, мэргэжлийн боловсон хүчнээр бэхжүүлэхийг чармайж ирснийг илтгэнэ.

БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1934 оны 5 дугаар хурлаар Шүүх яамны дэргэд Өмгөөлөгчдийн коллегийг байгуулж дүрмийг нь баталсан байна. Энэ нь өмгөөлөх байгууллагыг өөрчлөн шинэчилж байгуулсан анхны том алхам байв. Өмгөөлөгчдийн коллегийг зохион байгуулах, түүний ажлыг удирдах явдлыг Шүүх яам эрхлэн гүйцэтгэдэг байв. Өмгөөлөгчдийн коллегийн дүрмийг БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1952 оны 253, 1965 оны 243 дугаар тогтоол, АИХ-ын Тэргүүлэгчдийн 1978 оны 256 дугаар зарлигаар тус тус шинэчлэн баталж мөрдүүлсэн юм. Харин АИХ-ын Тэргүүлэгчдийн 1986 оны 127 дугаар зарлигаар Монголын өмгөөлөх байгууллагын тухай БНМАУ-ын хуулийг баталсан нь тус байгууллагын зорилт, үйл ажиллагааг анх удаа хуулийн хүрээнд зохицуулсан явдал болсон юм.

Монгол Улсын Их Хурлаас 1994 онд баталсан Өмгөөллийн тухай хууль нь зах зээлийн харилцаанд шилжих үеийн өмгөөлөх байгууллага, өмгөөлөгчдийн үйл ажиллагаа, эрх хэмжээг зохицуулснаараа өмнөх хуулиас онцлог юм. Энэ хуулийг

мөрдөх хүртэл Шүүх яам, Хууль зүй, арбитраж яам, Хууль зүйн яамны зүгээс Монголын өмгөөлөгчдийн коллеги, аймаг, нийслэлийн Хууль зүйн зөвлөгөө өгөх газрын удирдлагыг өөрчлөхөд тодорхой бодлогоор нөлөөлж төв, орон нутгийн өмгөөлөх байгууллагын үйл ажиллагааг шалгаж, үүрэг даалгавар өгөх зэргээр дотоод ажилд нь ямар нэгэн хэмжээгээр оролцож ирсэн болно.

Өмгөөллийн тухай хуулиар хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын эрх хэмжээг тодорхой болгож өгсөн. Тухайлбал, хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр өмгөөлөгчөөр ажиллах хүнийг сонгон шалгаруулах орон тооны бус мэргэжлийн хороог байгуулж, түүний бүрэлдэхүүн, дүрмийг баталж байхаар, өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх хүсэлт гаргасан, сонгон шалгаруулалтад тэнцсэн Монгол Улсын иргэнд өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгож, өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэхээс чөлөөлж, түдгэлзүүлэх, өмгөөлөгчдийн болон хуульчийн ёс зүйн хэм хэмжээг удаа дараа зөрчсөн бол өмгөөлөгчдийн сахилгын зөвлөлийн шийдвэрийг үндэслэн өмгөөлөл эрхлэх эрхийг хасч байхаар, өмгөөлөгчид сахилгын шийтгэл оногдуулах журам, Сахилгын зөвлөлийн дүрмийг Монголын өмгөөлөгчдийн холбооны саналыг үндэслэн баталж байхаар тус тус хуульчилж зохицуулсан болно.

Хэдийгээр хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгодог, уг эрхийг түдгэлзүүлдэг, хасдаг боловч Хууль зүй, дотоод хэргийн яам, түүний орон нутгийн байгууллага болох аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль зүйн хэлтэс эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцуулахаар өмгөөлөгчдийг томилох, сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч нарт өмгөөлөгчөө сонгоход нь нэр зааж туслах, Монголын өмгөөлөгчдийн холбоо, аймаг, нийслэлийн өмгөөлөгч нарын үйл ажиллагааг шалгаж үүрэг даалгавар өгөх зэргээр дотоод ажилд нь оролцдоггүй болно.

Харин Засгийн газрын тухай хуульд зааснаар Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын нэг болох “Засгийн газраас шүүх, прокурорын байгууллага, нотариат, өмгөөллийн олон нийтийн байгууллагатай харилцах асуудал”-ыг Засгийн газрын 2001 оны 51 дүгээр тогтоолоор баталсан “Хууль зүй, дотоод хэргийн яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр» 2.5. Үйл ажиллагааны гол зорилт 3.4-д: “шүүх, прокурор, өмгөөлөх, нотариат, орон нутгийн хууль зүйн албадын харилцан ажиллагааг хангах” гэж улам нарийвчлан тодруулж өгсөн байна.

Өмгөөллийн тухай хуульд “Хууль зүйн туслалцаа үзүүлэхэд төлөх хөлсний жишгийг Монголын өмгөөлөгчдийн холбооны саналыг үндэслэн Хууль зүйн болон Хүн амын бодлого, хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран тогтооно” гэж заасны дагуу хууль зүйн болон хүн амын бодлого, хөдөлмөрийн сайдын 1995 оны 44/63 дугаар тушаалаар батлан мөрдүүлсэн байна. Одоогоор энэ жишгийг гол төлөв хөдөөгийн өмгөөлөгчид өмгөөллийн хөлсөө олж авахын тулд эрх зүйн албан ёсны баримт бичгийн хэмжээнд мөрдөж байгаа бөгөөд Улаанбаатар хотод ажилладаг өмгөөлөгчид өмгөөллийн хөлсөө үйлчлүүлэгчтэйгээ тохиролцдог учраас ийм жишиг байдгийг тэдэнд хэлдэггүй бололтой.

Мөн хуулийн 16 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт: “талууд тохиролцвол хөлсний хэмжээг жишигт зааснаас ихэсгэх буюу багасгаж болно” гэсэн байдаг тул тухайн жишгийг баримтлаж байгаа эсэхийг яамны зүгээс ч, Монголын өмгөөлөгчдийн холбооны зүгээс ч нэг их сонирхож байгаагүй болно. Харин орон нутгийн татварын алба өмгөөлөгчдийн орлогын жил, улирал, сарын хэмжээг тодорхойлохын тулд уг жишгийг баримжаа болгож ашигладаг байдал ажиглагдсан.

Хууль зүй, дотоод хэргийн яамны зүгээс Монголын өмгөөлөгчдийн холбооны жилийн төсөв, түүний зарцуулалтын байдалд оролцдоггүй. Харин Монголын өмгөөлөгчдийн холбооны дүрмийн 11 дүгээр зүйлд зааснаар МӨХ-ны ерөнхий бага хурлаас 3 жилийн хугацаагаар сонгогдсон Хянан шалгагчдын зөвлөл нь МӨХ-ны удирдах зөвлөлөөс баталсан дүрмийг мөрдөж тус холбооны хөрөнгийн хуримтлал, зарцуулалт, санхүүгийн үйл ажиллагаанд хяналт тавьж, Удирдах зөвлөлд танилцуулж үнэлэлт дүгнэлт өгөх ёстой байтал ийм ажлыг хараахан хийдэггүй юм байна. Энэхүү Хянан шалгагчдын зөвлөл нь ёс төдий ажилладаг байдал ажиглагдсан.

Монголын өмгөөлөгчдийн холбоо

Өмгөөллийн тухай хуульд “Өмгөөлөгчдийн байгууллага нь өмгөөлөгчдийг эгнээндээ нэгтгэсэн, ашгийн төлөө бус олон нийтийн байгууллага” бөгөөд дараахь бүтэцтэй байна.

1. Монголын өмгөөлөгчдийн холбоо;
2. Аймаг, нийслэлийн өмгөөлөгчдийн зөвлөл.

«Монголын өмгөөлөгчдийн холбоо нь өмгөөлөгчдийг мэргэжил, арга зүйн нэгдмэл удирдлагаар хангах, өмгөөлөгч бэлтгэх, сургах, давтан сургах, тэдгээрийн эрх, ашиг сонирхлыг төр, захиргаа, олон нийтийн байгууллагад төлөөлөх, нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд туслалцаа үзүүлнэ гэж тус тус заасан байдаг.

Одоогоор 416 өмгөөлөгчийг эгнээндээ нэгтгэсэн Монголын өмгөөлөгчдийн холбоо, түүний салбар нэгж болох 22 аймаг, нийслэлийн өмгөөлөгчдийн зөвлөл ажиллаж байна.

Өмгөөллийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт: “Өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсан Монгол Улсын иргэн өмгөөлөл явуулж буй хэлбэрээс үл хамааран өмгөөлөгчдийн олон нийтийн байгууллагад нэгдэнэ” гэж заасан байдаг. Энд заасан өмгөөллийн үйл ажиллагаа нь бүхэлдээ хууль зүйн туслалцаа бөгөөд Өмгөөллийн тухай хуулийн 4 дүгээр зүйлд зааснаар энэ нь дор дурдсан төрөлд хуваагдана. Үүнд:

1. хууль зүйн асуудлаар зөвлөгөө, мэдээлэл, лавлагаа өгөх;
2. эрх зүйн ач холбогдол бүхий баримт бичгийн эх зохиож туслах;
3. иргэний хэрэг, захиргааны зөрчлийн талаар шүүх болон төр, захиргааны байгууллагад төлөөлөх;
4. хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаа болон эрүүгийн хэргийг шүүхээр шийдвэрлэхэд өмгөөлөгчөөр оролцох;
5. иргэд, байгууллагын хүсэлтээр хууль тогтоомжид заасан хууль зүйн бусад туслалцаа үзүүлэх зэрэг болно.

Өмгөөллийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт: “Хуульч мэргэжилтэй, ял шийтгэлгүй, өмгөөлөгчийн мэргэжлийн шаардлага хангасан, тогтоосон журмын дагуу сонгон шалгаруулалтад орж өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсан Монгол Улсын иргэн өмгөөлөгчөөр ажиллаж болно” гэж, Монголын өмгөөлөгчдийн холбооны дүрмийн 16 дугаар зүйлийн “в” хэсэгт: “зохих журмын дагуу сонгон шалгаруулалтад орж тэнцээд өмгөөллийн үйл ажиллагаагаа эрхлэх зөвшөөрөл авсны дараа Монголын өмгөөлөгчдийн холбооны гишүүнд элсэн бүртгэгдэж, өмгөөлөл хийх эрхийн үнэмлэх авсан хуульчийг өмгөөлөгч гэнэ” гэж тодорхойлсон байна. Өмгөөлөгч нь Өмгөөллийн тухай хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хууль болон бусад холбогдох хууль тогтоомжинд заасан эрх, үүргийн дагуу ажиллана. Гэхдээ өмгөөлөгчид хуулиар олгосон эрх, үүрэг хэрхэн хэрэгжих нь эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцогч бусад субъектуудын эрх, үүргийн хэрэгжилт, нөхцөл боломжоос ихээхэн шалтгаална. Иргэнд хууль ёсоор олгогдсон өмгөөлүүлэх эрхийг хэрэгжүүлэх үүрэг бүхий өмгөөлөгчид нь сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг тууштай хамгаалж, тэдэнд шаардлагатай хууль зүйн туслалцааг үзүүлээд зогсохгүй холбогдсон хэргийг тал бүрээс нь нягт нямбай, бодитойгоор шинжлэн судлаж, түүнийг хууль зүйн үндэслэлтэй, үнэн зөв мөрдөн шалгаж шийдвэрлэхэд туслах бөгөөд өөрийн үйл ажиллагаандаа зөвхөн хууль зүй, ёс суртахуунд нийцсэн аргуудыг ашиглах ёстой.

Өмгөөлөгч нь сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчид хохиролтойгоор ашиглаж болох тийм үйл ажиллагаа явуулах буюу тэдний холбогдсон хэргийг илчлэх, гэм бурууг нь хүндрүүлэх нотолгоог илрүүлэн гаргах ёсгүй. Учир нь хэргийг илрүүлэх, гэм бурууг нотлох баримтуудыг цуглуулах эрх хэмжээ, илрүүлэх арга хэрэгсэл хэрэг бүртгэх, мөрдөн байцаах байгууллагад хуулиар олгогдсон бөгөөд энэ үүргээ гүйцэтгэх эрх мэдэл, бололцоо тэдэнд дүүрэн байдаг.

Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцогч хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, өмгөөлөгч нарт хэргийн үнэн мөнийг олох нийтлэг зорилтоос гадна хуулиар тогтоосон өөр өөрсдийн биелүүлбэл зохих тусгай үүрэг бий. Өмгөөлөгчийн өвөрмөц энэ үүрэг нь сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийг зөвхөн өмгөөлөхөд чиглэгдсэн үйл ажиллагаа юм. Өөрөөр хэлбэл эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцож байгаа өмгөөлөгч нь сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийг өмгөөлөн хамгаалахаас бус тэднийг буруутгах, шийтгэх явдлыг шууд ба шууд биш, ил буюу далд ямар ч хэлбэрээр дэмжих ёсгүй байдлаар өмгөөллийн үйл ажиллагаа явуулдгаар түүний ач холбогдол тодорхойлогдоно. Ийнхүү хуулиар өмгөөлөгчид өмгөөлөх эрх олгосноос биш, харин яллах эрх олгоогүй болно. Өмгөөллийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт

зааснаар өмгөөлөгч мэргэжлийн үйл ажиллагаа явуулахад түүнд хэн ч шахалт, дарамт үзүүлэх буюу хөндлөнгөөс оролцох, саад учруулах, ямар нэг баталгаа шаардах, заналхийлэхийг хориглосон байдаг.

Өмгөөлүүлэх эрх нь эрүүгийн байцаан шийтгэх үйл ажиллагааны нэг үндсэн зарчим, сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч нараас эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцохдоо өөрийн эрх, ашиг сонирхлыг хууль зүйн дагуу хамгаалах эрхийн баталгаа.

Өмгөөллийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар өмгөөлөгчдийн холбоо, зөвлөл, товчоо нь хуулийн этгээдийн эрх эдлэх бөгөөд өөрийгөө санхүүжүүлэх үндсэн дээр үйл ажиллагаа явуулдаг. Өмгөөлөл, хууль зүйн бусад туслалцааг төлбөртэй үзүүлэх бөгөөд энэ нь өмгөөлөгчдийн хөдөлмөрийн хөлсний эх сурвалжийг бүрдүүлнэ.

Өмгөөллийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт өмгөөлөгчдийн хөдөлмөрийн хөлсний 6 хувийг Монголын өмгөөлөгчдийн холбоонд, 4 хувийг өмгөөлөгчийн хариуцлагын даатгалын санд төвлөрүүлэхээр заасан боловч амьдралд тэр бүр нийцээгүй тул Монголын өмгөөлөгчдийн холбооны 1997 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн ерөнхий бага хурлаас баталсан “Монголын өмгөөлөгчдийн холбооны дүрэм”-ээр зохицуулсан юм. Тухайлбал, дүрмийн 16 дугаар зүйлийн “в”-д: “МӨХ-ны гишүүн нь сар тутам Улаанбаатар хотод ажиллаж байгаа бол 7000, Дархан-уул, Орхон аймагт ажиллаж байгаа бол 6000, бусад аймагт ажиллаж байгаа бол 5000 төгрөгийн татварыг МӨХ-нд төлнө” гэж, мөн дүрмийн 27 дугаар зүйлийн “а”-д “Өмгөөлөгчийн сар бүр МӨХ-нд төлсөн татварын 20 хувийг МӨХ-ны өмгөөлөгчийн хариуцлагын санд төвлөрүүлнэ” гэжээ. Гэхдээ энэхүү санхүүжилт нь МӨХ-ны аппаратын цалин, бусад шаардагдах зардалд зориулагдаж ирсэн болно. Харин МӨХ-ны дүрэмд заасны дагуу аймаг, нийслэлийн өмгөөлөгчдийн зөвлөлийн санхүүжих журмыг баталж, аймгийн зөвлөлийн даргын цалин хөлсийг тогтоож мөрдөх талаар дорвитой арга хэмжээ аваагүй байгаа юм байна.

Өмгөөлөгчдийн мэргэжлийн онолын болон чадвар суулгах давтан сургалт болон өмгөөлөгчийн зөвшөөрөл олгох ажлыг зохион байгуулалгүй олон жил болсон байна. Өмгөөлөгчдөөс хураан авдаг татварын зарцуулалт, санхүүгийн тайланг өмгөөлөгчдөд нээлттэй мэдээлэх талаар өмгөөлөгчид шүүмжлэлтэй ханддаг байна.

Бүх шатны шүүхүүд

Эрүү, иргэний хэргийг анхан шатны болон давж заалдах шатны журмаар хянан хэлэлцэх шүүх хуралдаан мэтгэлцэх зарчмын үндсэн дээр явагддаг. Энэ үед эрүү, иргэний хэрэгт хууль зүйн туслалцаа хэр хангагдаж байгаа нь харагдаж, улмаар шүүхийн шийдвэрт тусгалаа олж эцсийн үр дүн нь харагдах болно.

Монгол Улсад шүүхүүд нь зохион байгуулалтын хувьд орон нутагт жигд тархан байрласан байдаг. Өнөөдөр Монгол Улсын 21 аймаг, нийслэлийн 22 шүүх, сум буюу сум дундын шүүх 29, дүүргийн шүүх 8, УДШ-ийг оролцуулаад нийт 60 шүүх ажиллаж байна. Гэвч шүүх өргөдөл, гомдлыг “түдгэлзүүлэх”, бусад байгууллагад шилжүүлэх, хугацаа хэтрүүлэх, буруу шийдвэрлэх зэргээр иргэдийг хохироох явдал гаргасаар байна. 2000 онд улсын хэмжээгээр 3533 хэргийн үлдэгдэлтэй гарсны 430-ийн хугацааг хэтрүүлсэн байв. Түүнчлэн шүүгчдийн нэлээд нь эрх зүйн шинэ харилцаатай холбоотой хууль, маргаан хоёрыг зөв авцалдуулан ойлгож, хэрэглэх мэдлэг, дадлага дутмаг, шүүгчийн ачаалал нэлээд их байгаа юм. Тухайлбал, 2000 онд анхан шатны нэг шүүгчид улсын дунджаар эрүү, иргэний 237 хэрэг ноогдож байв. Монгол Улсын Засгийн газар, НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрөөс хамтарч хийлгэсэн “Монгол дахь авилгалын талаархи олон нийтийн санаа бодол, байр суурь” гэсэн судалгаагаар хамгийн их авилгалд автсан байгууллагууд, эдний дотор судалгаанд хамрагдагчдын үнэлгээгээр эхний гуравт гааль /73.5 хувь/, банк /63.8 хувь/, харин шүүх 48.8 хувиар тус тус орсон нь хэдийгээр давхар нотолгоогүй ч олон түмэнд итгэл алдаж буйн илрэл юм. 2000 онд 5 шүүгч ёс зүйн дүрмийг удаа дараа зөрчсөн учир огцорсон, 2001 оны эхний хагас 24 шүүгчид сахилгын шийтгэл хүлээлгэж, гэмт хэргийн шинжтэй үйлдэл хийсэн, шүүн таслах ажилд ноцтой дутагдал гаргасны учир 2001 он гарсаар 8 шүүгчийг огцруулах саналыг Шүүхийн ерөнхий зөвлөлөөс оруулсан байна.⁷

Дүгнэн үзвэл, шүүх хэрэг маргааныг шийдвэрлэхгүй удааж иргэдийг чирэгдүүлдэг, хууль зөрчиж буруу шийдвэрлэдэг, танил тал хардаг, түүнчлэн иргэний

⁷ Хүний эрхийн төлөв байдал-2001 он, 96 дугаар хуудас

хэргийн шүүн таслах ажлын чанар хангалтгүй байгаа зэрэг төлбөрийн чадваргүй иргэдийн хувьд шударга шүүхээр шүүлгэх, эрхээ хамгаалуулах эрх баталгаатай хэрэгжиж байна гэх итгэл бага юм. Төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн туслалцаа үзүүлэх асуудал бол өмгөөлөгчдийн хувьд энэрэнгүй ёс, хүний эрхийг хамгаалах талаар нийгмийн өмнө хүлээсэн үүрэг юм. Төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн туслалцаа үзүүлэх асуудлаар мэргэжил, арга зүйн төдийгүй хүний эрхийн чиглэлээр сургалт, семинар зохион байгуулах асуудал чухал ач холбогдолтой.

Шүүх иргэд, аж ахуйн нэгжид хууль зүйн туслалцаа үзүүлэх тогтолцоонд тодорхой хэмжээний үүрэг гүйцэтгэдэг. Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт: “Шүүх хууль ёс, хүний эрх, эрх чөлөө, шударга ёсны баталгаа мөн” гэж заасан байдаг. Ийнхүү хүний эрх, эрх чөлөөний баталгаа хангах нэг субъект нь яах аргагүй өмгөөлөгч билээ. Мэргэжлийн өмгөөлөгч эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны аль үе шатаас эхэлж оролцоноос хамаарч тухайн хүний эрх хэр зэрэг хангагдав гэж хэлэх үндэслэлтэй. Мөн хуулийн 15 дугаар зүйлд: “Шүүн таслах ажиллагааг мэтгэлцэх үндсэн дээр хэрэгжүүлнэ. Эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэхэд прокурор, шүүгдэгч, түүний өмгөөлөгч, эрх зүйн маргааныг хянан шийдвэрлэхэд зохигчид, тэдний төлөөлөгч, өмгөөлөгч, түүнчлэн хуулиар эрх олгосон бусад оролцогч хэрэг, маргааны үйл баримт, шүүгдэгчийн болон зохиогчдын гэм буруу байгаа эсэхийг шүүхэд нотлох замаар мэтгэлцэнэ” гэж заасан нь шүүн таслах ажиллагаанд өмгөөлөгч зайлшгүй оролцох ёстойг хуульчилсан явдал мөн. Түүнээс гадна өмгөөлөх, өмгөөлүүлэх эрхийг хэрхэн хэрэгжүүлэх талаар мөн хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт: “Шүүгдэгч болон шүүхээр эрхээ хамгаалуулж байгаа аливаа этгээд өөрийгөө өмгөөлөх, өмгөөлөгчөө чөлөөтэй сонгон авах, хэргийн баримт сэлттэй танилцах, шүүх хуралдаанд биеэр оролцох эрхтэй. Харин хуульд өөрөөр заагаагүй бол шүүгдэгчийг шүүх хуралдаанд заавал биеэр оролцуулна” гэж заасан байдаг. Харин шүүх тухайн этгээдэд энэхүү эрхээ хэрэгжүүлэх боломжийг хангах үүрэг хүлээнэ. Төлөөллийн талаар ч хуульд тодорхой тусгагдсан байдаг. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 32 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт: “Өмгөөлөгч нь гэрээний үндсэн дээр иргэн, хуулийн этгээдийг төлөөлөхдөө төлөөлүүлэгчийн эрх, эрх чөлөө, хуулиар хамгаалсан ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор хуульд заасан бүх арга хэмжээ авах ба шаардагдах эрх зүйн туслалцаа үзүүлэх, хэргийн бодит байдлыг тогтооход туслах үүрэгтэй” гэж, мөн хуулийн 34 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт: “өмгөөлөгчийн бүрэн эрх нь эрх бүхий байгууллагаас олгосон баримт бичгээр батлагдана” гэж тус тус заасан байдаг.

Эрүүгийн байцаан шийтгэх болон иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд өмгөөлөгч томилох, томилуулах, өмгөөллийн ба төлөөллийн чанарт хяналт тавих зэрэг эрхийг шүүх эдлэхгүй. Шүүхийн тухай хуулинд ч энэ талаар тодорхой заалт байхгүй юм байна. Шүүх хуралд өмгөөлөгч заавал оролцуулах хэд хэдэн үндэслэл бүхий хуулийн заалт /ЭБШХ-ийн 47 дугаар зүйл/ хэрэгждэг учраас эрүүгийн хэргийн хувьд шүүх дээр өмгөөлүүлэх эрхийг хангах талаар шүүгчид нэлээд анхаардаг байна. Харамсалтай нь олон тохиолдолд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд өмгөөлөгчгүйгээр явсан шүүгдэгчийн хувьд өөрийнх нь хэргийн талаар огт мэдэгдэхүүнгүй хэн нэгэн өмгөөлөгчөөр зөвхөн шүүх хурал дээр нэр төдийхөн өмгөөлүүлсэн болоод өнгөрөх нь мэдээж хангалтгүй. Харин иргэний хэргийн хувьд шүүхэд энэ эрхийг эдлүүлэх байдал өөр байдаг нь иргэний хэрэгт заавал өмгөөлөгч оролцуулан шийдвэрлэх заалт байдаггүйтэй холбоотой. Иймээс төлбөрийн чадваргүй иргэдийн хэргээ шүүхэд шийдвэрлүүлэх, нотлох баримт гаргаж өгөх зэрэг нь доогуур түвшинд байна.

Цагдаа, прокурорын байгууллага

Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт: “хуулийг дээдлэх, шударга ёс, тэгш байдлыг хангах, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх нь цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны үндсэн зарчим мөн” гэж заасан байдаг. Энэхүү үндсэн зарчмын гол цөм нь болсон хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх асуудал эрүүгийн хэрэгт хэрэг бүртгэгч, мөрдөн байцаах ажиллагаа явуулах үед зөрчигдөж байна. Тухайлбал, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 45 дугаар зүйлд: “гэмт хэрэг үйлдсэн явдалд сэрдэгдэж албадан саатуулагдсан буюу байцаагдах үеэс эхлэн эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд өмгөөлөгч оролцох эрхтэй” гэсэн заалтыг хэрэгжүүлэх талаар цагдаагийн байгууллага санаачлага гаргахгүй байна гэж үзэх үндэслэлтэй. Учир нь Өмгөөллийн тухай хуулийн 5 дугаар зүйлд зааснаар иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын өмгөөлүүлэх, хууль зүйн туслалцаа авах эрхээ эдлэхэд туслахыг хүссэн

тохиолдолд хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, шүүх, прокурорын байгууллага нь мэргэжлийн өмгөөлөгчдийн болон өмгөөлөл эрхэлдэг байгууллагын нэр, хаягийн лавлагаа өгөх үүргээ хангалтгүй биелүүлснээр болон тухайн иргэнд энэхүү эрхээ эдлэх боломж олгохгүй байгаагаар тус тус тайлбарлагдана. Тухайлбал, 2001 оны 4 дүгээр сарын 9-нд Баянзүрх дүүргийн Цагдаагийн хэлтсийн албадан саатуулах байранд байсан 51 хоригдогсад бүгд өмгөөлөгч аваагүй, 4 сард мөн тэнд хоригдсон 1967 хүний 27 хувь нь буюу 524 хүнд өмгөөлөгчгүйгээр байцаан шийтгэх ажиллагаа явуулснаас харагдаж болох юм. Энэ нь цагдаагийн байгууллагын зүгээс хүний эрхийг зөрчиж буй жишээний нэг юм.

Прокурорын байгууллагын тухай хуулийн 2 дугаар зүйлд: “Монгол улсын прокурорын байгууллага нь хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавьж, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцох чиг үүргийг хэрэгжүүлнэ” гэж заасан байдаг. Прокурорын чиг үүргийн нэг болох хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавихдаа тухайн этгээд яагаад өмгөөлөгч аваагүй, эсвэл өмгөөлөгч оролцох боломжоор хангаагүйн аль нь болохыг прокурор тодруулах шаардлагатай гэж үзнэ. Ер нь хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд өмгөөлөгч заавал оролцох ёстой, оролцоогүй эсвэл оролцох боломжоор хангаагүй тохиолдолд гэм буруутай албан тушаалтан ямар нэгэн хариуцлага хүлээх ёстой гэсэн тодорхой заалт Эрүүгийн байцаан шийтгэх хуульд байдаггүй нь энэ асуудлаар прокурорын байгууллагатай хариуцлага тооцоход нэлээд хүндрэлтэй юм. Гэхдээ Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 20 дугаар зүйлд : “Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн өмгөөлүүлэх эрхийг зөрчсөн нь шүүхийн шийдвэрийг хүчингүй болгох үндэслэл болно” гэсэн ерөнхий заалт байдаг.

Иргэд прокурорыг ялагч гэсэн байр сууринаас ханддаг, прокурорууд ч энэ чиг үүргээ илүү баримталдаг байдал үүсчээ. Гэтэл прокурор эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд, тухайлбал хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт хуулийн дагуу явагдаж байгаа эсэхэд, энэ үйл явцад хүний эрх хэрхэн зөрчигдөж байна гэдэгт хяналт тавьдаг гол субъект гэдгийг иргэд тэр бүр сайн мэддэггүйгээс тэдэнд цагдаагийн үйл ажиллагааны талаар гомдол гаргаж шалгуулдаггүй байна. Нөгөөтэйгүүр иргэдийн прокурорт үл итгэх хандлага байж магадгүй юм.

Шүүхийн тухай хуулийн 20, Өмгөөллийн тухай хуулийн 17 дугаар зүйлийг үндэслэн Хууль зүйн сайд, Сангийн сайд, Хүн амын бодлого, хөдөлмөрийн сайдын 1995 оны 43/76/62 дугаар тушаалаар баталсан “Төлбөрийн чадваргүй иргэний өмгөөллийн зардлыг төсвөөс санхүүжүүлэх, тайлан тооцоо гаргах журам”-ыг хэрэгжүүлэх талаар аймаг, нийслэлийн шүүхийн Тамгын хэлтэс, өмгөөлөгчдийн зөвлөл санаачилга гаргахгүй, түүний биелэлтэд аймаг, нийслэлийн санхүүгийн хэлтэс хяналт тавихгүй өдий хүрснээс төлбөрийн чадваргүй иргэний өмгөөллийн зардал зохих эзэндээ, тухайлбал өмгөөлөгчид хүрэхдээ шаардлага хангахгүй байгаа нь судалгаанаас харагдлаа. Хууль зүй, дотоод хэргийн яамнаас энэ эрх хангалтгүй хэрэгжиж байгаад, мөн төлбөрийн чадваргүй иргэдийн үнэ төлбөргүй өмгөөллийн зардалд улсаас төсөвлөгдсөн мөнгө зохих эзэндээ хүрч чадахгүй байгаад дүгнэлт хийн практикт учирч байсан хийдлийг арилгуулах зорилгоор төлбөрийн чадваргүй иргэний өмгөөллийн хөлсний зардлыг 2001 оноос Хууль зүй, дотоод хэргийн яамны төсөвт суулгаж өгөх болсон байна. Гэвч хуучин журам шинэчлэгдээгүйгээс тухайн зардлыг 2001 онд ашиглаж чадаагүй байна.

Төрийн бүс механизм

1. Хууль зүйн клиник

Хууль зүйн клиникийн хувьд Монгол Улсын Их Сургуулийн хууль зүйн дээд сургууль дээр “Хүмүүнлэг”, Шигихутаг дээд сургууль дээр “Буян”, УБИС дээр « Хэрэглээний эрх зүй » зэрэг клиник төвүүд МННХ- Соросын сангийн санаачлага, дэмжлэгээр байгуулагдаж, тодорхой хүрээнд төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн зөвлөгөө үзүүлж байна. Клиник төв нь хуулийн сургалтын нэг хэлбэр учраас оюутнууд төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүй тусалцаа үзүүлэх, тэднийг хууль, шүүхийн өмнө төлөөлөх асуудалд мэргэжлийн өндөр түвшинд хийж гүйцэтгэхийг мэргэшсэн байгууллагын төвшинд үнэлэх боломжгүй юм. Түүнчлэн оюутнуудын төлөөлөл, үйл ажиллагаа хязгаарлагдмал, иргэдийг шүүх хуралд бие даан төлөөлөн оролцох боломжгүй байдаг.

Эдгээр клиникүүд үйл ажиллагааныхаа талаар олон нийт болон хуулийн байгууллагуудад мэдээлэл, сурталчилгаа сайн хийдэг нь тэдний үйлчилгээний хүртээмжтэй байдалд нөлөөлж байна.

2. Төрийн бус байгууллага

Эрүү, иргэний хэргийг шүүхэд хянан шийдвэрлэхэд сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчид мэргэжлийн өмгөөлөгчөөс өөр хууль зүйн туслалцаа үзүүлдэг мэргэшсэн, зөвхөн энэ чиглэлээр дагнан идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага одоогоор байхгүй юм байна. Харин Эрх зүйн шинэтгэлийг дэмжих хуульчдын төв, Хүний эрх ба хөгжил төв, Хүчирхийллийн эсрэг үндэсний төв, Глоб интернейшнл, ЭЯГБХУТК-ын төв, Хуульч эмэгтэйчүүдийн холбоо зэрэг эрх зүйн чиглэлээр төрөлжсөн төрийн бус байгууллагууд, түүнчлэн Монголын үйлдвэрчний эвлэл, Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэг зэрэг төрийн бус байгууллагууд иргэд, байгууллагад үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа үзүүлэх, хуульчдад мэргэжлийн сургалт зохион байгуулах, сонин, сэтгүүл, товхимол хэвлүүлэх зэргээр гарын авлагаар хангах ажлыг хийдэг байна. Эдгээр байгууллагууд ихэнх нь иргэдэд үнэгүй хууль зүйн туслалцаа үзүүлэх, тэдэнд мэргэжлийн зөвлөлгөө өгөх, мэдээллээр хангах ажлыг өөрсдийн сайн дураар, байгаа хүч бололцоондоо тулгуурлан хийдэг байна.

Өмгөөллийн тухай хуулийн 6-р зүйлийн 2 дахь хэсэгт: “Өмгөөлөгч нь товчоо байгуулан ажиллаж болно” гэж, мөн зүйлийн 3 дахь хэсэгт: “Өмгөөлөгчдийн холбоо, зөвлөл, товчоо нь хуулийн этгээдийн эрх эдлэх бөгөөд өөрийгөө санхүүжүүлэх үндсэн дээр үйл ажиллагаа явуулна” гэж заасан байдаг. Хуулийн энэ заалтын дагуу 1998 оны 4-р сарын 3-наас 2002 оны 5-р сарын 13-ны өдөр байгуулагдан Монгол Улсын-ын Төрийн Бус Байгууллагын тухай хуулийн 15-р зүйлд заасны дагуу Хууль зүй, дотоод хэргийн яаманд бүртгүүлж үйл ажиллагаа явуулж байгаа хот, хөдөөгийн 57, түүнчлэн 1997 оноос өмнө байгуулагдсан боловч тус яамны шинэчилсэн бүртгэлд ороогүй 25, бүгд 82 хууль зүйн товчоо иргэд, байгууллагад үйлчилж байна. Хууль зүйн товчоод нь өөрийгөө санхүүжүүлэх үндсэн дээр ажилладаг учраас иргэд, байгууллагад хөлсөөр хууль зүйн туслалцаа үзүүлдэг. Зарим товчооны өмгөөлөгчид төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн туслалцаа үзүүлэх томилолтыг аймаг, нийслэлийн өмгөөлөгчдийн зөвлөлөөс авсны үндсэн дээр төлбөрийн чадваргүй иргэдэд өмгөөллийн үйлчилгээ үзүүлдэг бөгөөд цөөн тооны зарим өмгөөлөгчид энэ тал дээр сэтгэлээсээ хандан сайн ажилласан тохиолдол байдаг байна.

ТББ-ууд иргэдэд хууль зүйн туслалцаа үнэ төлбөргүй сайн дурын үндсэн дээр үзүүлж байгаа жишээ нь Эрх зүйн шинэтгэлийг дэмжих хуульчдын төв ТББ нь өмгөөллийн үйл ажиллагааны талаар санал дэвшүүлсэн, шүүмжлэлтэй телевизийн нэвтрүүлэг явуулах, хуульчдад зориулсан мэргэжлийн сонингоор өмгөөлөгчдөд үнэгүй хүргэх зэргээр тэднийг мэдээллээр хангах, эрх нь зөрчигдсөн иргэдэд хууль зүйн болоод сэтгэл санааны туслалцаа, дэмжлэг үзүүлэх, тэдний асуудлаар албан тушаалтан, байгууллага болон шүүхэд гомдол гаргах, зөрчлийг хэвлэл мэдээллээр сурталчлах ажлыг зохион байгуулсан үйл ажиллагаа юм. Тэдний төвд иргэдийн эрх зүйн мэдлэгт зориулсан телевизийн цуврал нэвтрүүлгийн улмаас иргэд олноор хандаж байгаагаас харахад иргэдэд бодитой туслалцаа үзүүлэхэд мэдээлэл маш чухал гэдгийг харуулж байгаа юм.

Мөн Хүний эрх ба хөгжил төв, Хуульч эмэгтэйчүүдийн холбоо, ЭЯГБХУТКХХ төв, Хүчирхийллийн эсрэг үндэсний төв зэрэг байгууллагууд иргэдэд үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа үзүүлэх, тэдний асуудлыг зохих байгууллага, албан тушаалтанд уламжлах, мэдээллээр хангах зэрэг үйл ажиллагаа явуулдаг.

Зургаа. Хууль зүйн үнэ төлбөргүй туслалцааны санхүүжилт

Шүүхийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт: “Өмгөөллийн хөлс төлөх чадваргүй шүүгдэгчид төрөөс туслалцаа үзүүлнэ” гэж заасныг Өмгөөллийн тухай хуульд нэлээд дэлгэрэнгүй тусгасан байдаг. Жишээлбэл, тус хуулийн 17 дугаар зүйлд: “Төлбөрийн чадваргүй иргэний өмгөөллийн зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ. Энэхүү зардлыг санхүүжүүлэх, тайлан тооцоо гаргах журмыг Шүүхийн ерөнхий зөвлөл, Монголын өмгөөлөгчдийн холбооны саналыг үндэслэн хууль зүй, хүн амын бодлого, хөдөлмөрийн болон санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран тогтооно” гэжээ. Хуулийн энэ заалтыг үндэслэн Хууль зүйн, сангийн болон хүн амын бодлого, хөдөлмөрийн сайдын 1995 оны 43/76/62 дугаар тушаалаар “Төлбөрийн

чадваргүй иргэний өмгөөллийн зардлыг төсвөөс санхүүжүүлж, тайлан тооцоо гаргах журам"-ыг батлан мөрдүүлсэн боловч хэрэгжилт нь хангалтгүй, түүний биелэлтэд тавих хяналт сул байсаар өдий хүрсэн байна. Энэ журмын дагуу төлбөрийн чадваргүй иргэний өмгөөллийн зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэхдээ Шүүхийн ерөнхий зөвлөл болон аймаг, нийслэлийн шүүхүүдээр дамжуулан олгож байсан юм. Гэвч уг журмыг хэрэгжүүлэх талаар аймаг, нийслэлийн шүүхийн Тамгын хэлтэс, Өмгөөлөгчдийн зөвлөл санаачилга гаргахгүй, түүний биелэлтэд аймаг, нийслэлийн санхүүгийн хэлтэс хяналт тавихгүй өдий хүрснээс төлбөрийн чадваргүй иргэний өмгөөллийн зардал зохих эзэндээ, тухайлбал, өмгөөлөгчид хүрэхдээ шаардлага хангахгүй буйг олон жил шүүмжилж ирсэн. Мөн төлбөрийн чадваргүй иргэний өмгөөллийн зардлыг олгохдоо хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, шүүгч нар байцаан шийтгэх ажиллагааны үе шат бүхэнд өөр өөрсдийн шийдвэрийг гаргаж карт бөглөж байсан билээ. Гэтэл төсвийн санхүүжилтийг өөр өөр газраас тодорхойлж олон шат дамжлагатайгаар олгодгоос гүйцэтгэгч буюу өмгөөлөгч нь өмгөөллийн зардлаа олж авч чадахгүй хохирох явдал жил бүр гардаг.

Олон шат дамжсан бичиг баримт бүрдүүлдэг, тэдгээрт гарын үсэг зурдаг албан тушаалтны хойноос хөөцөлдөж цаг их үрдэг, нэгэнт бэлэн болсон бичиг баримт нь санхүүгийн шаардлага хангахгүй гологддог зэргээс шалтгаалдаг төдийгүй эхний 2-3 улирал өнгөрүүлбэл тухайн зардлыг шүүхийн Тамгын хэлтэс өөр зүйлд зарцуулаад хөрөнгийн эх үүсвэргүй болгодог дутагдал давхар нөлөөлдөг. Үүний улмаас жил бүрийн төсөвт тусгагдсан зардлууд зохих эзэддээ очихгүй шүүхийн Тамгын хэлтсийн мэдэлд зарцуулагддаг байв. Эцэст нь тухайн өмгөөлөгч өөрийн өмгөөлсөн, өмгөөлөгчдийн зөвлөл өмгөөлөгчдийн өмгөөлсөн төлбөрийн чадваргүй иргэний өмгөөллийн хөлсний бичиг баримтыг цагт нь бүрдүүлэхгүй хугацаа алдах, өнгөрсөн хойно нь олон баримт бичиг бүрдүүлэх гэж цаг алддаг зэрэг аль аль талын хариуцлагагүй байдал үүнд бас нөлөө үзүүлдэг байсан.

Төлбөрийн чадваргүй иргэдийн өмгөөллийн зардлын 1997-2000 оны төсөв, гүйцэтгэлийн байдлыг авч үзье.

1	Он	Батлагдсан төсөв /мян.төг/	Гүйцэтгэл /мян.төг/	Үлдэгдэл /мян.төг/	Үлдэгдэл /хувь
1.	1997	4000.0	1362.4	2637.6	65.9
2.	1998	2000.0	1199.5	800.5	40.0
3.	1999	7000.0	1112.5	5887.5	84.1
4.	2000	6525.0	I улирал 2096.3	4428.7	67.9
		19575.0	5770.7	13754.3	70.3

Судалгаанд хамрагдсан өмгөөлөгчид сүүлийн 3 жилд төлбөрийн чадваргүй иргэний эрүү болон иргэний хичнээн хэрэгт оролцож, өмгөөллийн хөлсөө хэрхэн авсныг хүснэгтээр харуулбал:

Асуулт	2000 он	2001 он	2002 оны эхний хагас	Дүн
1 Төлбөрийн чадваргүй иргэнийг өмгөөлсөн нийт тоо	1691	1946	1025	4662
Эрүүгийн	1478	1663	890	4031
Иргэний	176	226	126	528
Бусад	37	57	9	103
2. Өмгөөллийн хөлсөө аваагүй / хэргийн тоо, төг-ийн дүн/	1469 /31270,6/	1741 /33542,4/	918 /21195,4/	4128 /86008,4/
3. Хөлсөө төлөөгүй өмгөөлүүлэгчийн тоо	1637	1830	1046	4513
Амьжиргааны төвшнөөс доогуур	773	894	554	2221
Нэн ядуу	621	686	364	1671
Хоригдол	243	250	128	621

Өмгөөлөгчдийн ажлын хөлс олгогдохгүй байгаагаас зарим тохиолдолд өмгөөлөгчид төлбөрийн чадваргүй иргэдийг өмгөөлөхөөс татгалзаж, тэдгээр иргэдийн иргэний эрх ашиг хохирч хүний эрх зөрчигдөхөд хүрч байна. Иймд олон шат дамжлагатай олгогддог энэхүү журмыг өөрчилж, төсвийн санхүүжилтийг Хууль зүй, дотоод хэргийн яамны төсөвт суулгаж, улмаар Монголын өмгөөлөгчдийн холбоонд олгож, хяналт тавьж байхаар 2001 оноос өөрчилсөн байна.

Өмгөөллийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2002 оны 5 дугаар сард УИХ-аас баталж, дээрх зардлыг хэрхэн зохицуулах асуудлыг хуульчилсан. Одоогийн байдлаар Хууль зүй, дотоод хэргийн яамны 2002 оны төсөвт төлбөрийн чадваргүй иргэний өмгөөллийн хөлсний зардал 9.0 сая төгрөг тусгагдсан байна.

Хууль зүйн сайд, Хүн амын бодлого, хөдөлмөрийн сайдын 1995 оны хамтарсан тушаалаар баталсан хууль зүйн туслалцаа үзүүлэхэд төлөх хөлсний жишигийг тогтоожээ. Үүнд :

- ❖ Хөнгөн гэмт хэрэгт холбогдсон хүнийг өмгөөлөхөд 3500 хүртэл төгрөг
- ❖ Хүндэвтэр гэмт хэрэгт холбогдсон хүнийг өмгөөлөхөд 6000 хүртэл төгрөг
- ❖ Хүнд гэмт хэрэгт холбогдсон хүнийг өмгөөлөхөд 8000 төгрөг
- ❖ Онц хүнд гэмт хэрэгт холбогдсон хүнийг өмгөөлөхөд 12000 хүртэл төгрөг байдаг байна.

Гэвч энэхүү жишиг нь өнөөгийн нөхцөлд тэр бүр нийцэхгүй байна. Нэгэнт төлбөртэй үйлчилгээ үзүүлдэг өмгөөлөгч нар үйлчлүүлэгчтэйгээ тохирч үнийн дүнгийн 10-30 хувь хүртэл, зарим нь цагийн 30-70 доллар хүртэл үнэлэн ажиллаж байхад энэ жишиг үнэ төлбөргүй туслалцаа үзүүлж буй өмгөөлөгчийн хувьд шударга байж чадахгүй юм. Өмгөөлөх байгууллагын хувьд огт үнэгүй туслалцаа үзүүлснээс харин 5000 төгрөг ч гэсэн хүнд урам болно гэж үзэж байна.

Өмгөөллийн туслалцаа хүссэн ядуу хүмүүсийн цуваа МӨХ-оос тасардаггүй байна. Мөн орон байргүй, оршин суух хаяггүй, дөнгөж шоронгоос гарч ирсэн хүмүүст өмгөөллийн туслалцаа авахад илүүтэй хүндрэлтэй, бараг боломжгүй байдаг байна. Учир нь оршин суух хаяггүй учир тэдэнд оршин суугаа газрын харьяаллын Засаг даргын тодорхойлолт авах боломж байдаггүйтэй холбоотой аж.

Орон нутагт төлбөрийн чадваргүй иргэдийн өмгөөллийн туслалцаа авах боломж хотынхоос хэд дахин бага буюу 21 аймгийн 47,6 хувьд буюу 10 аймагт 1-3 өмгөөлөгч ажиллаж байна. Орон нутгийн өмгөөллийн зөвлөлд сүүлийн 2 жил төсөв олгогдоогүй байдал үүнийг харуулна. Энэ хугацаанд аймаг, нийслэлийн шүүх, өмгөөлөх байгууллагын хооронд төлбөрийн чадваргүй иргэний өмгөөллийн хөлсний талаархи асуудлаар багагүй маргаан гарч, тэр хэмжээгээр өмгөөлөгчид хохирч байсан. Жишээ нь: 2002 оны 3 дугаар сард Сүхбаатар аймагт хуулийн хэрэгжилтийн байдлыг шалгах явцад төлбөрийн чадваргүй иргэний өмгөөллийн хөлстэй холбогдсон нэг материалтай танилцсан юм. Аймгийн санхүүгийн хяналтын албанаас тус аймгийн шүүхийн тамгын хэлтсийн 2000-2001 оны санхүү, аж ахуйн баримтад шалгалт хийж, энэ талаар акт тавьсан байна. Уг актанд: “2000 онд өмгөөллийн зардлыг /төлбөрийн чадваргүй иргэний өмгөөллийн хөлс/ аймгийн Өмгөөлөгчдийн зөвлөлд олгоогүй зөрчил илэрсэн тул 197.000 төгрөгийг тус аймгийн Өмгөөлөгчдийн зөвлөлийн ХАА-н банк дахь 2148073 тоот дансанд 2002 оны 04.1-ны дотор оруулахыг тамгын хэлтсийн дарга, ня-бо нарт хариуцуулав” гэжээ. Ийм баримт аймаг болгонд байдаг боловч дээрх журмын 14 дүгээр зүйлд зааснаар төлбөрийн чадваргүй өмгөөлүүлэгчийн өмгөөллийн зардлын гүйцэтгэлд орон нутгийн санхүүгийн байгууллагаас хяналт тавих үүргээ биелүүлдэггүйгээс бодит тоо нэгтгэж хэлэх боломж байхгүй байна.

Өмгөөлөгч үйлчлүүлэгч хоёр хууль зүйн туслалцаа үзүүлсний хөлсийг хоорондоо тохиролцдог боловч хөдөө орон нутагт бэлэн мөнгө хомс байгаагаас шалтгаалж мал, эд хоришил өгөх, дараа төлөхөөр тодорхойлолт бичиж үлдээгээд тэр чигээрээ алга болох, эсвэл иргэний паспорт, бусад баримт бичгээ барьцаанд тавьж эргэж авахгүйгээр орхих зэрэг зүй бус үйлдлүүд нэлээд гардаг ажээ. Энэ асуудлыг аймгийн Өмгөөлөгчдийн зөвлөлийн зүгээс зохицуулах боломжгүй бөгөөд нэгэнт өмгөөлсөн хүнээсээ хөлс нэхэж шүүхээр заргалдах нь зохисгүй гээд ихэнх өмгөөлөгчид хохироод өнгөрдөг нь жирийн

үзэгдэл болоод байна. Түүнээс гадна хүмүүсийн амьжиргааны түвшингээс шалтгаалж төлбөрийн чадваргүй иргэдийн тоо өсөх хандлага ажиглагдаж байна.

Төлбөрийн чадваргүй иргэдэд үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа үзүүлэхэд зориулсан төсвийн хичнээн хувь нь эрүү болон иргэний хэрэгт, мөн хичнээн хувь нь яаралтай тусламж үзүүлэхэд зориулагдахаар төлөвлөсөн хуваарилалт байдаггүй юм байна. Нэгэнт төсвөө ингэж хуваарилаагүйгээс судалгаанд төсвийн зарцуулалтыг ялган тооцох боломж байсангүй. Харин төлбөрийн чадваргүй иргэний өмгөөллийн хөлсний зардлыг ШЕЗ-өөр (Шүүхийн Ерөнхий Зөвлөл) дамжуулан аймаг, нийслэлийн шүүхүүдэд 1998-2000 онд хуваарилж зарцуулсан судалгааг ШЕЗ-өөс авч 25-р хуудсанд хүснэгтээр харуулсан болно.

Долоо . ӨМГӨӨЛӨГЧИЙН ХҮРЭЛЦЭЭ БАХУУЛЬ ЗҮЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР

Монгол улсад сүүлийн 6 жилийн хугацаанд өмгөөлөгчийн сонгон шалгаруулалт явуулж өмгөөлөгчийн тусгай зөвшөөрлийг олгоогүй ба энэ нь үйлчлүүлэх хүсэлтэй хүмүүст хязгаарлалт учруулсан байж болох юм. Ялангуяа хөдөө орон нутагт нэг аймагт 2-3 өмгөөлөгч ажилладаг нь тухайн орон нутагт амьдарч буй иргэдийн хувьд өмгөөлөгчөө чөлөөтэй сонгох боломжийг нь хязгаарлаж буй хэрэг юм. Өдгөө улсын хэмжээнд өмгөөлөгчдийн 42 товчоо, 21 зөвлөлд 400 гаруй өмгөөлөгч ажиллаж байна. Гэвч өмгөөлөгчид нь хот, суурин газар ихээр төвлөрсөн байдгаас хөдөө орон нутагт мэргэжлийн өмгөөлөгч хангалтгүй байдаг байна. Тухайлбал, Булган аймагт гэхэд өмгөөллийн зөвлөл нь 40-60 насны хоёр өмгөөлөгч, хоёр дадлагажигч өмгөөлөгчтэйгээс нэг өмгөөлөгч нь эрхээ хасуулаад дахин сэргээгдсэн хүн байна. Мөн Говь-Алтай аймагт тэтгэврийн насны нэг өмгөөлөгч, хоёр дадлагажигч өмгөөлөгч ажиллаж байгаа болно.

Шинэ ЭБШХ-ийн “Мэргэжлийн өмгөөлөгч оролцох боломжгүй бол байцаан шийтгэх ажиллагаанд оролцоход харшлах шалтгаангүй этгээдийг сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч өөрөө өмгөөлөгчөөр сонгоно” /38. 2/ гэсэн нэмэлт өөрчлөлт нь энэ асуудалд тодорхой алхам болсон гэж хуульчид дүгнэж байна. Мэргэжлийн өмгөөлөгч оролцох боломжгүй ялангуяа хөдөө орон нутагт энэ нь ач холбогдолтой заалт юм.

Чанартай сайн өмгөөллийн туслалцаа хэрэгцээтэй байгаа нь эрх нь зөрчигдөж байна гэж үзэж буй хүмүүсийн хувьд элбэг байдаг. Шүүх, мөрдөн байцаалтын шатанд, түүнчлэн иргэний хэрэгт өмгөөллийн туслалцаа авч буй хүмүүсийн дунд түгээмэл байгаа хандлагын нэг нь өмгөөлөгч маань нөгөө талын нөлөөнд автаж байна, хоёр талд зэрэг ажиллаж байна гэсэн ойлголт ба өмгөөлөгч хахууль зуучлагчийн үүргийг гүйцэтгэгч болжээ гэж үзэж байгаа явдал юм. Иймээс өмгөөлөгч нь хуулийн дагуу шударга ажиллах, өндөр ёс суртахуунтай байх хэрэгтэй байна. Ялангуяа төлбөрийн чадваргүй иргэдийн хувьд өмгөөлөгчийн хүрэлцээ бэрхшээлтэй байдаг.

Өнөөдөр Монгол улсад өмгөөлөгчдийн мэргэжлийн үйл ажиллагааг үнэлэх, үйлчилгээний чанарт хяналт тавих, мониторинг хийх механизм хангалтгүй гэж үзэж болохоор байна. Хуульчдын үйл ажиллагаанд үзлэг явуулсан дүнгээс⁸ (2001 он) үзэхэд үзлэгт хангалтгүй дүн үзүүлсэн, ёс зүйн зөрчил гаргасан 41 өмгөөлөгч байсан ба тэдэнд сахилгын арга хэмжээ авах, үүнээс 6 өмгөөлөгчийн эрхийг хасах, 9 өмгөөлөгчид эрх хасахыг сануулах арга хэмжээ авсан тухай дурьджээ.

2001 оны 1 дүгээр сард “Монголын өмгөөлөгчийн мэргэжлийн ёс зүйн дүрэм”-ийг (3 хэсэг, 20 зүйлтэй) МӨХ-ны Удирдах зөвлөлийн хуралдаанаар баталжээ. Энэхүү дүрэмд заасан өмгөөлөгчийн ёс зүйн үндсэн хэм хэмжээг харилцааны хүрээнд дараахь байдлаар ангилан үзэж болох юм. Тухайлбал:

- 1.мэргэжил нэгтэнтэйгээ харилцах ёс зүйн хэм хэмжээ;
- 2.үйлчлүүлэгч, өмгөөлүүлэгчтэйгээ харилцах ёс зүйн хэм хэмжээ;
- 3.хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ба албадан саатуулах, урьдчилан хорих байгууллагатай харилцах ёс зүйн хэм хэмжээ;
- 4.шүүх болон байцаан шийтгэх ажиллагааны оролцогчидтой харилцах ёс зүйн хэм хэмжээ.

⁸ Хууль зүй, дотоод хэргийн яам, Мэдээлэл, №07, УБ. 2001

Өмгөөлөгч нь хэргийн ажиллагааг удаашруулах, өмгөөллийн хөлсийг урьдчилан авсныхаа дараа хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр харилцан тохиролцсон ажил үүргээ гүйцэтгэхгүй байх, шүүх хуралд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй болон шүүх хуралдаанаас удаа дараа хожимдох гэх зэргээр эрх зүйн туслалцааг хангалттай үзүүлэхгүй бол үйлчлүүлэгч буюу өмгөөлүүлэгч, сэжигтэн тухайн өмгөөлөгчийн талаар Монголын өмгөөлөгчдийн холбооны Ерөнхийлөгч, Монголын өмгөөлөгчдийн холбооны дэргэдэх Сахилгын зөвлөл, аймаг, нийслэлийн Өмгөөлөгчдийн зөвлөлд гомдол гаргах эрхтэй. Тус зөвлөл гомдлын дагуу шалгаж өмгөөлөгчийн буруутай нь нотлогдвол Өмгөөллийн тухай хуулийн 18-р зүйлд зааснаар хууль зүйн туслалцаа авагчид учирсан хохирлыг нөхөн төлүүлэх, гэрээнд заасан туслалцааг үзүүлээгүй бол хөлсийг буцааж өгүүлэх арга хэмжээ авна. Удаа дараа ийм зөрчил гаргасан өмгөөлөгчийг МӨХ-ны дэргэдэх Сахилгын зөвлөлд шилжүүлж, тус зөвлөлийн саналыг үндэслэн Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаалаар тухайн өмгөөлөгчийн өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх эрхийг хасна.

Монгол Улсын хууль тогтоомж төдийгүй өмгөөлөгчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн өмгөөлөгчийн тухай өргөдөл, гомдлыг сахилгын шийтгэл оногдуулах эрх бүхий этгээд болох МӨХ-ны ерөнхийлөгч, Сахилгын зөвлөл, аймаг, нийслэлийн Өмгөөлөгчдийн зөвлөл хүлээн авснаас эхлэн 30 хоногийн дотор шийдвэрлэх ёстой. Сахилгын зөрчил гаргасан өмгөөлөгчид дор дурьдсан сахилгын шийтгэл оногдуулдаг. (Өмгөөллийн тухай монгол улсын хууль, “Төрийн мэдээлэл”, 1995, '03) Үүнд:

- 1.сануулах;
- 2.өмгөөлөл эрхлэх эрхийг нь хасах тухай урьдчилан сануулах;
- 3.өмгөөлөл эрхлэх эрхийг хасах.

МӨХ-ны ерөнхийлөгч, Сахилгын зөвлөл нь хуульд заасан “сануулах”, “өмгөөлөл эрхлэх эрхийг нь хасах тухай урьдчилан сануулах” сахилгын шийтгэл (өмгөөлөл эрхлэх эрхийг нь хасуулахаар хууль зүйн асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүнд санал оруулах), аймаг, нийслэлийн өмгөөлөгчдийн зөвлөлийн дарга “сануулах” сахилгын шийтгэлийг тус тус ногдуулдаг байна.

Зөвхөн сахилгын шийтгэл оногдуулах нь энэ эрхийг хангах хяналтын механизм ажиллаж байна гэж үзэж болохгүй юм. Иймээс өөр ямар тохиромжтой хувилбарууд байгааг эрэлхийлж олж ажиллах нь зүйтэй юм. Олон нийтийн оролцоо бүхий хөндлөнгийн хяналтын механизмыг ч ажиллуулах боломжтой юм.

Найм. ЭМЗЭГ БҮЛГИЙН ХҮМҮҮСТ ҮЗҮҮЛЭХ ХУУЛЬ ЗҮЙН ТУСЛАЛЦАА

Хүний эрхтэй холбоотой хүндрэл бэрхшээл нь нийтийг хамрах шинжтэй байдаг хэдий ч нийгмийн тодорхой хэсэг бүлэг буюу эмзэг бүлгүүдийн хувьд илүү хүндээр тусч, Үндсэн хуулиар олгогдсон хүний эрх, эрх чөлөөгөө бүрэн эдлэх боломжийг нь хязгаарлаж байна.

ҮСГ-ын (Үндэсний Статистикийн Газар) судалгааны дүнгээс үзэхэд 1998 оны байдлаар хүн амын 35.6 хувь нь ядуу байсан бөгөөд өрх толгойлсон эмэгтэйчүүд ядууралд өртөмтгий байдаг аж. Түүнчлэн 1998 онд гэр орон, сууцанд гарсан гэмт хэргийн 20.6 хувийг, 2000 онд 25.2 хувийг тус тус эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэл эзэлж байжээ.

1998 онд ЭМНХЯ-наас (Эрүүл мэнд нийгмийн хамгаалалын яам) хийсэн түүвэр судалгаагаар манай улсын 4.8 хувь буюу 115000 хүн тахир дутуу бөгөөд тэдгээрийн 20900 нь оюуны хомсдолтой, 6500 нь хэл ярианы болон сонсох эрхтний согогтой, 28000 нь тулгуур эрхтний хөдөлгөөний хомсдолтой, 42000 нь бусад шалтгааны улмаас тахир дутуу болсон гэж үздэг байна.

Манай улсад нийгмийн бусад эмзэг бүлгийнхэнд хууль зүйн туслалцаа үзүүлэх асуудлын талаар хууль тогтоомжид тусгайлан заасан зүйл, баталгаа бага гэж үзэж болохоор байгаа юм. Гэр бүл дэх хүчирхийллийн асуудлыг зохицуулах зорилготой “Гэр бүлийн хүчирхийллийн эсрэг” хуулийн төслийг 1998 оноос Хүчирхийллийн эсрэг төв болон бусад эмэгтэйчүүдийн төрийн бус байгууллагаас санаачлан ажиллаж байгаа ч өнөөг хүртэл батлагдаагүй байна. Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдод туслалцаа үзүүлдэг гол байгууллага Хүчирхийллийн Эсрэг Үндэсний Төв өөрсдийн хуульчдаас гадна бусад эмэгтэй хуульчид гэр бүлийн хохирогч эмэгтэйчүүдэд хууль зүйн зөвлөгөө өгөх, тэднийг шүүхэд төлөөлөх зэрэг ажлыг сайн дурын үндсэн дээр хийж гүйцэтгэдэг. Мөн Хуульч эмэгтэйчүүдийн холбоо нь гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдод туслах төв

дэргэдээ ажиллуулдаг. Түүнчлэн ЭЯГБХУТК-ийн (Эмэгтэйчүүдийг Ялгаварлан Гадуурхах Бүх Хэлбэрийг Устгах Тухай Конвенц) үндэсний төв, Хүний эрх ба хөгжил төв, Тахир дутуу эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах төв зэрэг цөөхөн хэдэн ТББ-ууд эмэгтэйчүүдийн эсрэг нийгэм дэх бусад хүчирхийлэл, ялгаварлан гадуурхах асуудлаар үйл ажиллагаагаа идэвхтэй явуулж байна. Гэвч эмэгтэйчүүдийн хүний эрх зөрчигдсөн гэсэн тодорхой тохиолдлоор шүүхэд нэхэмжлэл гаргаж, зөрчигдсэн эрхийг нь сэргээлгэж, эрх ашгийг нь бодитой хамгаалах явдал хараахан хийгдээгүй байгаа бөгөөд үүний шалтгаан нь нэг талаасаа, хохирогч эмэгтэйчүүд өөрсдөө хүсдэггүй, тэд нийгмээс ирэх дарамт шахалтаас айдаг, нөгөө талаасаа эмэгтэйчүүдийн асуудлаар мэргэшсэн өмгөөлөгчид дутагдалтай байдаг байна. Харин эдгээр байгууллагууд эмэгтэйчүүдэд үнэ төлбөргүй хууль зүйн зөвлөгөө өгөхөөс гадна сэтгэл санааны дэмжлэг туслалцаа үзүүлдэг нь төрийн ачаанаас үүрэлцэж, иргэддээ тусалж байгаа үйл ажиллагаа юм.

Бусад орны туршлагаас харахад гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдод үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа үзүүлдэг өмгөөллийн тусгай хөтөлбөрүүд, хууль зүйн сургуулийн клиникүүд ажилладаг. Төрийн бус байгууллагууд болон хууль зүйн сургуулийн багш, оюутнууд оролцсон тусгай хөтөлбөрүүд хэрэгжих нь зүйтэй бөгөөд энэ талаархи үйл ажиллагааг донор болон төрийн байгууллагуудын зүгээс дэмжиж ажиллах нь зүйтэй юм.

Ес. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Ядуу, орлого бага, төлбөрийн чадваргүй иргэдийн хувьд Үндсэн хуулиар баталгаажсан Монгол Улсын иргэний эдлэх шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг, эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, нотлох баримтыг шалгуулах, шударга шүүхээр шүүллгэх, шүүхийн шийдвэрийг давж заалдах, уучлал хүсэх зэрэг үндсэн эрхээ хэрхэн хэрэгжүүлэх нь өмгөөлүүлэх эрх хэрхэн хангагдсанаас шалтгаалдаг. Хууль зүйн туслалцаа авах эрх хэрхэн хэрэгжиж байгааг хэмжих нэг гол шалгуур нь төлбөрийн чадваргүй, ядуу иргэдийн өмгөөлүүлэх эрх юм. Иймд төлбөрийн чадваргүй иргэний хууль зүйн үнэ төлбөргүй туслалцаа авах эрх нь нэлээд хэд хэдэн хувийн эрхийг хангах суурь “эрх” болж байгаа юм. Хэдийгээр иргэдийн өмгөөлүүлэх эрхийг баталгаажуулж, хуульчилж өгсөн хэдий ч манай судалгаанаас харахад энэ эрхийн хэрэгжилт туйлын хангалтгүй байгаа нь тодорхой байна.

Дамжин өнгөрүүлэх төв дээр хэсэг хоригдолтой уулзахад тэдний нэг нь “Би өмгөөлүүлэх эрхтэй гэдгээ мэдээгүй. Намайг шүүх хуралд орохоос нэг цагийн өмнө нэг өмгөөлөгчтэй уулзуулж шүүх хуралд оруулсан” гэж ярьж байлаа. Ингэж ярьж байгаа олон хоригдлуудтай бид таарсан юм. Тэгвэл зөвхөн шүүх хуралд биш түүнээс өмнө хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт хуулийн хүрээнд явагдаж байгаа эсэх, сэжигтэн, яллагдагчийн эрх зөрчигдөж байгаа эсэхэд хяналт тавигдаагүйгээс тухайн хүнд холбогдсон хэргийн хувь заяа шүүх дээр хэрхэн шийдэгдэх нь ойлгомжтой. Тэгвэл төлбөрийн чадваргүй иргэдийн үнэгүй хууль зүйн туслалцаа авах энэхүү эрхийг баталгаажуулах асуудлыг цогцод нь авч шийдвэрлэх нь чухал байна. Тухайлбал, иргэдийн өмгөөлүүлэх эрхийг нь сурталчлах, тэднийг өөрөө өөрийнхөө эрхийн төлөө тэмцэх чадвартай болгох, мөн хуульчид өмгөөлөгчдийг энэ асуудалд хүчин зүтгэх, өөрчлөлт шинэчлэл хийх тал дээр зоригжуулан хөдөлгөх гэх мэт зүйлүүдийг зэрэг хийх нь шаардлагатай юм. Түүнчлэн шүүн таслах үйл ажиллагаанд оролцогчид болох хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, шүүгч, прокурор, өмгөөлөгч бүгд л хуулиар өөр өөрийн хүлээсэн үүрэгтэй. Тэд өөр өөрийн хүлээсэн үүргийг зохих ёсоор биелүүлж, өөртөө тавих шаардлагыг улам өндөржүүлж, хуулийн заалтыг чанд биелүүлж чадсан цагт л хүний эрхийг хамгаалах, хангахтай холбогдсон асуудал бүрэн шийдвэрлэгдэн амьдралд хэрэгжиж чадах болно.

Судалгааны эцэст бид хуулийн хүрээнд болон практикт дараахь өөрчлөлтүүдийг хийх санал зөвлөмж дэвшүүлж байна:

1/. Улсаас төлбөрийн чадваргүй иргэдэд зориулсан төсвийг олон жил баталж, энэ асуудалд санаа тавьж байсан байна. Харамсалтай нь энэ асуудал зохион байгуулалтын байдлаас болж өмгөөллийн хөлс зохих эзэндээ хүрч чадахгүй байсны шалтгаан, учир холбогдлыг бид дээр өгүүлсэн билээ. 2002 оны 5-р сарын 16-ны өдөр УИХ-аас шинэчилсэн найруулгаар баталсан Өмгөөллийн тухай хуулийн 21-р зүйлд “Төлбөрийн чадваргүй иргэний өмгөөллийн зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ. Энэхүү санхүүжилтийг Холбоонд олгох бөгөөд уг зардлыг санхүүжүүлэх, тайлан тооцоо гаргах

журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн баталж, хэрэгжилтэд нь хяналт тавина” гэж заасан байдаг. Хуулийн энэ заалтыг дараахь хэлбэрүүдээр хэрэгжүүлэх боломжтой гэж үзэж байна. Үүнд:

- a. Улсын төсөв, төсөл, хандивын хөрөнгөөр хуримтлал бий болгох замаар тусгай сан байгуулж төлбөрийн чадваргүй иргэний өмгөөллийн зардлыг санхүүжүүлэх бөгөөд сангийн хөрөнгийг ХЗДХ-ийн сайдын тушаалаар баталсан журмын дагуу МӨХ захиран зарцуулж, үлдэгдэл хөрөнгийг дараа онд шилжүүлэн зориулалтаар нь ашиглаж, гүйцэтгэлд нь Хууль зүй, дотоод хэргийн яам хяналт тавьж ажиллахаар зохицуулах.
- b. Улсын өмгөөлөгч гэсэн эрх хэмжээтэй орон тооны өмгөөлөгчийг ялангуяа хөдөө орон нутагт томилон ажиллуулах, улсын төсвөөс цалинжуулах хувилбар байж болно. Гэхдээ шууд утгаар нь ийм өмгөөлөгч ажиллуулахыг урьтал болголгүйгээр аймаг, нийслэлийн хууль зүйн товчоо, өмгөөлөгчдийн дунд тендер зарлах замаар төв, орон нутгаас тодорхой тооны товчоо, өмгөөлөгчдийг шалгаруулан авч, хүсэлт гаргасан төлбөрийн чадваргүй иргэдэд шууд хүрч шуурхай үйлчлэх гэрээний үндсэн дээр ажиллуулж, зардлыг нь бөөнөөр нь олгож санхүүгийн тодорхой эх үүсвэрээр хангах зэргээр зохион байгуулах боломжтой юм. Тухайлбал Соросын сангийн шугамаар хэрэгжүүлсэн төслийн үр дүнд Латви улсад төрөөс санхүүждэг улсын өмгөөлөгчийн газар байгуулагджээ. Гэхдээ энэ нь өмгөөлөгчдийн бие даасан байдалд нөлөөлж магадгүй тул Латви улс үүнийг төрийн бус байгууллагын хэлбэрээр, удирдах зөвлөл байгуулах байдлаар зохицуулсан байна. Иймээс манайд улсын өмгөөлөгч гэсэн статустай орон тооны өмгөөлөгчдийг хөдөө орон нутагт томилж, улсаас цалинжуулах нь бодит байдалд нийцсэн алхам болно гэж үзэж байна. Ингэснээр хамгийн гол нь мөнгө эзэндээ очсоноор төлбөрийн чадваргүй иргэдэд өмгөөллийн тусламж очих боломж нээгдэх юм. Олон оронд улсын ба хувийн өмгөөлөл зэрэгцэн оршиж байдаг. Тиймээс ийм өмгөөллийн хэлбэр оршин тогтнох боломжтой нь нотлогдсон зүйл. Иргэдийнхээ өмгөөлүүлэх эрхийн хэрэгжилтэнд төрөөс асар их анхаарал халамж тавьж байгаагийн илрэл болох юм.

2/. Иргэдийн өргөдөл, гомдлоос ажиглахад хууль зүйн туслалцаа авах эрхээ мэддэггүй, сонирхсон өмгөөлөгчөө авч чаддаггүй байна. Үүнийг судалгаанд хамрагдсан 124 өмгөөлөгчийн 86,3 хувь нь хүлээн зөвшөөрч байгаа юм. Гол шалтгаан нь хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нэгдүгээрт тухайн иргэний өмгөөлөгч авах эрхийг хэлж өгдөггүй, энэ талаар санаачлага гаргадаггүй, хоёрдугаарт өөрийн таньдаг өмгөөлөгчөө санал болгож, тулгадаг явдал юм. Өмгөөлөгчийн нэр зааж, тулгадаг үйлдлийг прокурор, шүүгч нар ч хийдэг талаар иргэд гомдол гаргаж байдаг. Харин асуудлаа аль болох хурдан шийдүүлэх, хуулийн байгууллагын ажилтнуудын дургүйг хүргэхгүйн тулд хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн санал болгож өгсөн өмгөөлөгчийг аваад салахыг урьдал болгодог байдал ихэнх иргэдэд тохиолддог байна. Энэ бүгдээс дүгнэлт хийж дараахь арга хэмжээ авах шаардлагатай байна. Үүнд:

- a. Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч тухайн сэжигтэнд өмгөөлөгч авах эрхтэйг заавал хэлж ойлгуулдаг, хэрэгжүүлэх механизмыг нь зааж өгсөн журам гаргаж мөрдүүлбэл зохино. Ийм эрхийн баримт бичгийг Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаалаар батлах нь илүү оновчтой юм.
- b. Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч таньдаг өмгөөлөгчөө зааж өгөх, түүнийг нь сэжигтэн, авах боломжийг хаах. Үүний тулд аймаг, нийслэлийн өмгөөлөгчдийн салбар зөвлөлийн дарга төлбөрийн чадваргүй иргэнд үйлчлэх өмгөөлөгчид томилолт бичиж өгдөг, сүүлд тухайн томилолтыг үндэслэн өмгөөллийн хөлсийг олгодог журам тогтоож хэвшүүлэх.
- c. Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, шүүгч сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн өмгөөлөгч авах эрхийг тайлбарласан бичгийг уншуулж танилцуулан гарын үсэг зуруулж хэвшүүлэх.

3/. Хуулиар өмгөөлөгч заавал оролцохоор заасан хэргийн жагсаалтанд төлбөрийн чадваргүй иргэний хэргийг хамааруулаагүй байна. Учир нь хэргийн шүүгдэгчид цаазаар авах ял оногдуулах боломжтой, эсвэл насанд хүрээгүй хүний хэрэгт өмгөөлөгчийг заавал оролцуулахаар заасан хэргүүдийн нэгэн адил төлбөрийн чадваргүй иргэдийн асуудал

дээрхийн нэгэн адил эмзэг асуудал болоод байна. Төлбөрийн чадваргүй иргэний хэрэгт заавал өмгөөлөгч оролцоно гэж зааснаар, өмгөөлөгчид иймэрхүү төрлийн хэрэгт олноор оролцсоноор улсын төсвөөс төлбөрийн чадваргүй иргэдэд туслалцаа үзүүлэхэд зориулсан энэ мөнгийг хөөцөлдөж авах санаачлага өмгөөлөгч нарын зүгээс гарахад нь түлхэц үзүүлэх магадлалтай юм. Энэ асуудлыг юуны өмнө, ойрын хэдэн жилд эрүүгийн хэрэгт төлбөрийн чадваргүй иргэний хууль зүйн туслалцаа авах эрхийг хангах чиглэлээр зохицуулах хэрэгтэй. Улсын эдийн засгийн чадавхи сайжрахын хэрээр иргэн, Үндсэн хууль, захиргааны хэрэгт төлбөрийн чадваргүй иргэний хууль зүйн туслалцаа авах эрхийг хангах явдлыг дэс дараатай өргөжүүлэх арга хэмжээ авах нь зүйтэй гэж үзэж байна. Төлбөрийн чадваргүй, нэн ядуу гэдгийг тодорхойлоход бэрхшээлтэй байдаг болон ялангуяа өнөөдөр 40-100 ам доллартай тэнцэх хэмжээний цалин орлоготой ажилчин, албан хаагчид ч амьдралын өртгөөс шалтгаалан ядуу хүмүүсийн тоонд орж болохоор байгаа нь ийнхүү хууль зүйн туслалцааны асуудлыг өргөжүүлэхэд хүндрэл учруулах юм .

4/. Хууль зүйн клиникийг олноор байгуулах, тэдгээрийн үйл ажиллагааг шинэ төвшинд гарган чанартай ажиллуулах, үйл ажиллагааг нь олон нийттэй ажилладаг ТББ-тай холбож өгвөл энэ асуудалд ахиц гаргах нэг жишиг юм. Мөн түүнчлэн эрх зүйн тусгай салбаруудаар мэргэшүүлэн клиник ажиллуулдаг олон улсын туршлагыг нэвтрүүлэх тал дээр алхам хийх хэрэгтэй байна. Тухайлбал, манайд хамгийн ээдрээтэй, хамгийн их хэрэгцээтэйд тооцогдож байгаа гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид, насанд хүрээгүй хүмүүст үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа үзүүлэх асуудал хариуцсан тусгай клиникүүдийг нээж ажиллуулах нэн шаардлагатай байгаа юм.

5/. Хөдөө орон нутагт иргэдийн өмгөөлүүлэх эрх нэн зөрчигдөж байгаад дүгнэлт хийж, тэнд ажиллах өмгөөлөгчдийн цалин, хангамжийг өндөр болгох замаар төрийн тусгай бодлого барьж, хөдөө орон нутагт өмгөөлөгч дутагдалтайгаас иргэдийн өмгөөлүүлэх эрх зөрчигдөж байгаа дутагдлыг арилгахын тулд дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзэж байна. Үүнд:

- a. Тендер зарлах замаар тэдгээрт ялж төлбөрийн чадваргүй иргэнийг өмгөөлөх эрх авсан төв, орон нутгийн хууль зүйн товчоо, өмгөөлөгчдийн орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх шаардлагатай байгаа юм. Үүний тулд улсын эдийн засгийн боломжтой уялдуулан Хууль зүйн сайд, Хүн амын бодлого, хөдөлмөрийн сайдын 1995 оны 44/63 дугаар тушаалаар баталсан “Төлбөрийн чадваргүй иргэний эрх ашгийг хамгаалахад төлөх хөлсний жишиг”-ийг хөнгөн, хүндээр ялгаварлан 35-50 хувиар өсгөх замаар шинэчлэн мөрдүүлэх.
- b. Аймгуудыг мэргэжлийн өмгөөлөгчөөр хангах асуудалд илүү анхаарал тавих хэрэгтэй байна. Хөдөө өмгөөлөгч дутагдалтай учраас өмгөөлөх эрхгүй бөгөөд шүүх, прокурор, цагдаагийн байгууллагаас ажилд тэнцэхгүй шалтгаанаар халагдсан хүмүүс өмгөөлөгч хийж байгаа нь иргэдэд үзүүлж буй эрх зүйн үйлчилгээний чанарт болон өмгөөлөх байгууллагын нэр хүндэд муугаар нөлөөлж байна. Иймээс аймгууд, ялангуяа алслагдсан аймгуудад 5-аас доошгүй мэргэжлийн өмгөөлөгч ажиллаж байхаар тооцоолж боловсон хүчнээр хангах бодлогыг ХЗДХЯ, МӨХ-ны зүгээс баримталж хуульчдын сонгон шалгаруулалтад тэнцсэн хүмүүсээс мэргэшлийн шалгаруулалтанд оруулж шаардлага хангасныг нь тодорхой хугацаагаар томилон хөдөө явуулах хэрэгтэй юм. Ингэснээр иргэдэд үзүүлэх эрх зүйн үйлчилгээний хүрээ хөдөөд өргөжих боломжоор хангагдах болно.

Хавсралт-1

Судалгаанд ашигласан материал

Нэг. Хууль, тогтоол, журам, заавар

1. Үндсэн хууль (1992)
2. Монгол улсын эрүүгийн хууль (1993)
3. Монгол улсын эрүүгийн хууль (2002)
4. Монгол улсын эрүүгийн байцаан шийтгэх тухай хууль (1963)
5. Монгол улсын эрүүгийн байцаан шийтгэх тухай хууль (2002)
6. Монгол улсын үндсэн хуулийн цэцийн тухай хууль (1992)
7. Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хууль
8. Монгол улсын захиргааны хариуцлагын тухай хууль (1992)
9. Монгол улсын шүүхийн тухай хууль (1993)
10. Монгол улсын иргэний хууль
11. Монгол улсын иргэний хууль
12. Иргэний хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль
13. Иргэний хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль
14. Монгол улсын прокурорын байгууллагын тухай хууль (1993)
15. Шүүхийн шийдвэр биелүүлэх тухай хууль (1997)
16. Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны тухай хууль (1994)
17. Хорих байгууллагын болон хорих ял эдлүүлэх тухай Монгол улсын хууль (1993)
18. Сэжигтэн, яллагдагчийг албадан саатуулах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хууль (1999)
19. Өмгөөллийн тухай Монгол улсын хууль (1994)
20. Өмгөөллийн тухай Монгол улсын хууль (2002)
21. Цагдаагийн байгууллагын тухай хууль (1993)
22. Тагнуулын байгууллагын тухай хууль (1999)
23. Улсын Тэмдэгтийн хураамжийн тухай хууль
24. Өмгөөлөгчдийг сонгон шалгаруулах орон тооны бус мэргэжлийн хорооны дүрэм (1995)
25. Өмгөөлөгчдөд өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, чөлөөлөх, хасах журам (1995)
26. Төлбөрийн чадваргүй иргэний өмгөөллийн зардлыг төсвөөс санхүүжүүлэх, тайлан тооцоо хийх журам (1995)
27. Хууль зүйн туслалцаа үзүүлэхэд төлөх хөлсний жишгийг батлах тухай Хууль зүйн сайд, Хүн амын бодлого, хөдөлмөрийн сайдын 1995 оны 5 дугаар сарын 4- ний өдрийн 44/63 дугаар тушаал
28. Өмгөөлөгчдийн сахилгын зөвлөлийн дүрэм, өмгөөлөгчид сахилгын шийтгэл ногдуулах журам (1996)
29. Хоригдлын өмгөөллийн болон хууль зүйн туслалцаа авсны хөлсийг төлөх журам (1996)
30. Өмгөөлөгч цагдан хорих, эрүүлжүүлэх, баривчлах, албадан саатуулах байр болон хорих ангид нэвтэрч сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хоригдол болон баривчлагдсан хүнтэй уулзаж, хууль зүйн туслалцаа үзүүлэхэд мөрдөх журам (1998)
31. Хүн амын бодлого, Хөдөлмөрийн сайд, Сангийн сайдын 1993 онд баталсан “Амьдрал ядуу, бага орлоготой өрх, иргэдэд туслах сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах журам”

Хоёр. Ном, судалгааны тайлан, бусад материал

1. Монгол улсад хүний эрхийг хангах төсөл. Монгол улс дахь хүний эрхийн төлөв байдал 2001 он
2. Монгол улсад хүний эрхийг хангах төсөл. Улс төр болон хувийн эрхийн судалгааны багийн судалгааны тайлан
3. Хүний эрхийн үндэсний комисс. Монгол улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын тухай илтгэл 2002 он.
4. Хүний Эрхийн ТББ-ын анхдугаар чуулга уулзалтын илтгэл, ЭЗШДХТ, 2002
5. “Эрх зүйн шинэтгэл” сонин, ЭЗШДХТ, 2001, 2002 он.
6. ШЭМШХ төслөөс гаргасан шүүхийн талаарх судалгааны материал, 2002 он

7. Хүний эрх ба хөгжил төв. Монгол улс дахь хүний эрхийн байдал 2001 он.
8. Арбитрын сэтгүүл 2001/1
9. Монгол улсын гадаад худалдааны арбитрын шийдвэрлэсэн хэргүүд (1992-1996)
10. Хүний эрхийн Үндэсний комисс. Нийслэлийн цагдан хорих төв, албадан саатуулах байруудад хийсэн шалгалтын тайлан., 2001 он
11. ХЗДХЯ. Мэдээлэл., '07, УБ 2001. Хуульчдын үйл ажиллагаанд үзлэг явуулсан дүнгийн тухай
12. ХЗЯ, ШЕЗ., 2000 он, Монгол Улсын Шүүх Эрх Мэдлийн Стратеги Төлөвлөгөө

Товчилсон үгийн тайлал

1. ЭБШХ	Эрүүгийн байцаан шийтгэх хууль
2. ХЭҮТ	Хүчирхийллийн эсрэг үндэсний төв
3. ИХШХШТХ	Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль
4. УДШ	Улсын Дээд Шүүх
5. НҮБ	Нэгдсэн Үндэсний Байгууллага
6. ҮСГ	Үндэсний Статистикийн Газар
7. ЭМНХЯ	Эрүүл Мэнд Нийгмийн Хамгааллын Яам
8. ЭЯГБХУТК	Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг
устгах тухай конвенц	
9. ТББ	Төрийн бус байгууллага
10. ҮХЦ	Үндсэн хуулийн цэц
11. УИХ	Улсын Их Хурал
12. МӨХ	Монголын Өмгөөлөгчдийн Холбоо
13. БНМАУ	Бүгд Найрамдах Монгол Ард Улс
14. ХЗДХЯ	Хууль Зүй, Дотоод Хэргийн Яам
15. УЕПГ	Улсын Ерөнхий Прокурорын Газар
16. ЦЕГ	Цагдаагийн Ерөнхий Газар
17. АНУ	Америкийн Нэгдсэн Улс
18. ОУХА	Олон Улсын Хөгжлийн Агентлаг
19. ШЕЗ	Шүүхийн Ерөнхий Зөвлөл
20. ХАБХ сайд	Хүн Амын Бодлого, Хөдөлмөрийн Сайд

Хавсралт 2

Холбогдох хууль тогтоомжийн заалтууд

ЭРҮҮГИЙН БАЙЦААН ШИЙТГЭХ ХУУЛЬ

18 дугаар зүйл. Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хохирогчийн өмгөөлүүлэх эрхийг хангах

18.1. Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хохирогч өөрийгөө өмгөөлөх, өмгөөлүүлэх, хууль зүйн бусад туслалцаа авах эрхтэй.

18.2. Энэ хуулийн 40 дүгээр зүйлд заасан тохиолдолд хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүх нь сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хохирогчийг өмгөөлүүлэх бололцоогоор заавал хангах үүрэгтэй.

38 дугаар зүйл. Өмгөөлөгч

38.1. Хуульд заасан журмын дагуу сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хохирогчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалж, хууль зүйн туслалцаа үзүүлж байгаа этгээдийг өмгөөлөгч гэнэ.

38.2. Мэргэжлийн өмгөөлөгч оролцох боломжгүй бол байцаан шийтгэх ажиллагаанд оролцоход харшлах шалтгаангүй этгээдийг сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч өөрөө өмгөөлөгчөөр сонгоно.

38.3. Гэмт хэрэгт сэжигтнээр тооцогдсон үеэс эхлэн эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд өмгөөлөгч оролцох эрхтэй.

38.4. Хэргийн талаар харилцан эсрэг сонирхолтой хэд хэдэн сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийг нэг өмгөөлөгч өмгөөлж болохгүй.

39 дүгээр зүйл. Өмгөөлөгчийг сонгон авах, солих

39.1. Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хохирогч өмгөөлөгчөө өөрөө сонгоно.

39.2. Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хохирогчийн зөвшөөрснөөр буюу хүссэнээр түүний хууль ёсны төлөөлөгч, гэр бүлийн гишүүн, төрөл, садангийн хүн нь өмгөөлөгчийг сонгон авч болно.

39.3. Нэг этгээд хэд хэдэн өмгөөлөгчтэй байж болно.

39.4. Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хохирогч өмгөөлөгчөө сонгон аваагүй бол түүний хүсэлтээр эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд өмгөөлөгч оролцох боломжийг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүх хангах бөгөөд өмгөөлөгчөө сонгоход нь тодорхой хүний нэр зааж тулгаж болохгүй.

39.5. Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хохирогчийн сонгож авсан өмгөөлөгч уг хэрэгт оролцох боломжгүй болсон, түүнчлэн өмгөөлөгчөөсөө татгалзсан бол өөр өмгөөлөгч сонгон авна.

40 дүгээр зүйл. Өмгөөлөгчийг заавал оролцуулах

40.1. Дор дурдсан сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчид холбогдох хэргийн хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүх хуралдааны ажиллагаанд өмгөөлөгчийг заавал оролцуулна:

40.1.1. хэлгүй, дүлий, хараагүй зэрэг эрхтэн дутуу буюу сэтгэцийн өвчний улмаас өөрийгөө өмгөөлөх болон өмгөөлүүлэх эрхээ эдэлж чадахгүй;

40.1.2. насанд хүрээгүй;

40.1.3. монгол хэл мэддэггүй;

40.1.4. цаазаар авах ялаар шийтгэгдэж болох;

40.1.5. хэргийнхээ талаар харилцан эсрэг сонирхолтой сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн аль нэг нь өмгөөлөгчтэй байгаа бол бусад сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч.

40.2. Энэ хуулийн 40.1-д заасан тохиолдолд сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, эсхүл түүний хууль ёсны төлөөлөгч, гэр бүлийн гишүүн, төрөл, садангийн хүн, түүнчлэн түүний хүссэнээр буюу зөвшөөрснөөр бусад этгээд өмгөөлөгч сонгон аваагүй бол хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүх уг хэрэгт өмгөөлөгч оролцуулах явдлыг хангах үүрэгтэй.

41 дүгээр зүйл. Өмгөөлөгчийн эрх, үүрэг

41.1. Өмгөөлөгч нь сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хохирогчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалж, хууль зүйн туслалцаа үзүүлэх үүрэгтэй.

41.2. Хэрэгт оролцох талаар тохиролцсон буюу томилогдсон үеэс өмгөөлөгч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр өөрийн үүргээс татгалзах, хууль бусаар нотлох баримт цуглуулах эрхгүй.

41.3. Өмгөөлөгч нь дараахь эрх эдэлнэ:

41.3.1. хэрэгт оролцох үеэс эхлэн сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хохирогчтой ганцаарчлан уулзах, тэдгээрийг байцаахад байлцах, асуулт тавих;

41.3.2. энэ хуулийн 92 дугаар зүйлд заасны дагуу хууль зүйн туслалцаа үзүүлэхэд шаардлагатай эд зүйл, баримт бичиг, мэдээлэл, бусад нотлох баримтыг цуглуулах талаар хүсэлт тавих, гаргаж өгөх, түүнийгээ шалгуулан хавтаст хэрэгт тусгуулах;

41.3.3. хохирогч, гэрч, шинжээчийг байцаахад байлцаж, тэдгээрт асуулт тавих;

41.3.4. өмгөөлж байгаа этгээдийнхээ болон өөрийнхөө хүсэлтээр хийгдэж байгаа хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаанд байлцаж тухайн ажиллагаанд оролцож байгаа гэрч, шинжээч, бусад этгээдэд аль ч үед асуулт тавих;

41.3.5. өөрийн байлцсан байцаан шийтгэх ажиллагааны тэмдэглэлтэй танилцаж, засвар оруулах тухай саналаа бичгээр гаргах;

41.3.6. өөрсдийнх нь зөвшөөрснөөр иргэн, хуулийн этгээдээс тайлбар, баримт бичиг, тодорхойлолт гаргуулж авах;

41.3.7. хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, орчуулагч, хэлмэрч, шүүгч, иргэдийн төлөөлөгч, шүүх хуралдааны нарийн бичгийн даргыг татгалзан гаргах тухай хүсэлт гаргах;

41.3.8. хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт дууссаны дараа хэргийн бүх материалтай танилцаж, төр, байгууллага, хувь хүний нууцад үл хамаарах нотлох баримтыг өөрийн зардлаар хувилах, хуулбарлан авах;

41.3.9. шүүх хуралдаанд оролцох;

41.3.10. хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүхийн үйл ажиллагаа, шийдвэрт гомдол гаргах;

41.3.11. өмгөөлж байгаа сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих асуудлыг шүүхэд шийдвэрлэхэд хүсэлтээрээ байлцаж, шүүхэд санал гаргах;

41.3.12. давж заалдах болон хяналтын шатны шүүх хуралдаанд хүсэлтээрээ оролцох.

42 дугаар зүйл. Хохирогч

42.3. Хохирогч, түүний төлөөлөгч нь дараахь эрх эдэлнэ:

42.3.1. өмгөөлөгч авах /энэ заалт нь төлөөлөгч өмгөөлөгчөөр оролцож байгаа тохиолдолд хамаарахгүй/;

187 дугаар зүйл. Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны оролцогчид эрхийг нь заавал тайлбарлан өгөх ба түүнийг хангах

187.1. Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нь сэжигтэн, яллагдагч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, тэдний төлөөлөгч, түүнчлэн хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаанд оролцогч бусад этгээдэд тэдгээрийн эрх, үүрэг болон үүргээ биелүүлээгүйн улмаас үүсэх үр дагаврыг тайлбарлан өгч, байцаан шийтгэх ажиллагааны явцад эрхээ хэрэгжүүлэх боломжоор хангах үүрэгтэй.

200 дугаар зүйл. Яллагдагчийн эрхийг тайлбарлан өгөх

200.1. Яллагдагчаар татсан тогтоолыг танилцуулсны дараа энэ хуулийн 36 дугаар зүйлд заасан эрхийг яллагдагчид тайлбарлан өгч тэр тухай анхны байцаалтын тэмдэглэлд тусгаж, гарын үсэг зуруулна.

241 дүгээр зүйл. Шүүх хуралдааны ажиллагаанд өмгөөлөгч оролцох

241.1. Өмгөөлөгч нотлох баримт шинжлэхэд оролцох, шүүх хуралдааны явцад гарсан асуудлаар санал гаргах, шүүгдэгчийг цагаатгах, түүний хариуцлагыг хөнгөрүүлэх байдлын тухай болон шүүгдэгчид оногдуулах ялын талаар саналаа хэлнэ.

241.2. Өмгөөлөгч ирээгүй бөгөөд түүнийг солих боломжгүй бол хэрэг хэлэлцэх ажиллагааг хойшлуулна.

241.3. Өмгөөлөгчийг солих асуудлыг энэ хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу шийдвэрлэнэ.

241.4. Энэ хуулийн 40 дүгээр зүйлд зааснаас бусад тохиолдолд шүүгдэгч өөрийгөө өмгөөлөх хүсэлтийг бичгээр гаргасан бол хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэж болно.

242 дугаар зүйл. Шүүх хуралдаанд прокурор, өмгөөлөгч ирээгүйн холбогдол

242.1. Шүүх хуралдаанд прокурор, өмгөөлөгч ирээгүй нь шүүх хуралдааныг хойшлуулах үндэслэл болно.

242.2. Прокурор, өмгөөлөгч шүүх хуралдаанд цаашид оролцох боломжгүй бол тэдгээрийг сольж болох бөгөөд энэ тохиолдолд хэрэг хэлэлцэх ажиллагааг эхнээс нь шинээр явуулах ба тэдгээрт хэргийн бүх материалтай танилцах бололцоо олгоно.

242.3. Шүүгдэгч өөрийгөө өмгөөлж байгаа бол энэ хуулийн 242.1 дэх заалт хамаарахгүй.

ЭМНЭЛГИЙН ЧАНАРТАЙ АЛБАДЛАГЫН АРГА ХЭМЖЭЭ ХЭРЭГЛЭХ АЖИЛЛАГАА

380 дугаар зүйл. Өмгөөлөгчийг оролцуулах

380.1. Энэ хуулийн 378 дугаар зүйлд / Сэтгэцийн хувьд хэрэг хариуцах чадваргүй үедээ гэмт хэрэг үйлдсэн, эсхүл гэмт хэрэг үйлдсэнийхээ дараа сэтгэцийн өвчнөөр өвчилсөн/ заасан этгээдийн хэрэгт өмгөөлөгчийг заавал оролцуулна.

ӨМГӨӨЛЛИЙН ТУХАЙ

2002 оны 5 дугаар сарын 16-ны өдөр
Өмгөөллийн үйл ажиллагаа

12 дугаар зүйл. Өмгөөлөгчийн бүрэн эрх

12.3.8. өмгөөлөгч жилд хоёр удаа төлбөрийн чадваргүй иргэнийг өмгөөлөх;

20.3. Өмгөөлөгч үйлчлүүлэгчийн эд хөрөнгийн болон бусад байдлыг нь харгалзан үзэж түүнийг өмгөөллийн үйлчилгээний хөлс төлөхөөс чөлөөлж болно.

21 дүгээр зүйл. Төлбөрийн чадваргүй иргэний өмгөөллийн зардал

21.1. Төлбөрийн чадваргүй иргэний өмгөөллийн зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ. Энэхүү санхүүжилтийг Холбоонд олгох бөгөөд уг зардлыг санхүүжүүлэх, тайлан тооцоо гаргах журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн баталж, хэрэгжилтэд нь хяналт тавина.

ШҮҮХИЙН ТУХАЙ ХУУЛЬ

2002 оны 7 дугаар сарын 4-ний өдөр

9 дүгээр зүйл. Өмгөөлөх, өмгөөлүүлэх эрх

9.1. Шүүгдэгч болон шүүхээр эрхээ хамгаалуулж байгаа аливаа этгээд өөрийгөө өмгөөлөх, өмгөөлөгчөө чөлөөтэй сонгон авах, хэргийн баримт сэлттэй танилцах эрхтэй.

9.2. Шүүх энэ хуулийн 9.1-д заасан эрхийг шүүгдэгчид тайлбарлаж, энэхүү эрхээ хэрэгжүүлэх боломжийг хангах үүрэгтэй.

9.4. Төлбөрийн чадваргүй иргэний өмгөөллийн зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ. Уг зардлыг санхүүжүүлэх, тайлан тооцоо гаргах журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн баталж, хэрэгжилтэд нь хяналт тавина.

Сэжигтэн, яллагдагчийг албадан саатуулах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хууль

1999 оны 7 дугаар сарын 1-ний өдөр

Хоригдсон этгээдийн эрх, үүрэг, түүнийг хэрэгжүүлэх

17.1.4. өмгөөлөгчтэй уулзах, хууль зүйн туслалцаа авах;

115 дугаар зүйл. Ялтны эрх, үүрэг

115.1. Ялтан дараахь эрх эдэлнэ:

115.1.3. өмгөөллийн болон хууль зүйн туслалцаа авах;

ЗАРИМ ОРНУУДЫН ЭРХ ЗҮЙН ТУСЛАЛЦААНЫ ҮНДЭСНИЙ ТОГТОЛЦОО⁹

Улс орнуудад эдүгээ үйлчилж буй эрх зүйн туслалцаа үзүүлдэг тогтолцоонд олон төрлийн үйлчилгээ хамрагддаг. Зарим улс орнууд гагцхүү эрүүгийн хэрэгт, нөгөө хэсэг нь эрүүгийн болон иргэний хэрэгт нэгдмэл нэгэн тогтолцооны хүрээнд, бусад нь эрүүгийн болон иргэний хэрэгт хоёр тусдаа хууль зүйн туслалцаа үзүүлдэг.

1 Эрх зүйн туслалцааны асуудлыг хариуцдаг институцууд

Англи зэрэг зарим орны эрх зүйн тогтолцоонд эрүүгийн хэрэгт эрх зүйн туслалцаа үзүүлэх эсэхийг шүүхээс тогтоодог. Өмнөд Африк, Нидерланд зэрэг орнуудад эрх зүйн туслалцаа үзүүлэх асуудлаар төрөлжин байгуулагдсан засгийн газрын тусгай агентлаг шийдвэр гаргадаг. АНУ-д хоёр төрлийн тогтолцоо байдаг ба эрүүгийн хэрэгт шүүх шийдвэр гаргадаг бөгөөд иргэний асуудлаар засгийн газрын баталсан удирдамжийн дагуу ажилладаг ашгийн төлөө бус, эрх зүйн туслалцааны байгууллага шийдвэр гаргадаг.

Австралид Эрх зүйн туслалцааны Комисс, Өмнөд Африк, Нидерланд болон Шотландад Эрх зүйн Туслалцааны Зөвлөлүүдэд улсын өмгөөлөгч ажилладаг ба тэд тухайн хэргийг хувийн өмгөөлөгчдөд шилжүүлэх боломжтой аж. Дурдсан тусгай агентлагийн эрх үүрэг улс орнуудад харилцан адилгүй боловч ерөнхийдөө эрх зүйн туслалцааны тогтолцоог бүхэлд нь удирдах, түүний төсвийг захиран зарцуулах, өмгөөлөгчдөөс үзүүлж буй эрх зүйн туслалцаанд чанарын жишиг тогтоох, эрх зүйн туслалцаа үнэ төлбөргүй үзүүлэх эсэхийг шийдвэрлэх үүрэг хүлээдэг. Ихэнх эрх зүйн туслалцаа үзүүлдэг байгууллагууд үйл ажиллагааны тайлан мэдээг тогтмол хэвлэн нийтэлдэг байхад Шотланд зэрэг цөөн оронд тус байгууллагын үйл ажиллагааг Парламент хянадаг.

Эрх зүйн туслалцаа үзүүлэх үндэслэл улс орон бүрд харилцан адилгүй боловч эрх зүйн олонх тогтолцоонд баримталж буй шалгуур үзүүлэлтүүдийг санхүүгийн, эрх зүйн хэмээн үндсэн хоёр бүлэгт ангилж болно. Эрх зүйн туслалцааг үнэ төлбөргүй авахын тулд тухайн хүн өмгөөлөгч хөлслөх мөнгө хөрөнгөгүй байх ёстой. Тэгэхээр хувийн орлого, хөрөнгийн хэмжээ, зарим орны хувьд түүний хамтран амьдрагчийн орлого, өрхийн ам бүл гэх мэт хүчин зүйлийг энд харгалзан үздэг ёстой аж. Эрх зүйн туслалцаа хүртэх эрхтэй эсэхийг АНУ-д хувь хүний санхүүгийн мэдүүлгээр, Шотландад орлогын баримт, банкны тодорхойлолтоор, Өмнөд Африкт цалингийн цэсээр, Нидерландад хотын захиргаанаас олгодог баримтаар тогтоодог. Финляндад эрх зүйн туслалцаа хүсэгч этгээд санхүүгийн боломж нөхцлөө тодорхойлон танилцуулах тусгай маягт бөглөж, оршин суудаг хотынхоо захиргааны санхүүгийн ажилтнаар баталгаажуулсан орлогын хэмжээг нотолсон баримт, эхнэр буюу нөхөр эсвэл хамтрагчийнхаа орлого, татвар, хүүхдийн халамжийн мөнгө, холбогдох бусад мэдээллийг хавсаргах ёстой байна.

Зарим оронд эрх зүйн туслалцааг бүтнээр нь эсвэл хэсэгчилсэн байдлаар үзүүлдэг. Финляндад эрх зүйн туслалцааг хэд хэдэн бүлэгт ангилдаг. Амьжиргааны тодорхой түвшингээс доогуур нөхцөлд аж төрдөг хүмүүс эрх зүйн туслалцааг бүрэн үнэ төлбөргүй эдэлдэг. Гэтэл амьжиргааны тэрхүү түвшингээс дээгүүр нөхцөлд аж төрдөг боловч эрх зүйн туслалцааны төлбөрийг бүтэн, эсвэл хэсэгчилсэн байдлаар төлөх боломжгүй иргэдэд эрх зүйн үйлчилгээний зардлынх нь 25-аас 90 хүртэл хувийг олгодог. Энэ мэтчилэн Нидерландад өндөр цалинтай хүмүүс эрх зүйн туслалцаа авсан тохиолдолд өмгөөлөгчийн хөлсний ахиу хэсгийг төлөх өгсөх шатлал хэрэглэгддэг.

Эрх зүйн үзүүлэлтийг шалгуур болгох нөхцөлд тухайн хэргийн шинж байдал нь үндсэн хүчин зүйл болдог. Торгууль хүлээлгэх гэмт хэргээс бусад эрүүгийн бүх төрлийн хэрэгт холбогдогчид эрх зүйн туслалцаа үзүүлдэг ба энэ нь хуулийн эрх ашигт нийцдэг.

Олон оронд иргэний хэрэгт эрх зүйн туслалцаа үзүүлдэг. Жишээ нь Өмнөд Африк болон Финляндад гэр бүл салалт, хүүхдийн тэтгэвэр, хөдөлмөрийн маргаан, захиргааны зөрчил, өндөр насны тэтгэвэр гэх мэт хэрэгт эрх зүйн туслалцаа үзүүлдэг.

2 Эрүүгийн хэрэгт эрх зүйн туслалцаа үзүүлэх механизмууд

Улс орнууд эрүүгийн хэрэгт буруутгагдсан иргэддээ эрх зүйн туслалцаа үзүүлэхдээ төрөл бүрийн загварыг ашигладаг. Спангенбергийн бүлгийн эрх зүйн туслалцааны мэргэжилтэн Роберт Спангенберг болон Мариа Фриман нарын

⁹ “Pursuing the public interest” ном 2001 он 6-р бүлэг «Нийгмийн эмзэг бүлэгт эрх зүйн туслалцаа үзүүлэх» 227-250-р тал

тодорхойлсноор АНУ-д гурван загвар байдгийг тодорхойлсон байна. Үүнд 1. өмгөөлөгчдийг томилон ажиллуулах / Ex officio/, 2. Гэрээний үндсэн дээр ажиллуулах, 3. Улсын өмгөөлөгч. Ийм хэв загвар бусад оронд ч байдаг бөгөөд эдгээр механизмын нэгийг буюу хэд хэдийг хамруулсан шинэ загвар ч үүсэх боломжтой. Тэрчлэн хуулийн сургуулиудын клиникийн үзүүлдэг зарим төрлийн эрх зүйн үйлчилгээ нь боловсронгуй эрх зүйн туслалцааны тогтолцоонд эрх зүйн төлөөллийг улам өргөжүүлдэг.

2.1 Томилгооны тогтолцоо / Ex officio/ .

Магадгүй хамгийн эртний гэж хэлж болох томилгооны тогтолцоо нь өдгөө Австрали, Европын олонх орон, Өмнөд Африк, АНУ зэрэг дэлхийн олон оронд байгаа боловч тун цөөн улс орон энэ загварыг хууль зүйн тогтолцоондоо дангаар нь авч хэрэглэдэг байна. Энэ загварын дагуу шүүх, Барын холбоо болон эрх зүйн зөвлөгөө өгөх байгууллага туслалцаа хүссэн ядуу нэгэнд өмгөөлөгч томилдог бөгөөд өмгөөлөгчийн төлбөрийг чухамхүү энэ зорилгоор байгуулагдсан төрийн сангаас барагдуулдаг.

Томилгооны уламжлалт тогтолцоонд шүүх буюу Барын холбооны аль нэгэн гишүүнийг аливаа нэгэн шаардлага тавилгүйгээр томилно. Үүнд өөр ямар нэг нэмэлт шаардлага тавигддаггүй. АНУ-д эрх зүйн туслалцаа үзүүлдэг өмгөөлөгчдийн ярьж буйгаар өмгөөлүүлэгч шүүхийн танхимд байхад өмгөөлөгчийг томилох шийдвэр гардаг тал бий гэнэ. Энэ нь томилгооны өмгөөлөгчид төрөөс маш бага төлбөр төлдөгтэй холбоотой бөгөөд чадвар муутай өмгөөлөгч томилдог гэх шүүмжлэлийн шалтгаан болдог. Томилгооны тогтолцоог шүүмжлэгчид томилогдсон өмгөөлөгчийн мэдлэг чадварыг тогтоох, үйл ажиллагааных нь чанарт тавих хяналт байдаггүй хэмээдэг. Томилгооны уламжлалт тогтолцоо одоо төдийлөн их ач холбогдолтой биш болсон бөгөөд олонх орон өмгөөлөгчдийг тэдний туршлага, мэдлэг, хэргийн нарийн төвөгтэй шинжээс хамаарч ротацийн зарчмаар томилдог тогтолцоог илүү боловсронгуй болгон хэрэглэж байна. Ихэнх улс орнууд өмгөөлөгчдийн эзэмшвэл зохих мэдлэг чадварын наад захын жишиг түвшинг тодорхойлж, тэдний үйл ажиллагаанд хяналтын зарим хэлбэрийг нэвтрүүлэн, сургалт зохион байгуулах замаар томилгооны тогтолцоог боловсронгуй болгож байна. АНУ-ын хууль эрх зүйн тоймчид томилгооны уламжлалт ad hoc тогтолцоо нь хуульчдыг эдийн засгийн хувьд шүүхийн “сайн санаа”-аас ихэд хамааралтай болгоно гэж үздэг ч зохицуулалт бүхий ротацийн загварыг хэрэглэснээр энэ байдлыг үлэмж багасгах боломжтой. Эдгээр хэрэгт өмгөөлөгчийг томилох арга ажиллагаа нь эрх зүйн туслалцаа үзүүлэх тухай хууль тогтоомжоор нарийн зохицуулагдсан байдаг.

Өмгөөлөгчийн томилгооны тогтолцоо эерэг, сөрөг тал

Эерэг

- Удирдахад хялбар
- Захиргааны ачаалал бага
- Томилох арга ажиллагаа түргэн шуурхай

Сөрөг

- Томилогонд тавих хяналт сул
- Удирдлага, чанарын хяналт хязгаарлагдмал
- Сургалтад хамрагдах, мэргэжилдээ өсөх боломж муу
- Ирээдүйн төсвийг бодитой тооцоолоход бэрхшээлтэй
- Шүүхийн томиллогооноос үүдэн өмгөөлүүлэгчийг тууштай төлөөлөх зарчим зарим оронд алдагдах эрсдэлтэй
- Хэрэг бүрд гарах зардлын хувьд хуульчдыг хөдөлмөрийн хөлс /цалин/-өөр эсвэл гэрээгээр ажиллуулах загварыг бодвол өндөр
- Эрүүгийн хэрэгт мэргэших боломж бага

2.2 Гэрээний тогтолцоо

Англид саяханаас гэрээний тогтолцоог хэрэглэсэн. АНУ-ын олон мужийн хууль зүйн тогтолцоо бүхэлдээ буюу хэсэгчилсэн байдлаар энэ хэлбэрээр ажилладаг. Гэрээний тогтолцоонд муж, орон нутаг, хотын Эрх зүйн туслалцааны зөвлөл тогтсон тарифаар тодорхой тооны хэрэгт эрх зүйн туслалцаа үзүүлэхээр хуулийн пүүс, орон нутгийн барын холбоо, төрийн бус байгууллага, зарим тохиолдолд хувь өмгөөлөгчтэй гэрээ байгуулж тохирдог. Энэ гэрээний дагуу өмгөөлөгч эрүүгийн бүх төрлийн хэрэгт тухайн нутаг дэвсгэрийн хүрээнд, Шотландад насанд хүрээгүйчүүдийн эсвэл сонирхлын зөрчлөөс үүдэн улсын өмгөөлөгч ажиллах боломжгүй хэрэг гэх мэт онцгой хэрэг дээр ажилладаг. Гэрээг тодорхой хугацаагаар, ихэвчлэн нэг эсвэл хоёр жилээр байгуулдаг бөгөөд гэрээ дуусмагц дараагийн пүүсийг шуурхай томилох замаар үйлчлүүлэгчдийн хуулийн туслалцаа авах эрхийг хохироохгүй байхад анхаардаг. Тухайн нутаг дэвсгэрийн хүрээнд ядуу хүмүүст үйлчлэх хүсэлтийг хуулийн ямар ч пүүс, төрийн бус байгууллага гаргаж болно. Эрх зүйн туслалцааны газар буюу хотын захиргаа Хуулийн пүүсүүдийн үнийн санал, нэгэн зэрэг хэчнээн хэрэг дээр ажиллах боломжтой болон бусад талыг харгалзан гэрээ байгуулах хуулийн пүүсээ шалгаруулан сонгодог.

Гэрээнүүдэд эрх зүйн үйлчилгээний чанарыг найдвартай хангах баталгааны тухай заалт тусгагддаг. 1990 онд Америкийн Барын Холбоо тус улсад үнэ төлбөргүй үзүүлэх эрх зүйн туслалцааны чанарт хяналт тавих шаардлагатайг дурдсан заалтыг бүх гэрээнд оруулахаар журамласан. Үүний нэгэн адил Англид Хууль зүйн үйлчилгээний комисс /хуучин нэрээр Эрх зүйн туслалцааны зөвлөл/ болон хуулийн пүүсүүдийн хооронд хэлэлцэн тохирдог Ядуу хүмүүсийн хууль зүйн төлөөллийг хангах гэрээ нь үйлчилгээний чанар болон түүнд тавих хяналтын механизмын талаар заалтыг тусгах шаардлагатай. Шотландад Эрх зүйн туслалцааны зөвлөлтэй гэрээ байгуулахын тулд хуулийн пүүс тус газарт урьдчилан бүртгэгдсэн байх ёстой. Тийнхүү бүртгэгдэхийн тулд хуулийн пүүс мэргэжлийн ажиллагааны ёс зүйн хэм хэмжээг сахиж, хавтаст хэрэг хадгалах, бичиг хэрэг, баримт материал хөтлөлт, хариуцлага тооцох талаар тавигддаг шаардлагыг биелүүлэх учиртай.

Хэрэг тус бүр дээр төлөөлөн ажиллах чанарт болон үйлчлүүлэгчдээ анхаарал тавихад нь сөргөөр нөлөөлөхүйц олон хэрэг нэг зэрэг ногдуулахгүй байхад улсын өмгөөлөгч анхаарах ёстой.

Өмнөд Африкийн Үндсэн хуульд урьдчилан хоригдсон болон баривчлагдсан хүн болгон хуулийн ажилтны зөвлөгөөг авах эрхтэй хэмээн заадаг. Ингэсний дүнд Хууль зүйн туслалцааны газар нь цагдаагийн анги, шорон бүрд төлбөргүй харилцах утас байрлуулж саатуулагдсан, баривчлагдсан хүмүүс хуульчидтай зөвлөх боломж олгосон байна. Гэвч Өмнөд Африкийн дээрх газрын мэдэгдэж буйгаар шаардлагатай бүх хүнд эрх зүйн туслалцаа үзүүлэх хөрөнгө мөнгөний боломж үгүй аж. Өмнөд Африкийн энэхүү газар нэгэн үе ажиллагааны нь өртөг зардлаа нөхөхийн тулд хөрөнгө мөнгө хуримтлуулах зорилгоор харилцуур утсаар эрх зүйн зөвлөгөө өгөх үйлчилгээг эхлүүлэхээр завдсан ч энэ санаачилгаа хэрэгжүүлээгүй билээ.

Болзошгүй сонирхлын зөрчлөөс сэргийлэхийн тулд АНУ-ын Барын Холбоо нь эрх зүйн туслалцаа үзүүлэх үйлчилгээг улсын өмгөөллийн тогтолцоонд хэтэрхий тулгуурласан өрөөсгөл байдлаар бус дээрх загваруудын аль алийг нь оролцуулсан холимог байдлаар зохион байгуулахыг муж улсуудын засгийн газраас шаарддаг.

3 Иргэний хэрэгт эрх зүйн туслалцаа үзүүлэх механизмууд

Иргэний хэрэгт эрх зүйн туслалцаа үзүүлэхэд эрх зүйн мэдээлэл, лавлагаа гаргах үйлчилгээ, олон нийтийн эрх зүйн боловсрол, хувь хүмүүст зөвлөх, зөвлөгөө өгөх, зуучлах гэх мэт олон үйлчилгээ хамрагдаж болно. Эдгээр үйлчилгээнд шүүхэд төлөөлөх, олон хүний ашиг сонирхлыг хөндсөн асуудлаар тодорхой бүлгийг төлөөлсөн хэрэг нэхэмжлэх, давж заалдах шатны шүүхэд өмгөөлөх гэх мэт үйлчилгээ мөн багтана. Дурдсан үйлчилгээг зарим үед шүүхэд засгийн газрын байгууллагууд шууд гүйцэтгэдэг боловч ихэвчлэн төрийн бус байгууллага буюу хувийн өмгөөлөгчид гүйцэтгэх нь нийтлэг үзэгддэг.

Олон оронд улсаас санхүүждэг үйлчилгээнээс гадна хувийн буяны байгууллагын үзүүлдэг үйлчилгээ бас байдаг. Аль болох олон хүнд хүрч үйлчлэх үүднээс хуулийн

байгууллагын орон тооны ажилтнууд болон хуульч бус өмгөөлөгчдийг /paralegal/ хэрэглэхэд улам бүр ач холбогдол өгдөг болж байна.

Ядуучууд, хүүхэд, хүчирхийлэлд өртөж хэлмэгдсэн зэрэг хүмүүст эрх зүйн туслалцаа, нийгмийн үйлчилгээг хүргэх явдлыг хангах нь эрх зүйн туслалцаа үзүүлдэг байгууллагуудын төдийгүй, олон нийтийн өмнө тавигдаж байгаа зорилт юм. Өмгөөллийн үйлчилгээ, онцгой нөхцөлд байр сууц, хоол хүнсээр хангах, хүүхэд багачуудыг асрах, зөвлөгөө өгөх, эрүүгийн хэргийн хувьд хувь хүнд хамгаалалт туслалцаа шаардагдсан нөхцөлд хандаж болох чухал суваг бол олон нийтийн байгууллагууд юм.

Эдгээр байгууллага нь хохирсон эмэгтэйчүүд, өндөр настай, тахир дутуу иргэд, бусад хүмүүс гэх мэт үйлчлүүлэгчдийн тодорхой бүлэг давхаргад чиглэж ажиллахад үлэмж шаардагддаг мэдлэг, туршлага хуримтлуулсан байдаг болно. Эрх зүйн туслалцааны нийгэмлэг буюу хуульчид ийм байгууллагын боломж бололцоог ашиглах буюу шаардлагатай тохиолдолд тэдэнд хандахыг үйлчлүүлэгчдээ зөвлөж болно. Эрх зүйн туслалцаа үзүүлдэг олон байгууллагын үйл ажиллагаа нь тэдэнд санхүүжилт өгдөг засгийн газраас эсвэл эрхэм зорилгоо онцлог байдлаар тодорхойлж явцуу хүрээнд мэргэшсэн байдгаас үүдэн нийтийг хамарсан асуудлыг тэдний нэрийн өмнөөс дэвшүүлэн тодруулах, шийдвэрлэх арга замыг нь тайлбарлан таниулахад олон нийтийн байгууллагууд чухал үүрэг гүйцэтгэдэг.

Эрх зүйн туслалцааны Нью Йоркийн нийгэмлэг /ЭЗТНН/ бол олон нийтийн байгууллага эрх зүйн туслалцааг нийгмийн бусад үйлчилгээтэй хэрхэн уялдуулж болдгийн тод жишээ юм. 1876 онд байгуулагдсан ЭЗТНН-ийн гүйцэтгэдэг үүрэг өнгөрсөн хугацаанд нэлээд өөрчлөгдсөн юм. Эхний үед германы цагаачдын эрх ашгийг хамгаалахаар үүссэн эл байгууллага 1990-ээд оны эхээр ядуучуудад эрх зүйн зөвлөгөө өгдөг болж үйлчилгээнийхээ хүрээг тэлсэн байна. Өнөөдөр ЭЗТНН бол АНУ дахь олон нийтэд үйлчилдэг ашгийн бус, хуулийн хамгийн том пүүс болжээ. Эл байгууллага орон тооны 900 гаруй хуульчтай бөгөөд нийгмийн асуудлаар тулгамдсан хэрэгцээ бүхий 300 гаруй мянган хүнд хүрч үйлчилдэг, Нью Йоркийн эмзэг бүлгийнхний эрхийг хамгаалдаг тун чухал хүч болсон байна.

Иргэний асуудлаар эрх зүйн туслалцаа үзүүлдэг олон загвар байдаг боловч тэдгээрийн олонх нь зөвлөгөө өгөх алба, “шууд харилцах утас” буюу орон тооны өмгөөлөгчийн, хувийн өмгөөлөгчийн хөтөлбөр хэмээх үндсэн гурван бүлгийн аль нэгэнд хамрагддаг.

3.1 Зөвлөгөө өгөх алба болон “шууд харилцах утас”

Дэлхийн хоёрдугаар дайны дараагаар Нэгдсэн Вант Улс анх Англи, Уэльс, Умард Ирландад “Иргэдэд зөвлөх товчоо” байгуулсан байна. Нэн өргөн хүрээтэй асуудлаар хүмүүст зөвлөх, практик туслалцаа үзүүлэх үүрэг хүлээсэн тэдгээр товчоо эхнээсээ эрх зүйн зөвлөгөө өгөх алба байдлаар байгуулагдаагүй боловч орон сууц, хөдөлмөр эрхлэлт, гэр бүлийн харилцаа зэрэг эрх зүйн учир холбогдол бүхий үндсэн олон асуудлаар нэлээд их зөвлөгөө өгдөг болсон байна. “Иргэдэд зөвлөх товчоо” нь олон нийтийн хуулийн байгууллага/ 4.3.2-дахь хэсгийг үзнэ үү/-тай байнга холбоотой ажилладаг бөгөөд Олон нийтийн үйл ажиллагааны хөтөлбөр гэдэг түүнтэй төстэй байгууллага 1960-аад онд АНУ-д үүсч орон нутгийн хуулийн байгууллагуудтай ойр дотно холбоотой ажилладаг болжээ.

Польшид Английн загвараар 1996 онд анх байгуулагдсан “Иргэдэд зөвлөх товчоо”/ИЗТ/ эдүгээ 17 газарт үйл ажиллагаа явуулдаг /Нэгдсэн Вант Улсад 2000 гаруй ажилладаг/ бөгөөд цаашид хүрээгээ тэлэхээр төлөвлөж байна. ИЗТ-ны үйл ажиллагааг Варшавт байрладаг Иргэдэд зөвлөх товчоонуудын Холбоо дэмжиж зохицуулдаг байна. Английн ИЗТ-ны маягийн үйл ажиллагаа Чех Улсад мөн явагддаг.

ИЗТ-ны үндсэн үйл ажиллагаа нь мэдээлэл цуглуулах, түгээх, сургалт зохион байгуулах, хувь хүн, хамтын олны үйл ажиллагааг хөхүүлэн дэмжихэд оршдог. Жишээ ИЗТ орон нутгийн болон улсын хэмжээний байгууллагууд, ТББ-ын үйл ажиллагаа, үйлчилгээний талаар иргэдэд мэдээлэх, иргэний эрхийн асуудлаар мэдээллийн тогтолцоо бүрдүүлж шинэчлэн баяжуулах, орон нутгийн захиргаа болон бусад байгууллага, ТББ-ын нийтлүүлсэн мэдээ материалыг түгээн тараах чиглэлээр ажилладаг.

Польшийн ИЗТ хувь хүмүүсийн иргэний эрх, үүргийн талаарх мэдлэг, ойлголт /жишээлбэл, орон сууцны хөнгөлөлт эдлэх боломж, эрхээ хэрэгжүүлэх арга ажиллагаа гэх мэт/-ыг нэмэгдүүлдэг. Нийгмийн халамжаас хүртэх журам, энэ чиглэлээр бичиг баримт бүрдүүлж өгөх хууль дүрмийг тайлбарлан тодруулах зэргээр иргэний эрхийг эдлэх арга

замыг тайлбарлан таниулахад чиглэсэн хөтөлбөр боловсруулан материал бэлтгэж тараах ажлыг эрхэлдэг. ИЗТ мөн нийтлэг бэрхшээлтэй тулгарсан хувь хүн болон хамт олонд тухайн асуудлаар хэрхэн ажиллах талаар зааж, тусалж дэмждэг. ИЗТ-ны философич нь эрх зүйн талаар тулгарсан бэрхшээлээ шийдвэрлэхийн тул иргэд эрхээ бүрэн гүйцэд мэдэх ёстой гэдэгт оршдог. ИЗТ-ны зөвлөхүүд үйлчлүүлэгчдийнхээ өмнөөс шийдвэр гаргадаггүй харин боломж хийгээд үр дагаврын олон хувилбарыг нэг бүрчлэн тодруулж мэдэхэд тэдэнд тусалдаг байна.

ИЗТ олон нийтийг идэвхийг өрнүүлэхийн зэрэгцээ хувь хүн бүрийг үндсэн мэдлэг, шаардлагатай мэдээллээр хангах замаар олон нийтэд үйлчилдэг. Ингэж, ИЗТ нийгмийн оролцоо, хамтын хүчин чармайлтын дүнд орон нутгийн хэмжээний бэрхшээлийг даван туулах арга замыг иргэдэд зааж сургадаг.

Хууль зүйн “шууд харилцуур” нь ялангуяа АНУ-д олон жилийн турш иргэний асуудлаарх эрх зүйн үйлчилгээний тогтолцооны чухал бүрэлдэхүүн нь болон хөгжсөн юм. Эдгээр байгууллагууд үндсэн гол асуудлаар зөвлөх, лавлагаа өгөх, хэнд хандвал зохихыг хэлэх үйлчилгээг харилцуур утсаар гүйцэтгэдэг. Олонх тохиолдолд мөн төрийн өмгөөлөл/4.3.2дугаар хэсэг/-ийн хөтөлбөрт хамрагдах боломжтой эсэхийг тодруулж өгдөг. Шууд харилцуурын эдгээр үйлчилгээг ихэвчлэн засгийн газрын санхүүжүүлэлтээр ТББ-ууд гүйцэтгэдэг. Өмгөөлөгчийн хяналтын дор хуулийн байгууллагын ажилтан, хуулийн салбарын оюутан эсвэл жирийн сайн дурынхан үйлчлүүлэгчдэд зөвлөгөө өгдөг. Зарим тохиолдолд өмгөөлөгч өөрөө зөвлөгөө өгдөг бөгөөд өгөгдсөн зөвлөгөөний ихэнх нь тухайн харилцуур утсанд залгасан хүний өгсөн мэдээлэлд тулгуурлан нэмэлт судалгаа хийлгүй, гуравдагч этгээдээс лавлаж тодруулалгүй хийгддэг. Олон тохиолдолд шууд харилцуур нь мөн шуудангаар бичмэл материал илгээдэг. Утсаар ярьсан хүн өөр төрлийн үйлчилгээ авахыг хүсвэл уг дуудлагыг хүлээн авсан ажилтан чухам хаана, хэнд хандаж болохыг хэлж өгдөг.

Зөвлөх алба болон шууд харилцуур

Эерэг тал

- Олон хүнд хүртээмжтэй
- Өргөн хүрээний асуудлыг хамрах боломжтой
- Зөвлөгөө болон практик туслалцаа үзүүлдэг
- Хаанаас ямар үйлчилгээ авч болохыг зөвлөдөг
- Аливаа урьдчилсан нөхцөл шаарддаггүй

Сөрөг тал

- Зөвлөгөөний хамрах хүрээ, агуулга хязгаарлагдмал
- Шүүхэд төлөөлдөггүй
- Хуулийн системтэй өмгөөлөл биш

3.2 Орон тооны өмгөөлөгчийн / Staff attorney/ хөтөлбөр

АНУ-д иргэний асуудлаар эрх зүйн туслалцаа үзүүлдэг гол механизм нь орон тооны өмгөөлөгчийн хөтөлбөрүүдээр хэрэгждэг. Тэдгээр нь ядуучуудыг гэр бүлийн хууль, орон сууц, хөдөлмөр эрхлэлт, засгийн газраас үзүүлдэг хөнгөлөлтүүд, хэрэглэгчийн болон эдийн засгийн холбогдолтой бусад сэдвийн суурь асуудлуудаар төлөөлөх илэрхий зорилго агуулж байгуулагдсан хувийн, ашгийн төлөө биш байгууллагууд юм. Эдгээр байгууллага голлон үйлчлэх хүн амтайгаа ойр дотно хэлхээ холбоотой байх үндсэн зорилгоо илтгэж ихэвчлэн Олон нийтийн хууль зүйн үйлчилгээ гэсэн нэртэй байдаг ба захирлуудын зөвлөл нь өмгөөлөгчид болон тэднийг удирддаг үйлчлүүлэгчдээс бүрддэг. Орон тооны өмгөөлөгчдийн олонх нь тухайн байгууллагын гүйцэтгэх ажлын шинж чанар, түүгээр үйлчлүүлэгчдийн хүрээг нарийн тогтоож, хязгаарладаг бөгөөд Холбооны засгийн газраас санхүүждэг Хууль зүйн үйлчилгээний компаниас санхүүгийн дэмжлэг авдаг. Хэдэн жилийн тэртээ Холбооны засгийн газрын холбогдох хуульд нэлээд өөрчлөлт оруулснаар олон байгууллага Хууль зүйн үйлчилгээний компаниас санхүүжилт авахын оронд мужийн засгийн газар, улсын болон хувийн бусад эх үүсвэрээс гаралтай санхүүжилтийг илүүд үздэг болсон.

Орон тооны өмгөөлөгчийн хөтөлбөр нь ихэвчлэн орон сууцны, гэр бүлийн хууль гэх мэтээр төрөлжин байгуулагддаг. Тэдгээр байгууллагын үндсэн ажиллагаа нь тухайн бэрхшээлийг шийдвэрлэхэд илүү тохирох туслалцаа дэмжлэгийг хувь үйлчлүүлэгчид үзүүлэхэд оршдог. Үүнд зөвлөгөө өгөхийн тулд зөвлөгөө өгөх уулзалт, захидал бичих, утсаар ярих хэлбэр зонхилдог.

Эдгээр хөтөлбөр нь шүүхэд болон засгийн газрын байгууллагад төлөөлөл гүйцэтгэхэд голлон анхаардаг бөгөөд өмгөөлөгчид нь хариуцсан хэргийнхээ эцсийг үзтэл тууштай ажилладаг. Хууль зүйн үйлчилгээ үзүүлдэг олон хөтөлбөр олон хүнийг хамарсан өмгөөлөлд түлхүү ач холбогдол өгдөг. Өмгөөллийн энэ төрөлд тодорхой хэсгийг төлөөлсөн үйл ажиллагааны хэрэг нэхэмжлэх, хуулийн тодорхой зүйл заалтын эсрэг нэхэмжлэл гаргах, хуулийн төсөл боловсруулах, засгийн газрын гаргасан журамд өөрчлөлт оруулахад нөлөөлөх, ядуучуудыг төлөөлөн ажилладаг бусад байгууллагатай хамтран ажиллах явдал багтдаг.

АНУ-ын орон тооны өмгөөлөгчийн хөтөлбөртэй төстэй байгууллагууд Нэгдсэн Вант Улс, Канад, Австрали, Өмнөд Африк болон бусад улсад байдаг. Тэдгээр нь тухайн улсын засгийн газраас эсвэл орон нутгийн засаг захиргаа, хувийн хандивлагчаас санхүүжиж болно. Өмнөд Африкийн Эрх зүйн Нөөцийн төв /ХНТ/ бол арьсны өнгөөр ялгаварлан гадуурхагч аппартейд дэглэмийн үед иргэний болон улс төрийн эрхийг хамгаалахаар үүсч улмаар орон сууц, хөдөлмөр эрхлэлт, гэх мэт эдийн засгийн асуудлууд болон гэр бүлийн хүчирхийлэл гэх мэт хувь хүний эрхийг хамгаалах асуудалд үйл ажиллагаагаа чиглүүлсэн байгууллагуудын нэгэн жишээ юм. ХНТ Өмнөд Африкт иргэний асуудлаар эрх зүйн туслалцааг чанарын өндөр түвшинд үзүүлж болдгийг харуулж чадсанаар төстэй үйл ажиллагаа бүхий Хууль зүйн төвүүдийн сүлжээг санхүүжүүлэх шийдвэрийг Хууль зүйн туслалцааны Зөвлөлөөр гаргуулсан юм.

Орон тооны өмгөөлөгчийн хөтөлбөр

Эерэг тал

- Орон нутгийн тэргүүлэх зорилтыг тодорхойлдог хүчтэй механизм
- Олон нийтэд бодитой үйлчилдэг
- Олон төрлийн үйлчилгээ үзүүлдэг
- Томоохон асуудлыг тайлбарлан таниулах идэвхтэй стратеги
- Санхүүжилт олох үндэс

Сөрөг тал

- Хувийн өмгөөллийн механизмыг бодвол уян хатан бус
- Эхлэлийн шатанд ажилтнуудын туршлага дутмаг байх талтай
- Өмгөөлөгчийн ажлын ачаалал их

3.3 Хувийн өмгөөлөгчийн хөтөлбөр

Олон оронд иргэний асуудлаар эрхийн туслалцаа үзүүлэх засгийн газрын хөтөлбөрийн хүрээнд хувийн өмгөөлөгчдөд нөхөн олговор өгдөг. Нэгдсэн Вант Улс энэ загварыг уламжлалт хэв шинжийг саяхан болтол илтгэн харуулдаг байсан. Энэ тогтолцооны хүрээнд эрх зүйн туслалцааг үнэ төлбөргүй авахыг хүссэн хүний өргөдөл хүсэлтийг Эрх зүйн туслалцааны Зөвлөл тухайн хүний орлого, уг хэргийн шинж чанар гэх мэт талаас нь нягтлан үнэлэлт өгдөг. Ингээд хүсэлт нь батлагдсан нөхцөлд тухайн хүндээ хөлсөө төлсөн хүмүүсийн нэгэн адил хувийн өмгөөлөгчөөр төлөөлүүлж эрх зүйн туслалцаа авдаг бөгөөд Эрх зүйн туслалцааны Зөвлөл сонгож олсон өмгөөлөгчийн ажлын хөлсийг төлдөг. Энэ үйлчилгээнд санхүүгийн чадамжийн талаасаа хамрагдах эрхтэй хүн, мөн тохирох төрлийн хэрэгт хүртээх учиртай хэмээн эрхийн хүрээг зааж тодруулсан байдлаар энэ хөтөлбөр Нэгдсэн Вант Улсад хэрэгждэг. Энэ нь хувийн өмгөөлөгчид ажиллаж ирсэн уламжлал бүхий бүх хэрэгт хууль зүйн туслалцааг хамруулах байдлаар хүртээмжийг нэмэгдүүлсэн байна. Өмнөд Африк зэрэг Хамтын нөхөрлөлийн гишүүн олон орон Английн загвараар тус тусынхаа тогтолцоог бүрдүүлсэн нь “Judicare” гэж нэрлэгддэг.

Нэгдсэн Вант Улсын Хууль зүйн туслалцааны газар 2000 оны 4 дүгээр сард өөрчлөгдөн, иргэний хэрэгт эрх зүйн туслалцаа үзүүлэх шинэ тогтолцоог үүсгэн Хууль зүйн үйлчилгээний Комисс гэдэг нэртэй болсон. Шинэ тогтолцоо нь эрүүгийн хэрэгт дээр дурдсанчлан гэрээний хэлбэрийг нэвтрүүлсэн бөгөөд иргэний хэрэгт олон нийтийн хууль зүйн үйлчилгээ /ОНХЗҮ/ санхүүгийн чадамж, хэргийн шинж чанарын талаасаа тохирох хүнд үнэ төлбөргүй хууль зүйн төлөөлөл гүйцэтгэдэг болсон байна. Хууль зүйн үйлчилгээний комисс /ХЗҮК/ нь гэр бүл салалт болон гэр бүлийн хуулийн холбогдолтой бусад асуудал, халамжийн хөнгөлөлтүүдийн талаарх зөвлөгөө, зээл, өр авлагын асуудлууд, байр эзэмшигч хийгээд түрээслэгчдийн хоорондын маргаан, цагаачлал, харьяатын асуудал зэрэг олон төрлийн асуудлаар зохих эрх бүхий үйлчлүүлэгчдэд туслалцаа үзүүлдэг. Тэрчлэн ХЗҮК-ын эрхлэх асуудлын хүрээнд төрийн болон улсын бусад байгууллагын шийдвэрийг эсэргүүцэх, цагдаагийн ажилтны зүй бус ажиллагааг буруушаах ажил ч багтдаг.

Засгийн газраас санхүүжүүлдэг эрх зүйн туслалцааны хөтөлбөрүүдээс гадна хувийн өмгөөлөгчид сайн дурын үндсэн дээр иргэний асуудлаар ядуучуудад эрхийн туслалцаа үзүүлдэг. АНУ-д хууль зүйн сангууд ашгийн төлөө бус байгууллагуудад үйлчлүүлэгчдийг “pro bono” буюу сайн дурын өмгөөлөгчдөд хандахыг тэдэнд зөвлөх зэргээр ажилладаг. Винкосин, Пэнсильванни гэх мэт зарим нэг муж judicare хөтөлбөрийг ямар нэг байдлаар хэрэгжүүлдэг. Ийм хөтөлбөр нь сайн дурын өмгөөлөгчдийг элсүүлж, ядуучуудад хамааралтай эрх зүйн тодорхой асуудлаар сургаж мэргэшүүлэн үйлчилгээний чанарыг хангахын тулд зарим төрлийн үйл ажиллагаа явуулдаг. Зохих хэлбэрээр бүтэцжсэн ийм хандлага нь сайн дурын үйлчилгээг нэлээд өргөжүүлэхэд хүргэдэг. Өмгөөлөгчдийн ажиллагааг журамлах үүрэг хүлээсэн олон тооны барын холбоо, шүүхүүд өмгөөлөгчдийг сайн дурын буюу “pro bono” асуудлаар ажиллахад хүчтэй хөхиүлэн дэмждэг бөгөөд энэ байдал нь эрх зүйн улам олон төрлийн үйлчилгээ сайн дурын журмаар хийгдэхэд хүргэдэг.

Хувийн өмгөөлөгчийн хөтөлбөрүүд/Эрх зүйн туслалцаа

Эерэг тал

- Дадлага туршлага бүхий хувийн өмгөөлөгчид ажиллана.
- Ядуучуудад үзүүлэх эрх зүйн туслалцааг хуулийнхны зүгээс хөхиүлэн дэмжинэ
- Төлөөлөлтэй болох олон боломж үйлчлүүлэгчид нээгдэнэ.

Сөрөг тал

- Өндөр үнэтэй болж болзошгүй
- Үйлчилгээний чанарыг хангахад бэрхшээл үүснэ
- Шүүхээр шийдвэрлүүлэх нь маргаан шийдвэрлэх бусад аргаас илүүд тооцно
- Олон нийтийн тэргүүлэх зорилтыг тодорхойлох боломжийг уламжлал ёсоор үл олгоно.

Эрх зүйн туслалцаа үзүүлэх үндсэн механизмын зэрэгцээ хуулийн клиник, Хууль бидний амьдралд хөтөлбөр гэх мэт ядуучуудад эрх зүйн туслалцаа үзүүлэх бусад арга замыг зарим оронд хэрэглэдэг. Эрх зүйн тогтолцоогоо эдгээр нэмэлт арга замын аль нэгэнд үндэслэн бүрдүүлсэн улс байдаггүй ч эрх зүйн туслалцаа үзүүлэхэд дээр өгүүлсэн хоёр арга нэмэлт боломжийг бүрдүүлдэг.

Хуулийн клиник бол хуулийн салбарын оюутнуудыг бэлтгэдэг сургалтын үндсэн бүрэлдэхүүн хэсэг боловч багш буюу хуульчдын эсвэл хоюулангийнх нь хяналтын дотор тухайн үйлчлүүлэгчтэй шууд бодит хэрэг дээр ажиллах боломжийг оюутанд олгодог. Хуулийн клиник энэ утгаараа оюутныг хуулийн практикт ойртуулан хуулийн үйл ажиллагааны үндсэн дадлагыг эзэмшүүлэн сургах, хуульчдаас мэргэжлийн туслалцаа авах бололцоогүй ядуу хүмүүст сайн чанартай эрх зүйн туслалцаа үзүүлэх үндсэн хоёр зорилготой билээ. Хуулийн клиникийг эрх зүйн туслалцаа үзүүлэх тогтолцоондоо нэгтгэсэн сонирхолтой туршлага Өмнөд Африкт байдаг юм билээ. Төв болон Дорнод

Европын олон орны адил Өмнөд Африкт хуульч болохоор хуулийн сургуулийг дөнгөж дүүргэсэн шинэхэн төгсөгч төгсөлтийн дараа хувийн өмгөөлөгчдийг дагалдан дадлага хийх шаардлагатай. Төв болон Дорнод Европын олонх орны нэгэн адил тийм дадлага хийх орон тоо ямагт хүрэлцдэггүй байжээ. 1993 онд ийм дадлагын ажил хийх журмыг өөрчилснөөр хувийн өмгөөлөгчдөөс гадна хуулийн клиникт эсвэл нийтийн ашиг сонирхлыг төлөөлдөг хуулийн пүүст дадлага хийхийг хуулийн сургууль шинэ төгссөн оюутнуудад зөвшөөрчээ. Ингэснээр шинэ төгсөгчдөд орон тоо аажмаар нэмэгдсэн бөгөөд хуулийн клиникт тэднийг оролцуулах болсноор шинэ төгсөгчдийн ажлыг удирдахуйц хангалттай туршлага бүхий хуульчдыг мөн хуулийн клиникүүд ажиллуулж эхэлсэн байна. Тэдгээр клиникүүд Эрх зүйн туслалцааны Зөвлөлөөс шууд санхүүжиж, тойргийн шүүхэд улсын өмгөөлөгчийн газар мэт ажилладаг болжээ. Хуулийн зөвлөгөө өгөх ажилд татан оролцуулах замаар оюутнуудыг хуулийн үндсэн арга ажиллагаанд сургаж дадлагажуулахад хуулийн клиникууд чухал боловч эрх зүйн туслалцааг хүртээмжтэй болгоход тулгарч буй бэрхшээлийг зарим нэг талаар шийдвэрлэхээс бус төгс төгөлдөр арга хэмжээ хараахан биш юм. Өмнөд Африкт байдаг хууль зүйн үйлчилгээ үзүүлэх олон нийтийн клиник эс тооцвол тэдгээр клиникүүд нь тухайн хөтөлбөрийн сургалтыг агуулгыг эрх зүйн туслалцаа авахыг хүссэн үйлчлүүлэгчийн эрэлт хэрэгцээтэй уялдуулах зайлшгүй шаардлагаас үүдэн эрх зүйн төлөөлөл гүйцэтгэх тийм ч үр дүнтэй механизм биш юм.

Эрх зүйн үйлчилгээг ядуучуудад хүртээмжтэй болгох өөр нэгэн арга бол Хууль бидний амьдралд хөтөлбөрөөр дамжиж хэрэгждэг. Хууль бидний амьдралд хөтөлбөр бол дунд сургуулийн сурагчид болон бусад оролцогчдод эрх зүйн тогтолцооны үйл ажиллагаа явагддаг зарчмыг тайлбарлах, тэдний өдөр тутмын амьдралд нөлөөлж болох эрх зүйн асуудлуудын талаарх үндсэн мэдэгдэхүүн олгоход чиглэдэг. Хууль бидний амьдралд хөтөлбөрүүд нь Эрүүгийн хууль, өсвөр үеийнхэн, орон сууц нийгмийн халамж болон бусад асуудлаарх хуулийн асуудлуудыг сонсогчдод тайлбарлан ойлгуулахад хуулийн салбар оюутан-сургагчдыг бэлтгэх замаар их сургуулиудад ямагт түшиглэдэг. Жишээ нь Варшавын Их сургуулийн Хуулийн салбарын Хууль бидний амьдралд хөтөлбөрт оролцогч оюутнууд иргэний эрхийн асуудлаарх бичмэл материал бэлтгэж эрх зүйн туслалцаа авахыг хүссэн олон үйлчлүүлэгчиддээ тараасан байна. Хууль бидний амьдралд хөтөлбөр нь иргэний эрхийн талаар болон эрх зүйн туслалцааг хаанаас авч болох талаар оролцогчдоо зааж сургадаг учраас хуулийн клиникийн чухал бүрэлдэхүүн юм.

5 Санхүүжилт

Эрх зүйн туслалцаа үзүүлдэг тогтолцоо үндсэндээ улсын төсвөөс санхүүждэг. Холбооны улсын тухайд эрх зүйн туслалцаа үзүүлдэг тогтолцоог санхүүжүүлэх үүрэг төв болон орон нутгийн захиргаанд ижилхэн ногддог. Засгийн газрын санхүүжилт тэр бүр бүрэн хүрэлцээтэй байдаггүй болохоор олон орон дахь эрх зүйн туслалцааны хөтөлбөрүүд санхүүжилтийн хоёрдогч үүсвэр хайдаг. Эрх зүйн туслалцаа үзүүлдэг тогтолцоог санхүүжүүлдэг нэгэн чухал хэлбэр бол Хуульчдын хамтын дансны хүү тооцох хөтөлбөр /ХХДХТХ/ юм. Эдүгээ Австрали, Канад, Шинэ Зеланд болон АНУ-д хэрэгжиж байгаа ХХДХТХ-ийн дагуу өмгөөлөгчид Санд хувийн хандив оруулахад тэр нь дансны хүүгээр өсч арвижаад үйлчлүүлэгчдэд хүрдэг. ХХДХТХ-өөр хуримтлагдсан хөрөнгө нь ядуучуудад эрх зүйн туслалцаа үзүүлдэг хуулийн пүүсүүдэд хуваарилагдан очдог. Өнөөдрийн байдлаар АНУ-д ХХДХТХ-аар жил бүр ойролцоогоор 100 сая ам доллар хуримтлагддаг бөгөөд уг мөнгө бага орлоготой 1.7 сая америкчуудад эрх зүйн наад захын үйлчилгээ үзүүлэхэд зориулагддаг. Хууль зүйн боловсрол, сургалт, итгэмжлэгдсэн их сургуулиудын дэргэдэх эрх зүйн туслалцаа үзүүлдэг хуулийн клиникийг тусалж дэмжихэд ХХДХТХ-тэй төстэй Санг Өмнөд Африкт ашигладаг.

АНУ-ын зарим муж өөр өөр арга замаар өөрсдийн эрх зүйн туслалцаа үзүүлдэг тогтолцоог санхүүжүүлдэг. Жишээ нь Алабама мужид Шударга шүүхийн татварын Сан байгуулж ядуу иргэдийн шүүхийн ажиллагааны зардлыг уг сангаас төлдөг. Арканзас мужид эрүүгийн болон иргэний хэрэгт эрх зүйн туслалцаа үзүүлэхэд муж, дүүргүүдээс хуваарилагддаг санхүүжилтийн зэрэгцээ бүх төрлийн эрүү болон иргэний хэрэгт 5 ам. долларын хураамж ногдуулдаг. Кэнтакки муж эрүүгийн хэрэгт эрх зүйн туслалцаа авагчдад 40 ам. долларын захиргааны хураамж төлөх ёстой боловч төлбөрийн чадваргүй эсвэл урьдчилан хоригдсон хүмүүсийг энэ төлбөрөөс чөлөөлдөг. Тэрчлэн согтуугаар автомашин жолоодсон бүх хүн 200 ам. долларын үйлчилгээний хураамж төлдөг бөгөөд 50

ам. доллар нь эрх зүйн туслалцааны санд ордог. Монтана мужид эрүүгийн хэрэгт эрх зүйн туслалцаанд зориулагдсан Санг автомашины бүртгэлийн хураамжаас бүрдүүлдэг байна.

6. Хүн бүрийг үр дүнтэй төлөөлөх явдлыг хөгжүүлэх нь

Ядуу буурай бүлгийнхэнд эрх зүйн үр нөлөө сайтай үйлчилгээ үзүүлэх явдал Төв болон Дорнод Европын улсуудад тун чухал асуудлын нэг юм. Гэвч тус бүс нутаг дахь эрх зүйн туслалцааны ирээдүйг өөдрөгөөр харах зарим шалтгаан байгаа. Зохих жишигт нийцсэн хууль зүйг нийтэд хүртээмжтэй болгох, эрх зүйн туслалцааны, бодитой ажилладаг тогтолцоог бүрдүүлэх нь анх бодсон шиг тийм ч сэтгэл түгшээсэн, бэрхшээл биш аж.

1. Стратегийн нэхэмжлэл гаргах замаар “Шударга шүүхийн жишиг”-ийг бататгах нь

Одоогийн байдлаар Төв болон Дорнод Европын улсуудын Эрүүгийн мөрдөн байцаах ажиллагааны хууль тогтоомж төлбөрийн чадваргүй байдлыг эрх зүйн туслалцааг үнэ төлбөргүй авах үндэс болно хэмээн тооцдоггүй. Эрүүгийн мөрдөн байцаах ажиллагааны хуульд тодорхой төрлийн гэмт хэрэгт татагдсан хүнд зөвлөх томилж ажиллуулах механизм бий боловч хорих ял авч болзошгүй байдалд буй асар олон тооны шүүгдэгч тэдгээр төрөлд хамрагддаггүйгээс эрх зүйн туслалцааг үнэ төлбөргүй авах эрх нь баталгаатай бус байна. Энэ байдал бол хүний эрхийн олон улсын жишгээс эрс гажууд юм. Хоригдох ял авч болзошгүй сэжигтэнд эрх зүйн туслалцааг үнэ төлбөргүй үзүүлэхгүй байх нь шударга шүүхийн зарчмыг зөрчихөд хүргэж магадгүйг Хүний эрхийн Европын шүүхийн саяхан шийдвэрлэсэн нэгэн хэрэг харуулсан билээ. Эрх зүйн туслалцааг үнэ төлбөргүй авах сэжигтний эрх зөрчигдөж буйг үндэсний шүүхийн өмнө гаргаж тавих, Хүний эрхийн Европын шүүх /ХЭЕШ/ээс тухайн хэргийг шийдвэрлэсэн байдалд тулгуурлан үндэслэл гаргах буюу ХЭЕШ-д хэрэг нэхэмжлэх зэргээр өмгөөлөгчид үндэснийхээ хууль тогтоомжийг Хүний эрхийн Европын конвенцэд нийцүүлэн боловсронгуй болгох, жишигт нийцсэн хууль зүйн ажиллагааг дотооддоо хүртээмжтэй болгох бололцоотой юм.

2 Судалгаа болон туршилтын төслөөр хэрэгцээ шаардлагыг тодорхойлох нь.

Төв болон Дорнод Европын орнуудын статистик нь хууль зүйн байгууллагад хандахад чухамдаа хэдий хэр бэрхшээл тулгардаг болохыг харуулах боломжгүй байдаг. Тиймээс ядуу хүмүүсийн эрэлт хэрэгцээ ямар байгааг тодорхойлох болон уг тогтолцоог шинэчлэн өөрчлөх талаар ямар арга хэмжээ авах шаардлагатайг тодорхойлон тогтооход хүндрэл учруулдаг. Тиймээс судалгааны ажил болон туршилтын төслүүд нь практик хэрэгцээг тодорхойлох чухал хэрэглүүр болдог. Судалгааны ажил болон туршилт төслүүд нь эрх зүйн салбарт өргөн хүрээтэй шинэчлэл явуулахад хууль тогтоогчдыг дорвитой татан оролцуулахын тулд лоббидоход тодорхой үүрэгтэй. Өмнөд Африкт эрх зүйн туслалцааны тогтолцоог шинэчлэхэд судалгааны ажил болон туршилт төслүүд маш чухал үүрэг гүйцэтгэсэн юм билээ.

2.1 Судалгааны ажлууд

Эрх зүйн туслалцааны тогтолцоог өөрчлөхөд судалгааны ажлууд үр дүнтэй хэрэгсэл болдог. Шинжлэх ухааны үүднээс бодож төлөвлөсөн судалгаа, бодит байдлын талаар нягт нямбай цуглуулж эмхэтгэсэн үр дүнгүүд нь эрх зүйн туслалцааны шинэ тогтолцоог засгийн газраар дэмжүүлэхэд тустай бөгөөд эрх зүйн туслалцааны тогтолцоог үндсээр нь өөрчлөхөөр шийдвэрлэж ноцтой шүүмжлэлтэй тулгарсан үед засгийн газарт тулх сайтай бодит дэмжлэг болдог. Болгар болон Польшийн Төрийн бус байгууллагууд одоогийн тогтолцооны алдаа дутагдал, тэдгээрийг засч залруулах арга замыг тодорхойлох зорилго бүхий нийт салбарын хэмжээний томоохон судалгаа явуулсан байна.

2.2 Туршилтын төслүүд

Зарим оронд эрх зүйн туслалцааны тогтолцоог шинэчлэхийг эрмэлзэгчид туршилтын төслүүд хэрэгжүүлэн шинэчлэлийг явуулах арга замуудыг задлан шинжилдэг. Урьд өмнө байгаагүй шинэ байгууллын ач тусыг эртнээс мэдэрч, өргөн олны талархал, улс төрийн

дэмжлэгийг өрнүүлэх бололцоо олгодог учраас эрх зүйн шинэчлэлийг эхлүүлэхэд туршилтын олон төсөл ач холбогдолтой болохоо харуулсан. Нөгөөтэйгүүр, туршилтын төслүүд бол тухайн хөтөлбөрийн сөрөг талыг судалж, болзошгүй уршгийг багасгахад тустай талаасаа хууль тогтоогчдын лаборатори гэгддэг.

3. Эрх зүйн туслалцааны шинэ тогтолцоо

Эрүүгийн хэрэгт татагдсан ядуу хүмүүсийн эрх зүйн туслалцаа үнэ төлбөргүй авах эрхийг хүний эрхийн олон улсын гэрээнүүдэд заасанчлан бодитой хэрэгжүүлэхэд төрөөс томилогдсон өмгөөлөлд хандах хүмүүсийн тоо ихээхэн нэмэгдэх төлөвтэй байгаа юм. Эрх зүйн туслалцаа авах эрх бол хүний эрхийн олон улсын жишгийн дагуу үр дүнтэй эрх зүйн туслалцаа авах эрх болохоор томилогдсон өмгөөлөгчдийн үзүүлж буй үйлчилгээний үр ашиг, чанарыг баталгаажуулах зарим арга механизмыг бий болгохыг зүй ёсоор шаардах болно. Хүн бүрд өмгөөлөгч томилж ажиллуулдаг өнөөгийн хэлбэр нь улам бүр нэмэгдэж буй ажлын ачаалал, эрх зүйн туслалцааны чанарт тавих хяналт гэх мэт талаас үзвэл зохистой бус байгаа юм. Эрх зүйн туслалцаа үзүүлэх ажиллагаанд шинэ хэлбэр нэвтрүүлэх явдал нийт эрх зүйн салбарын шинэчлэлийн зайлшгүй үр дүн юм. Эрх зүйн туслалцааг зохион байгуулах, удирдах хийгээд түүний санхүүжүүлэлтийн хамгийн зүй зохистой хэлбэрийг сонгох нь тухайн орны өвөрмөц нөхцөл байдлаас хамаарна. Гэхдээ эрх зүйн салбарыг шинэчлэгчдийн өмнө тулгарах нийтлэг хэдэн асуудал бий.

3.1 Ядуу гэдгийг хэрхэн тогтоох вэ?

Эрх зүйн үйлчилгээний хөтөлбөр оршин тогтнох, цаашид үргэлжлэн хөгжихөд хамгийн чухал асуудлын нэг нь тухайн байгууллагын үйлчлүүлэгчийнхээ ядуу гэдгийг бодитойгоор баримтжуулах чадвар юм. Тус бүс нутгийн эдийн засгийн өнөөгийн амаргүй нөхцөлд эрх зүйн туслалцааны байгууллага хэрэв тусламж авах хэрэгцээ шаардлагагүй хүмүүст хөрөнгө мөнгийг зарцуулаад байна гэж шүүмжлүүлбэл засгийн газраас санхүүжиж оршин ажиллахад бэрх болно. Тийм учраас эрх зүйн туслалцаа үзүүлдэг байгууллагууд нэгдүгээрт үйлчлүүлэгч үнэхээр ядуу, хоёрдугаарт, үнэхээр хэрэгцээтэй хүмүүст нь туслах талаар хөтөлбөр хүчин чармайлт тавьж байгааг харуулах зорилгоор үйлчлүүлэгчдийн орлого гэх мэт үзүүлэлтийг ашиглан шүүмжлэлд няцаалт өгөх хэрэгтэй юм.

3.2 Загвар тогтолцоог сонгох нь

Эрх зүйн туслалцаа үзүүлдэг байгууллагын шинэ буюу шинэчилсэн загвар тогтолцоог тогтооход Хууль зүйн Яам, Барын холбоо, Сангийн Яам, төрийн санхүүгийн холбогдох байгууллагууд, төрийн бус байгууллагууд зэрэг төрөл бүрийн байгууллагын уялдуулан зохицуулсан хамтын чармайлт шаардлагатай. Оролцогч байгууллагуудын байр суурь өөр хоорондоо зөрүүтэй байж болох хэдий ч эрх зүйн туслалцааны шинэчлэл амжилттай болох эсэх нь тэд бүгдийн оролцооноос хамаарна. Хүн амд эрх зүйн туслалцааны чухам ямар тогтолцоо илүү нийцтэй байхыг мэдлэгтэй, аль нэг тал руу хэлбийлгүй, тэнцвэртэй шийдвэрлэхийн тулд шийдвэр гаргагчид дараах асуудлуудад анхаарал хандуулах шаардлагатай гэж үзнэ. Үүнд:

- Эрх зүйн туслалцаа үзүүлдэг тогтолцоонд нэг жилийн хугацаанд хэдэн хэрэг хамрагдах хийгээд, тэдгээрт эрх зүйн туслалцаа үзүүлэх ажилд ямар хэмжээний хөрөнгө мөнгө шаардагдахыг тооцох,
- Тухайн эрэлт хэрэгцээ төсөвт зохион байгуулалтын ямар хэлбэр зохистойг тогтоох,
- Хуулийн байгууллагад тогтсон уламжлалт хандлага, түүнд хандах талаарх хүмүүсийн хэвшмэл төсөөлөл,
- Шинэ тогтолцоо сайн ажилладаг болгохын тул хууль тогтоомжийг хэрхэн өөрчлөх,
- Эрх зүйн туслалцаа үзүүлэх тогтолцооны ил тод тайлагнах, хяналт тавих арга ажиллагаа.

Ядуу зүдүү байдлаас эсвэл дарангуйллын дэглэмээс үүдэн хүн амын дийлэнх хэсэг нь хуулийн хамгааллын ач холбогдлыг мэдэрч хэвшээгүй оронд хууль учир холбогдол багатай байдаг. Эрх зүйн үйлчилгээ нь хувь иргэний өмнөөс хуулийн ач тусыг харуулах замаар хараахан өртөөгүй хүмүүсийн хүч бололцоог нэмэгдүүлж, нийгэмд хуулийн эзлэх байр суурь, үзүүлэх нөлөөллийг нэмэгдүүлдэг. Эрх зүйн туслалцаа үзүүлдэг өмгөөлөгчид

үйлчлүүлэгчдээ хуулийг болон түүний хамгааллын ач холбогдлыг тодорхой тайлбарлан таниулж, хувь хүний иргэний эрх, эрх чөлөөг хүлээн зөвшөөрөх, сахин хамгаалах талаар хуулийн, засаг захиргааны болон шүүхийн тогтолцоонд шахалт үзүүлж няхуур бөгөөд шаргуу ажиллах ёстой. Нийгэм хийгээд хуулийн байгууллагын хоорондох хоосон орон зайг эрх зүйн ямар ч туслалцаа дүүргэхгүй. Гэвч энэ нь засгийн газар болон хуульд дургүйцэх явдлыг бий болгодог нийгэмд ихээхэн газар авсан ялгарлыг багасгахад томоохон үүрэг гүйцэтгэдэг.

ТӨВ БОЛОН ДОРНОД ЕВРОПЫН ОРНУУД ДАХЬ ХУУЛИЙН БАЙГУУЛЛАГЫГ НИЙТЭД ХҮРТЭЭМЖТЭЙ БОЛГОХ НЬ

Дорнод Европт идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг Болгарын Хельсинкийн Хороо, Польш дахь Хүний эрхийн Хельсинкийн Сан, Инттерайтс болон Колумбын Их сургуулийн Хуулийн салбарын дэргэдэх Шилжилтийн шатанд буй орнуудын нийтийн ашиг сонирхлын Хууль санаачлах төсөл /ШШОНАСХСТ/ гэдэг Төрийн бус 4 байгууллага эрх зүйн туслалцаа, хуулийн байгууллагуудыг нийтэд хүртээмжтэй болгох чиглэлээр шинэчлэл өрнүүлэх зорилгоор 2000 онд бүсийн хэмжээний төсөл хэрэгжүүлэхэд хүчин чармайлтаа нэгтгэсэн юм. Ингэхдээ Польш, Болгарыг туршилт болгон сонгож төсөлд оролцогч талууд бодит байдлын судалгаа явуулж, холбогдох талуудыг хамруулан үндэсний хэмжээний чуулган зохион байгуулж улмаар бүсийн бага хурал хийжээр төлөвлөсөн. Төслийн хүрээнд авч хэрэгжүүлсэн үйл ажиллагааны дүнд эрх зүйн туслалцааг бэхжүүлэхийг эрмэлзсэн хүний эрхийн хуульчид шүүгчид, барын холбоодын удирдагчид, хууль зүйн яамны албан тушаалтнуудаас бүрдсэн эвсэл тус бүс нутагт бий болсон. Шүүхийн байгууллагыг нийтэд хүртээмжтэй болгох төслийн хүрээнд Нью Йорк хотын Барын Холбоотой хамтран ШШОНАСХСТ-өөс дэлхий олон оронд нийтийн эрх ашгийг хөндсөн асуудлаар дагнан ажилладаг хуульчид эрдэмтэд, идэвхтэнүүдэд хэд хэдэн боломж олгосон шүүхийн байгууллагыг нийтэд хүртээмжтэй болгох асуудлаарх цахим чуулганыг ВЭБ хуудсанд эхлүүлсэн. Шүүхийн байгууллагыг нийтэд хүртээмжтэй болгох асуудлаарх цахим чуулган нь оролцогчдоос интернэт ашиглан аливаа материалыг чөлөөтэй байршуулах, хүлээн авах боломж бүхий, төвлөрсөн биш өгөгдөхүүний санг бүрдүүлсэн бөгөөд аливаа шинэ чиг хандлагыг хэлэлцэх, эрх зүйн туслалцаа, шүүхийг нийтэд хүртээмжтэй болгоход холбогдолтой бусад асуудлаар нэг нь нэгэндээ зөвлөх, мэдээлэл солилцох бололцоо олгосон хэлэлцүүлгийн салбартай билээ.

Латвийн эрх зүйн туслалцааны туршилтын төсөл

Ядуу хүмүүст эрх зүйн туслалцааг үнэ төлбөргүй үзүүлэх тогтолцоо байгуулах зорилго бүхий Эрх зүйн туслалцааг үнэ төлбөргүй үзүүлэх Хөтөлбөр 1999 оны 4 дүгээр сард хэрэгжиж эхэлсэн. Хөтөлбөр эхний шатанд эрх зүйн туслалцаа үзүүлэх тухайн үеийн хууль тогтоомж, эрх зүйн шинэчлэл явуулах шаардлагыг судалсан байна. Түүнчлэн Болгарын Хельсинкийн Хорооны явуулсан судалгааны ижилд нэгэн судалгаанд тулгуурлан Латвийн тухайн үеийн нөхцөл байдалд үнэлэлт өгсөн аж. Хөтөлбөрийн гуравдахь шатанд Улсын өмгөөлөгчийн албыг байгуулсан байна.

Латвийн Парламент Эрх зүйн туслалцааг Төрөөс баталгаажуулах тухай хуулийг 2000 оны 3 дугаар сарын 28-нд баталсан бөгөөд уг хууль 2001 оны 1 дүгээр сарын 1-нд хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлжээ. Шинэ хуулийн дагуу жилийн орлого болон хөрөнгийн хэмжээ нь Латвийн засгийн газраас тогтоосон хэмжээнээс доогуур, олон улсын хуулиар эрх зүйн туслалцаанд үнэ төлбөргүй хамрагдах ёстой Латвийн иргэд хуулийн төлөөллийг үнэ төлбөргүй хийлгэх эрхтэй болсон байна. Хуулийн шаардлагын дагуу эрүүгийн, иргэний болон захиргааны хэргүүдэд эрх зүйн туслалцаа үзүүлдэг болжээ. Тухайн хүний орлогын хэмжээнээс шалтгаалан эрх зүйн туслалцааны үнийг төрөөс тодорхой шатлалаар хариуцдаг байна. Орон нутгийн засаг захиргааны албадаас санал болгосны дагуу эрх зүйн туслалцааг хувийн өмгөөлөгчид үзүүлдэг. Улсын өмгөөлөгчийн алба зэрэг улсын байгууллага болон хуулийн клиникүүд Хууль зүйн яамнаас баталсан журмын дагуу эрх зүйн туслалцаа үзүүлэх болжээ. Улсын байгууллагууд нь зохих хуулийн дагуу хандиваар санхүүжихээс гадна мөнгөн болон биет хэлбэрийн хандивыг төрийн болон орон нутгийн захиргааны байгууллагуудаас авдаг. Үйл ажиллагааны эхний жилд 8 сая орчим латс буюу 200 мянган ам. долларын хандив хуримтлуулахаар төлөвлөснөөс үзэхэд хөтөлбөрийг байнга хэрэгжүүлэхэд нэмэлт санхүүжилт шаардлагатай аж. Латвийн

Нээлттэй нийгмийн хүрээлэн, Үндсэн хуулийн болон хуулийн бодлогын хүрээлэн хамтран туршилтын журмаар Улсын өмгөөлөгчийн албыг Сиаулиай хотод 5 өмгөөлөгчтэйгээр 2000 оны 3 дугаар сард байгуулсан байна. Улсын өмгөөлөгчийн албыг Сиаулиай ажиллагаагаа эхэлснээс хойш 8 сард гүйцэтгэсэн ажлын үр дүн нь нэлээд урам төрүүлсэн бөгөөд шүүхийн шатанд хуулийн төлөөлөл шаардагдсан хэргүүдийн 50 хувийг дээрх 5 өмгөөлөгч гүйцэтгэсэн байна. Гэтэл нийт хэргийн үлдсэн 50 хувьд нь томилогдсон хувийн 34 өмгөөлөгч ажилласан байна. Урьдчилсан мөрдөн байцаалтын явцад эрх зүйн өмгөөлөл шаардагдсан нийт хэргийн 80 хувьд нь Сиаулиайн Улсын өмгөөлөгчийн албыг ажилласан. Улсын өмгөөлөгчийн алба бол Латвийн хуульд цоо шинэ ойлголт бөгөөд Төв болон Дорнод Европын эрх зүйн уламжлалд урд байгаагүй байгууллага юм. Олон нийтэд төдийлөн сайн танигдаагүй хэр нь Улсын өмгөөлөгчийн алба Сиаулиай хотын хууль сахиулах тогтолцооны салшгүй хэсэг болсон бөгөөд Сиаулиайд уг хөтөлбөр хэрэгжсэнээс 8 сарын дараа шүүгчид, прокурорууд, цагдаагийн мөрдөн байцаагч нартай ярилцаж үзэхэд тэдний хэн нь хуучин тогтолцоонд эргэж орох талаар төсөөлөх ч хүсэхгүй, бүгд л хөтөлбөрийг цаашид үргэлжлүүлэхийг эрмэлзэж байжээ.

Улсын өмгөөллийн тогтолцоо

Эерэг тал

- Мэдлэг чадвар сайтай хуульчид эрх зүйн туслалцаа үзүүлдэг
- Чанарыг хянах боломжтой
- Сургалтад хамрагдан, мэргэжлийн хувьд өсөх боломжтой
- Ажиллагааны зардал хямд
- Ирээдүйн төсвийг төлөвлөх, зарцуулалтыг хянахад нэн хялбар
- Статистик бүртгэл нь ил тод байдлыг хангахад ихээхэн төстэй

Сөрөг тал

- Орон тооны өмгөөлөгчид ажлын ачаалал өндөр
- Төстэй хэргүүдэд хэвшмэл байдлаар хандах эрсдэлтэй
- Улсын өмгөөлөгч төрийн хууль зүйн аппаратын хэсэг мэт төсөөлөгддөг

Өмнөд Африкын Бүгд Найрамдах Улс дахь хууль зүйн туслалцааны зөвлөл нь сүүлийн арван жилийн хугацаанд эрх зүйн туслалцаа үзүүлдэг үндсэн байгууллага болоод байна. Тус улс апартэйд дэглэмийн үед иргэний хэргийн чиглэлээр эрх зүйн туслалцаа үзүүлэх шаардлагыг хүлээн зөвшөөрч, 1969 онд Хууль зүйн туслалцааны зөвлөлийг байгуулсан. Зөвлөл 1971 оноос үйл ажиллагаагаа эхэлсэн бөгөөд төсвийн ихэнхи хөрөнгө тэр ч байтугай эрүүгийн хэрэгт ноогдох хөрөнгийг гэр бүл салалт, хохирлын нэхэмжлэл зэрэг иргэний хэргийг шийдвэрлэхэд зарцуулж байсан байна. Харин сүүлийн жилүүдэд иргэний хэрэгт зарцуулагдах зардлын хэмжээ харьцангуй багасч, төсвийн ихэнхи хэсэг эрүүгийн хэрэгт хууль зүйн туслалцаа үзүүлэх ажилд зориулагдах болсон.

Хууль зүйн туслалцааны зөвлөлийн гол үүргийг “Ядуу буурай хүмүүст хууль зүйн туслалцаа үзүүлэх эсхүл тийм боломжийг бий болгох” гэж хуульд заасан. Тус зөвлөл нь шүүгч, өмгөөлөгч, хуулийн зөвлөх, засгийн газрын яамдын ажилтан, хууль зүйн туслалцааны асуудлаархи судлаач зэрэг төлөөлөлтэй байдаг бөгөөд зөвлөлийн үйл ажиллагааг дэмжих гурван нэмэлт гишүүн, мөн Бүгд Найрамдах Улсын ерөнхийлөгчөөс Засгийн газартай зөвшилцөн нэмэлт зургаан гишүүнийг томилж болдог байна. Зөвлөл нь орон нутгийн 31 нэгжид хууль зүйн төвтэйгөөс гадна магистратийн 40 шүүхэд өмгөөлөгч томилон ажиллуулдаг. Зөвлөл нь Хууль зүйн яамны магистратийн шүүх дэх албан хаагчдын туслалцаатайгаар өөрийн салбар зөвлөлгүй хотод үйл ажиллагаагаа явуулдаг.

А. ХУУЛЬ ЗҮЙН ТУСЛАЛЦААНЫ ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Хууль зүйн туслалцааны зөвлөл нь ядуу буурай хүмүүст хууль зүйн туслалцаа үзүүлэхэд шаардлагатай бүхий л үйл ажиллагаа явуулах эрхтэй. Зөвлөл анх өмгөөллийн америк тогтолцоо буюу өмгөөлөгч томилох болон цалинтай хуульчийн холимог загварын оронд өмгөөлөгч томилдог Английн тогтолцоог авч хэрэглэсэн юм. Тус зөвлөл нь хуульд заасан

болон Хууль зүйн туслалцааны удирдамжид тодорхойлсон үйл ажиллагааны дүрэм журмын дагуу өөрийн эрхийг хэрэгжүүлж ажилладаг. Уг удирдамжид Зөвлөлийн албан хаагч болох Хууль зүйн туслалцааны эрхлэгчийн хяналтын дор шийдвэрийг хэрэгжүүлж байхаар заасан. Удирдамжид хуулийн дадлагажигч нар хийсэн ажлынхаа төлөө хөлс авах ёстойг хүлээн зөвшөөрдөг бөгөөд төлбөрийн хэмжээг тэдэнд танилцуулсан байдаг. Ерөнхийдөө хууль зүйн туслалцааны зөвлөлийн албан хаагч нь шаардлага хангасан хүсэлт гаргагчийг дэмждэг боловч, хэрэв тэд хууль зүйн туслалцаа авах шаардлагыг хангахгүй тохиолдолд тэднийг хууль зүйн дадлагажигчийг сонгон авахуулахаар илгээж болдог. Хэрэв хүсэлт гаргагч огт шаардлага хангахгүй бол Хууль зүйн туслалцааны зөвлөлийн албан хаагч нь түүнийг зохих төрийн байгууллага эсхүл холбогдох байгууллагад илгээдэг.

Санхүүгийн шаардлага

Хэдийгээр хууль, тогтоомжид ядуу хүн гэсэн ойлголтыг тодорхойлоогүй боловч Хууль зүйн туслалцааны зөвлөлөөс тухай бүр зохих шалгуурыг шинэчлэн тогтоож байдаг. Өнөөдрийн байдлаар ядуу хүн гэдэгт нэг сард дээд тал нь 600 Рандын орлоготой ганц бие хүн, 1200 Рандын орлоготой гэр бүлийг хэлдэг бөгөөд хүүхэд тус бүрт 180 Рандын орлогын хязгаарлалт тогтоодог. Жишээлбэл: дөрвөн хүүхэдтэй эхнэр нөхөр хоёр нийтдээ 1920 р-ийн сарын орлоготой байж болно /1200+720/4x180/. Хэдийгээр ийм хязгаарлалт тогтоодог боловч онцгой тохиолдолд Хууль зүйн туслалцааны зөвлөлийн захирлын шийдвэрээр энэ шаардлагаас гадна үлдсэн хүмүүст хууль зүйн туслалцаа үзүүлж болдог.

2. Үл хамаарах хүчин зүйлс

Удирдамжид зааснаар “хуульчийн туслалцаа шаардлагатай бүх тохиолдолд” хууль зүйн туслалцаа үзүүлэх ёстой. Хэдийгээр хүсэлт гаргагч нь туслалцаа авах шаардлагыг бүрэн хангаж байсан ч зарим төрлийн эрүүгийн болон иргэний хэргүүд нь удирдамжийн дагуу хууль зүйн туслалцааны хүрээнээс хасагддаг.

Эрүүгийн хэргийн үл хамаарах хүчин зүйлс

Үндсэн хуулийн зүйл, заалтыг зөрчихүйц шударга бус үр дүн бий болгохоос бусад тохиолдолд дараахь эрүүгийн хэрэг нь хууль зүйн туслалцаанд үл хамаарна. Үүнд: а) Яллагдагч гэм буруугаа хүлээсэн эсхүл түүний гэм бурууг баттай нотлож чадах, б) Гэмт үйлдлээ хүлээн зөвшөөрсөн эсхүл яллагдагчийг тун хялбараар хамгаалах эсхүл ялаас хэлтрүүлэх нь хууль зүйн туслалцаагүйгээр хийгдэж болох тохиолдолд, в) Замын хөдөлгөөний гэмт хэрэг буюу ямар нэг авто машин ашиглаж үйлдсэн гэмт хэрэг, г) Хүсэлт гаргагч нь хувийн яллах ажиллагаа хүссэн, д) Эрүүгийн хэргийн давж заалдах шатны ажиллагаа амжилттай болно гэдэгт Зөвлөлийн захирал итгэлтэй бус байгаа тохиолдолд, е) Зөвлөлийн шийдвэрийн дагуу хэд хэдэн удаа хууль зүйн туслалцаа үзүүлэхээс хасагдсан, ё) Тухайн этгээд нэг төрлийн гэмт үйлдэлд гурав дахь удаагаа эсхүл дараалан яллагдаж байгаа тохиолдолд, ж) Яллагдагч нь гэр бүл салалтын тэтгэлэгийг төлж чадаагүй тохиолдолд.

Иргэний хэргийн үл хамаарах хүчин зүйлс

Дараахь тохиолдолд иргэний хэрэгт хууль зүйн туслалцаа үзүүлдэггүй байна. Үүнд: а) Өрөө барагдуулаагүй хариуцагч талын шүүх ажиллагаанд, б) Нас барагчийн өв хөрөнгийн асуудал болон нас барагчийн өрийг барагдуулахад хөрөнгө нь хүрэлцэхгүй үед үүссэн асуудал, в) Хүний нэр төрийг унагах, амлалтаа зөрчих, хувийн нууцад халдах, зүй бус аргаар эр эмийн харьцаанд уруу татах, итгэл эвдэх, г) Хуулийн туслалцаа шаардлагагүйгээр гэр бүлийн шүүхээр тодорхойлуулж болох тэтгэлэгийн нэхэмжлэл, д) Ямар нэг гэр бүлийн жижиг асуудлуудтай холбоотой нэхэмжлэл, шүүхэд гаргасан нэхэмжлэлийн хэмжээ нь шүүхэд авч хэлэлцэх хэмжээнээс илүү гарахгүй байгаа үед, е) Зөвлөлийн захирлын давж заалдах шатны ажиллагаа амжилттай болно гэдэгт бүрэн итгэлтэй байгаагаас бусад иргэний хэргийн давж заалдах шатны ажиллагаа, ё) Арбитрын буюу шүүхээр гадуур маргаан шийдвэрлэх ажиллагаа, ж) Үйлчлүүлэгчид бодитой ашиг тус өгөхөөргүй хэрэг, з) Зөвлөлийн шийдвэрээр хэд хэдэн удаа хууль зүйн туслалцаанаас хасагдсан хэрэг, и) Хүсэлт гаргагчийн талд гарах шийдвэрийн хэрэгжилт нь хэт бага ашиг

тус өгөхөөр байвал, й) Зөвлөлийн захирлын урьдчилсан зөвшөөрөлгүйгээр насанд хүрээгүй хүүхдийн мөрдөн байцаалтын ажиллагаанд, к) Гэр бүлийн маргаанаас үүссэн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх зорилгоор өргөдөл гаргасан үед тухайн шийдвэрийг хуульчийн туслалцаагүйгээр авч чадаагүй хүн дээд шүүхийн регистрарт хандаж өөр журмаар туслалцаа хүсч болдог. Иргэний хэрэг маргаанд туслалцаа үзүүлэх тохиолдолд тухайн хэрэг нь ашигтай буюу амжилт олох ирээдүйтэй гэдэгт Зөвлөл итгэл үнэмшилтэй байх ёстой. Цаашилбал, хүсэлт гаргагч өөрөө ажилд эргэн орохоос зайлсхийж байгаа, эсвэл зөвхөн хууль зүйн туслалцаа авах зорилгоор ажлаас гарсан зэрэг тохиолдолд хууль зүйн туслалцаа үзүүлэхээс татгалзана.

3. Хүсэлт

Өмнөд Африкт хууль зүйн туслалцааны хүсэлт гаргагч нь Английн шүүхийн тогтолцооны адилаар хувийн өмгөөлөгчид шууд хандах, хүсэлт гаргах боломжгүй бөгөөд уг хүсэлтийг хууль зүйн туслалцааны зөвлөлийн албан хаагч, Зөвлөлийн салбар алба эсвэл зохих Магистратийн шүүхээр хянасны дараа уг хэргийг өмгөөлөгчид шилжүүлдэг. Эхлэж хувийн өмгөөлөгчид хандсан тохиолдолд тухайн өмгөөлөгч нь хүсэлт гаргагчийг орон нутгийн хууль зүйн туслалцааны Зөвлөлийн албан хаагчаас өөрийг нь өмгөөлөгчөөр ажиллахыг зөвшөөрсөн эрх авахуулахаар илгээдэг. Харин хууль зүйн туслалцааны албан хаагч нь хууль зүйн туслалцаа авах шаардлагыг хүсэлт гаргагч хангаж байгаа эсэх, хууль зүйн туслалцааны удирдамжид заасан үл хамаарах хүчин зүйлд хамаарах эсэхийг хянадаг. Хэрэв хүсэлт гаргагч шаардлагыг хангаж байвал, түүнийг өмгөөлөгч, өмгөөллийн товчоо эсвэл Хууль зүйн туслалцааны зөвлөлийн Хуулийн зөвлөгөө өгөх төвд илгээдэг. Саяхнаас Хууль зүйн туслалцааны алба, өмгөөллийн товчоод, хууль зүйн туслалцааны зөвлөлийн хууль зүйн зөвлөгөө өгөх клиникууд нь Хууль зүйн төвүүд буюу “Нэг-зогсолттой хууль зүйн туслалцааны төв”-д нэгдэн үйл ажиллагаагаа явуулж байна.

Татгалзал

Хууль зүйн туслалцаа хүсэгч нь туслалцаа үзүүлэхээс татгалзсан хууль зүйн туслалцааны албан хаагчийн шийдвэрийг Хууль зүйн туслалцааны зөвлөлийн захиралд давж заалдах эрхтэй. Хууль зүйн туслалцааны албан хаагч нь хүсэлт гаргагч нь ийм эрхтэй болохыг түүнд мэдэгдэх үүрэгтэй. Харин хүсэлт гаргагч нь бичгээр давж заалдах ёстой бөгөөд түүнийг хууль зүйн туслалцааны албан хаагч Зөвлөлийн захиралд шилжүүлдэг журамтай. Хүсэлт гаргагч нь хууль зүйн туслалцааг түдгэлзүүлсэн, зогсоосон эсвэл туслалцаа үзүүлэхээс татгалзсан зөвлөлийн захирлын шийдвэрийг Зөвлөлийн даргад давж заалдах эрхтэй.

Хууль зүйн туслалцааны зардал

Хууль зүйн туслалцааны зөвлөл нь байгуулагдсан цагаасаа хойш зөвхөн Парламентаас буюу олон нийтийн хөрөнгөөр санхүүжиж ирсэн Зөвлөлд хуваарилагдах санхүүжилтийн хэмжээ сүүлийн 5 жилийн хугацаанд жил бүр нэмэгдэж ирсэн.

1991-2 онд 35,2 сая
1992-3 онд 56,4 сая
1993-4 онд 62,1 сая
1994-5 онд 66,3 сая
1995-6 онд 182,4 сая
1996-7 онд 156,5 сая
1997-8 онд 301,2 сая
1998-9 онд 260 сая
1999-2000 онд 224 сая
2000-2001 онд 341 сая
2001-2002 онд 246 сая

1994-5 онд 66.3 сая Ранд байсан санхүүжилт дараагийн жилүүдэд даруй дөрөв дахин нэмэгдсэн нь Үндсэн хуульд заасан хууль зүйн туслалцаа үзүүлэх Төрийн үүргийг Хууль зүйн туслалцааны зөвлөл төлөөлөн гүйцэтгэж байгаатай холбоотой юм. Хэдийгээр

санхүүжилт нэмэгдсэн боловч туслалцаа хүссэн хүн болгонд хүрэлцэхүйц хөрөнгө мөнгө байхгүй байна. Түүнээс гадна Үндсэн хуулийн дагуу хүний эрхийн хэргүүдэд хууль зүйн туслалцаа үзүүлэх, өмгөөллийн тогтолцоог өргөжүүлэх, хуульчийн туслалцаа авч чадахгүй байгаа олон сая Өмнөд Африкчуудад зөвлөгөө өгөх төвүүдийг байгуулахад нэмэлт санхүүжилт шаардагдсаар байна. Ядуу хүмүүст хууль зүйн тусламж үзүүлэх ажилд Төрийн санхүүжилтээс гадна хөрөнгийн өөр эх үүсвэр олох хэрэгтэй. Энэ чиглэлээр нэг сард 10-15 Рандын төлбөртэй утсаар зөвлөгөө өгөх үйлчилгээ явуулах боломжийг Зөвлөлөөс санаачлаж байсан. Энэ үйлчилгээ хэрэгжвэл Зөвлөлийн хөрөнгийг жилд 350 сая Ранд хүртэл нэмэгдүүлэх, ингэснээр Парламентыг санхүүгийн их ачааллаас чөлөөлөх, хууль зүйн туслалцаа үзүүлэх хөрөнгийг нэмэгдүүлэх боломжтой. Гэвч ийм аргаар санхүүжихийг хуулиар зөвшөөрөөгүйн улмаас энэ ажил хэрэгжээгүй юм. Храин Хууль зүйн туслалцааны тухай хуулийн дагуу 1994-5 онд амжилттай шийдвэрлэгдсэн хэргийн зардлаас нийт 3,2 сая Рандын санхүүжилтийг Зөвлөл олсон.

Үндсэн хуулийн нөлөөлөл

Хэрэв энэ нь шударга бус үр дүнд хүргэхээргүй бол Үндсэн хуулийн 35 (3) (ж)-д заасны дагуу эрүүгийн хэргийн шүүх ажиллагаанд хуулийн төлөөллийг төрийн зардлаар оролцуулах ёстой бөгөөд энэ нь Хууль зүйн туслалцааны зөвлөлийн үйлчилгээг бий болгодог эрх зүйн гол хүчин зүйл юм. Доод шатны шүүхэд яллагдагч, дунджаар 684 000 хүний 20% нь төрөөс хууль зүйн төлөөлөл авах шаардлагыг хангадаг бөгөөд энэ нь дор хаяж 136 840 яллагдагчид хууль зүйн үйлчилгээ үзүүлнэ гэсэн үг юм. Хэрэв өмгөөлөгч томилох тогтолцоог хэрэглэсэн тохиолдолд зөвлөл хууль зүйн төлөөллийн зардалд 92 сая Рандыг зарцуулах тооцоо гарсан. Учир нь нийт 12 000 орчим хувийн өмгөөлөгчдийн багахан хэсэг нь эрүүгийн хэрэг дээр ажилладаг учраас өмгөөлөгч томилох тогтолцооны дагуу жил бүр 137 000 яллагдагчийг хууль зүйн төлөөллөөр хангах боломжгүй болж улмаар олон нийтийн буюу төрийн өмгөөллийн тогтолцооны асуудал яригдах болох юм. Харин олон нийтийн өмгөөллийн тогтолцоог хэрэглэснээр 67 сая Рандын зардлаар 144 000 яллагдагчийг хууль зүйн төлөөллөөр хангах тооцоо гарсан.

Цаашилбал дээр дурдсаны адилаар, энэ нь шударга бус үр дүнд хүргэхгүй нөхцөлд Үндсэн хуулийн 35(2)(с)-д баривчлагдсан болон түр хоригдсон этгээд нь төрийн зардлаар өмгөөллийн туслалцаа авах, зөвлөлдөх эрхтэй гэж заасан. Өмнөд Африкт ойролцоогоор 1000 орчим цагдаагийн хэлтэс байдаг бөгөөд жилд 1.6 сая хүн цагдан хоригддог. Хэрэв тэдний 50% нь төрийн зардлаар хуульчийн үйлчилгээг авах боломжтой гэж үзэхэд зөвхөн 1 өдөрт дунджаар 2000 гаруй хууль зүйн зөвлөгөө өгөх ажлыг төрөөс зохион байгуулах шаардлагатай болох тооцоо гарсан. Хууль зүйн туслалцааны зөвлөл баривчлагдсан болон цагдан хоригдсон хүмүүст утсаар зөвлөгөө өгдөг 24 цагийн үйлчилгээг нэвтрүүлсэн. Цагдаагийн бүх хэсэг, хорих газруудад утасны дугаарыг бүгдэд харагдахаар дэлгэн үзүүлсэн байдаг бөгөөд албан тушаалтнууд баривчлагдсан болон хоригдсон хүмүүсийг уг утсаар үнэ төлбөргүй саадгүй яриулах ёстой. Тэдгээр хоригдсон хүмүүс өмгөөлөгчтэй утсаар зөвлөлдөх, эсвэл түүний баривчлагдсан эсвэл хоригдсон газар биечлэн ирж зөвлөгөө өгөхийг хүсч болдог. Өмгөөлөгч нь Хууль зүйн туслалцааны зөвлөлийн гишүүнээс утсаар зааварчилгаа авсны дагуу тухайн үйлчлүүлэгчид тусламж үзүүлэхээр хүрэлцэн очдог. Өмгөөлөгчийн ажлын хөлс болон тээврийн зардлыг Төрийн нэрийн өмнөөс Зөвлөл хариуцан төлдөг.

Б. ХУУЛЬ ЗҮЙН ТУСЛАЛЦААНЫ ЗӨВЛӨЛӨӨС ХУУЛЬ ЗҮЙН ТУСЛАЛЦАА ҮЗҮҮЛЭХ ТУХАЙ

Хууль зүйн туслалцааны зөвлөл нь дараах хэлбэрээр хууль зүйн үйлчилгээ үзүүлдэг. Үүнд: а) Төрөөс санхүүждэг хувийн өмгөөлөгч, б) Төрөөс санхүүждэг улсын өмгөөлөгч, в) орон нутгийн хуулийн товчоод дахь төрөөс санхүүждэг хуулийн зөвлөл, г) Төрөөс санхүүждэг хуулийн клиник, д) Төрөөс санхүүждэг хууль зүйн төв, е) Хувийн хуулийн мэргэжсэн товчоодтой байгуулсан хамтын ажиллагааны гэрээ, ё) Бие даасан хуулийн зөвлөгөө өгөх клиниктэй байгуулсан гэрээ, ж) Эрх зүйн зөвлөгөө өгөх албадтай байгуулсан хамтын ажиллагааны гэрээ.

Төрөөс санхүүждэг хувийн өмгөөлөгч

Энэ нь АНУ, Англи, Канад, Австрали, Нидерланд зэрэг улсуудад хууль зүйн үйлчилгээ үзүүлэх арга болж хэрэглэгддэг. Түүнчлэн Африк, Азийн олон оронд хэрэглэгдэж байна. Олон жилийн туршид Хууль зүйн туслалцааны зөвлөл нь өмгөөлөгч томилох үндсэн аргыг хэрэглэж байсан юм. Хууль зүйн туслалцааны зөвлөлийн дүрмийн дагуу хууль зүйн туслалцаа үзүүлдэг хувийн өмгөөлөгчид нь тогтоосон тарифын дагуу зохих ажлын хөлсөө авдаг. Харин шинэ Үндсэн Хууль батлагдсанаар Зөвлөлөөс уг аргыг хэрэглэх боломжгүй болсон юм. Ажиллах хэргийн болон өмгөөлөгчдийн дансны тоо нэмэгдсэн нь Зөвлөлөөс хууль зүйн туслалцаа үзүүлэх ажлыг зохицуулах боломжгүй болж дампуурахад хүрсэн юм. 1970-1998 он хүртэл 28 жилийн хугацаанд 997 707 хэргийг хуулийн зөвлөхүүдэд шилжүүлсэн бөгөөд эдгээр хэргийн ихэнх нь эрүүгийн хэргүүд байв. Тэдгээрийн 559 238 нь 1994-5 оноос хойш шинэ Үндсэн хуулийн дагуу эрх олгогдсон. Энэ нь 1998 он хүртэл сүүлийн дөрвөн жилд хууль зүйн туслалцааны эрх олгогдсон хүсэлт нь Зөвлөлөөс үйлчилгээ үзүүлсэн нийт хэргийн 56%-ийг эзэлж байна гэсэн үг юм. Шийдвэрлэх ёстой эрүүгийн хэргийн тооны өсөлт нь Зөвлөлийн үйлчилгээний үндсэн арга болох өмгөөлөгч томилох тогтолцоог орхихоос өөр аргагүйд хүргэсэн. 1997-8 онд хувийн өмгөөлөгчид нь 105 732 хэрэг /80% нь эрүүгийн хэрэг/ дээр ажилласны төлөө хөлс авсан. Зөвлөлийн тооцоолсоноор тухайн үед энгийн эрүүгийн хэрэгт дунджаар 864 Ранд, Үндсэн хуулийн эрүүгийн хэрэгт 1707 Ранд, иргэний хэрэгт 1498 Рандын зардал гаргаж байсан байна. Бусад улсын нэгэн адилаар өмгөөлөгч томилох ажиллуулах тогтолцоо нь цалинтай хуульчийн тогтолцоог бодвол харьцангуй зардал өндөртэй болох нь Өмнөд Африкийн туршлагаас харагдсан юм. 1990 онд улам өсөн нэмэгдэж буй иргэн, эрүүгийн хэргийг шийдвэрлэх зорилгоор улсын өмгөөлөгчийн хөтөлбөрийг эхлүүлсэн. 1994 онд Хууль зүйн туслалцааны зөвлөлийн Хууль зүйн зөвлөгөө өгөх төвүүд байгуулагдсан. 1995 оны үед өмгөөлөгч томилох буюу хувийн өмгөөлөгчдөд эрүүгийн хэрэг өгч ажиллуулахад 822 Рандын зардалтай байсан бол улсын өмгөөлөгчийн ажилласан эрүүгийн хэргийн зардал 555 Ранд байв. Харин хууль зүйн зөвлөгөө өгөх клиникийн зардал үүнээс ч бага байсан. Хууль зүйн туслалцааны зөвлөл нь өмгөөлөгч томилох ажиллуулах тогтолцооны зардлыг багасгах зорилгоор хэрэг-тус бүрт-тогтоосон-хөлсний гэрээний хэлбэрийг хэрэглэх боломжийг судлаж байна. Хөлсний хязгаар тогтоох арга нь төдийлэн сайн арга биш болох нь нотлогдсон бөгөөд зарим өмгөөлөгчид Хууль зүйн туслалцааны зөвлөлөөс хэрэг хүлээн авахаас татгалзах тохиолдол гарч байсан. Зарим хуулийн товчоод тендэр зарлахыг боломжийн арга гэж үздэг бөгөөд ийнхүү тендэрт оролцсоноор Зөвлөлөөс хөлслөн ажиллуулдаг хуульчдаас илүү хямд үнээр хэрэг дээр ажиллах боломжтой. Хэдий тийм боловч Зөвлөл хувийн өмгөөлөгч томилох ажиллуулах хэлбэрээс илүү цалинтай өмгөөлөгчийн хэлбэрийг хэрэглэхээр шийдвэрлэсэн.

Туршлага

Өмнөд Африкийн туршлагаас харахад хувийн өмгөөлөгч томилох тогтолцоо нь түүнийг сайтар дэмжихүйц захиргааны бүтэц, албан хаагчид, ажлын хөлсийг түгээх сүлжээ зэрэг холбогдох нөхцөл бүрдсэн үед амжилттай хэрэгжих нь тодорхой харагдсан. Компьютерийн шинэ сүлжээг үл харгалзан өдөр тутам шинээр нээгддэг данс тооцоо нь Хууль зүйн туслалцааны зөвлөлийн төв байран дахь албан хаагчийн боловсруулж чадах хэмжээнээс хэтэрсэн. Энэ нь үйлчилгээ үзүүлсэний төлбөр хийгдэлгүй олон жилээр хойшлох, хуульч, өмгөөлөгчид итгэл алдан цаашид эрх зүйн туслалцааны хэрэг авахгүй байхад хүргэх, зарим үед хөлсөө авах талаар шүүхэд нэхэмжлэхэд хүргэдэг. Зөвлөлөөс эрүүгийн хэргийн үйлчилгээнд хөлсний хязгаар тогтоосон нь сөргөөр нөлөөлж өмгөөлөгчдыг эрүүгийн хэргээс зайлсхийхэд хүргэсэн. Зөвлөл цалинтай өмгөөлөгч бүхий Хууль зүйн төвийн загварыг хэрэгжүүлэхээр шийдвэрлээд байгаа бөгөөд өмгөөлөгч томилох хэлбэрийг орлох байдлаар хэрэглэх юм. Өмгөөлөгч томилох арга нь төсвийн хязгаарлалттай орчин нөхцөлд тохиромжгүй бөгөөд зарлагын урьдчилсан төлөвлөлт шаардлагатайг харуулдаг. Энэ арга нь хууль зүйн туслалцаа үзүүлэх бүхэл тогтолцооны нэг хэсгийн хувьд зайлшгүй хэрэглэгдэх бөгөөд гэрээний үндсэн дээр хийгдэж байх шаардлагатай юм.

Төрөөс санхүүжих улсын өмгөөлөгч

1990 онд Хууль зүйн туслалцааны зөвлөлөөс хуульч, өмгөөлөгчдийн холбоодтой зөвшилцсэны дагуу Өмнөд Африкийн Бүгд Найрамдах Улсад тохиромжтой өмгөөллийн тогтолцоог судлах, үүнд зориулж 2,5 сая Рандын хөрөнгө оруулахыг Хууль зүйн сайдаас хүссэн юм. Үүний дагуу ядуу буурай хүмүүсийг төлөөлөх хууль зүйн дагуу шаардлага хангасан хүнийг олж ажиллуулах боломжийг Зөвлөлд олгосон юм. Йоханнэсбург хот дахь ийм төсөл нь 2 жилийн хугацаатай хэрэгжих, мөн өмгөөлөгч бүр жилд 200 эрүүгийн хэрэг дээр ажиллахаар тооцоолж байсан. 1992 оны 11 дүгээр сар гэхэд Йоханнэсбургт 10 өмгөөлөгч 2200 эрүүгийн хэрэг дээр ажилласан буюу түүнээс гэм буруугүйг нотлох хэргийн 57%, барьцаагаар суллагдах хүсэлтийн 90% нь биелсэн амжилттай байсан. Уг төслийн алба 1993-4 онд 2808 яллагдагчид, 1995-6 онд 3794 яллагдагчид өмгөөллийн үйлчилгээ үзүүлсэн байна. Зөвлөлөөс Төслийг амжилттай хэрэгжсэн гэж үзсэн. Өнөөдөр улсын өмгөөлөгч нар бүсийн 40 магистратийн шүүхэд үйл ажиллагаагаа явуулж, сард 20 хэрэг дээр ажиллаж байна. 2001 оны тооцоогоор тэдгээр улсын өмгөөлөгчид жилд доод тал нь 8800 эрүүгийн хэрэгт өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх боломжтой нь харагдсан.

Туршлага

Төрийн өмгөөллийн тогтолцоо нь өмгөөлөгч томилох тогтолцоог бодвол харьцангуй хямд бөгөөд төсвийн хувьд хязгаарлагдмал, өмгөөлөгч томилох тогтолцоог хэрэглэж байгаа улс орнууд төрийн өмгөөллийн тогтолцооны ашиг талыг авч хэрэгжүүлэх, ялангуяа эрүүгийн хэргийн ажиллагаанд хэрэглэх нь зүйтэй. Өмнөд Африк болон бусад хөгжиж буй орнуудад бүрэн туршлагажсан улсын өмгөөлөгчдийн сүлжээ нь хэдий өндөр өртөгтэй боловч төрийн санхүүжилт бүхий хууль зүйн клиник зэрэг бусад хэлбэрийг эрэлхийлэх нь зүйтэй юм.

Орон нутгийн хуулийн товчоод дахь Төрийн санхүүжилт бүхий өмгөөлөгч

1995 онд Хууль зүйн туслалцааны зөвлөл нь хөдөөгийн хот, сууринд төрийн санхүүжилтээр хууль зүйн туслалцааны ажил эрхлэх хуулийн зөвлөх ажиллуулах талаар “Хүний эрхийн төлөөх хуульчид” гэдэг төрийн бус байгууллагатай тохиролцоонд хүрсэн. Хууль зүйн товчоод нь орон нутгийн хууль зүйн тойргийн хуваарийн дагуу зохион байгуулагдах бөгөөд Зөвлөлөөс тухайн хууль зүйн туслалцаа үзүүлэх өмгөөлөгчтэй түүнийг цалинжуулан ажиллуулах талаар тохиролцдог. “Хүний эрхийн төлөөх хуульчид” байгууллага нь тохиромжтой өмгөөлөгчдыг санал болгох, төслийн явцад хяналт тавих чиглэлээр туслаж ажилласан. Төсөл хөдөө орон нутагт хууль зүйн үйлчилгээг өргөжүүлсэнээс гадна тухайн орон нутагт байгаа боловсон хүчнийг хууль зүйн мэргэжлээрээ ажиллах боломжийг олгосон юм. Хуулийн зөвлөх нь Зөвлөлийн нэрийн өмнөөс сар тутам дор хаяж 10 хууль зүйн үйлчилгээ үзүүлэх хэрэг дээр үнэ төлбөргүй ажиллах ёстой бөгөөд долоо хоногт нэг удаа олон нийтийн эрх зүйн үйлчилгээ үзүүлэх ёстой байдаг. 1996-7 оны эцэс гэхэд 8 хуулийн зөвлөх хамрагдсан 2 төсөл үйл ажиллагаа явуулж байсан. Тэд ихэвчлэн эрүүгийн хэрэг дээр зарим үед гэр бүл салалтийн хэрэг дээр ч зөвлөгөө өгч байсан. Жишээлбэл: Хөдөөгийн 4 хуулийн товчоо нь 1997 оны 3 сарын 1-нээс 1998 оны 2 сарын 28-ны хугацаанд 400 эрүүгийн, 73 иргэний хэрэг дээр ажилласан байна.

Туршлага

Энэ хэлбэр нь зардал хэмнэдэг давуу талтай бөгөөд илүү олон хэрэг хамруулах зорилгоор өргөжүүлэх боломжтой. Энэ тогтолцоог оюутнуудыг хуульч мэргэжлээр ажиллахын өмнө мэргэжлээрээ ажиллаж тодорхой дадлага хийсэн байхыг шаарддаг улс орнуудад, ялангуяа хөдөө орон нутагт хүн ам ихтэй, орон нутгийн жижиг хот сууринд хуулийн товчоодтой улсад хэрэглэгдэх боломжтой. Орон нутгийн хуулийн товчоодод хуулийн зөвлөх цалинжуулан ажиллуулах нь шүүхээс гадуур маргаан шийдвэрлэх арга хэрэглэдэг учраас хууль зүйн туслалцаа авах хүсэлт бага байдаг тэдгээр орон нутагт Зөвлөлийн салбар товчоодыг байгуулан ажиллуулахаас харьцангуй хямд юм.

Төрөөс санхүүждэг хууль зүйн клиник

1993 онд Өмнөд Африкийн Өмгөөллийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт орж, зохих хууль зүйн шаардлагыг хангасан хуулийн зөвлөх нь практик туршлага эзэмших зорилгоор тодорхой хугацаанд олон нийтийн үйлчилгээ үзүүлэхийг зөвшөөрсөн юм. Олон нийтийн үйлчилгээг мужийн холбогдох хуулийн байгууллагаас магадлан итгэмжлэл авсан хууль зүйн клиник үзүүлж болдог. Олон нийтийн үйлчилгээний хөтөлбөрт хамрагдаж байгаа сургууль төгсөгчдын ажилд мэргэжлийн хяналт тавьж байх хангалттай дадлага туршлага бүхий өмгөөлөгч ажиллуулахыг Хууль зүйн клиникээс шаарддаг. Нэг хяналт тавих өмгөөлөгчид арван дадлагажигч өмгөөлөгч ноогдох байдлаар өмгөөлөгч, дадлагажигч өмгөөлөгчийг ажиллуулдаг. Энэ тогтолцооны зорилго нь а) Хууль зүйн туслалцаа авах шаардлага хангасан хүнд туслалцаа үзүүлэх, б) Сургууль төгсөгчид болон залуу өмгөөлөгчдөд олон нийтийн үйлчилгээний гэрээ болон өмгөөллийн тухай хуулийн дагуу дадлагажигч бололцоог гаргаж өгөх явдал юм. 1996-1997 оны хооронд 150 дадлагажигч өмгөөлөгч өмгөөлөл хийх эрх авсан бөгөөд тэдний 49% нь эмэгтэйчүүд, 60% нь нийгмийн доод хэсгийн хүмүүсээс гаралтай байсан. Зөвлөл 5 их сургууль дээр хууль зүйн клиникийн төсөл хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд өнгөрсөн хугацаанд 20 сургууль дээр клиник ажиллуулж, сургууль тус бүрт 430 000 Рандын хөрөнгө оруулаад байна. Сүүлийн үед зарим клиникэд 8 дадлагажигч, 2 мэргэжлийн өмгөөлөгч ажиллуулах болсон бөгөөд ингэснээр мэргэжлийн өмгөөлөгч нар мужийн магистратийн шүүхэд шүүх ажиллагаанд оролцох боломжтой болж байна. Харин дадлагажигч өмгөөлөгчид нь доод шатны шүүх ажиллагаанд оролцдог бөгөөд 1994 оны 7 сарын 1-нээс 1996 оны 12 сарын 31-ны хугацаанд хууль зүйн клиникүүдээс авч ажилласан 24513 эрүүгийн, 12997 иргэний хэргийн дундаж зардал 433 Ранд байсан. Энэ нь өмгөөлөгч томилон ажиллуулах тогтолцооны зардал буюу 976 Рандаас даруй нэг дахин бага юм. Тэр ч байтугай энэ нь төрийн өмгөөллийн тогтолцооноос хямд байгаа юм. 1997-1998 оны хугацаанд хууль зүйн клиникүүд нийт 33 951 хэрэг дээр ажилласнаас 20 042 нь эрүүгийн, 13 909 нь иргэний хэрэг байсан. Өнөөдрийн байдлаар төрийн санхүүжилттэй хууль зүйн клиникүүд нь шинээр байгуулагдсан хууль зүйн төвүүдэд нэгдсэн. Хууль зүйн төвүүд дэх хууль зүйн клиникүүдэд 10 дадлагажигч өмгөөлөгчид 1 зөвлөх өмгөөлөгч гэсэн харьцаатай ажиллаж байна. 2001 оны тооцоогоор 1 дадлагажигч өмгөөлөгч нь нэг сарын хугацаанд магистратийн шүүх дэх 30 хэрэг дээр ажилласан тооцоо гарсан. Үүнээс харахад 31 хууль зүйн төв дэх 310 дадлагажигч өмгөөлөгч нь 103 000 хэрэг дээр ажиллах боломжтой гэсэн үг юм.

Туршлага

Олон нийтийн үйлчилгээний хөтөлбөрүүд нь нийгмийн гишүүдэд боломжийн үнээр хууль зүйн үйлчилгээг үзүүлж, өсөж байгаа хуульч өмгөөлөгчдөд дадлагажих, мэргэжих таатай боломжийг бүрдүүлдэг. Энэ хэлбэр нь мэргэжлийн хуульчаар ажиллахаас өмнө шинэ хуульчдыг мэргэжлээрээ ажилласан байхыг шаарддаг улс орнуудад мөн ийм шаардлага тавьдаггүй улс орнуудад ч тохиромжтой. Өмнөд Африкийн туршлагаас үзэхэд Хууль зүйн туслалцааны зөвлөлийн хууль зүйн клиникийн дадлагажигч өмгөөлөгч нар нь эрүүгийн болон ядуурлын хэргүүд дээр тусгайлан ажилладаг тул тэдний доод шатны шүүхэд ажилласан хэргийн чанар нь мэргэжлийн өмгөөлөгчид болон хувийн нэр дэвшигч өмгөөлөгчдөөс хавьгүй илүү байдаг.

Төрөөс санхүүжих хууль зүйн туслалцааны төвүүд

Өмнөд Африкийн Хууль зүйн туслалцааны зөвлөл нь үйлчлүүлэгчдэд нэг дор бүрэн үйлчилгээгээр хангах хууль зүйн туслалцааны төвүүдийг байгуулж эхлээд байна. Эдгээр төвүүд нь хууль зүйн туслалцаа үзүүлэх чиг үүрэг бүхий хууль зүйн туслалцааны ажилтан, улсын өмгөөлөгч, хууль зүйн клиникийн ажилтан, хуулийн туслах ажилтан, захиргааны ажилтнуудыг өөртөө нэгтгэж байгаа юм. Хууль зүйн туслалцааны ажилтан нь тухайн хэрэг дээр ажиллах боломжгүй тохиолдолд хэргийг хувийн хуулийн зөвлөхөд шилжүүлдэг. Дадлагажигч өмгөөлөгч болон тэдний зөвлөх өмгөөлөгчид нь дүүргийн шүүх болон дээд шүүх дэх эрүүгийн хэргүүд дээр ажилладаг. Хууль зүйн туслах ажилтнууд нь анхан шатанд үйлчлүүлэгчидтэй харьцах, бусад бэлтгэл ажлыг гүйцэтгэх байдлаар өмгөөлөгчдын ажилд тусладаг. Эдгээр төвүүд нь ядуу буурай үйлчлүүлэгчдэд хууль зүйн болон бусад нийгмийн үйлчилгээг үзүүлэхэд зориулагдсан. Нэг дор бүрэн үйлчилгээ

үзүүлэх энэ арга нь томоохон хот сууринд амжилттай хэрэгжиж байгаа боловч түүний үйл ажиллагааны зардлыг төлж чадахуйц хэмжээний ажил байхгүй хөдөө орон нутагт хэрэгжилт тийм сайнгүй байна. Ийм нөхцөлд Хууль зүйн туслалцааны зөвлөлөөс бие даасан хууль зүйн клиник, хуулийн товчоо, хууль зүйн болон нийгмийн үйлчилгээний товчоодтой хамтын ажиллагааны гэрээ байгуулан ажиллах нь илүү тохиромжтой юм. 2001 оны 1 сараас 4 сарын хооронд 8 хууль зүйн төв байгуулагдсан бөгөөд 2004 он хүртэл хугацаанд 60 тийм төвийг байгуулахаар төлөвлөөд байна. 2001 оны эцэс үеийн тооцооноос харахад 31 хууль зүйн төв нь жилд 115 900 эрүүгийн хэрэгт өмгөөлөлийн ажил хийсэн байдаг.

Туршлага

Хууль зүйн төвүүд нь ядуу буурай иргэдэд нэн шаардлагатай хууль зүйн бүхий л үйлчилгээг нэг дор үзүүлдэг. Үйлчлүүлэгчид нь хууль зүйн зөвлөгөө, дүүргийн болон мужийн магистратийн шүүх, дээд шүүхэд төлөөлүүлэх зэрэг олон төрлийн үйлчилгээг хүлээн авдаг. Хууль зүйн төвийн үнэ өртөг нь бусад өмгөөллийн хэлбэрийг бодвол харьцангуй хямд юм.

Хувийн тусгай мэргэшлийн хуулийн товчоодтой хийсэн хамтын ажиллагааны гэрээ

Тусгай мэргэжлийн хуулийн товчоод нь ядуу буурай хүмүүст иргэний эрх зүйн чиглэлээр туслалцаа үзүүлэх ажилд томоохон үүрэгтэй байдаг. Энэ хуулийн товчооний хэлбэр нь АНУ-аас гаралтай бөгөөд сүүлийн үед Ази, Африк, Зүүн европын хөгжиж буй орнуудад нэвтэрч байна. Тусгай чиглэлийн хувийн хуулийн товчооны нэг жишээ бол Хууль зүйн нөөцийн төв юм.

Хууль зүйн нөөцийн төв

Анхны Хууль зүйн нөөцийн төв нь 1979 онд Йоханнэсбургт байгуулагдсан бөгөөд одоо Кэйп Таун, Порт элизабет, Дурбан, Преториа зэрэг 6 хотод ийм төв байрлаж байна. Хууль зүйн нөөцийн төв нь ялангуяа иргэний хэрэгт мэргэжлийн туслалцаа хүссэн хүмүүст практикийн зөвлөгөө өгдөг. Ашгийн бус анхны ийм төв байгуулагдсанаас хойш 23 жилийн хугацаанд олон сая ядуучууд болон ядуу буурай нийгмийн хэсэг бүлэгт хууль зүйн туслалцаа үзүүлсэн. Хууль зүйн нөөцийн төвийн дүрэмд: Энэ байгууллага нь Өмнөд Африкт арьс өнгө, нийгмийн анги, гарал, нас хүйс, бие, сэтгэл зүйн дутмаг байдал, нийгэм, эдийн засгийн болон түүхийн учир шалтгааны улмаас гадуурхагдсан ядуу, гэр оронгүй, өөрийн газар, хөрөнгөгүй хүн болон тийм нийгмийн хэсэг бүлэгт хууль зүйн туслалцаа үзүүлэх замаар эрх тэгш зарчимд үндэслэсэн ардчилсан нийгмийг хөгжүүлэхийн төлөө ажиллана” гэж заасан байдаг. 1994 оны сонгуулиас өмнө энэ төв нь олон мянган ядуу буурай хүмүүсийн эрхийг хамгаалахаар маргаан үүсгэх, ийнхүү үүсгэхээр сүрдүүлэх аргыг хэрэглэж байв. Хууль зүйн нөөцийн төв нь пост-апартейд дэглэмийн дараа өөрийн байр суурийг дахин хянаж үзсэний дагуу өнөөдөр 2 хөтөлбөр дээр төвлөрөн ажиллаж байна. Эдгээр нь Үндсэн хуулийн эрхийн хөтөлбөр ба Газар, орон байр ба хөгжлийн хөтөлбөр юм. Үндсэн хуулийн эрхийн хөтөлбөр нь шударга шүүхэд хандах боломж, хүйсийн тэгш байдал, хүүхдийн эрх болон эрүүл мэнд боловсрол, орон байр, ундны ус болон үндсэн хуулийн шинэчлэлийн асуудлыг хамардаг. Газар, орон байр ба хөгжлийн хөтөлбөр нь хот, хөдөөгийн газрын буцаан олголт, дахин хуваарилалт, газар эзэмших эрхийн аюулгүй байдал, орон байр, газрын эрх зүйн шинэтгэл, хот хөдөөгийн газрын хөгжлийн асуудлыг хамаардаг. Хуульч, өмгөөлөгчид болон хууль зүйн туслах ажилтнуудыг сургах явдал нь тус төвийн нэг чухал хөтөлбөр юм. Мөн хар арьстануудад зориулсан эрх зүйн тэтгэлэгт сургалт хэрэгжүүлдэг бөгөөд жилд 12-15 ийм оюутныг ажлын байраар хангадаг. Хууль зүйн нөөцийн төв нь төлбөр хураамж болон төрийн санхүүжилт авдаггүй. Харин гадаадын болон дотоодын хандивлагчдын дэмжлэгээр ажилладаг Хууль зүйн нөөцийн траст гэдэг байгууллагаас санхүүждэг. Хууль зүйн нөөцийн төв нь их дээд сургуулиудын хууль зүйн туслалцааны байгууллагуудын холбоотой хамтран ядуу буурай хэсэгт үзүүлэх үйлчилгээг өргөжүүлэх зорилгоор Хууль зүйн туслалцааны зөвлөлөөс бие даасан санхүүжилт бүхий өмгөөллийн байгууллагуудтай хамтын ажиллагааны гэрээ хэлцэл байгуулан ажиллахад нь дэмжлэг үзүүлэн байна.

Туршлага

Хууль зүйн нөөцийн төв нь нийгэм дэх гадуурхагдсан ядуу буурай хэсэгт иргэний чиглэлээр хамгийн амжилттай туслалцаа үзүүлж байгаа тусгай мэргэжлийн хуулийн байгууллага юм. Түүний амжилт нь чадварлаг хуульчид болон Хууль зүйн нөөцийн траст байгууллагаас үзүүлдэг санхүүгийн дэмжлэг юм. Өмнөд Африкт тогтсон ардчилсан дэглэмийн ачаар гадаадын хандив, туслалцаа ихээр нэмэгдэж байгаа нөхцөлд, нийгэм дэх ядуу буурайчуудын томоохон хэсэгт шударга шүүх тогтолцооны бодит жишээг харуулж чадсанаараа тус төв нь илүү нөлөөтэй болж байна.

Бие даасан хуулийн клиникүүдтэй байгуулсан хамтын ажиллагааны гэрээ

1973 онд Фордын сангаас Өмнөд Африкт хууль зүйн туслалцааны асуудлаар бага хурал зохион байгуулсан нь хуулийн клиникийн хөдөлгөөнийг эхлүүлэх үндэс болсон. Тухайн үед ердөө 2 клиник ажиллаж байсан бол 2 жилийн дараа 5 клиник шинээр ажиллаж эхэлсэн. Өмнөд Африкийн 21 их сургуулийн дийлэнх нь өөрийн дэргэд хууль зүйн клиник ажиллуулдаг бөгөөд практикийн хуульч, өмгөөлөгчдийг захирлаар авч ажиллуулдаг. Клиникийн Захирал нь өмгөөлөгч байгаа тохиолдолд уг клиник орон нутгийн хуулийн нийгэмлэгээс магадлан итгэмжлэл авах бөгөөд ийнхүү зөвшөөрөл авсны дараа оюутнууд болон дадлагажигч өмгөөлөгчид тэнд суралцах, ажиллах боломжтой болдог. Клиник санхүүжилтээ гадны хандивлагчдаас авдаг. Мөн клиникийг удирдах хуульчдыг хөлслөн ажиллуулах зардлыг Өмгөөлөгчдын итгэлийн сангаас магадлан итгэмжлэгдсэн клиникүүдэд олгодог.

Бие даасан хууль зүйн клиникүүд нь Хууль зүйн туслалцааны зөвлөлийн шаардлагыг бодвол харьцангуй хөнгөн хууль зүйн туслалцааны шаардлагыг хэрэглэдэг бөгөөд ийм шаардлагыг хангасан хүмүүст хууль зүйн үйлчилгээг үнэ төлбөргүй үзүүлдэг. 1985 онд боловсруулан гаргасан оюутны дадлагажих дүрмийн дагуу клиникт дадлагажиж байгаа төгсөх курсийн оюутан нь төлбөрийн чадваргүй хүнийг дүүргийн шүүхэд төлөөлөх боломжтой. Пост-апартэйд Засгийн газар ийм хууль тогтоомжийг гаргах талаар амлаж байсан боловч хэрэгжээгүй байна. Өмнөд Африкийн хуулийн сургуулиас жилд дунджаар 3000 оюутан төгсдөг. Хэрэв төгсөх курсийн оюутан бүр өвлийн болон зуны амралтын үеэрээ жилд 10 хэрэг дээр ажиллана гэж тооцоход энэ нь нийт 30 000 эрүүгийн хэргийг хууль зүйн өмгөөллөөр хангаж чадна гэсэн үг. Энэ нь хууль зүйн туслалцааны зөвлөлийг эрүүгийн хэргийн ачааллаас чөлөөлж, иргэний хэрэгт илүү цаг хүч зарцуулах боломжийг олгох юм. Клиникийн хувьд санхүүжилт ярвигтай асуудал бөгөөд дадлагажигч нарыг сургах, чанартай өмгөөллийн үйлчилгээг үзүүлэх асуудал нь түүнд хязгаарлах хүчин зүйл болдог. Зарим их сургуулийн клиникүүд Хууль зүйн туслалцааны зөвлөлтэй хамтын ажиллагааны гэрээ байгуулсан нь тэднийг өөрийн үйлчилгээг үзүүлсэний дагуу Зөвлөлөөс нөхөн төлбөр авах боломжтой болгож байна. Зөвлөл энэ зорилгоор 10 сая Рандын хөрөнгийг хуваарилдаг. Харин ийм хамтын ажиллагааны гэрээ хэлцэлд орохын тулд тухайн байгууллага нь олон нийтийн эрх зүй болон идэвхитэй нийгмийн үйлчилгээний тодорхой дадлага туршлагатайгаа харуулах шаардлагатай байдаг. Хамтын ажиллагааны тохиролцоог Хууль зүйн туслалцааны зөвлөлөөс үйл ажиллагаа явуулдаггүй орон нутагт дэд бүтэц бүхий хууль зүйн туслалцаа үзүүлэгч байгууллагатай эсвэл Зөвлөлөөс тодорхойлсон тэргүүлэх чиглэлээр эрх зүйн туслалцаа үзүүлэх мэргэжсэн байгууллагатай байгуулдаг. Өмнөд Африк дахь хууль зүйн туслалцааны асуудалд оюутнууд багагүй хувь нэмэр оруулж чадна гэж 20 гаруй жилийн өмнө үзэж байсан бөгөөд өнөөдөр ч үзэл бодол хэвээр байна. Оюутнууд нь хөдөлмөрлөх хямд хүч бөгөөд зохих хяналтыг стандартын хэмжээнд хүртэл хэрэгжүүлсэн үед оюутнууд залуу хуульчийн хэмжээнд ажиллах чадвартай. Сайн хяналтын дор ажиллуулсан оюутнууд нь ядуу буурайчуудад үзүүлэх хууль зүйн үйлчилгээг илүү хүртээмжтэй болгох бөгөөд энэ хэлбэрийг ядуучуудад үзүүлэх хууль зүйн туслалцаа алс ирээдүйд сайн, чанартай болох хүртэл оюутны хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх нь үр ашигтай юм.

Туршлага

Ардчилсан эрх зүйн тогтолцоо болон хууль зүйн туслалцаа үзүүлэхэд төрөөс гарах илүү зардал нь бие даасан хуулийн клиникүүдын үйлчилгээний ачааллыг хөнгөлж өгөх ёстой. Гэвч бодит байдал дээр энэ нь эсрэгээр байгаагийн учир нь Хууль зүйн туслалцааны

зөвлөлөөс иргэний хэрэгт зарцуулах зардлыг багасгаж төрөөс нийгэм, эдийн засгийн эрхийг гартаа авах боломжийг нэмэгдүүлсэн явдал юм. Хуулийн клиникүүд нь хууль зүйн туслалцаа үзүүлэх зөвлөлийн заримтай нь хамтран ажиллах хэлбэрээр байгуулсан байна.

8. Хуульч бус хуульчдын зөвлөгөө өгөх албатай байгуулсан хамтын ажиллагааны гэрээ

Хуульч бус хуульчдын зөвлөгөө өгөх алба нь хөгжингүй болон хөгжиж буй олон улс оронд байдаг. Зарим хэргүүдэд хуульч бус хуульчид төлбөртэй ажилладаг байхад заримд нь сайн дурихан байна. Зарим нь хуульчидтай нягт ажилладаг байхад зарим нь бие даан ажиллана. Ихэнхи хэрэгт энгийн ажилтнууд нь үйлчилгээ үзүүлж буй нийгэмлэгтэй шууд нүүр тулж ажилладаг.

Өмнөд Африкийн Бүгд Найрамдах Улсад хэд хэдэн байгууллагууд хуульч бус хуульчдын зөвлөгөө өгөх үйл ажиллагаанд хамрагддаг. Тэдгээр байгууллагууд олон нийтэд хуулиар олгогдсон холбогдох эрхийг нь тайлбарлан таниулах, хуульч бус хуульчдад зөвлөгөө хэрхэн өгөх талаар сургалт явуулах замаар хууль зүйн туслалцаа үзүүлдэг байна. Зарим байгууллага /жишээлбэл: Нийгэмшлийн эрх зүй болон орон нутгийг хөгжүүлэх төв /НЭЗБОНХТ/, Хүний эрхийн төлөөх хуульчид /ХЭТХ/, Стелленбош/-ын үйл ажиллагаа орон нутагт чиглэгдсэн байхад, зарим нь /жишээлбэл: Блэк Саш/ хот, суурийн газарт төвлөрдөг байна. Үйлчилгээг хүн ам ихтэй дүүргүүдийн албад дээр өгдөг энгийн зөвлөгөөнөөс эхлээд Йоханесбург дэх Хууль зүйн туслалцааны зөвлөлийн нэгэн адилаар байнгын хууль зүйн зөвлөгөө өгч үйлчилгээг хэдэн шатаар үзүүлдэг байна.

Өмнөд Африкийн зөвлөгөө өгдөг албадын ажилтнууд ерөнхийдөө цалинтай ажилладаг боловч ихэвчлэн цалингийн хэмжээ бага бөгөөд зарим хэрэгт бүр цалингүй ажилладаг. Хуульч бус хуульчдын сургалт нь ХЭТХ болон Дурбан дахь НЭЗБОНХТ-ийн дипломын курс бүхий албан сургалтаас гол төлөв “ажлын байран дээрхи” практик, туршлагаас заадгаараа ялгаатай юм. Илүү чанартай зөвлөгөө өгдөг албадын зарим нь Хууль зүйн нөөцийн төв, ХЭТХ, НЭЗБОНХТ гэх мэтийн байгууллагуудтай нэгддэг байхад зарим нь хувийн дадлага, туршлагатай хууль зүйн дадлагажигчдад үзүүлдэг үнэгүй үйлчилгээнд тулгуурладаг байна. Зөвлөгөө өгдөг албадын өгч буй зөвлөгөө нь ихэнх тохиолдолд асуудлыг шийдвэрлэж чаддаг байна. Тэдгээрийн ихэнх нь тэтгэвэр, ажилгүйдлын даатгал, шударга бус ажлаас халалт гэх зэрэг асуудлаар мэргэжилтнүүдийг нэмж авсан байна. Зөвлөгөө өгдөг албадууд асуудлыг шийдвэрлэж чадахгүйд хүрвэл холбогдох тал асуудлыг Хууль зүйн туслалцааны зөвлөлд, эсхүл өөрийн сонгосон хуулийн товчоонд шилжүүлдэг юм. Түүнээс гадна хууль зүйн туслах ажилтнууд зөвлөлийн хууль зүйн шинэ төв болон хамтын ажиллагааны гэрээнд оролцож байдаг. Үндэсний Хууль зүйн хүрээлэн нь 350 гаруй хуульч бус хуульчдад зөвлөгөө өгөх албаныг сургалтад хамруулах, санхүүг нь нэмэгдүүлэх талаар туслалцаа үзүүлж байх зорилгоор байгуулагдсан бөгөөд мөн тэд нарт итгэмжлэлийн гэрчилгээ олгох үйл явцад шалгалт хийдэг байна. Уг байгууллага Их сургуулийн хууль зүйн туслалцаа үзүүлэх хүрээлэнгийн холбоотой нягт хамтран ажилладаг юм.

Хуульч бус хуульчдын зөвлөгөө өгөх алба нь орон нутагт илүү тохиромжтой байдаг. Саяхнаас зарим хуульч бус хуульчдын байгууллагууд Хууль зүйн туслалцааны зөвлөлтэй хамтын ажиллагааны гэрээ байгуулж эхэлсэн байна. Орон нутаг дахь хуульч бус хуульчдын зөвлөгөө өгөх албаны үр дүнтэй хөтөлбөрүүдийн нэг жишээ бол Ква Зулу-Натал дахь Нийгэмшлийн эрх зүй болон орон нутгийн хөгжлийн төв юм.

Нийгэмшлийн эрх зүй болон орон нутгийн хөгжлийн төв

Дурбан дахь НЭЗБОНХТ нь 1989 онд байгуулагдсан бөгөөд өдгөө Ква Зулу-Натан болон зүүн Капе орчимын тосгонуудад амьдарч буй 1 сая гаруй Өмнөд Африкчуудад үйлчилгээ үзүүлж байна. НЭЗБОНХТ нь а/хувийн хариуцлага, ур чадвар, өөртөө итгэх итгэл, найдварыг нэмэгдүүлэх замаар Өмнөд Африкийн өөрчлөлтөд оролцуулах, б/ орон нутгийн иргэдэд ардчилал, сонгууль болон иргэний нийгмийн талаар сургалт явуулах, в/хуулийн заалтуудын үйлчлэлийг Өмнөд Африкийн орон нутагт бэхжүүлэх зэрэгт зөвлөгөө өгөх, сургах замаар орон нутгийн нийгмийг баталгаажуулах зорилгоор байгуулагдсан юм. Уг байгууллага орон нутгийн хөгжлийн загвар болохуйц хууль зүйн

зөвлөгөө, боловсрол, сургалтын бие даасан хөтөлбөрийг боловсронгуй болгох чиглэлээр ажиллаж байсан. НЭЗБОНХТ нь орон нутгийн олон нийтэд хуримтлалыг хэрхэн өсгөх, зохицуулах талаар зааж, ӨАБНУ-д хууль тогтоомжийн хэрэгжилт, гүйцэтгэх үүргийг өргөн хүрээнд ойлгох явдлыг хөгжүүлэх гэж хичээдэг. Хууль нь өөртөө итгэх итгэлийн чухал хэрэгсэл боловч үүнээс өөр хэрэгсэл байгааг ухамсарласнаар өөрсдөө өөртөө итгэх итгэл, найдвар, хариуцлагын мэдрэмжийг хөгжүүлснээр олон нийтийг Өмнөд Африкийн өөрчлөлтөд ур чадвартайгаар оролцоход тусалдаг юм. Засгийн газрын бүхий л түвшинд үүргээ эрхэмлэсэн, өөрсдийн иргэдийнхээ өмнө хариуцлага хүлээх чадвартай гэж үздэг эрх дээдэлсэн соёлыг хөгжүүлэх замаар ардчилалын ололт амжилтыг дэмждэг. НЭЗБОНХТ нь заншлын хуулиар зохицуулагдаж, омгийн даргаар удирдуулж буй 56 орон нутгийн зорилгот нийгэмлэгэд ажиллаж байгаа бөгөөд эдгээр нь омгийн удирдагч, омгийн зохицуулагч болон цалингүй зөвлөхүүдээс бүрддэг юм. Өөрсдийн нийгэмлэгийн цогц асуудлыг улам сайтар зохицуулах гэж буй эдгээр омгийн удирдагчдад албан сургалт явуулдаггүй бөгөөд “барууны хууль” болон заншилын хуулийн хооронд ихэвчлэн зөрчилдөөн үүсдэг байна. Шинээр батлагдсан Үндсэн Хуулийн дагуу энэхүү зөрчил улам өссөн билээ. Өнөөгийн байдлаар НЭЗБОНХТ нь өмгөөлөгчдийн туслах ажилтны сургалтыг зохион байгуулдаг хуульч бус хуульчдын нийгэмлэгийг байгуулсан. Мөн НЭЗБОНХТ нь хуулийн 36 төрлөөр тус бүр хоёр сараар 2 семестр буюу 4 сарын эрчимтэй сургалтын хөтөлбөрийг ашигладаг. Энэхүү сургалтыг дүүргээд эрх зүйн туслагч нар 12 сар өөрийн нийгэмлэгт ОНХЭЗОНХТ-ийн багш нарын хяналтан доор дадлага хийдэг бөгөөд эдгээр багш нар нь сард нэгээс доошгүй удаа албан дээр нь ирж ажил, гүйцэтгэлд нь хяналт-шинжилгээ, үнэлгээ хийдэг байна. Сургалтын төгсгөлийн шатанд хуульч бус хуульчид Дурбан дахь Наталийн Их сургуулийн Хуулийн салбарын дипломтой төгсдөг байна. 2000 оны туршид НЭЗБОНХТ 2 654 хэрэг дээр гардан ажиллаж орон нутгийн оршин суугчдад 6 сая гаруй Рандын орлого оруулж, хэд хэдэн нийгэмлэгийн эрх зүйн сургалт, семинарыг зохион байгуулж, мөн Засгийн газрын гүйцэтгэх үүрэг хариуцлагыг дүгнэж хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн байна. НЭЗБОНХТ нь орон нутгийн олон нийтийн ашигтай загвар бөгөөд хөгжиж буй орны хуульчдын анхаарлыг татдаг байна.

Туршлага

Хуульч бус хуульчдын зөвлөгөө өгөх алба нь хуульчдын хуулийн туслалцаа үзүүлэх хэвшсэн схемээс ашигтай хэлбэр юм. Хууль зүйн туслалцааны үйлчилгээ нь байх ёстой бөгөөд олон нийт эрх зүйтэй анхны удаа холбогдож байгаа тохиолдолд хуульч бус хуульчид чухал үүрэг гүйцэтгэдэг юм. Хуульч бус хуульчдын зөвлөгөө өгөх алба нь хуулийн эхний тайлбарт шалгалт, шинжилгээ хийх, заргалдагчдад хуульчдын үйлчилгээг санал болгоход үнэтэй үүргийг гүйцэтгэх боломжтой бөгөөд энэхүү үүргийг нь Хууль зүйн туслалцааны зөвлөл тэднийг өөрийн шинэ хууль зүйн төвд нэгтгэсэнээрээ, мөн зарим хамтын ажиллагааны гэрээнд хамруулах найдвар төрүүлж байгаагаараа хүлээн зөвшөөрч байгаа юм. Хуульч бус хуульчдын зөвлөгөө өгөх албыг үр ашигтай ажиллуулахад ажилтнуудыг нь цалинжуулах, сайн сургах шаардлагатай байна. Албадууд өөрсдөө найдвартай санхүүгийн тэнцэл бүрдүүлсэн байх шаардлагатай бөгөөд үүнийг үндэсний хууль зүйн туслалцааны схемд албадыг оруулсанаар биелүүлэх боломжтой юм.

Г. ДҮГНЭЛТ

Өмнөд Африкийн Бүгд Найрамдах Улсын Хууль зүйн туслалцааны Зөвлөлөөс үзүүлж буй хууль зүйн туслалцааны үйлчилгээний туршлагаас доорхи дүгнэлтийг хийж болно. Үүнд:

Хууль зүйн туслалцаа үзүүлэх бие даасан, ашигтай хэлбэр байхгүй бөгөөд олон нийтийн өмгөөлөл, өмгөөлөгч томилох загвар хосолсон хөтөлбөр нь хамгийн хэрэгтэй хэлбэр болов уу. Хэрэв өмгөөлөгч томилох тогтолцоог хэрэглэсэн тохиолдолд энэ нь төрөл бүрийн гэрээгээр зохицуулагдах ёстой. Улсын өмгөөлөгчидтэй хамтрах тохиолдолд энэ нь хөгжиж буй улс орны нөхцөлд тохирсон байх шаардлагатай.

Хуульчдын болон санхүүгийн эх үүсвэрийн дутагдалтай байгаа тухайн Африкийн улс орнуудад жишээлэхэд төрөөс санхүүжилттэй болон бие даасан хуулийн клиникүүдийн

адил хууль зүйн туслалцаа үзүүлэх ажиллагаанд хуулийн салбарын оюутнууд болон хуулийн сургууль төгсөгчидийг хамруулан нарийн хэлэлцүүлэг хийх шаардлагатай.

Үндэсний хууль зүйн туслалцаа үзүүлэгч этгээд нь бие даасан хууль зүйн үйлчилгээ үзүүлэгчдтэй тохируулсан хоршооллын хэлбэртэй нэгдэх асуудлыг бодолцох хэрэгтэй юм. Хуульч бус хуульчдын зөвлөгөө өгөх албыг гол эх үүсвэр гэж хүлээн зөвшөөрөх ёстой бөгөөд хэрэв хүлээн зөвшөөрөгдвөл дээрхи хэлэлцээрт хамруулах шаардлагатай юм.

ИЗРАИЛ УЛСЫН ӨМГӨӨЛӨГЧДИЙН ТОВЧОО, СУРГАМЖ, ИРЭЭДҮЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

**Моше Хакохен , Иерусалим хотын дүүргийн өмгөөлөгч,
Израил Улсын Өмгөөлөгчдийн товчоо**

Өмнөх үг

Израил Улсын Өмгөөлөгчдийн товчоо /ИУӨТ/ нь 1995 оны хуулиар байгуулагдсан юм. Тус товчоог байгуулсан явдал бол эрдэмтэд, хуульчидтай хамтарч Шүүх засаглалын болон Кнессет /Израилийн парламент/-ийн олон гишүүдийн гаргасан хүчин чармайлтын үр дүн болно. 1980-аад оны эхэн үед цөөн тооны дэмжигчдийн хүрээнд уг санаа боловсрогдож эхлээд 1990-ээд оны эхэн гэхэд эрч хүчээ авсан байна. ИУӨТ байгуулагдахаас өмнө, сэжигтнүүдийн 20%, хариуцагчдийн 30% нь л өмгөөлөгчөөр төлөөлүүлж байжээ. Өнөөдөр ИУӨТ-ны сэжигтнүүд болон хүүхдийн өмгөөлөлийн хөтөлбөрийг хэрэгжүүлсэн дүүргүүдэд дунджаар нийт сэжигтнүүдийн 70%, хариуцагчдийн 50% гаруй нь эрүүгийн хэрэг шийдвэрлэхэд өмгөөлөгчөөр төлөөлүүлдэг болжээ. Тоон үзүүлэлтээр авч үзвэл ИУӨТ байгуулагдахаас өмнө нийтдээ нэг жилд 4000 хэргүүд өмгөөлөгчийн оролцоотой шийдвэрлэгдэж байв. Өнөөдөр Улсын Өмгөөлөгчдийн Товчооны янз бүрийн түвшингийн салбарууд 23000 хэрэг шийлвэрлэхэд оролцож байна. Алс хэтийн төлөвийг тодорхойлохдоо өнөөгийн байдлаар Израил улс 6 сая гаруй иргэдтэй гэдгийг дурдъя.

ИУӨТ байгуулагдахаас өмнөх үеийн эрх зүйн болон бодит орчин

1992 он хүртэл Израил улсад гэмт хэрэгт сэжиглэгдсэн болон яллагдсан хүмүүсийн эрхийн талаарх Үндсэн Хуулиар тогтоосон баталгаа байхгүй байсан байна. (Тухайлбал үндэслэлгүй баривчилгаанаас хамгаалах тухай, яллагдаж байгаа хэргийнхээ тухай мэдээлэл авах эрх, хуулийн дагуу таслан шийдвэрлүүлэх эрх, харгис хэрцгий ял оноохын эсрэг заалт) . Хэдийгээр мөрдөгдөж буй заалтууд нь уг чанартаа энгийн хуулийн шинжтэй байсан бөгөөд тиймээс Кнессетийн энгийн олонхийн саналаар өөрчлөх боломжтой байвч тухайлбал яллагдсан этгээдэд өмгөөлөгчөөс зөвлөгөө авах хүнд эрүүгийн хэрэг шийдвэрлэхэд өмгөөлөгчөөр төлөөлүүлэх эрхийг баталгаажуулж байв. Гэхдээ эдгээр нь төлбөрийн чадваргүй хариуцагч этгээдэд хууль зүйн үндсэн туслалцааг олгохыг заасан байв. Израилийн хүний эрхийн тухай үндсэн хууль гэж үзэж болох “ Хүний нэр төр эрх чөлөөний” тухай хууль нь хэрэгжиж, гэмт хэрэгт яллагдсан этгээдийн дээр дурьдсан эрхүүдийн эрх зүйн байдал өргөжиж байгаа хэдий ч өмгөөлөгчийг сонгох эсвэл томилох нь тодорхойгүй орхигдсон байна. Израилийн эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 15-р зүйлд заасанчлан төлбөрийн чадваргүй хариуцагч нь дараах тохиолдолд шүүхээс томилох өмгөөлөгч авах эрхтэй байлаа:

Ялын дээд хэмжээ авах , 10- аас дээш жил хорих ял эдлэх гэмт хэрэгт яллагдсан, хариуцагч өөрийгөө өмгөөлөх чадваргүй эрүүл мэндийн болон сэтгэл санааны хүнд байдалд орсон, 16 нас хүртэлх насанд хүрээгүй хүүхэд ноцтой гэмт хэрэгт яллагдсан, Яллагч хариуцагчийг шүүхийн эцсийн шийдвэр гаргах хүртэл барьцаалан суллах эрхгүйгээр саатуулан хорих тухай шийдвэр гаргах үед хариуцагчаар татсан зэрэг тохиолдлууд юм.

Насанд хүрээгүй иргэд болон байцаах зорилгоор цагдаагийн газар түр саатуулсан этгээдүүд өмгөөлөгч авах шаардлагатай гэсэн хүмүүсийн тоонд ордоггүй байлаа. Тийм ч учраас насанд хүрээгүй хүүхдийн хэргийг авч үздэг шүүхийн гишүүд өмгөөлөгчийн оролцоо хэргийг шүүн таслах явцыг хүндрүүлж, зохих ёсны засан хүмүүжүүлэх арга хэмжээ авахад гаж буруу нөлөө үзүүлдэг хэмээн дүгнэдэг байв.

Түр саатуулагдсан этгээдүүдийн тухайд өмгөөлөгчийн оролцоо хэргийг мөрдөн байцах явцад саад тотгор учруулж, ямар ч тохиолдолд шүүгч түр саатуулагдсан этгээдийн эрхийн хамгаална гэсэн ойлголтыг шүүгч нар мөрдлөг болгож байсан магадлалтай. Шүүх насанд хүрээгүй иргэнд цөөхөн тохиолдолд өмгөөлөгч томилж, мөрдөн байцаах шатанд томилогдсон өмгөөлөгч онцгойд тооцогдож байсан нь дээрхийг илтгэнэ. ИУӨТ байгуулагдсанаар байдал эрс өөрчлөгджээ.

Улсын Өмгөөлөгчийн тухай хууль батлахаас өмнөх үеийн Өмгөөлөгчийн томилгоо

ИУӨТ байгуулагдахаас өмнөх 47 жилийн туршид төлбөрийн чадваргүй хариуцагч нарт үзүүлэх хууль зүйн өмгөөллийн зонхилох систем нь шүүх ад нос зарчмаар өмгөөлөгчийг томилдог систем байлаа. Энэхүү систем нь учир дутагдалтай байсан бөгөөд шүүмжлэлд өртөж байв. Тухайлбал:

Шүүгч нар болон шүүх байгууллагын ажиллагсад ихэнхдээ туршлага чадварыг нь харгалзахгүйгээр өмгөөлөгч томилох тухай асуудлыг шийдэж байв. Түүнчлэн тэд өмгөөлөгчдөд өгөх цалингийн хэмжээг шийддэг байлаа. Учир нь өмгөөлөгчдөд төлөх мөнгөний хэмжээг шүүх хуралдааныг тэргүүлэх шүүгчийн өөрийн мэдлийн дагуу шийдэж байсан бөгөөд энэ нь зөвхөн шүүх хуралдаанд оролцоход төлөх хуулинд заагдсан төлбөрийн дээд хэмжээ болон өмгөөлөгчид өгөх шүүгчийн дүгнэлтээр хязгаарлагдаж байв.

Нэг хариуцагчийг зүй ёсоор өмгөөлөх нөгөө талаас шүүгчид таатай хандлага харуулах эрмэлзэл сөргөлдөх тохиолдолд томилогдсон өмгөөлөгч маань ихэнхдээ хоёрдмол байдалд орж байлаа. Ялангуяа хэргийн тухайд шүүгч эсрэг дүгнэлт гаргасан тохиолдолд өмгөөлөгч нар хариуцагчийн талд хэргийг шийдвэрлүүлэхээр тууштай ажиллахаас зайлсхийж байв. Уг систем нь өмгөөлөгч хэргийг аль болох хурдан шийдвэрлүүлж улмаар томилсон шүүгчид таатай сэтгэгдэл төрүүлэн илүү олон удаа томилолт авах явдлыг хөхүүлэн дэмжиж байв.

Шүүхээр томилогдсон өмгөөлөгчид үүсэж болох “хоёрдмол байдал” нь хариуцагч этгээдэд өмгөөлөгчдөө бүрэн итгэхэд эргэлзээ төрүүлж улмаар хэргийг өмгөөлөхөд илүү төвөгтэй болгодог байна.

Шүүгч өмгөөлөхөд гарах зардлыг батлах эрхтэй байв. Тийм учраас ямар нэгэн зардлыг (сэтгэл мэдрэлийн эмчийн дүгнэлт гаргуулах, нэмэлт мөрдөн байцалт явуулах г.м.) батлуулах хуралдаанд оролцсон яллагч нь өмгөөлөгчийн стратегийг урьдчилан мэдэх боломжтой болж байв.

ИУӨТ байгуулснаар гарсан өөрчлөлтүүд

Улсын өмгөөлөгчийн тухай хууль нь дараах хоёр гол зорилготой юм:
Төлбөрийн чадваргүй хариуцагч, түр хоригдсон хүмүүсийг зохих ёсоор өмгөөлөх зорилгоор хууль зүйн туслалцаа авах ёстой дээр дурьдсан хүмүүсийн тоог нэмэгдүүлэх, өмгөөллийн чанарыг дээшлүүлж, өмгөөлөгчийг шүүх томилдог хуучин системтэй холбогдсон алдаа дутагдлыг засах

Өмгөөлөгчөөр төлөөлүүлэх үндэслэлийг өргөжүүлсэн нь

Шинэ хуулиар, 5-аас 10 жил хоригдох ял авч болзошгүй төлбөрийн чадваргүй хариуцагч улсын өмгөөлөгчөөр өмгөөлүүлэх эрхтэй болжээ.

Хүсэлт гаргагч нь санхүүгийн хүндрэлтэй гэдгээ хүн амын нэг сарын дундаж орлогын (одоогоор 1000 ам. доллартай тэнцэнэ) гуравны хоёроос бага орлоготой, мөн үнэ нь 4500 ам.доллароос илүү өмч хөрөнгө эзэмшдэггүй гэдгээ батлах ёстой юм. Кнессетийн баталсан хууль тогтоомжийг мөрдөж эхэлснээр улсын өмгөөлөгчөөр өмгөөлүүлэх эрх зүйн үндэслэл өргөжиж дээрх шалгуурт тохирох түр хоригдсон этгээд болон орлогын хэмжээнээс үл хамааран, замын хөдөлгөөний зөрчлөөс бусад тохиолдолд насанд хүрээгүй хүүхдүүд үүнд хамрах болжээ. Төсөв хөрөнгийн хүндрэлээс хамааран мөрдөн байцаалтын шатанд байгаа түр хоригдсон этгээд болон насанд хүрээгүй иргэдийг

өмгөөлөх хөтөлбөрийн хэрэгжилт Израилийн шүүхийн таван дүүргийн хоёрт хойшлогдож байгаа юм. Түүнчлэн ИУӨТ байгуулагдсаны дараахан шүүгч нар Улсын өмгөөлөгчийн тухай хуулийн 18-р зүйлд заасанчлан хариуцагч этгээд ИУӨТ-д хандахыг олон удаа зөвшөөрч хуульд заасан санхүүгийн шалгуурт тохирохгүй болон таваас бага жил хоригдох гэмт хэрэгт татагдсан тохиолдолд ч зөвшөөрөх хандлага ажиглагдаж байна. Бодит байдал дээр улсын өмгөөлөгчөөр өмгөөлүүлж буй хэрэгт татагдсан насанд хүрэгчдийн 50% нь Улсын өмгөөлөгчийн тухай хуулийн 18-р зүйлд заасан шүүхийн шийдвэрийн дагуу ИУӨТ ханддаг байна. Хорих ялаар шийтгүүлж буй бүх хүмүүст улсын өмгөөлөгчөөр өмгөөлүүлэх эрх олгож өгөх тухай Хууль зүйн яаманд хандсан Израилийн хүний эрхийн байгууллагын өргөдлийг Шүүх засаглалын дээд байгууллага болох Дээд шүүх авч хэлэлцэж байна. Дээд шүүхээс өмгөөлүүлэх эрх бүхий хариуцагч нарын тоогоо нэмэгдүүлэх тухай ямар арга хэмжээ авч болохыг зургаан сарын дотор тодруулахыг Хууль зүйн яаманд даалгажээ.

Өмгөөллийн чанарыг дээшлүүлэх талаар

Улсын өмгөөлөгчийн тухай хуультай холбоотой гарч ирсэн систем нь шүүх томилдог өмгөөлөгчийн системийг улсын өмгөөлөгчийн болон гэрээгээр ажилладаг өмгөөлөгчийн “холимог” хэмээн нэрлэгддэг системээр сольжээ.

Хэдийгээр улсын өмгөөлөгчийн тухай хуулийн дагуу ИУӨТ нь Хууль зүйн яамны бүтцэд ордог ч, “улсын өмгөөлөгчийн танхим” товчооны бие даасан байдлын баталгааг хангах зорилготой юм. Тус хуулийн гуравдугаар зүйлийн дагуу танхим улсын ерөнхий өмгөөлөгчийг томилох эрхтэй бөгөөд товчооны үйл ажиллагааг хянадаг юм. Нэг талыг барьсан шийдвэр гаргахаас урьдчилан сэргийлэх зорилгоор танхим дараах таван гишүүнээс бүрдэнэ: Хууль зүйн сайд /тэргүүлэгч/, тэтгэвэрт гарсан Дээд шүүхийн гишүүн, өмгөөлөгчийн холбооны үндэсний зөвлөлөөс сонгогдсон эрүүгийн хэргийг хариуцсан өмгөөлөгч, Өмгөөлөгчдийн холбооны тэргүүлэгчтэй зөвшилцсөний үндсэн дээр Хууль зүйн сайдын томилсон эрүүгийн хэргийг хариуцсан өмгөөлөгч болон эрүүгийн эрх зүйн эрдэм шинжилгээний ажилтан нар юм. ИУӨТ нь таван жилийн хугацаагаар дахин сонгогдох эрхтэй бөгөөд Улсын өмгөөлөгчдийн танхимаас томилогдсон Улсын Ерөнхий өмгөөлөгч тэргүүлнэ. Дүүргийн улсын өмгөөлөгч нь таван жилийн хугацаатай ажиллана. Тэтгэвэрт гарах, өөр ажилд томилогдсон үед эсвэл Улсын өмгөөлөгчдийн танхимын шийдвэрээр албан тушаалаасаа чөлөөлөгднө.

Улсын өмгөөлөгчийн хуулийн дагуу ИУӨТ эрүүгийн хэргийг хэлэлцэхэд чанартай өмгөөлөл явуулах үүргийг хүлээдэг юм. Энэ нь дараах зүйлээр баталгаажна:

ИУӨТ төлбөрийн чадваргүй хүмүүсийг өмгөөлөх хувийн өмгөөлөгчтэй гэрээ байгуулах эрхтэй. Хуульч мэргэжилтэй бөгөөд өмгөөлөгчөөр ажиллахыг сонирхсон хүн улсын өмгөөлөгчийн жагсаалтанд орох тухайгаа бичгээр мэдэгдэнэ. ИУӨТ жагсаалтад оруулахдаа хүмүүсийн мэргэжлийн ур чадварыг шалгаж сургалтанд хамруулдаг байна. Өмгөөлөгчийн ур чадвар, туршлагаас хамааран хяналт тавьдаг байна. Хэрэг шийдвэрлэх бүрт товчооны албаны хүмүүс шүүх хуралдааны протоколтой нарийвчлан танилцах байдлаар хувийн өмгөөлөгч өмгөөлөлөө хэрхэн явуулж байгаа байдалтай танилцаж шаардлагатай үед хэрэг шийдвэрлэх явцад оролцдог байна. Шаардлагатай үед дүүргийн улсын өмгөөлөгч хувийн өмгөөлөгчийг солих эрхтэй бөгөөд зарим тохиолдолд улсын өмгөөлөгчөөр процесст оролцохыг түтгэлзүүлдэг байна.

Дээр дурьдсан өөрчлөлтүүд, өмнөх үеийнхтэй түвшинтэй харьцуулахад нэмэгдсэн цалин хөлс, шүүх, цагдаа, прокурорын байгууллага болон өмгөөлүүлж буй хүмүүст шинэ ойлголт төрж, улсын өмгөөлөгч болох хүсэлтэй хуульчдийн тоо нэмэгдэж байгаа зэрэг нь ИУӨТ өмгөөлөгч нараас сонголт хийх болон өөрийн үйл ажиллагааны чанарын түвшинг дээшлүүлэх бололцоо олгож байгаа юм.

Насанд хүрээгүйчүүдийг өмгөөлөх

Улсын өмгөөлөгчийн хууль болон түүний зохих заалтууд хүчин төгөлдөр болохоос өмнө насанд хүрээгүй иргэдийн 10% нь хэрэг шийдвэрлүүлэхдээ өмгөөлүүлдэг /эцэг, эх нь өмгөөлөгч хөлсөлдөг/ байсан бол харин өнөөдөр нийт насанд хүрээгүйчүүдийн 70%

өмгөөлүүлж, үүнд улсын өмгөөлөгч нар зонхилох болжээ. Энэ нь насанд хүрээгүй иргэдийн хэргийг шийдвэрлэх шүүхийн процесст томоохон өөрчлөлт оруулсан байна. Ийм төрлийн шүүх хуралдаан хаалттай хэлбэрээр явагдаж шүүгч, яллагч, засан хүмүүжүүлэгч нарын санал зонхилж өмгөөлөгч туслах чанарын үүрэг гүйцэтгэдэг байсан юм. Харин одоо улсын өмгөөлөгч процессын зайлшгүй оролцогч болсон байна.

Өмгөөлөгч шүүх хуралдаанд оролцох болсноор шүүгдэгчийн процесст оролцох эрх болон гэм бурууг нь эргэлзээгүйгээр тогтооход түлхүү анхаарах болсон байна. Сонирхолтой нь улсын өмгөөлөгч шүүгдэгчийн эрх ашигт нийцэх, зарим талаар шүүх хэргийг зохистой байдлаар шийдвэрлэхэд дөхөм болдог байна. Насанд хүрээгүй иргэдийн өмгөөллийн асуудал нь өмгөөлөгчийг тодорхой ур чадвар, мэдлэг эзэмшихийг шаардах тул ИУӨТ-өөс тусгай сургалт явуулдаг. Тус сургалтад насанд хүрээгүй иргэний хэргийг өмгөөлөх өмгөөлөгч бүр хамрагдаг.

Түр саатуулагдсан этгээд /сэжигтэн/-ийг өмгөөлөх

Хүний эрхийг хамгаалах үүднээс харахад байцаалт авах өөрөөр хэлбэл гэм бурууг хүлээн зөвшөөрүүлэх зорилгоор сэжигтнийг цагдаагийн газар саатуулах явдал нь Израилийн эрүүгийн шүүхийн системийн төвөгтэй асуудлын нэг байсаар иржээ. Израилийн хуулиар цагдаагийн газар байцаалт авах зорилгоор хорин дөрвөн цагаас хэтрэхгүй хугацаанд түр саатуулан хорих эрхтэй бөгөөд энэ хугацаанд магистр шүүгчид сэжиглэгдэж байгаа хэргийг танилцуулан хорих хугацааг сунгадаг байна. Сэжигтэн гадаад ертөнцөөс бүрэн тусгаарлагдсан, гэмт хэрэгт холбоотойг нь хүлээн зөвшөөрүүлэх зорилгоор сэтгэл санааны болон бага зэргийн бие сэтгэлийн дарамтанд орж болзошгүй тул сэжигтэнд эрхээ хамгаалах хилс хэрэгт гүтгэгдэхээс сэргийлэх зорилгоор өмгөөлөгчөөс зөвлөгөө авах шаардлагатай байдаг юм. Түүнчлэн манай эрүүгийн хэргийг шийдвэрлэх системд магистр шүүгч сэжигтнээс байцаалт авах зорилгоор сэжигтнийг үргэлжлүүлэн арван таван хоног хүртэлх хугацаагаар сунгаж хорих шийдвэр гаргах эрхтэй. Үүнийг нийтдээ зургаан сар хүртэл хугацаагаар сунгаж болно. Магистр шүүгчийн хэлэлцэх шүүх хуралдааны нотолгоо баримтууд нь нууцлагддаг тул сэжигтэнд учир битүүлэг санагддаг. өмгөөлөгч ийм хуралдаанд оролцох явдал чухал бөгөөд шударгаар хэргийг шийдэх, сэжигтнийг онцын шаардлагагүйгээр удаан хугацаагаар хорихоос хамгаалахад чиглэгдэнэ. ИУӨТ байгуулагдаж, төлбөрийн чадваргүй иргэдийн эрхийг хамгаалах хүрээ өргөжихөөс өмнө нийт сэжигтнүүдийн 20-оос бага хувь нь ихэнхдээ хувийн өмгөөлөгчөөр төлөөлүүлж байжээ. Өнөөдөр ИУӨТ-ийн сэжигтнийг өмгөөлөх хөтөлбөр хэрэгжиж буй дүүргүүдэд сэжигтний 70% нь голцуу улсын өмгөөлөгчөөр өмгөөлүүлж байна. Одоогоор төлбөрийн чадваргүй сэжигтнүүдэд туслах зорилгоор сэжигтэнтэй ярилцах, зөвлөгөө өгөх, хорих газар болон цагдаагийн газарт байнга ажиллаж байх улсын өмгөөлөгчдийн бүлэг бүхий шинэ системийг нэвтрүүлж байна. Тухайн өмгөөлөгч сэжигтнийг шүүх хуралдаанд ч төлөөлж, шүүхийн эцсийн ялыг сонсох хүртэл үргэлжлүүлэн өмгөөлж байсан. Шинэ системийг нэвтрүүлснээр магистр шүүгчийн байцаалт авахад ноогдуулдаг хорих хугацаа эрс багасаж, цагдаагийн газрын зүгээс хуулиар тогтоосон хугацаа болох хорин дөрвөн цаг дуусахаас өмнө сэжигтний асуудлыг шийдэх болоцоотой нь харагдаж байна.

Шинэ системд тулгарч буй асуудлууд

ИУӨТ 1996 онд анх байгуулагдснаас хойш төсөв нь таван зүйлээр нэмэгдэж Хууль зүйн яамны ерөнхий төсөвт эзлэх хувь 2-оос 10 хувь болж өсжээ. Өнгөрсөн хугацаанд Хууль зүйн яамнаас санхүүжүүлсэн хөрөнгийг тооцон нэг хүнд ноогдох хэмжээгээр Европ, Хойт Америкийн хөгжингүй орнуудын түвшинтэй харьцуулахад төлбөрийн чадваргүй иргэдийн өмгөөллийн зардал хэтрээгүй гэсэн дүгнэлт гаргасан байна. ИУӨТ-ийн онөөгийн төсөв ойролцоогоор 11сая доллар байхад бодит үйл ажиллагааны зардал 20 сая доллар болж байна. Энэхүү хэтрүүлэн зарцуулалт гарах болсон шалтгаан нь ИУӨТ хамтран ажиллаж буй хувийн өмгөөлөгчдөд төлөх төлбөрийг Хууль зүйн яамнаас түр зогсоож Төрийн сангаас гадны өмгөөлөгчдөд төлөх естой зардлыг (жишээ нь шинжээчийн дүгнэлтийн зардал) түр хугацаагаар батлахгүй шийдвэр гарсантай холбоотой юм. Төрийн сан санал болгосон бүтцийн өөрчлөлтийн хүрээнд хувийн өмгөөлөгч нарт төлөх тогтоогдсон төлбөрийн хэмжээ бүхэлдээ 22%-аар буурсан байна. Түүнчлэн үр дүн, зохистой эсэх нь хараахан тодорхойгүй байгаа

хөтөлбөрийн дагуу насанд хүрээгүй иргэдийн тухайд хэргийг эцэслэн шийдвэрлэх хүртэлх явцыг хариуцуулах өмгөөлөгч нартай нийтлэг нэг гэрээ байгуулах зарчмыг хэрэгжүүлэх юм. Үүний үр дүнд хувийн өмгөөлөгч нарт төлөх цалин хөлсний хэмжээ өнөөгийн түвшингөөс багасна. Хууль зүйн яам, Төрийн сангийн шийдвэр гаргах албан тушаалтан нарын зорилт нь ИУӨТ хуваарилагдсан төсвийг 40%-аар бууруулахад оршино. Шийдвэр гаргагч нарт тулгамдаж буй илүү өргөн хүрээтэй асуудал гэвэл улсын өмгөөлөл авч болох шүүгдэгч нарын тоог хязгаарлах явдал юм. Саяхан яамны хууль тогтоомжийн хороо Улсын өмгөөлөгчийн тухай хуулийн 18-р зүйлийн заалтыг хоёр жилээр түр зогсоох тухай яаралтай арга хэмжээ авах тухай саналыг зөвшөөрсөн байна. Энэ саналын дагуу онцгой нөхцөл байдлын улмаас хуулийн шалгуурт тохирохгүй шүүгдэгчдэд өмгөөлөгч томилох тухай шүүгчийн эрхийг хязгаарлаж шүүх хуралдааныг тэргүүлэх шүүгчийн зөвшөөрлөөр томилох болсон байна. Хууль тогтоох байгууллага хараахан батлаагүй байгаа ийм арга хэмжээг хатуу мөрдөж эхлэхэд улсын өмгөөлөгчөөр төлөөлүүлэх шүүгдэгчийн тоог 40%-аар бууруулах магадлалтай. ИУӨТ ийм байдал үүсэхийг эрс эсэргүүцэж дээр дурьдсан шийдвэрүүд төлбөрийн чадваргүй иргэдийн хууль зүйн туслалцаа авах эрхийг гуйвуулж байна гэж мэдэгдснийг дурьдах шаардлагагүй юм.

Энэхүү шийдвэрийг эрүүгийн хэргийн шүүх явцыг хурдасгах талаар хийгдэж буй засаг захиргааны өөрчлөлттэй холбон үзэх шаардлагатай юм. Ноогдсон хугацаанд шүүгч бүр нэг өдөрт хэд хэдэн хуралдаан явуулж болно. Тусгайлан заагдсан хугацаанаас өмнө шүүгдэгчийг өмгөөлөх үүрэг хүлээсэн улсын өмгөөлөгч нь шүүгдэгчтэй зөвхөн шүүх хурал дээр анх уулзах ёстой бөгөөд яллагч талын мөрдөн байцалтын материалтай хэрэг хэлэлцэгдэхээс өмнө танилцсан байх шаардлагатай. Ийм өмгөөлөгч нар хэргийн тоогоор бус өдрийн тоогоор цалинжих бөгөөд ингэснээр эрүүгийн хэргийг шийдэхэд төлөгдөх өмгөөлөгчийн зардлыг бууруулж улмаар улсын өмгөөлөгчдөд өгөх санхүүжилтийг 80 хүртлэх хувиар багасгаж болох юм. Төлөвлөгдсөн энэ өөрчлөлтүүд нь их зөрчилтэй бөгөөд эрүүгийн шүүхийн системийн салбарт ажиллагсдын зүгээс хатуу шүүмжлэл хүртэж байна. Одоогийн шатанд шүүгдэгчийн өмгөөллийн чанарт хэрхэн нөлөөлөх нь зөвхөн таамаглал төдий байна.

Израилийн Барын холбоотой харилцах харьцаа

ИУӨТ байгуулагдаж шүүх хуралдаанаас өмнөх шатанд сэжигтний өмгөөллийн тоо эрс нэмэгдсэнээр Израилийн Барын холбооны өмгөөлөгчид орох явдал олширсон байна. Энэ нь улсын өмгөөлөгчийн хувьд өмгөөлөл явуулж буй / Барын холбооны гишүүн болох/ өмгөөлөгч эрүүгийн хэрэг хариуцах, үйлчлүүлэгч нарын хүрээ нь ихэнхдээ доод, дунд амьжирганы түвшингийн хүмүүс болох, бусад гишүүдээсээ шударга, давуу байдалд байгаатай холбоотой юм. Түүнчлэн хууль тогтоомжид заасанчлан хүсэлт тавьсан хүн санхүүгийн бололцоогүй гэдгийг шалгалгүйгээр ИУӨТ туслалцаа үзүүлж байна гэсэн асуудал дэвшигдэж байгаа юм.

Өмгөөлөгчдийн холбооноос гаргаж буй шүүмжлэл ИУӨТ-г шаардлагатай үед хувийн мөрдөгчийн туслалцаатайгаар хүсэлт гаргасан хүний санхүүгийн байдал хуульд заасан шалгуурт нийцэх эсэхийг нарийвчлан шалгаж байхад хүргэж байна. Түүнчлэн ИУӨТ боломжтой тохиолдолд аль болох олон өмгөөлөгч нарт хэргүүдийг хуваарилах болон залуу, туршлагагүй өмгөөлөгч нарт хүндрэл үл учруулах өмгөөлөл явуулах өөрийн тогтоосон шалгуураа зөөлрүүлэх тухай саналууд дэвшигдсэн байна.

Төлбөр ноогдуулах тухай

ИУӨТ санхүүжүүлэхэд тус дэм болох зорилгоор хууль зүйн туслалцаа авч буй төлбөрийн чадваргүй иргэд тодорхой хэмжээний төлбөрийг төлж байх тухай өөрчлөлтийг 2000 онд улсын өмгөөлөгчийн тухай хуулинд оруулжээ. Сэжигтэн, хоригдол, насанд хүрээгүй иргэд, хуулиар заагдсан өмгөөлөл авах эрхтэй зарим нэгэн шүүгдэгчээс бусад шүүгдэгч нар улсаас өмгөөлөл авах хүсэлтэй бол төлбөр төлөх ёстой юм. Энэхүү зохицуулалт төлбөр ноогдуулах болон авахтай холбоотой олон асудлуудтай тулгарч байна. Төлбөрийн тухай асуудал эхэн үед эрүүгийн процесийн оролцогчдын санааг түгшээж, хэрэг шийдвэрлэх явц саатаж үүний хариуд шүүгч нар өмгөөлөгч томилохоос татгалзах тухай болгоомжлол төрүүлж байв. Дараа нь төлбөрийн чадваргүй шүүгдэгчдийн улсаас өмгөөлөл авах сонирхлыг бууруулна гэсэн дүгнэлт гарч байжээ. Харин бодит амьдрал дээр шүүгчид шүүгдэгчийг төлбөрөөс чөлөөлөх эрхээ хэрэгжүүлж эсвэл хэргийг эцэслэн шийдвэрлэх хүртэл төлбөрийг хойшлуулж байсны улмаас цөөхөн тохиолдолд төлөгдөж байсан байна.

Тийм ч учраас ийм төлбөр нь бичиг цаасны ажил хүнд суртлыг нэмэгдүүлснээс өөр нөлөө үзүүлсэнгүй.

ЛИТВА УЛС ДАХЬ ЭРХЗҮЙН ТУСЛАЛЦААНЫ АСУУДАЛ

2002 оны 6 дугаар сарын 6-7-ны өдрүүдэд Варшав хотноо зохион байгуулагдсан “Хууль зүйн туслалцаа” сэдэвт хуралд Литва дахь COLPI-н эрх зүйн туслалцааны хөтөлбөрийн хуулийн зөвлөх, “Bernotas & Dominas Glimstedt” хууль зүйн товчооны өмгөөлөгч Линас Сесикасын тавьсан илтгэл

Энэхүү илтгэл нь Литва улс дахь хууль зүйн туслалцаа үзүүлэх тогтолцоо, практик болоод Литва дахь Соросын сан ба COLPI-н хамтарсан идэвх санаачлагын дүнд байгуулагдсан туршилтын загвар болох Улсын өмгөөлөгчийн газрын талаархи асуудлуудыг хамарна.

1. Зохицуулалтын тогтолцоо

Литвийн Бүгд Найрамдах Улсын Үндсэн хуулиар гэмт хэрэгт сэжиглэгдэж байгаа буюу буруутгагдаж байгаа этгээд нь түүнийг баривчлан хорьсон үеэс эсхүл анхны байцаалт өгөх үеэс хамгаалалт эдлэх буюу өөрийн өмгөөлөгчтэй байх эрхтэй. Төрийн баталгаат хууль зүйн туслалцааны тухай хуулийн дагуу төрийн баталгаат хууль зүйн туслалцаа нь эрүүгийн хэрэгт мөрдөн байцаагч, прокурор, эсхүл шүүгчийн томилсон өмгөөлөгч байна.

Эрүүгийн байцаан шийтгэх тухай хуульд зааснаар өмгөөлөгч нь сэжигтэн эсхүл буруутай этгээдийн хүсэлтийн дагуу түүнийг баривчлан хорих буюу анхны байцаалт авах тэр үеэс эхлэн хэрэгт оролцох ёстой. Сэжигтэн эсхүл гэмт буруутай этгээдийн өмгөөлөгч авах эсэх талаархи хүсэлтийг протокол хөтлөн баталгаажуулж түүнд сэжигтэн буюу гэм буруутай этгээд, мөн мөрдөн байцаагч гарын үсэг зурна. Хариуцагч нь хэд хэдэн өмгөөлөгчтэй байж болно. өмгөөллийн үйл ажиллагаа явуулах хүн нь өмгөөлөгч байх шаардлагатай ба Литвийн Барын Нийгэмлэгийн гишүүн байх ёстой. Хоёр буюу түүнээс дээш сэжигтэн эсхүл гэм буруутай этгээд, хариуцагчийн өмгөөлөгч эсхүл өмгөөлж буй этгээдийн ашиг сонирхол харшилж буй тохиолдолд нэг өмгөөлөгч ажиллахыг хориглоно. Сэжигтэн, гэм буруутай этгээд, хариуцагчийн хүлээн зөвшөөрсөн өмгөөлөгчийн эрх зүйн статус нь бусад эрх бүхий этгээдээс олгосон эсхүл сэжигтэй, гэм буруутай этгээд, хариуцагчийн зөвшөөрсөн хэмжээнд байна. Сэжигтэн, гэм буруутай этгээд, хариуцагчийн хүсэлтийн дагуу ажиллах өмгөөлөгчийн оролцоог мөрдөн байцаагч, шүүгч эсхүл шүүх баталгаажуулна. Сэжигтэн, гэм буруутай этгээд, хариуцагчийн сонгосон өмгөөлөгч нь таваас дээш хоног хэргийн явцад оролцож ажиллахгүй тохиолдолд мөрдөн байцаагч, шүүгч эсхүл шүүх сэжигтэн, гэм буруутай этгээд, хариуцагчид өөр өмгөөлөгч авахыг санал болгох эрхтэй. Өмнө дурдсан хэрэгт, хэрвээ сэжигтэн, гэм буруутай этгээд, хариуцагч өөрөө өмгөөлөгч аваагүй, эсхүл тэдгээрийн зөвшөөрлийг авалгүйгээр өмгөөлөгч сонгосон бол мөрдөн байцаагч, шүүгч эсхүл шүүх өмгөөлөгчийг томилох ёстой. Эрүүгийн байцаан шийтгэх тухай хуулийн 56 дугаар зүйлд хууль зүйн туслалцааны төлбөрийн асуудлыг зохицуулсан байдаг. Үүнд хэрвээ мөрдөн байцаагч, прокурор, шүүгч эсхүл шүүх сэжигтэн, гэм буруутай этгээд, хариуцагчийг хууль зүйн туслалцааны төлбөрөөс чөлөөлсөн бол өмгөөлөгчийн ажлын хөлсийг Литвийн Засгийн газраас тогтоосон журмын дагуу төр хариуцна. Эрүүгийн байцаан шийтгэх тухай хуулийн 56 дугаар зүйлд өмгөөлөгчийн зайлшгүй оролцох хэргийн нөхцлүүдийг зааж өгсөн байна. Үүнд: 1\ сэжигтэн буюу гэм буруутай этгээд цөөнх бол, 2\ гэмт хэргийг хэлгүй, дүлий эсхүл оюуны болон бие махбодийн хувьд өөрийн хийсэн үйлдлийг хамгаалах чадваргүй этгээд үйлдсэн бол, 3\ сэжигтэн, гэм буруутай этгээд, хариуцагч нь хэргийг шийдвэрлэх процедур явагдах хэлийг мэдэхгүй бол, 4\ тухайн гэмт хэрэгт насаар нь хорих ял оноож болзошгүй бол, 5\ сэжигтэн, гэм буруутай этгээд, хариуцагч нарын аль нэг нь өмгөөлөгчтэй бөгөөд тэдгээрийн хооронд ашиг сонирхлын зөрчилдөөн бий болсон тохиолдолд, 6\ тухайн хэрэгт прокурор оролцож байгаа бол, 6\ шаардлагатай бусад хэргүүд.

Төрийн баталгаат хууль зүйн туслалцааны тухай хууль нь 2001 оны 1 дүгээр сарын 1-нээс хүчин төгөлдөр болсон бөгөөд дараахь этгээдүүд төрийн баталгаат хууль зүйн туслалцааг авах боломжтой: 1\ Жилийн орлого, эд хөрөнгө нь Литвийн Засгийн газраас тогтоосон орлого, эд хөрөнгийн хязгаарлалтаас хэтрээгүй этгээд Төрийн баталгаат хууль

зүйн туслалцааны тухай хуулийн дагуу эрх зүйн туслалцаа авч болно, 2\ Литва улсын хууль болон олон улсын гэрээнд заасан бусад этгээдүүд. Хууль зүйн туслалцаа нь даатгалтай холбоотой асуудалд хамаарахгүй. Тухайн этгээдийн төрийн баталгаат хууль зүйн туслалцааг авах эрхтэйг нотлох баримт бичиг нь : 1\ төрийн баталгаат эрх зүйн туслалцаа авахаар хүсэлт гаргахаас өмнөх эд хөрөнгө болон орлогын мэдүүлэг. Мөн хуулийн дагуу хууль зүйн туслалцаа нь нэгээс дээш жил үргэлжлэх бол жил бүр эд хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргаж өгөхийг шаарддаг. 2\ тухайн этгээд нь төрийн асрамж хамгаалалтад байсныг нотлох гэрчилгээ. 3\ бусад бичгэн нотолгоо, баримтууд. Төрөөс хууль зүйн туслалцаа авч байгаа тохиолдолд мөрдөн байцаагч, шүүгч, прокурор, эсхүл шүүх эрх зүйн туслалцаа авч байгаа этгээдээс түүний өөрийнх нь болоод гэр бүлийн нь гишүүдийнх нь эд хөрөнгийн байдлын талаархи нэмэлт магадлагаа гаргуулах эрхтэй байдаг. Төрийн баталгаат хууль зүйн туслалцааны төлбөр нь тухайн этгээдийн хөрөнгө, орлогын хэмжээнээс хамаарч төрөөс төлөгддөг: 1\ нэгдүгээр түвшин-100 хувь 2\ хоёрдугаар түвшин-95 хувь, 3\ гуравдугаар түвшин-80 хувь, 4\ дөрөвдүгээр түвшин-65 хувь, 5\ тавдугаар түвшин-50 хувь. Хэрвээ тухайн этгээдийн хөрөнгө, орлогын түвшин нь хууль зүйн туслалцааны үед өөрчлөгдвөл төрийн баталгаат эрх зүйн туслалцааны зардлын хувь нь мөн адил өөрчлөгдөнө. Төрийн баталгаат хууль зүйн туслалцааны зардлын дээд хэмжээг Литвийн Засгийн газар тогтооно.

Төрийн баталгаат хууль зүйн туслалцаа нь дараахь тохиолдолд дуусгавар болно:

- 1\ төрийн баталгаат хууль зүйн туслалцааг авч байсан этгээд цаашид авах эрхгүй болбол,
- 2\ хууль зүйн туслалцааны төлбөрийн нэг хэсэг болгон төлөхөөр үүрэг болгосон төлбөрийг тухайн этгээд улсын төсөвт төлөөгүй бол
- 3\ тухайн этгээд өөрийн орлого, эд хөрөнгийн төлөөр мөн тухайн хэргийн талаар илт худал мэдээлэл өгсөн бол.

Төрийн баталгаат хууль зүйн туслалцааг дараахь тохиолдолд зогсооно:

1\ хэрвээ тухайн этгээдийн орлого, эд хөрөнгийн түвшин өөрчлөгдсөн ба үүнээс үүдэн гарах төрийн баталгаат хууль зүйн туслалцааны зардлын нэг хэсгийг нөхөн төлөх чадваргүй бол,

2\ тухайн этгээдийн төрийн баталгаат хууль зүйн туслалцааг авах эрхтэйг нотолсон баримт материалыг мэдүүлээгүй бол,

3\ хэрвээ шүүх тухайн этгээдэд төрийн баталгаат хууль зүйн туслалцаа үзүүлэх шаардлагагүй, эрх, ашиг сонирхол нь хуулиар хамгаалагдсан бөгөөд өөрийгөө өмгөөлүүлэх болоод хэргийг шийдвэрлэх процедурт ямарваа нэг зөрчил байхгүй гэж үзвэл. Төрийн баталгаат эрх зүйн туслалцааг дуусгавар болгох шийдвэрийг дараахь этгээд гаргана: 1\ тухайн хэргийг хянаж байгаа прокурор, төрийн баталгаат эрх зүйн туслалцаа тухайн этгээдэд мөрдөн байцаагчийн шийдвэрт үндэслэн олгогдсон бөгөөд буруутгагдаж байсан этгээдийг шүүх шийтгээгүй бол, 2\ тухайн хэргийг шийдвэрлэж байгаа байгууллага, албан тушаалтан, төрийн баталгаат эрх зүйн туслалцаа нь прокурор, шүүгч, эсхүл шүүхийн шийдвэрт үндэслэн олгогдсон бол. Төрийн баталгаат эрх зүйн туслалцааг дуусгавар болгосон тохиолдолд төрийн баталгаат эрх зүйн туслалцааны зардлыг уг туслалцааг авсан этгээд хуулиар тогтоосон журмын дагуу төлнө.

2. Байгууллагын болон санхүүгийн зохицуулалт

Улсын Өмгөөлөгчийн газар байгуулагдахаас өмнө эрүүгийн хэргийн хариуцагч нарын хууль зүйн төлөөллийг дүүргийн өмгөөлөгчдийн товчооноос томилогдсон өмгөөлөгч нар хэрэгжүүлж байв. Хэдийгээр өмгөөлөгч нар байгууллагаас даалгасан хэрэг дээр ажиллаж зохих хөлс авдаг ч тэдний ажил эмх замбараагүй, урьдчилан төлөвлөхөд хэцүү бөгөөд хөлс нь бага, заримдаа засгийн газрын төсвийн дутагдлаас болоод хэдэн сараар хүлээхэд хүргэдэг байна. Өмгөөлөгч ихтэй зарим хотуудад зарим өмгөөлөгчдийн ажил нь зөвхөн байгууллагаас өгөх хэргээс хэтэрдэггүй, тиймээс ч маш бага орлоготой байдаг. Гэтэл хүмүүсийн ярьж байгаагаар, Вилниус, Каунас зэрэг хотуудад олон хувийн өмгөөлөгч нар маш завгүй ажиллацгаадаг бөгөөд энэ хэргийн талаар огтхон санаа зовдоггүй байна. Олон хотод шүүгчид тэдгээрийн хамтран ажиллагсад хуулиар хянан шийдвэрлэх процедурын бүх үе шатанд өмгөөлөгч заавал байх ёстой хэргийг шүүхээр

шийдвэрлэхэд байлцуулахаар өмгөөлөгч нар луу хэдэн цагаар утасдан цагаа барж, тэр байтугай ямар нэг башир арга заль хэрэглэн шүүхэд ирүүлдэг байна. Прокурор, мөрдөн байцаагч нар өөрсдийн үндсэн ажлаа хийх цагаа байгууллагаас өгсөн хэргийг дуртай дургүй өмгөөлөх өмгөөлөгчтэй зууралдаж тэдэнд үйлчлүүлэгчээ эрх зүйн төлөөллөө хангах ёстой гэдгийг ухуулан ойлгуулах гэсээр өнгөрүүлдэг байна. Тэдэнд хариуцагчийг цагдан хорих хуулиар заасан хугацааны хязгаарлалт байнга түвэг учруулж байдаг ба энэ нь өмгөөлөгч нар хариуцагчийг шүүх хурал болтол цагдан хорих шийдвэр гаргадаг эр бүхий байгууллагатай ойр байдагтай холбоотой. Шүүгч нар үргэлж л томилогдсон зөвлөл байх боломжгүй, түүнгүйгээр шүүх хурал хийвэл үндсэн хууль зөрчсөн болно гэдэг шалтгаанаар шүүх хурлыг хойшлуулж байдаг. Мөрдөн байцаагч нар тухайн хэргийн мөрдөн байцаалтын үе шатанд хуульчийг мөрдөн хөөж барих, ярилцлагын үеэр байлцах өмгөөлөгчийг олохын тулд өдөрт 4-5 цаг зарцуулдаг байна. Прокурор нар ч мөн адил. Хэдэн жилийн өмнө бүх өмгөөлөгч нар байгууллагаас өмгөөлөхөөр даалгасан хэргийг заавал авах үүрэгтэй байсан. Энэ нь хувийн өмгөөлөгч нарыг засгийн газраас ногдуулж буй ачаанаас үүрэлцэхэд хүргэдэг байв. Эрх зүйн үйлчилгээний нэг цагийн хөлс бага байсан бөгөөд одоо ч бага хэвээр буюу дунджаар 14 Литас \3.5 ам.доллартай тэнцэнэ\ байна.

Хүснэгт 1. Төрийн баталгаат хууль зүйн туслалцааны улсын сан \Литас—Литва улсын мөнгөн тэмдэгт\

	1999 Литас	2000 Литас	2001 Литас	2002 Литас
Улсын төсөв	6,760,832,000	6,851,088,000	7,414,456,000	10,003,411,000
Улсын төсөвт төлөвлөсөн хөрөнгө	2,535,000	2,750,000	5,055,000	4,800,000
Хүлээн авсан хөрөнгө	2,080,500	2,750,000	5,032,100	
Бодит зардал	2,163,100	3,166,100	4,989,900	
Төрийн баталгаат эрх зүйн туслалцаанд зөвшөөрөгдсөн хөрөнгийн улсын төсөв дэх хувь	0,0374	0,0401	0,0681	0,0479

3. Литва улсад туршилтын өмгөөлөгч нарын байгууллагыг байгуулсан нь—хууль зүйн туслалцаа авах тогтолцооны байгууллагын шинэчлэлд оруулах хувь нэмэр

1999 онд төрийн баталгаат хууль зүйн туслалцаанд хамаарах бүрэн сайжруулсан тогтолцоог бий болгох Засгийн газрын үйл ажиллагаатай зэрэгцэн Үндсэн хуулийн болон хууль тогтоомжийн бодлогын институт \COLPI\ Соросын сан \албан ёсоор Литвийн Нээлттэй Сан-OLF гэж нэрлэдэг\ -тай хамтран Литва улсад болоод Төв болон Зүүн Европын бүс нутагт өмгөөлөгч заавал оролцох эрүүгийн хэргийн эрх зүйн туслалцааны чанарыг сайжруулах үүднээс туршилтын өмгөөлөгчдийн байгууллага байгуулахад туслах зорилгоор томоохон төсөл хэрэгжүүлсэн. Энэхүү төсөл нь эрүүгийн хэрэг дэх эрх зүйн туслалцааг сайжруулах зайлшгүй шаардлага дээр тулгуурласан юм. Гэсэн хэдий ч үндэслэн байгуулагчид нь төрийн баталгаат эрх зүйн туслалцааг мөн иргэний болон захиргааны хэрэгт үзүүлэх боломж нөхцөл, тэдгээрт эрх зүйн үйлчилгээний чанар болон зардлыг тэгш тогтоох талаар мөн авч үзсэн юм. Өмгөөлөгчдийн байгууллагыг үндэслэгчид нь Хууль зүйн яам, Литвийн Барын Холбоо болон Литвийн Нээлттэй Сан юм. Сиаули болон Вилниусийн Өмгөөлөгчдийн байгууллагыг байгуулах гэрээнд 1999 оны 12 дугаар сарын 13 болон 2001 оны 10 дугаар сарын 11-ний өдрүүдэд гарын үсэг зурсан юм. Байгууллагууд нь Сиаулиад 200 оны 3 дугаар сарын 31, Вилниусд 2002 оны 4 дүгээр сарын 26-ны өдөр албан ёсоор үйл ажиллагаагаа эхэлсэн. Сиаулиа дахь байгууллага нь 5 өмгөөлөгч, 1 захиргааны ажилтан, Вилниус дахь байгууллага нь 8 өмгөөлөгч \тэдний 2 нь насанд хүрээгүй хүүхдийн хэрэгт голлон ажилладаг ба энэ ажил нь Хууль зүйн яам болон Насанд хүрээгүйчүүдийн эрх зүйн туслалцааны хөтөлбөрийн дагуу НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс олгогдсон 20000 ам.долларын санхүүгийн дэмжлэгтэйгээр явагддаг\, 1 захиргааны ажилтантай үйл ажиллагаагаа явуулж байна. Эдгээр байгууллагын өмгөөлөгч нарын ажлын хөлс нь байгууллагаас өгсөн хэрэгт ажилладаг

өмгөөлөгч нарынхтай адил боловч нэмэгдэл хөлсийг COLPI болон OSF-аас олгодог бөгөөд энэ нь тэдний орлогыг дунджаар 50 хувь нэмэгдүүлдэг юм. Өмгөөлөгч нар мөн эрүүл мэндийн даатгал, иргэний хариуцлагын даатгал, Барын холбооны гишүүнчлэлийн хураамж, мэргэжил дээшлүүлэх сургалт болон 4 долоо хоногийн амралт зэрэг хөнгөлөлтүүдийг эдэлдэг. Өмгөөлөгчдийн байгууллагын эрх зүйн статус нь Олон нийтийн байгууллагын тухай хуулийн дагуу засгийн газрын бус байгууллага юм. Байгууллагыг байгуулахтай холбогдсон бүх зардлыг COLPI болон OSF гаргасан байна.

Сианулиа дахь Өмгөөлөгчдийн байгууллага (СӨБ)

Эхэндээ СӨБ-ын үйл ажиллагаа нь нэхэмжлэгч, хариуцагчийн эрхийг ямар нэг байдлаар урамшуулан дэмждэггүй Зөвлөлт үеийн уламжлалт тогтолцоотой эрүүгийн эрх зүйн системтэй уялдаж болох эсэх нь тодорхойгүй байлаа. Гэсэн хэдий ч шүүх болон эрх зүйн системд харьяалагддаг бусад агентлагууд мэргэшсэн өмгөөлөгчдийн нэгдсэн боловсон хүчнийг сайшаан хүлээж авах нь тодорхой байсан. СӨБ нь 2000 оны 4 дүгээр сараас үйл ажиллагаагаа явуулж эхлээд 2 жил гаран болж байна. Энэ 2 жилийн хугацаанд 2000 оны 4 дүгээр сараас 2002 оны 4 дүгээр сар СӨБ-ын өмгөөлөгч нар мөрдөн байцаагч, шүүгч, прокурор, шүүхээс хүссэн нийт 4069 өмгөөлөгч заавал оролцох эрүүгийн хэрэг дээр ажилласан бөгөөд энэ нь жилд 2034, сард 169 хэрэг гэсэн үг юм. Дунджаар өмгөөлөгч бүр сард 33 хэрэг дээр бүрэн ажилласан байна. СӨБ-г байгуулахад гарсан нийт зардал нь 76989 Литас буюу 19247 ам.доллар. Үйл ажиллагааны зардал нь төслийн эхний жилд 2000 оны 4 дүгээр сараас 2001 оны 4 дүгээр сар 285760 Литас буюу 71440 ам.доллар\Хууль зүйн яамны 27023 Литас буюу 6755 ам.долларын өртөг бүхий шууд бус хандив оролцуулахгүйгээр\, хоёр дахь жилд 260223 Литас буюу 65055 ам.доллар \ Хууль зүйн яамны 76859 Литас буюу 19214 ам.долларын өртөг бүхий шууд бус хандив оролцуулахгүйгээр \ болсон байна. СӨБ-ын өмгөөлөгчдийн эрх зүйн үйлчилгээнд төлөх Хууль зүйн яамны мөнгөн хөрөнгө нь 176859 Литас\ Сианулиад 12 сарын хугацаанд эрх зүйн үйлчилгээ үзүүлсэн бүх өмгөөлөгчдийн үйлчилгээний хөлсний 22.4 хувьтай тэнцэж байгаа юм. \Нийт дүн 343100 Литас-доорхи хүснэгтэд харуулав\

Хүснэгт 2. Сианулиад төрийн баталгаат эрх зүйн туслалцаа үзүүлсэн өмгөөлөгчдийн ажлын хөлс—2001 он

Шүүхийн нэр	Гарсан бодит зардал	Зарцуулсан хөрөнгө
Šiauliai Хотын Дүүргийн Шүүх	186100	196900
Šiauliai Бүсийн Дүүргийн Шүүх	60800	64800
Šiauliai Бүсийн Шүүх	96200	102300
Нийт	343100	364000

СӨБ-ын үйл ажиллагаа нь зөвхөн хэрэг дээр ажиллаад зогсохгүй бусад хуульч өмгөөлөгчдийн ажлыг зохицуулдаг. Тухайн хэргийн өмгөөлөгч байхгүй тохиолдолд СӨБ түүнийг орлодог, өмгөөлөгч тухайн хэрэг дээр ажиллаж чадахгүй бол СӨБ шүүгч, мөрдөн байцаагч, прокурор нарт түвэг удахгүйгээр хяналтын болон шүүхийн аль ч шатанд өөр хуульч, өмгөөлөгчдийг олж, уг хэрэг дээр ажиллахыг санал болгож ажиллуулдаг. СӨБ нь дээр дурдсанчлан шүүх, прокурор, цагдаагийн мөрдөн байцаалтын шатанд бүхий л ачааг үүрдэг. Ингэснээрээ СӨБ-ын 5 хуульч эрүүгийн эрх зүйн системийн үйл ажиллагааг сайжруулж байгаа юм. Эдгээр агентлагууд энэ байгууллага дахь хуульчдын тоо өсөн нэмэгдэж мөн тэдний авч гарч чадах хэргийн тоо нэмэгдсээр байгаатай санал нэгтэй байгаад гайхах зүйлгүй юм. СӨБ нь сард дунджаар 30-35 хэрэгт өмгөөлөгчдөө оролцуулдаг ба энэ нь нэг өмгөөлөгч өдөрт 2-3 хэрэгт оролцдог гэсэн үг юм. СӨБ нь өмгөөлөгчдөө шүүхэд мөн мөрдөн байцаалтын шатанд, прокурорын ярилцлагад ч мөн оролцуулдаг. СӨБ-ын өмгөөлөгчид нь босоо төлөөллийн системээр ажилладаг. Хэрэг СӨБ-д хамаарах үеэс эхлэн уг хэргийг дуусалт үйлчлүүлэгчтэй хамтарч ажилладаг ба үүнд давж заалдах шат ч мөн хамаарна. Үйлчлүүлэгч зөвхөн нэг өмгөөлөгчтэй байх нь хэрэг шийдвэрлэх шат болгонд шинэ өмгөөлөгчтэй ажиллахаас харьцангуй давуу талтай байдаг. СӨБ-ын ажиллах журмын дагуу өмгөөлөгч бүр тухайн хэргийн бүх шатанд холбогдох бүх мэдээллийг авч, оролцож ажилладаг. Хэрвээ СӨБ-ын нэг өмгөөлөгчийн өөр өөр шүүх хуралд оролцох цаг давхцах тохиолдолд СӨБ-ын өөр нэг өмгөөлөгч хоёр

дахь хэрэгт оролцож ажилладаг. СӨБ-ын өмгөөлөгч нар өөрсдийн ажиллаж буй хэргийн талаар уулзаж санал бодлоо солилцож хэлэлцдэг ба тухайн долоо хоногт өмгөөлөгчдийн оролцохоор төлөвлөсөн хэргүүдийн хуваарь өмгөөлөгч тус бүр дээр долоо хоног тутам гардаг.

СӨБ дахь шинэ үйл ажиллагаа

Төв болон Зүүн Европын бүс нутагт СӨБ нь энэ төрлийн анхны байгууллага бөгөөд гол зорилго нь Сиаулиа дахь эрүүгийн эрх зүйн системийн менежмент болон зохицуулалтын асуудлаас илүүтэйгээр түүний өдөр тутмын үйл ажиллагаанд шинэ санаачлага, арга зам бий болгож, нэвтрүүлэх явдал юм. Мөн түүнчлэн, уг байгууллага нь туршилтын хугацааны туршид үнэлэх шалгуур үзүүлэлтийг тогтоогоогүй байгуулагдсан билээ. СӨБ-ын өмгөөлөгч нар нь энэ байгууллагад ажиллахаас өмнө тухайн салбарт ажилласан туршлагатай, бие даасан хүмүүс юм. СӨБ-ын үйл ажиллагааны эхэн үед практикт хэр холбоотойг нь үнэлэх үзүүлэлт байгаагүй. Гэсэн ч тэд бие даасан, хараат бус хуульчид байсан. Мөн тэд хамтарч ажиллаж чаддаггүй эсвэл хүсдэггүй гэж үзэх үндэслэл байгаагүй. СӨБ нь өмгөөлөгч болон байгууллагын үйл ажиллагааны чанарын стандартын хэрэгжилтийн хоорондын удааширсан зохицуулалтыг нэгтгэх зорилгогүй. СӨБ бүх хариуцагч нарын хэргүүдийн ач холбогдлыг сайжруулснаар өмгөөлөгч нар хоорондоо өөрсдийн хэргүүдийн талаар нээлттэй байж зарим хэрэгт оролцох болон асуулт хариултын ажиллагааг “утсаар” явуулах боломжтой болсон байна. “Утсаар” үйл ажиллагаа явуулах систем нь зөвхөн СӨБ-ын өмгөөлөгчдийн үл ажиллагаанд биш мөн байгууллагаасаа ажиллах үүрэг авсан зарим өмгөөлөгч нар шүүхэд эсхүл холбогдох байгууллага хариуцагчаас асуултад хариулт авах тохиолдолд биеэр оролцож чадахгүй үед нийтлэг хэрэглэгддэг байна. Энэ нь өмгөөлөгч СӨБ-ын холбогдох хэрэгт зай завгүй ажиллаж байх үедээ шүүх хуралд бэлэн болсон хэрэг хүлээж авсан тохиолдолд үр дүнтэй аргад тооцогддог. СӨБ-ын үйл ажиллагааны эхний жилд оффисын үйл ажиллагаа маш шахуу, ачаалалтай байсан бөгөөд явагдсан хэргийн материал, мэдээлэл замбараагүй, хэргийн талаархи тэмдэглэлүүд тогтмол хадгалагдах боломж муу байсан. СӨБ нь тухайн хэрэг шийдвэрлэгдэж хаагдахаас өмнө ямар ч мэдээлэл өгдөггүй байсан бөгөөд үйлчлүүлэгчийн өмнөөс хийх ёстой хэргийн файл буюу нэгдсэн сан байгаагүй. СӨБ, COLPI/ОSЕ-н үйл ажиллагааны дутагдалтай талыг үнэлж түүнийг арилгах зорилгоор 2001 оны 6 дугаар сард байгууллагын менежмент, зохицуулалт, чанарын хяналтын талаар өмгөөлөгч нарт зориулсан сургалт зохион байгуулсан бөгөөд энэхүү сургалтаар байгууллагын үйл ажиллагааны ерөнхий чиглэлийг гаргаж өгсөн байна.

1/ “хамтарсан” хэргийн систем

Бусад өмгөөлөгчдийн шүүх хуралд бэлэн болсон болоод бусад хэргүүдийн талаар мэдээлэлтэй байх нь тухайн нэг хэрэг дээр багаараа ажиллахад тустай байдаг. “Хамтарсан” хэрэг дээр ажиллаж байгаа өмгөөлөгч бүр өөр өөрийн үүрэгтэй байх бөгөөд баг нь тухайн хэргийн стратеги болоод онолын асуудлаар нэгдсэн байх ёстой. Хэрвээ шүүгч шүүх хурлыг түр хугацаагаар хойшлуулбал, нэг өмгөөлөгч нь үйлчлүүлэгчид ямар нэг хохирол учруулахгүй байх асуудлыг хариуцах жишээтэй.

2/ Байцаалт болон шүүх ажиллагаанд оролцох уялдаа холбоо

Багаар ажиллах ажлыг сайжруулснаар СӨБ-ын хэд хэдэн өмгөөлөгчийн прокурор эсхүл мөрдөн байцаагчтай уулзах ажил нь нэг газар болохоор байвал нэг нь бусдаа төлөөлөн оролцох боломжтой юм. Энэ нь мөн тусгай мэдлэг шаардсан, зөвхөн нэг өмгөөлөгч оролцох хэргээс бусад хэргийн хувьд шүүх ажиллагаанд ч мөн адил үйлчлэх боломжтой.

3/ Шүүн таслах ажиллагаанаас өмнөх баривчилгаанаас хариуцагчийг чөлөөлүүлэх хүсэлт гаргах

Хариуцагчийг чөлөөлүүлэхтэй холбогдсон маргааны талаар өмгөөлөгчийн зүгээс хийгдэх шаардлагатай болоод боломжтой бүх нотлох баримт, мэдээллүүдийн талаар СӨБ-д танилцуулна.

4/ Шүүн таслах ажиллагаанаас өмнөх баривчлагаанаа хариуцагчийг чөлөөлүүлэх мэдүүлгийн үр дүнгийн талаар мэдээлэх

СӨБ хариуцагчийг цагдан хорихоос суллахтай холбоотой боломжит бүхий л үйлдлүүдийг хийдэг /хариуцагч хүч хэрэглэсэн гэмт хэрэгт буруутгагдсан, эсхүл бусдад хор хохирол учруулж магадгүй байдлаар авирласнаас бусад хэрэгт/. Энэ практик нь Литвад цагдан хорих аргыг хэт хэрэглэх, мөн тухайн хэргийн талаархи шүүхийн шийдвэр мөрдөн байцаагчийн эсхүл прокурорын гаргасан шийдвэрээс өөр тохиолдолд чухал мэдээлэлд тооцогддог.

5/ Боломжтой бүх хэргүүдэд бодит гэрч болон экспертын дүгнэлт мөн бичгээр мэдүүлэг гаргах

Экспертын нотлох баримтад хийсэн шинжилгээг стандарт загварынх нь дагуу танилцуулах /хурууны хээ, оюун санааны байдал/.

6/ магадлагааг шүүхэд баталгаажуулах саналаа мэдүүлэх /боломжтой бол/

7/ Сонгох ял, төлбөрийн хэмжээг бууруулах тухай хүсэлт, нотлох баримтыг буруугаар ашигласан тухай мэдүүлэх

8/ тухайн байгууллагаас томилогдсон өмгөөлөгчид оролцоогүйгээс шүүх дээр “гацсан” хэргүүдийн тоог бууруулах

Энэ тохиолдолд хүндэтгэн үзэх шалтгаантайгаар хойшлуулснаас бусад хэрэгт СӨБ-н өмгөөлөгчдөд бэлтгэх цаг хангалтгүй байдгийг анхаарах нь чухал.

9/ Прокурор, мөрдөн байцаагч нараас үйлчлүүлэгчид тавьж буй шаардлагатай бус эсхүл яаралтай бус байцаалтыг зогсоох

Хяналтын болон мөрдөн байцаалтын шатан дахь байцаалт нь цаг үеэ олдоггүй— хариуцагчийг баривчилснаас хойшхи эхний 72 цагийн дотод явагддаг.

10/ Өмгөөлөгч тус бүрт долоо хоногт дор хаяж нэг өдөр оффист ажиллах боломж олгох

Энэ санал нь өмгөөлөгч шүүх, прокурор, мөрдөн байцаах газар руу явалгүйгээр нэг өдрийг өөрийн ажлыг төлөвлөх зорилгоор оффист ажиллах нь зүйтэй гэсэн утгатай.

11/ Бүх хэргүүдийн талаар шүүх ажиллагаа явагдсаны дараа мэдээллийн санд оруулах

Өмгөөлөгч шүүх ажиллагаанд оролцсон талаархи тэмдэглэлийг бусад холбогдох асуулт, хариулт, явцын талаархи мэдээлэлтэй хамт оффисын ажилтанд өгөх бөгөөд уг ажилтан мэдээллийн санд оруулах үүрэгтэй байна.

СӨБ нь Сиаулиад эрүүгийн эрх зүйн системд чухалд тооцогдох ажлыг хийж байгаа бөгөөд хэдий өмгөөлөгчид энэхүү загвар системтэй танил биш байсан ч тэдний энэ системд хандах хандлага нааштай байна. Тэд Сиаулиад эрүүгийн эрх зүйн системд эерэг нөлөө бүхий өөрчллийг хийж байна. Ямар ч байсан СӨБ эрүүгийн эрх зүйн системд тодорхой байр суурьтай болжээ. Шүүгч, прокурор, мөрдөн байцаагч нартай хийсэн ярилцлагаас харахад тэд СӨБн оронд хуучин тогтолцоог буцаан хэрэглэх талаар төсөөлөхгүй байгаа бөгөөд энэ байгууллагыг үйл ажиллагаагаа улам өргөжүүлэхийг хүсч байгаа юм.

Вилниус дахь өмгөөлөгчдийн байгууллага /ВӨБ/

Вилниусын Өмгөөлөгчдийн байгууллага 2002 оны 4 дүгээр сард байгуулагдсаныг өмнө дурдсан. ВӨБ байгуулагдсаны дараа өмгөөлөгчдөд зорилго, үйл ажиллагаагаа танилцуулж мэдээлэл өгөх зорилгоор сургалт явуулсан бөгөөд үйл ажиллагааны процедур Сиаулиа дахь байгууллагатай үндсэндээ ижил бөгөөд өмгөөлөгчид нэг хэрэгт

хамтарч ажиллах талаар илүү мэдээлэл өгсөн байна. Уг байгууллагад компьютерийн шинэ сүлжээ суурилуулсан бөгөөд энэ нь өмгөөлөгчид өөр хоорондоо мэдээлэл солилцох, мөн хэргийг компьютерт хадгалах мэдээллийн сан байгуулах зорилготой юм.

Өмгөөлөгчдийн байгууллагын цаашдын үйл ажиллагаа

СӨБ-д зарцуулсан зардлаас харахад өмгөөлөгчдийн байгууллага нь холбогдох байгууллагаас томилогдон ажилладаг өмгөөлөгч нарын зардлаас илүү зардалтай байна. Гэвч энэ нь уг байгууллагын цаашдын үйл ажиллагаа болоод олон нийтийн эрх ашгийг хамгаалах тогтолцоог өргөжүүлэх ажлыг зогсоох шалтгаан болохгүй. Шүүгч, прокурор, мөрдөн байцаагч нарын төлөөлөгчид СӨБ байгуулагдахаас өмнөх үйл ажиллагааг одоогийнхтой харьцуулан ач холбогдлыг нь үнэлж байна. Хууль зүйн яам болоод Шүүх энэ системийг өргөжүүлэхийн тулд нэлээд хэмжээний цаг, мөнгө зарцуулж байна.

Хурлын оролцогчид

Нэг. Төрийн байгууллагууд

Хууль зүй, дотоод хэргийн яам

Сайд Ц. Нямдорж

Дэд сайд Ц.Мөнх-Оргил

Төрийн нарийн бичгийн дарга Б. Цэрэндорж

Хууль зүйн бодлогын газрын дарга Д.Баярсайхан

Ахлах мэргэжилтэн Б. Цэвээн

Мэргэжилтэн А. Анунаран

УИХ-ын Хууль зүйн байнгын хороо

Хууль зүйн байнгын хорооны дарга Б. Шаравдорж

УИХ-ын гишүүн Ц. Оюунбаатар

УИХ-ын гишүүн Б.Долгор

УИХ-ын гишүүн С.Төмөр

УИХ-ын гишүүн С.Сугар

Ерөнхийлөгчийн Тамгын Газар

Ерөнхийлөгчийн хуулийн зөвлөх Г.Баясгалан

Хүний эрхийн Үндэсний Комисс

Дарга С. Цэрэндорж

Ахлах референт, комиссын гишүүн Н. Дашдорж

Улсын дээд шүүх

Ерөнхий шүүгч Ч. Ганбат

Эрүүгийн хэргийн тэнхмийн тэргүүн шүүгч Н. Төрбат

Иргэний тэнхимийн шүүгч Б. Доржготов

Нийслэлийн шүүхийн ерөнхий шүүгч Батдэлгэр

Улсын Ерөнхий Прокурорын газар

Ерөнхий прокурор Н. Алтанхуяг

Ерөнхий прокурорын туслах Т. Сүхбаатар

Нийслэлийн прокурорын газрын дарга Д. Дагвадорж

Хэрэг бүртгэх ажиллагааны хяналт тавих хэлтсийн дарга О. Нямаа

Мөрдөн байцаах ажиллагааны хяналт тавих хэлтсийн дарга Т. Сүхбаатар

Ял эдлүүлэх ажиллагаанд хяналтын хэлтсийн дарга Ц. Ариунболд

Цагдаагийн ерөнхий газар

Дарга, хошууч генерал Д. Сандаг-Очир

ЦЕГ-ын Мөрдөн байцаах газрын дарга М. Энх-Амгалан

ЦЕГ-ын Хэрэг бүртгэх албаны дарга Л. Сүхээ /хурандаа/

ЦЕГ-ын Хууль зүйн мэдээлэл, сургалтын төвийн дарга П. Ихзаяа

Цагдаа олон нийтийн хамтын ажиллагаа төслийн зохицуулагч М.Хоролсүрэн

Нийслэлийн цагдаагийн газрын Хүүхдийн тасгийн дарга Г. Болдбаатар
Нийслэлийн Цагдаагийн газрын дарга Н. Ганболд
Сүхбаатар дүүргийн цагдаагийн хэлтсийн дарга Ш. Энхбат
Баянзүрх дүүргийн Цагдаагийн хэлтсийн дарга М. Ганхүү
Чингэлтэй дүүргийн цагдаагийн хэлтсийн дарга Д. Майсүрэн
Баянгол дүүргийн Цагдаагийн хэлтсийн дарга Ш. Батсүх
Сонгинохайрхан дүүргийн Цагдаагийн хэлтсийн дарга Л. Цог
Хан-Уул дүүргийн Цагдаагийн хэлтсийн дарга С. Отгонбаатар
Налайх дүүргийн Цагдаагийн хэлтсийн дарга З. Сайжрах
Багануур дүүргийн Цагдаагийн хэлтсийн дарга Ц. Батчулуун
Багахангай дүүргийн Цагдаагийн хэлтсийн дарга Д. Ганболд
Төв аймгийн Цагдаагийн хэлтсийн дарга Х. Энхжаргал

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар

Дарга, хурандаа Ж. Чойжанцан

Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны дарга Д. Даваа-Очир

Насанд хүрээгүйчүүдийн хорих ангийн дарга Д. Сээсэд

Урьдчилан цагдан хорих төвийн дарга Ж. Сугаржав

Хууль тогтоомж, шүүх эрх мэдлийн эрдэм шинжилгээ, сургалт, мэдээлэл, сурталчилгааны
үндэсний төв

Захирал Ж.Амарсанаа

Захиргааны хэлтсийн дарга Ж.Энхнасан

Хоёр. Гадаадын донор байгууллагууд

Монголын Нээлттэй нийгэм хүрээлэн /Соросын сан/-ийн Гүйцэтгэх захирал Стефен Д. Ванс

АНУ-ын Колумбын их сургуулийн ОНАСХ эрх зүйн санаачилга байгууллагын гүйцэтгэх захирал Эдвин Рекош

Монголын Нээлттэй нийгэм хүрээлэн /Соросын сан/-ийн Иргэний Нийгэм хөтөлбөрийн захирал Л.Ариунаа

Монголын Нээлттэй нийгэм хүрээлэн /Соросын сан/-ийн Эрх зүйн хөтөлбөрийн зохицуулагч Ж.Баярцэцэг

Монголын Нээлттэй нийгэм хүрээлэн /Соросын сан/-ийн Цагдаагийн шинэтгэл хөтөлбөрийн зохицуулагч Ч.Жаргал

Монголын Нээлттэй нийгэм хүрээлэн /Соросын сан/-ийн Хэвлэл мэдээлэлтэй харилцах ажилтан Ш.Алтанзагас

НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр Ван Хи Ли

Германы Техникийн Хамтын ажиллагааны нийгэмлэг Л. Заяа

Дэлхийн банкны Шүүхийн шинэтгэлийн хөтөлбөр Д. Оюунчимэг

Шүүх эрх мэдлийн шинэтгэлийн төсөл Роберт Ла Монт

Хүний эрхийн Үндэсний хөтөлбөр боловсруулах төсөл Н.Цогт

НҮБ-ын Хүүхдийн Сан Ричард Прадо

НҮБ-ын Хүүхдийн Сан Франсис Косстик

Ханнс-Зайделийн сан Ц.Сарантуяа

Гурав. Монголын Өмгөөлөгчдийн Холбоо

Ерөнхийлөгч Б. Пүрэвням

Дэд ерөнхийлөгч Л. Ринчин

Нийслэлийн салбар зөвлөлийн дарга Я. Нямжав

Эдвокэйт хуульзүйн товчоо О. Баасанхүү

Эдвокэйт хууль зүйн товчоо До. Батсүх

Сувд хуульзүйн товчоо Э. Болорчулуун

Тусламж хууль зүйн товчоо Я. Баатар

Орчлон хууль зүйн товчоо Б. Энх-Амгалан

Элч хууль зүйн товчоо Б. Ганбаатар

Цэгц хууль зүйн товчоо Д. Туяа

Баянзүрх хууль зүйн товчоо Г. Хужаа

Их засаг хууль зүйн товчоо Ц. Алимаа

Эв хууль зүйн товчоо З. Алтангэрэл

Архангай аймгийн Өмгөөлөгчдийн зөвлөл Р. Эрдэнэ-Очир
Баян-Өлгий аймгийн Өмгөөлөгчдийн зөвлөл А. Еркегүл
Булган аймгийн Өмгөөлөгчдийн зөвлөл С. Ванчиг
Баянхонгор аймгийн Өмгөөлөгчдийн зөвлөл Д. Уранчимэг
Говь-Алтай аймгийн Өмгөөлөгчдийн зөвлөл М. Энхзаяа
Говьсүмбэр аймгийн Өмгөөлөгчдийн зөвлөл Э. Сайханаа
Дорнод аймгийн Өмгөөлөгчдийн зөвлөл Б. Уранцэцэг
Дорноговь аймгийн Өмгөөлөгчдийн зөвлөл Т. Саранчимэг
Дундговь аймгийн Өмгөөлөгчдийн зөвлөл Д. Даваа
Завхан аймгийн Өмгөөлөгчдийн зөвлөл В. Содномцэрэн
Орхон аймгийн Өмгөөлөгчдийн зөвлөл Д. Нямаа
Өмнөговь аймгийн Өмгөөлөгчдийн зөвлөл Б. Алтанжаргал
Өвөрхангай аймгийн Өмгөөлөгчдийн зөвлөл Л. Нямдорж
Дархан-Уул аймгийн Өмгөөлөгчдийн зөвлөл Д. Дандар
Сэлэнгэ аймгийн Өмгөөлөгчдийн зөвлөл Р. Атарцэцэг
Төв аймгийн Өмгөөлөгчдийн зөвлөл Б. Энхтуяа
Ховд аймгийн Өмгөөлөгчдийн зөвлөл Б. Отгонжаргал
Хэнтий аймгийн Өмгөөлөгчдийн зөвлөл Б. Сүхбат
Сүхбаатар аймгийн Өмгөөлөгчдийн зөвлөл Б. Баярцогт
Хөвсгөл аймгийн Өмгөөлөгчдийн зөвлөл Б. Батдорж
Увс аймгийн Өмгөөлөгчдийн зөвлөл Н. Оюун
Багануур дүүргийн өмгөөлөгч Ц. Цэцэгмаа
Зүүнхараа сумын өмгөөлөгч Ц. Цогзолмаа

Дөрөв. Хүний эрхийн төрийн бус байгууллагууд

Хуульч эмэгтэйчүүдийн холбоо Д.Дүгэржав
Хүчирхийллийн эсрэг үндэсний төв Ц.Энхжаргал
Хүчирхийллийн эсрэг үндэсний төв Х.Мөнхзул
Эрх зүйн шинэтгэлийг дэмжих хуульчдын төв М. Ичинноров
Эрх зүйн шинэтгэлийг дэмжих хуульчдын төв Б.Сайнзаяа
Хүний эрх ба хөгжил төв Ж.Уранцоож
Хүний эрх ба хөгжил төв Т.Цэнд-Аюуш
Хүний эрх ба хөгжил төв Ч.Чинчулуун
Хүний эрх ба хөгжил төв Н. Дондов
Глоб интернэйшнл Х.Наранжаргал
Эрх чөлөө төв Ц.Оюунгэрэл
Амнести Интернэшнл Б.Алтантуяа
Тахир дутуу эмэгтэйчүүдийн холбоо О.Сэлэнгэ
Олон Улсын Засан Сайжруулах холбоо Б.Оюунбадам
Олон Улсын Засан Сайжруулах холбоо А.Энхтуяа

Тав. Хуулийн сургуулиуд

МУИС- ийн Хууль зүйн сургууль, Хүмүүнлэг клиник

Хууль Зүйн Дээд сургуулийн Захирал С.Нарангэрэл
«Хүмүүнлэг» клиникийн менежер Н.Туяа

Шихихутуг дээд сургууль, Буян киник

Шихихутуг дээд сургуулийн захирал Д. Оюунцэцэг
Буян клиникийн менежер Ц. Цэлмэг

Улсын Багшийн Их сургууль, Хэрэглээний эрх зүйн клиник

Улсын Багшийн их сургуулийн Хэрэглээний эрх зүйн клиникийн зохицуулагч О. Өнөрцэцэг
